Монгол Улсын Үндэсний Номын Сан

Нийтийн номын сангуудын тайлан 2011

Ред: Д.Бямбасүрэн / Дэд захирал, докторант/

Эмхэтгэсэн: Б.Сарандэлгэр/ Аргазүйч/

Улаанбаатар хот

2012 он

Өмнөх үг

Аймаг, хотын нийтийн номын сангуудын үйл ажиллагааны тайлангийн эмхэтгэл та бүхэнд 8 дахь удаагаа хүрч байна. Энэ удаагийн дугаараас эхлэн бүхэндээ электрон хэлбэрээр хүргэдэг боллоо.

Энэхүү эмхэтгэл нь та бүхнийг бусад нийтийн номын сангийн үйл ажиллагаатай дэлгэрэнгүй танилцуулж, харилцан туршлага судлан ажил үйлчилгээндээ авч хэрэгжүүлэхэд тус дөхөм болно гэдэгт бид найдаж байна.

Та бүхнийг тайлан, судалгаагаа ирүүлж хамтран ажилласанд талархлаа илэрхийлье.

Номын цагаан буян арвижих болтугай.

Агуулга

Өмнөх үг 3
Монгол Улсын Үндэсний Номын Сангийн 2010 оны бүтээгдэхүүн нийлүүлэлтийн ажлын тайлан 6
Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын төв номын сангийн 2010 оны үйл ажиллагааны болон бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээний тайлан 27
Хүүхдийн Номын Ордны 2010 он ажлын тайлан 44
Архангай аймгийн нийтийн номын сан мэдээллийн төвийн 2010 оны жилийн ажлын тайлан 67
Баян-Өлгий аймгийн нийтийн номын сангийн 2010 онд хийсэн ажлын тайлан 72
Баянхонгор аймгийн нийтийн номын сангийн 2010 онд хийсэн ажлын тайлан 79
Булган аймгийн төв номын сангийн 2010 онд хийсэн ажлын тайлан 94
Говь-Алтай аймгийн нийтийн номын сангийн 2010 онд хийсэн ажлын тайлан 102
Говьсүмбэр аймгийн нийтийн номын сангийн 2010 онд хийсэн ажлын тайлан 107
Дархан-Уул аймгийн төв номын сангийн 2010 онд хийсэн ажлын тайлан 112
Дорноговь аймгийн төв номын сангийн 2010 онд хийсэн ажлын тайлан 118
Дорнод аймгийн төв номын сангийн 2010 онд хийсэн ажлын тайлан 127
Дундговь аймгийн төв номын сангийн 2010 онд хийсэн ажлын тайлан 135
Завхан аймгийн төв номын сангийн 2010 онд хийсэн ажлын тайлан 139
Орхон аймгийн номын төвийн 2010 онд хийсэн ажлын тайлан 147
Өвөрхангай аймгийн төв номын сангийн 2010 онд

хийсэн ажлын тайлан 157
Өмнөговь аймгийн төв номын сангийн 2010 онд
хийсэн ажлын тайлан 162
Сүхбаатар аймгийн нийтийн номын сангийн 2010 онд
хийсэн ажлын тайлан 175
Сэлэнгэ аймгийн нийтийн номын сангийн 2010 онд
хийсэн ажлын тайлан 183
Төв аймгийн нийтийн номын сангийн 2010 онд
хийсэн ажлын тайлан 194
Увс аймгийн төв номын сангийн 2010 онд
хийсэн ажлын тайлан 199
Ховд аймгийн нийтийн номын сангийн 2010 онд
хийсэн ажлын тайлан 213
Хөвсгөл аймгийн нийтийн номын сангийн 2010 онд
хийсэн ажлын тайлан 220
Хэнтий аймгийн нийтийн номын сангийн 2010 онд
хийсэн ажлын тайлан 230

ҮНДЭСНИЙ НОМЫН САНГИЙН 2010 ОНЫ БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭЛТИЙН АЖЛЫН ТАЙЛАН

Улаанбаатар хот. 2010.12.26.

Үндэсний номын сан нь тайлангийн хугацаанд соёл урлагийг хөгжүүлэх төр засгийн бодлогыг хэрэгжүүлэх, номын сангийн үйл ажиллагааг өргөжүүлэх, ном судрын хадгалалт хамгаалалт, орчны тохижилт үйлчилгээг сайжруулах, орон нутгийн номын санчдыг давтан сургах, номын сангийн үйлчилгээнд шинэ техник, технологи нэвтрүүлэх, гадаад, дотоодын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалт, үр ашгийг нэмэгдүүлэхэд гол анхаарлаа чиглүүлэн ажиллалаа.
Үндэсний номын сангийн тулгамдсан асуудлын нэг болох шинэ барилгыг барих асуудлыг хөөцөлдөж, Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга., Ерөнхий сайд, БСШУ-ны сайд, Гадаад хэргийг сайд, Монгол Улсаас Кувейт улсад суугаа Элчин сайд нарт шаардлага хангахаа больсон одоогийн барилгын нөхцөл байдал, шинэ барилга барих зайлшгүй шаардлагын талаар албан бичиг явуулсан. Шинэ ордон барих асуудлаар ЕТГ-тай харилцаатай ажиллаж, Үндэсний номын сангийн шинэ барилгын төсөл боловсруулж, Ерөнхийлөгчийн Тамгын Газарт хүргүүллээ.

Удирдлага, зохион байгуулалтын үйлчилгээ:

Тайлангийн хугацаанд байгууллагын удирдлагын арга барил, ур чадварыг дээшлүүлэх, зохион байгуулалтыг боловсронгуй болгох талаар анхаарч, Засгийн Газрын тогтоол болон БСШУЯ, Соёл Урлагийн Хорооноос ирүүлсэн тушаал шийдвэрийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.
Энэ оны 3-р сараас Үндэсний номын сангийн захирлаар МЗЭ-ийн Хорооны Удирдах зөвлөлийн дарга Х.Чилаажав томилогдсон.
Захиргааны зөвлөлийн хурлыг 15 удаа, номын сангийн хамт олны хурал 2, Үнэлгээний комиссын хурал 6 удаа, дээврийн засварын ажлын хүлээн авах комиссын хурлыг тус тус хийж, номын сангийн тайлан, төлөвлөгөө, ажлын явц, ном судрын хадгалалт хамгаалалт, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, боловсон хүчин, орчны тохижилт үйлчилгээ зэрэг асуудлуудыг хэлэлцэн тухай бүр шийдвэрлэж ажиллалаа. Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээг БСШУ-ны сайдтай байгуулан ажиллаж, гэрээний дагуу төлөвлөсөн бүтээгдэхүүнийг нийлүүллээ.
Номын сангийн үйлчилгээг боловсронгуй болгох, ном судрын хадгалалт хамгаалалтыг сайжруулах, байгууллагын удирдлага зохион байгуулалтыг оновчтой болгох зорилгоор улсын хэмжээнд болон өөрийн номын сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөх дараах дүрэм журмыг боловсруулж БСШУЯ-д хүргүүллээ.Үүнд:
Улсын хэмжээнд мөрдөгдөх журам:

- “Ном дахин үнэлэх журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах /төсөл/
- Номын сангийн ээлжит ба ээлжит бус тооллого явуулах журам /төсөл/
- Номын сан хоорондын ном солилцооны журам /БСШУЯ-ны СУГ-т энэ журамд оруулах санал өгсөн/.

- Зөөврийн номын сан ажиллуулах аргачлал зэрэг баримт бичгүүдийг боловсруулан БСШУЯ-нд хүргүүлсэн болно. Зөөврийн номын сан ажиллуулах аргачлал нь батлагдан номын сангуудын үйл ажиллагаанд мөрдөгдөж эхлээд байна. Үндэсний номын сангийн хэмжээнд мөрдөгдөх журам: Ур чадвар олгох журам /шинэчилсэн/

Гар бичмэл барлаìал ном, диссертаци уншуулах журам., /шинэчилсэн/ Солонгосын мэдээллийн төвийн үйлчилгээний журам" /шинээр/ тус тус боловсруулан "Номын сангийн зөвлөл" болон Захиргааны зөвлөлөөр хэлэлцэн баталж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Номын санчдын мэргэжлийг дээшлүүлэх, сургалтанд хамруулах талаар:

Номын сангийн хүний нөөцийн судалгааг нарийвчлан гаргаж, тэднийг мэргэшүүлэх, давтан сургах ажлуудыг зохион байгуулж ирлээ. БНСУ-ын Үндэсний номын сангийн тэтгэлгээр нэг номын санч 6 сарын мэргэжил дээшлүүлэх сургалтанд.,

- ✓ ӨМӨЗОрны Бугат хотын нийтийн номын санд туршлага судлуулахаар 5 номын санч.,
- ✓ ЮНЕСКО-ийн Бээжин дэх салбар, БНХАУ-ын Соёлын өвийн төвөөс хамтран зохион байгуулсан Азийн 5 орны "Цаас судлал, түүний хадгалалт хамгаалалт" эрдэм шинжилгээний бага хуралд нэг ажилтан.,
- ✓ ОХУ-ын Буриад Улсын Үндэсний номын санд танилцах дадлага хийж, мэргэжил дээшлүүлэх сургалтанд 2 номын санч.,
- ✓ ШУТИС-иас зохион байгуулсан "Номын сан- цахим шийдэл" сургалтанд 2 ажилтан.,
- ✓ Монгол дахь Гетёгийн сангийн сургалтын төвөөс зохион байгуулсан "Номын чимэглэлие́н урлагаар уншигчдын эгнээг өргөжүүлэх нь" сургалтанд 2 ажилтан.,
- ✓ 4Н Америкийн хүүхдийн байгууллагын Монгол дахь төвөөс "Хүүхдийн уншлагыг дэмжих" нь сэдвээр зохион байгуулсан сургалтанд 4 номын санчийг тус тус хамруулсан байна.
- ✓ БНСУ-ын Үндэсний номын сан, Номын Сангийн Холбоотой хамтран "Ном хэвлэлийн хадгалалт, хамгаалалт" сэдэвт 5 өдрийн сургалтыг зохион байгуулж, нийтийн болон их дээд сургуулийн 30-аад номын сан оролцлоо.Уг сургалтанд Солонгосын талаас номын сан судлалын доктор 2 ажилтан, цаасан баримт бичгийн сэргээн засварлалтаар мэргэшсэн 3 ажилтан хүрэлцэн ирлээ. Монгол, Солонгосын мэргэжилтнүүд хамтарч 8 сэдвээр лекц уншиж, дадлагын ажлыг хийсэн болно. Солонгосын Үндэсний номын сангаас 1600$-ийн өртөг бүхий ном ариутгагч төхөөрөмж, ном судрын цаасан хайрцаг зэрэг номын санд шаардлагатай материалыг òóñ номын санд хандивласан болно.
- ✓ Тус номын сангаас нийт 3 ажилтан магистрт суралцаж байна. Үүнд:

- Удирдлагын Академийн Төрийн удирдлагын магистрын ангид нэг ажилтан.,
- СУИС-ийн Соёлын дээд сургуулийн номын сангийн магистрын ангид нэг номын санч
- Хүмүүнлэгийн их сургуулийн англи хэлний орчуулагчийн ангид нэг ажилтан тус тус 2009-2010 оны хичээлийн жилд суралцаж төгслөө.
- Соёлын дээд сургуультай хамтран ажиллаж, тус номын сангийн эх бичиг судлаач 2 ажилтан цагийн багшаар ажиллаж, номын сангийн ангид төвд хэлний 280 цагийн хичээлийг заасан байна.

- ✓ "Номын сангийн үйлчилгээний соёл, чанарыг дээшлүүлэх нь" лекцийг зохион байгуулж, номын санчдыг хамрууллаа. Номын санчдад зориулан НОБГ-тай хамтран "Галын аюулгүй байдлыг хангах нь" лекцийг зохион байгуулж, нийт 78 ажилтан хамрагдлаа.

Нийгмийн халамж, үйлчилгээний талаар:

- Төрийн албан хаагчдын 4000 айлын орон сууц хөтөлбөрийн дагуу хамт олны хурлыг зохион байгуулж, тус байгууллагад олон жил ажилласан 2 хүнийг хамрууллаа.
- 2009 оны жилийн эцсийн тайлан балансыг хугацаанд нь чанартай сайн хийж гүйцэтгэсэн ахлах ня-бо Э.Энхзул, аж ахуйн нярав О.Бат-Очир нарыг нийт 732.725 төгрөг, Соёлын дээд сургуулийн ойд зориулж, байгууллагаас 100,000, БСШУЯ-ны жуух болон шагнал хүртсэн хоёр хүнд нийт 50,000, Ном худалдан авах ажилд хичээл зүтгэл гарган оролцсон 4 хүнд нийт 544,000, эд хөрөнгийн тооллогыг чанартай гүйцэтгэсэн 5 хүнд 175,000 төгрөгийн шагнал, урамшуулал, мөн давхардсан тоогоор байгууллагын 78 ажилтанд 5,190,000 төгрөг, цэцгийн уралдаан зарлаж 220,000 төгрөгийн шагналыг зарцуулав.
- Хамтран ажилладаг Соёлын дээд сургууль, ХТНС зэрэг 3 байгууллагын ирүүлсэн хүсэлт албан бичгийн дагуу 7 хүнийг нийт 209.500 төгрөгөөр, өөрийн 2 ажилтныг 50,000 төгрөгөөр тус тус урамшуулсан.

Буцалтгүй тусламж, тэтгэмж:

- ✓ Тус байгууллагаас өндөр настны тэтгэвэрт гарсан эрдмийн зөвлөлд байсан хүн нас барсан тул ар гэрт нь 180,000 төгрөг, 6 ажилтанд нийт 581,000 төгрөг олгосон. Нэр бүхий 10 хүний цалингийн шатлалыг нэмсэн.
- ✓ Нийт 25 номын санчдад 10-25%-ийн ур чадварыг олгож байна. Ур чадвар олгох асуудлыг улам боловсронгуй болгох зорилгоор "Ур чадвар олгох журам"-ыг шинэчлэн боловсруулж баталлаа.
- ✓ Ўмчлүүлэх шаардлагатай 2 хүнд 442.000 төгрөгийн тэтэгэмжийг олголоо.
- ✓ Байгууллагын шилдэг ажилтныг шалгаруулах , дээд байгууллагын шагналд тодорхойлох зэргээр номын санчдыг урамшуулж, бүтээлч санал санаачлагыг дэмжин ажиллаж байна. Энэ онд: Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан цол тэмдгээр 1 ажилтан, 2 ажилтан БСШУЯ-ны "Жуух бичиг"-ээр, Үндэсний номын сангийн "Шилдэг ажилтан"-аар 1 ажилтан, "Захирлын нэрэмжит шагнал"-аар 6 ажилтан тус тус шагнагдлаа.
- ✓ Номын санчдын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, баг, хамт олныг бүрэлдүүлэх зорилгоор спортын зал 10 удаа авч, ХТНС-аас зохион байгуулсан шатрын тэмцээнд эрэгтэй баг 2- р байр, сагс эрэгтэй баг 1-р байр, эмэгтэй баг 3-р байр, волейбол эрэгтэй баг 2-р байр, теннис эрэгтэй, эмэгтэй баг 2-р байр тус тус эзэллээ.

Гадаад, дотоод хамтын ажиллагаа:

- ✓ Номын сангийн гадаад харилцааг өргөжүүлэх талаар олон талт ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үү н д : eIFL-net олон улсын байгууллагатай тогтмол харилцаатай байж, орчин үеийн номын сангийн үйлчилгээний чиглэлээр зөвлөгөө авч ажиллаж байна. Уг байгууллагын дэмжлэгээр "Үндэсний номын сангийн стратеги 2010-2016 он"-ийг боловсруулсан болно.
- ✓ АНУ-ын АСЗКО /ACIP/ хөтөлбөртэй хамтран "Төвд ном судрыг компьютерт оруулах", "Төвд ном судрын дижитал хуулбар" төслүүд хэрэгжиж байна. Одоогийн байдлаар 186140 ном компьютерийн каталогт ороод байна.

- ✓ БНСУ-ын Үндэсний номын сантай хамтран “Солонгосын мэдээллийн төв” байгуулснаас гадна сургалт зохион байгууллаа.
- ✓ БНСУ-ын Койка Олон Улсын байгууллагаас 2010 онд компьютерийн инженер, номын санч, соёлын өвийн чиглэлээр 3 сайн дурын ажилтанг тус номын санд ажиллууллаа.
- ✓ Турк Улсын Элчин Сайдын яам, ТИКА Олон Улсын байгууллага нь тус номын сангийн үйлчилгээнд зориулж 10 компьютер, 2 принтер, 1 скайнер . 1 канон зэрэг техник тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтыг хийлээ. Эдгээр тоног төхөөрөмжийг номын сангийн үйлчилгээг өргөжүүлэхэд ашиглаж байна.
- ✓ Бээжин болон Монгол дахь ЮНЕСКО-ийн Үндэсний Хороотой хамтран бичиг соёлын өв дурсгалын хадгалалт хамгаалалтыг сайжруулах, энэ чиглэлээр хурал зөвлөлгөөн зохион байгуулах, төсөл хөтөлбөр боловсруулах ажлуудыг хийж байна.
- ✓ Хятадын Үндэсний номын сан болон ӨМӨЗОрны номын сангуудтай ном хэвлэл солилцох, мөн туршлага солилцох чиглэлээр тогтмол харилцаатай ажиллаж байна. Хятадын Үндэсний номын сангаас “Нээлттэй цонх” төслийн хүрээнд 425ш номыг хүлээн авч, зохих журмын дагуу уншигч хэрэглэгчдийн хүртээл болгож байна.
- ✓ Хамтран ажиллах гэрээний дагуу ӨМӨЗОрны Бугат хотын 4 номын санч туршлага солилцох ажлаар тус номын санд 7 хоног айлчиллаа.
- ✓ БСШУЯ-тай хамтран Буриад Улсын Үндэсний номын санд “Монголын соёл мэдээллийн төв” байгуулах ажлыг гүйцэтгэж, МҮНС-ийн бэлтгэл фондноос сүүлийн онуудад хэвлэгдэн гарсан монголын түүх, соёл, уран зохиол болон бусад шинжлэх ухааны 132 нэрийн 1.006.390 төгрөгийн ном, мөн монгол орныг сурталчлах бэлэг дурсгалын зүйл, монгол дуу, кино болон бусад техник тоног төхөөрөмжийг бэлтгэж илгээсэн юм.
- ✓ Гадаадын харилцаат номын сангуудтай харилцаатай ажиллаж, Япон, Өвөрмонгол, БНСУ-ын номын сангууд руу нийт 34 шинэ ном хэвлэлийг илгээлээ. Харилцаат номын сангуудаас 317 нэрийн 357 ном, 6 нэрийн 1413 сонин, 128 нэрийн 493 сэтгүүлийг хүлээн авлаа.
- ✓ Тайлангийн хугацаанд “Явуулын номын сан”, “Үндэсний номын сангийн шинэ барилга”, Билл болон Мелинда Гейтсийн сан, олон улсын eIFL.net байгууллагаас санаачилсан Нийтийн Номын Сангийн Шинэчлэлийн Хөтөлбөрт “Нийтийн Номын Сангуудын Нэгдсэн Каталоги бий болгох нь” төсөл зэрэг нийт 6 төслийг орчуулж холбогдох газарт илгээх, гадаад, дотоод албан бичгүүдийг орчуулах, хариу явуулах, сургалт семинарыг хөрвүүлэх, гадаадын байгууллагуудтай гэрээ байгуулах зэрэг гадаад харилцааг хөгжүүлэх ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Дотоод хамтын ажиллагаа:

Үндэсний номын сан нь тайлангийн хугацаанд БСШУЯ, Соёл Урлагийн Хороо, аймаг хотын нийтийн номын сангууд, төрийн болон төрийн бус байгууллагуудтай дараах чиглэлээр хамтран ажиллалаа.Үүнд:

номын сангийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох /“Номын сангийн хууль”, мөн дүрэм, журмыг шинээр боловсруулах/

- шинэ ном хэвлэлээр сан хөмрөгийг баяжуулах
- ном хэвлэлийг сурталчлах, соёл олон нийтийн ажлыг зохион байгуулах,
- Ном судрыг хадгалалт хамгаалалтыг сайжруулах төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх,
- Номын санчдын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх сургалт зохион байгуулах,
- номын сангийн орчны тохижилт, үйлчилгээ, материаллаг базыг бэхжүүлэх чиглэлд хамтран ажиллаж байна.

Санхүүгийн ажлын талаар:

Тус номын сан нь Монгол Улсын Нэгдсэн Төсвийн тухай, Төсвийн Байгууллагын Удирдлага Санхүүжилтийн хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчтай 2010 оны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулан уг гэрээний дагуу 364 581.6 мянган төгрөгийн санхүүжилт авч ажилёалаа.

Тайлангийн хугацаанд Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг мөрдлөг болгон НББОУС-д нийцүүлэн үйл ажиллагаагаа тайлагнаж ирлээ. Мөн Сангийн сайдын 2005 оны 5-р сарын 04-ний өдрийн 122 тоот тушаалаааар батлагдсан ТТ-1, ТТ-2, МГТ-1, ЗЭБ-2 маягтаар төсвийн гүйцэтгэлийг сар бүрийн 2-ны дотор үнэн зөв гаргаж төсвийн статистик мэдээлэлийг өөрийн санд өгч хэвшлээ.

Нийгмийн даатгалын тайланг сар бүр гарган Сүхбаатар дүүргийн татварын хэлтэст, татварын тайланг хугацаанд нь гаргаж,СБД-ийн Татварын хэлтэст өгч тооцоо нийлэн ажиллалаа.

- Ажиллагсдын нийгмийн даатгал болон эрүүл мэндийн дэвтрийг хөтөлж, баталгаажуулах ажлыг хийж байна.
- Захиалах, шалгах хуудас, интернет зэрэг өөрийн орлогыг сар бүр Төрийн санд тушааж ажиллалаа.

Орлого/ Зарлага

Тайлангийн хугацаанд 14,313.9 мянган төгрөгийн үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого олж, 173,103.6 мянган төгрөгийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна. Нийт 504 056.5 мянган төгрөгийн зарлага гарснаас ажилагчтай холбоотой зардалд 274,062.2 мянган төгрөг, 26,584.8 мянган төгрөгийн тогтмол зардал, 28,172.3 мянган төгрөгийн бусад бараа үйлчилгээний зардал, 13,340.4 мянган төгрөгийн ажил олгогчоос өгөх бусад тэтгэмжийн зардалд, 143,258.5 мянган төгрөгний төсөл арга хэмжээ /Соёл урлаг хөгжүүлэх/ -ний зардал тус тус гарсан байна.

2010 оны 01-р сараас бичиг хэрэг, аж ахуйн материал, тэтгэмж, цалин, томилолт, шагнал, урамшуулал, зочид төлөөлөгчдөд 15.368.213 авч зарцуулсан.

1. Номын сангийн үйлчилгээ:

1.1. Ном бүрдүүлэх, боловсруулах, солилцох ажил:

Ном бүрдүүлэх ажил:

Шинээр 2000 ширхэг ном худалдан авахаас 791 нэрийн 2383 ном авч 119% (1-30-р фактур, 25.674.220 төг)

- Нөхөн бүрдүүлэлтээр 30 ном бүрдүүлэхээс 45-ыг бүрдүүлэн 150% (234,300төг)
- Бэлгийн журмаар 1200 ширхэг ном авахаас 956 нэрийн 2122 ширхэг ном авч 177 % (28.661.330төг)
- 128 диссертац, 10 хураангуйг хүлээн авч, зохих журмын дагуу бүртгэн, ангилагчид хүлээлгэн өглөө. (фактур №1-7; 1.330.000төг)
- 2010 оны сүүлийн хагас жилийн (95 нэрийн 1.758.976 төг) ба 2011 оны эхний хагас жилийн тогтмол хэвлэлийн захиалгыг (103 нэрийн 1.834.576 төг) хийв. (нийт 103 нэрийн 3.593.552 төгрөгийн тогтмол хэвлэл захиалав.)
- Үндэсний номын санд бэлэг, хандивын журмаар гадаад, дотоодын байгууллага, хувь хүмүүсээс 28.661.330 төгрөгийн 2122 номоос гадна Өнөөдөр, Өдрийн сонин,
- Үндэсний шуудан, Зууны мэдээ сонины редакциас 2 хүртэлх хувийг захиалгаас гадуур үнэ төлбөргүй хүлээн авч байна.
- Төрийн ба төрийн бус байгууллагуудаас эрхлэн хэвлүүлсэн ном болон бусад

баримтыг Үндэсний номын сангаар дамжуулан нийслэл, орон нутгийн нийт номын сангуудад түгээн, тараах ажлыг гардан гүйцэтгэж байна.

Ном ангилах, ажиллах, данслах ажèë:

- 3100 ном ангилахаас 2227 нэрийн 4904 ширхэг ном ангилж 158%
  - ✓ Монгол бичгийн албаны каталогийн редакцийн ажилтай уялдан ангилал зөрсөн 1482 ширхэг номыг фондоос татаж, шифрийг өөрчлөн дахин шинээр ангилсан.
  - ✓ Дорно дахины фондын аравтын 590 ширхэг номын ангиллыг ННА-аар сольж ангилав.
  - ✓ "Монголын Үндэсний бүртгэн мэдээлэх номзүй"-г боловсруулан, хэвлүүлэх ажлаар 4550 нэрийн номын мэдээллийг оруулав.
  - ✓ Архивын номзүйн баазад 1889 нэрийн номын засварыг хийж, баазад ороогүй байсан 867 ширхэг мэдээллийг шинээр нэмж оруулсаí.
- 3180 ном данслахаас 2228 нэрийн 4940 ширхэг ном дансалж 155%
  - ✓ Нэгдсэн бүртгэлийн 11 ширхэг дэвтэр хөтөлсөн.
  - ✓ Нийт 9 нэгбүрчилсэн бүртгэлд буюу 45225 ширхэг номыг шинэчлэн хуулцгаасан байна.
  - ✓ Шинэчлэн хуулсан бүртгэлийг хуучин бүртгэлтэй тулган хянах ажлыг эхэлж нийт 8 дансны хуулалтын ажлыг шалгалаа.
- 3100 ном ажиллахаас 4304 ширхэг ном ажиллаж 139%
  - ✓ *Үүнд:* худалдааны 1245 нэрийн 2269ш, солилцооны 183 нэрийн 230ш, бэлгийн 963 нэрийн 1362ш, монгол судлалын 192 нэрийн 305ш, 131нэрийн 138 ширхэг диссертац, хураангуй хүлээн авч ажиллав.
- 5000 ширхэг карт бичихээс 7660 ширхэг карт бичиж 153%
  - ✓ *Үүнд:* монгол номын 3402ш, өрнө дахины номын 1119ш, монгол судлалын 661ш, архивын 2478ш картыг тус тус бичиж каталогч нарт хүлээлгэн өглөө.
  - ✓ Монгол фондод шинээр ирсэн 1364 нэрийн 2366 номын тухай мэдээллийг компьютерт шивж, бар код нааж шилжүүлэв.
  - ✓ 131 нэрийн 138 диссертац, хураангуйн мэдээллийг компьютерт шивсэн.
  - ✓ Монгол бичгийн албаны каталогийн редакцийн ажилтай уялдан 1482 ширхэг номын шифр, бар кодыг шинээр хийж, солин фондод тушаав.

Гадаад солилцооны ажèë:

- Гадаадын номын сан, эрдэм шинжилгээний байгууллагуудад:
- ✓ 150 ном илгээхээс 531400 төгрөгийн 55 нэрийн 112 ном бүрдүүлэгчээс хүлээн авч, Японд 16ш, Өвөр Монголд 8 ширхэг, БНСУ-д 10ш номыг илгээж, илгээгдээгүй 78ш ном байна. Илгээх ажлын биелэлт 75%
- Гадаадын номын сан эрдэм шинжилгээний байгууллагуудаас:
- ✓ 300 ном хүлээн авахаас 317 нэрийн 357-г авч 119% (9.566.050 төг)
- ✓ 1000 сонин хүлээн авахаас 6 нэрийн 1413-ыг авч 141% (320.330төг)
- ✓ 300 сэтгүүл хүлээн авахаас 128 нэрийн 493-ыг авч 164% (821.360төг)

2010 онд нийт 10.707.740 төгрөгийн ном, сонин, сэтгүүлүүдийг гадаадын харилцаат байгууллага, номын сангуудаас хүлээн авч холбогдох фондуудад хуваарилан, фактурлаж, ангилагчид хүлээлгэсэн өгсөн ба илгээхээр хүлээн авсан номуудаас 78 номыг хуваарилан бэлтгэлээ.

Каталогийн ажил:

- 5000 картыг шинээр байрлуулахаас 7672-ыг байрлуулж 153% Үүнээс:
- ✓ монгол-3437, орос-573, гадаад-478, архив-2434, диссертацийн-411, монгол судлалын-315, монгол бичгийн 24.
- ✓ 30000 картанд редакц хийхээс 35268-д хийж 118%
- ✓ 12000 карт хуулахаас 13804-ийг хуулж 115%
- ✓ 1300 ялгагч хийхээс 1581-ийг хийж 121%

- Монгол бичгийн алба, үсэг дараалал, төрөл ангийн ба электрон каталогийг фондын номтой тулгах редакцийн ажлыг хийцгээж, фондын номыг цэгцлэв.Үүнд:
  - ✓ Карт бүрийг электрон каталог, ерөнхий данстай тулгаж фондод байхгүй номын картыг ялгав.
  - ✓ Картнаас монгол бичгээр хуулах ажлыг хийх явцад фондын ном эмх цэгцгүй, ижил номууд өөр өөрөөр ангилагдсанаас янз бүрийн байранд байрлагдаж,

карт давхардсан байлаа. Иймд фондоос ном нэг бүрийг татаж картыг дахин бичлээ.

  - ✓ Шифр, бар код зөрсөн бүх номуудыг фондоос татаж ном ангилагч, ажиллагч нарт өгч залруулга хийлгэн, дахин карт бичлээ.
  - ✓ Карт бүрийн мэдээллийг криллээр хөрвүүлэн, алба, үсэг дараалал, төрөл ангийн каталогуудад байрлуулахаар ном бүрт 3 хувийг бичиж, холбогдох каталогуудад байрлууллаа.Энэхүү каталогийн редакцийг хийж дуусгаснаар монгол номын фондод байгаа монгол бичгийн номуудын байрлал эмх цэгцтэй боллоо.
  - ✓ Номын сангийн дотоод сүлжээнд байгаа монгол бичгийн номын мэдээлэлд дараах засваруудыг хийлээ. Үүнд:
    - Сүлжээнд буруу шивэгдсэн байсан бар код, зохиогч, номын нэр, шифр, он, хуудас зэрэг мэдээллүүдийг засав.
    - Сүлжээнд номын нэр гүйцэд шивэгдээгүй орсон мэдээллийг бүрэн болгон засч оруулав.
    - Монгол бичгээр хэвлэгдсэн болон Өвөр Монгол номын нэр бүрийн ард <Монгол бичгээр>, <Өвөр Монголоор> гэсэн тодотголыг нэмж оруулж өгөв.
- ✓ Архивын фондод шинээр хүлээн авсан 2434 номын мэдээллийг архивын баазад нэмлээ.

Архив ба бэлтгэл фондын àæèë:

- Архивт шинээр 900 ном авч байрлуулахаас 1261 ном хүлээн авч байрлуулан 140% (худалдаагаар-619, бэлгээр-633, нөхөн бүрдүүлэлтээр-9.)
- Архивт 2010 оны 95 нэрийн шинэ тогтмол хэвлэл хүлээн авч байрлуулахаас 95 нэрийн тогтмол хэвлэл хүлээн авч байрлуулан 100%
- Архивын 2010 онд хүлээн авсан болон урьд онуудын тогтмол хэвлэлийг хавтаслуулах 250-иас 230 нэгж хавтаслуулж 92%
- Бэлтгэл фондод шинээр 50 ном авч байрлуулахаас 36-г авч 72%
- Архивын нийт 30775 ширхэг номыг нэгбүрчилэн татаж, номзүйн мэдээллийг шивүүлж, буцаан байрлуулав.
- Архивын фондын электрон мэдээллийн санг бий болгох баазыг бүрдүүлэх, номзүйн бүртгэл хийх ажилтай уялдан нийт 24000 ном татан, ярлыкийг сольж, буцаан байрлуулав.

- **Хяналт, тооллогын ажил:**

МҮНС-ийн захирлын 2010 оны 3 сарын 4-ний 8 тоот тушаалаар ЮНЕСКО-гийн номын санч Ц.Мөнхчимэгийн ажлыг Г.Өлзийхутагт хүлээлгэн өгөх ээлжит бус тооллогыг Б. Бат-Эрдэнэ, О.Нарантуяа нар 2010 оны 3 сарын 9-нөөс 3 сарын 24-нийг хүртэлх ажлын 10 хоногт багтаан тоолж, дүнг гарган 4 сарын 6-ны захиргааны зөвлөлийн хурлаар оруулав. Тооллогоор: хуучин №1-5-р дансанд байх 34969, шинээр дансанд авсан 3774 ширхэг, тоологдвол зохих нийт 38743 номноос 7619 ном тоологдож, зохих журмын дагуу тэмдэглэгээг хийж Г.Өлзийхутагт хүлээлгэн өглөө.

- ÌҮНС-ийн захирлын 2010 оны 3 сарын 26-ны 14 тоот тушаалаар төвд номын фондочийн ажлыг гүйцэтгэж байсан Б.Отгонтуяагаас Т.Баярлахад хүлээлгэн өгөх ээлжит бус
- тоологыг 2010 оны 3 сарын 26-наас эхлэн ажлын 3 хоногт тоолж, дүнг гарган 5 сарын 11-нд Захиргааны зөвлөлийн хурлаар оруулав.
- ÌҮНС-ийн захирлын 2010 оны 4 сарын 6-ны 18 тоот тушаалын дагуу архив-бэлтгэл фондонд байх үнэт ховор номын музейн 14 тавиуртай сейфэн дэх эд зүйлс, сейфний түлхүүрийг мэдээллийн сан бүрдүүлэгч Х.Түмэнбаярт хүлээлгэн өгөх тооллогыг

Б.Бат-Эрдэнэ, О.Нарантуяа, Т.Баярлах, Э.Энхзул нар 2010 оны 4 сарын 21-ний өдөр тоолж хүлээлгэн өгсөн.

- “Ардын элч” төслийн 1-3 дугаар форматын 17.0 гаруй номын жагсаалтыг солилцооны номын санчид гаргаж, гадаад харилцааны мэргэжилтэнд файлаар хүлээлгэн өглөө.
- Урьд хийгдсэн ба хийсэн тооллогуудын илтгэх хуудсууд, жагсаалтыг компьютерт шивж, хэвлэн хавтаслуулж архивлах, CD-д бичиж хадгалах ажлын хүрээнд 2006 оноос өмнө хийгдсэн тооллогын материалуудыг компьютерт шивж дуусгав.
- Шинэчлэн хуулсан бүртгэлийг хуучин бүртгэлтэй тулган хянах ажлыг эхэлж нийт 9 дансны хуулалтын ажлыг шалгалаа.
- Өрнө дахины фондоос шинжлэх ухааны салбараар нь 94 ширхэг орос номыг татан, дахин үнэлгээний журамд нийцүүлэн үнэлэх ажлыг хийж гүйцэтгэлээ.
- Монгол номын фондод байсан 564 ширхэг плакаòààñ архивын фондод байхгүй 19 ширхэг плакатыг дахин данслàí 545 плакатûã дахин үнэлæ, “Тусгаар тогтнолын музей”-д шилжүүлэх ажлыг холбогдох байгууллагын зөвшөөрлөөр хийлээ.

1.1. Уншлага үйлчилгээний ажлын талаар:

Тайлангийн хугацаанд уншлагын танхимуудаар танхимууд 48459 ирцэд 163524 ном, хэвлэл олгож үйлчиллээ.

- **Нийтийн уншлагын танхим:**

а/. Ирц
1.Төлөвлөгөө - 44000
2.Гүйцэтгэл - 38174
3.Хувь - 87%

б/. Ном олголт
Төлөвлөгөө - 116000
Гүйцэтгэл – 93399
Хувь – 81%

.

- Нийтийн уншлагын танхимаас тайлангийн хугацаанд хувилан олшруулах үйлчилгээгээр нийт 907500₮-ийн орлоготой ажилласан ба үүнээс каноны хор, засвар үйлчилгээ, цаас худалдан авахад 307500 төгрөг зарцуулсан байна. /Няравт 600 мянган төгрөг тушаасан/.

- **Эрдэм шинжилгээний уншлагын танхим:**

а/. Ирц
1.Төлөвлөгөө - 4950
2.Гүйцэтгэл – 5747
3.Хувь – 117%

б/. Ном олголт
1.Төлөвлөгөө - 19800
2.Гүйцэтгэл – 21175
3.Хувь – 107% /ЭШ-ний уншлагын танхимын ажлын үзүүлэлт 112%-тай байна/.

Тус хугацаанд захирлын зөвшөөрлөөр гадаад, дотоодын их дээд сургуулиас албан хүсэлттэй ирсэн 26 хүнд, мөн фондын хэлтсийн даргын зөвшөөрлөөр 415 уншигчдад 2240 гар бичмэл номоор үйлчилж, 597 хүнд аман лавлагаа өглөө. Татгалзлын дэвтрийг тогтмол хөтлөн ажиллаж байна.

- **Уншигчийн үнэмлэх нээлт:**

а/. Нийтийн уншлагын танхим
1.Төлөвлөгөө - 1800

2.Гүйцэтгэл – 2223
3.Хувь – 123%

б/. Эрдэм шинжилгээний уншлагын танхим
1.Төлөвлөгөө - 500
2.Гүйцэтгэл – 671
3.Хувь – 134%

/Үнэмлэх нээлтийн нийт үзүүлэлт 129%-тай байна/.

- 2036 ширхэг үнэмлэхэнд сунгалт хийж тооцоог тухай бүр хийсэн ба 2894 уншигчдад шинээр үнэмлэх нээн бүртгэлийн хуудасны зургийг наах, хэвлэн гаргах, сүлжээнд холбох ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Мөн кодгүй болсон уншигчийн үнэмлэхийг тухай бүрт нь кодлон, шинээр үнэмлэх нээлгэж буй уншигчдад лавламж зөвлөлгөө өгч ажиллалаа. Ахлах номын санч Г.Алтанцэцэг нь уншлаганд хамгийн олон гардаг 591 номын нэрс болон фондын номын санч Х.Алтанцэцэгтэй хамтран 2009 онд эрэлт ихтэй байсан нөхөн бүрдүүлэх шаардлагатай 59 номын нэрс тус тус гаргасан.

- **Ном солилцоо:**

-Номын сангийн ажилтнуудад ном солилцоогоор 3374 ном гаргаж үйлчилсэн ба 2225 номыг эргүүлэн авсан байна. ХААИС-ийн номын сантай байгууллага хоорондын ном солилцооны гэрээ хийж ажиллалаа.

- **Ойрын фонд:**

а/.Уншлагаар гаргах ном
1.Төлөвлөгөө - 46000
2.Гүйцэтгэл – 32975
3.Хувь – 71.6%

б/. Буцааж байрлуулах ном
1.Төлөвлөгөө - 46000
2.Гүйцэтгэл – 33249
3.Хувь – 72.2%

/Ойрын фондын ажлын үзүүлэлт 71.9%-тай байна/.

- îéðûí ôîíäûã 137 шинэ номоор фондоо баяжуулсан. Одоогийн байдлаар үндсэн фондоос 16 удаагийн ном авалтаар нийт 4965 номоор үйлчилж байна.

- **ЮНЕСКО-гийн уншлагын танхим:**

а/. Ном ангилах, ажиллах, данслах, байрлуулах
1.Төлөвлөгөө - 2000
2.Гүйцэтгэл - 1533
3.Хувь – 77%

б/.Карт бичих, байрлуулах
1.Төлөвлөгөө - 4000
2.Гүйцэтгэл – 2706
3.Хувь – 68%

- Тус уншлагын танхимын номын санч Г.Өлзийхутаг нь МУҮНС-ийн захирлын 2010 оны 03-р сарын 04-ний өдрийн 08 тоот тушаалаар 03-р сарын сарын 01-нээс ажилдаа томилогдон ажилласан. Захирлын 2010 оны 08 тоот тушаалаар 2010 оны 03-р сарын 05-25-ныг хүртэлх ажлын 14 хоногт багтаан Хяналтын номын санч Б.Бат-Эрдэнэ, О.Нарантуяа, номзүйч Г.Баяртуяа нарын комиссын бүрэлдэхүүнтэй НҮБ, ЮНЕСКО-гийн уншлагын танхимын номыг тоолж дуусган 03-р

сарын 29-нд Ц.Мөнхчимэгээс ажлаа хүлээн авсан. Мөн 2009 оноос хойш ЮНЕСКО-д хуримтлагдсан материалуудын боодлыг задалж, хуудас материал болон номыг ялгав. Танхимын номын тавиурын байранд өөрчлөлт хийж номуудаа байрлуулñàí.

- **Тогтмол хэвлэлийн уншлагын танхим:**

а/. Ирц

1.Төлөвлөгөө - 2200
2.Гүйцэтгэл - 2193
3.Хувь – 100%

б/. Уншлагаар гаргах

	Сонин	Сэтгүүл	Задгай сонин
1.Төлөвлөгөө	3000	5500	1500
2.Гүйцэтгэл	3746	7740	2065
3.Хувь	125%	141%	138%

/Тогтмол хэвлэлийн у/т-ын ажлын үзүүлэлт 126%-тай байна/.

- **Интернэт танхим, төлбөрт үйлчилгээ:**

- Тус танхим нь 1095 уншигчдад интернэт үйлчилгээ болон үнэмлэхгүй уншигчдад төлбөртэй ном, сонин, сэтгүүл, каноны үйлчилгээ үзүүлж нийт 511870 төгрөгийн орлого оруулж үүнээс 68500 төгрөг зарлагадсан ба бэлнээр 443370 төгрөг тушаасан байна. Үүнд:

-Интернэт үйлчилгээ - 74040төг.
-Хэвлэлт – 233х.- 23300төг.
-Ном - 235ш.- 117500төг.
-Тогтмол хэвлэл – 542ш. – 67700төг.
-Каноны үйлчилгээ - 160830 төгрөгийн орлого тус тус оруулсан.

- Ажиллах хугацаанд 5 цагийн урамшуулал 5 хүүхдэд өгсөн ба аман лавлагаа тогтмол өгч үйлчилсэн.

- **Турк номын уншлагын танхим:**

- Турк номын танхим нь МУИС-ийн Түрэг судлалын ангийн оюутнууд болон нийт 766 уншигчдад 402 турк ном хэвлэл олгож үйлчилсэн. Шинээр нийт 41 ширхэг сэтгүүл, 34 ширхэг ном хүлээн авч бүртгэж дансалсан ба òурк шинэ номын үзэсгэлэнг 54 ном зохиолоор болон 36 сэтгүүлээр тус тус үзэсгэлэн гаргаж сурталчиллаа.

- **Солонгос мэдээллийн төв:**

- Тус танхим нь 2200 ном ажиллахаас 3600 ном бүртгэх, ангилах, данслах, тамгалах, бар кодлох, ялтас наах, өнгө наах, компьютерт шивэх зэрэг техник ажиллагаа хийсэн.

- 500 ирцэд үйлчлэхээс 484 ирцэд үйлчилж,

-1500 ном олгохоос 1245 ном олгохын зэрэгцээ уншигчдад уншигчдад сонин, сэтгүүлийн материал хувилан олшруулах үйлчилгээг үзүүлж байна.

Солонгос хэлний сурах бичгүүд 55 ширхэг номоор, мөн Солонгос хэл болон Уран зохиолын 60 ширхэг номоор, “Солонгос орны түүх, соёлтой танилцацгаая” үзэсгэлэнг 42 номоор, “Солонгос хэл сурцгаая” сэдвээр 36 номоор тус тус сэдэвчилсэн үзэсгэлэнгүүд гаргасан. Солонгосын Ýлчин сайдын яамнаас ирсэн хэвлэмэл болон хэвлэмэл бус материалуудыг хүлээн авч бүртгэлд бүртгэв. Тус төвийн талаар 4 мэдээ мэдээлэл бэлтгэж ÌҮНС-ийн вэб сайтад байрлуулав.

Мэдээллийн төвийг уншигчдад сурталчлах зорилгоор танхимын танилцуулгóóâûã бэлтгэж хэвлэн уншигчдад болон МУИС-ийн СЭЖУН солонгос хэлний курс, МУБИС-ийн солонгос хэлний ангийн оюутнууд болон солонгос хэл суралцагсдад гарын авлага болгон тараахаас гадна мэдээллийн самбарыг байнга шинэчлэн, шинэ номын жагсаалт, бусад мэдээ мэдээллээр баяжуулан ажиллаж байна.

Солонгос мэдээллийн төвийн тооллого хийж, тооллогын тайланг бичиж танилцууллаа.

Танхим тус бүрийн ажлын үзүүлэлтийг хүснэгтээр үзүүлбэл:

Д/д	**Танхим**	**Биелэлт** /хувиар/
1.	Нийтийн уншлагын танхим	84%
2.	Эрдэм шинжилгээний уншлагын танхим	112%
3.	Уншигчдын үнэмлэх нээлт	129%
4.	Ойрын фонд	71.9%
5.	ЮНЕСКО-гийн уншлагын танхим	73%
6.	Тогтмол хэвлэлийн уншлагын танхим	126%
7.	**Хэлтсийн нийт үзүүлэлт**	**128.6%**

Соёл олон нийтийн ажлын талаар:

- Монгол суу ухааны “Манукол” академийн ерөнхийлөгч, физикч, философийн ухааны доктор, монгол судлаач Зулаагийн Бат-Отгон “Монголоороо хөгжихүй” сэдвээр номын сангийн уншигч, номын санчдын дунд лекц уншлаа. З.Бат-Отгон нь 20-иод ном товхимол болон эрдэм шинжилгээний 32 өгүүлэл бичсэн ба 17 илтгэл хэлэлцүүлж, сонин хэвлэлд 5 нийтлэл тус тус нийтлүүлсэн байна. Мөн 2009 онд “Ертөнцийг танихад туслахуй” цуврал номуудыг гаргажээ.

Арга хэмжээний хүрээнд докторын бүтээлүүдээр номын үзэсгэлэн гаргасан. Лекцэнд СДС, МУИС-ийн оюутнууд, уншигч, номын санчид нийт 80 гаруй хүн оролцож сонирхсон асуултандаа хариулт авлаа.

“Үндэсний бичиг үсгийн баяр”: “Үндэсний бичиг үсгийн баяр”-ын үйл ажиллагааг 2010 оны 05-р сарын 07-09-ний өдрүүдэд БСШУЯ, СУХ, Соёл урлагийн сан, Төрийн хэлний зөвлөл зэрэг байгууллагуудтай хамтран зохион явууллаа. Энэ удаагийн ажлын хүрээнд”

- Анх удаа Төрийн албан хаагчдын монгол бичгийн анхдугаар олимпиад, байгууллага,
- Байгууллага, хувь хүмүүс, зохиолч, уншигчдаас номын санд ном хандивлах “Номын өглөг хандив”-ын арга хэмжээ
- МҮОНТВ-тэй хамтран “Үндэсний хэл бичиг соёл” нэвтрүүлэг
- “МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САН” уран бичлэгийн уралдаан
- Аймаг, нийслэлийн номын сангуудад 2009 онд шалгарсан шилдэг номын дээжсээс гардуулах ёслол
- “Уран бичлэгийн уралдаан” /МУБИС-ийн оюутнуудын дунд/
- “Тэргүүний уншигч” шалгаруулах улсын V уралдаан зэрэг олон арга хэмжээг зохион байгуулж монгол бичгээ сурталчиллаа.

Тус арга хэмжээний хүрээнд Монгол бичгийг иргэдэд заах, сургах, дэлгэрүүлэх үйлсэд амжилт гаргаж буй багш, сурган хүмүүжүүлэгч, соёлын ажилтан нарт Засгийн газрын шагнал гардуулах ёслолын ажиллагаа болж олон хүнийг шагнаж урамшуулсан юм.

"Үндэсний бичиг үсгийн баяр"-ын хүрээнд МҮНС дээр "Үндэсний бичиг үсгийн дурсгал" сэдэвт номын үзэсгэлэн зохион байгуулснаас гадна "Хүмүн бичиг" сонины газар, МУБИС-ийн оюутнуудын дунд зарласан уралдаанд шалгарсан Монгол бичгийн уран бүтээлийн үзэсгэлэнгүүд, түүнчлэн яруу найрагчдын бүтээсэн уран бичлэгийн /каллиграфийн/ үзэсгэлэн зэрэг 4 томоохон монгол бичгийн үзэсгэлэнг гаргасан юм.

Үйл ажиллагааны хүрээнд уламжлал ёсоор Эрдэм шинжилгээний бага хурал, "Үндэсний бичиг, соёл" сэдэвт зохиолч, уншигчдын уран бүтээлийн уулзалт, Ховор номын дуудлага худалдаа, Номын өргөтгөсөн худалдаа зэрэг арга хэмжээнүүд явагдсан.

"Соёл урлагийн ажилтны өдөр"-ийг ХНО, ХТНС-тай хамтран зохион байгуулж, "Ардын дуу", "Замд гарья", "Неу,Неу" зэрэг Телевизийн хөгжөөнт нэвтрүүлэг, "Дэмбээ мэдэх үү", "Онигооны тэмцээн" зэрэг олон сонирхолтой арга хэмжээг зохион байгууллаа.

- БСШУЯ, Соёл Урлагийн Хороо, Хүүхдийн номын ордонтой хамтран **"Номын яармаг - 2010"** номын баярыг зохион байгууллаа.
- **"Өнгө төгөлдөр Алтай" – Номын баяр**Говь-Алтай аймаг үүсэн байгуулагдсаны 70 жилийн ойн хүрээнд Говь-Алтай нутгаас төрөн гарсан зохиолчид, яруу найрагчид, сэтгүүлчдийн бүтээлээс бүрдсэн "Өнгө төгөлдөр Алтай" нэртэй номын нээлт 2010 оны 6-р сарын 27-ны өдөр ÌҮНС-ийн нийтийн уншлагын танхимд зохион байгуулагдлаа. Уг арга хэмжээíä Алтай нутгаас төрөн гарсан үе үеийн зохиолч, сэтгүүлч, яруу найрагчäààñ ãààíà УИХ-ын гишүүн Ж.Энхбаяр, НИТХ-ын дарга Г.Билэгт ìºí утга зохиол, ñî¸ё урлагийн салбарт өөрийн байр сууриа эзэлсэн нэрт хүмүүс, аймаг сумын удирдлагууд зэрэг 100-гаад хүн оролцлоо. Номын баярын нээлтийн ажлын хүрээнд ÌҮНС-аас Говь-Алтай аймгаас төрөн гарсан зохиолч, яруу найрагчдын бүтээлээр нийт 62 зохиолчийн 286 номоор үзэсгэлэн гаргалаа.
- Олон Улсын Түрэг-Монгол судлаач, академич, түүхийн шинжлэх ухааны доктор, профессор Хавишийн Исламын Дэлхийн Түрэг-Монголчуудын түүхийн товчоо болох "**Тураны Ертөнц**" – Номын баярыг зохион явууллаа.
- Монгол Улсын нийслэлд анх удаагаа зохиогдсон Буриад зон олны "Алтаргана 2010" урлаг, спортын наадмын хүрээнд "Алтаргана-2010" Олон Улсын яруу найргийн тэмцээн 2010 оны 07-р сарын 22-нд ÌҮНС дээр болж өнгөрлөө. Íээлтийн ажиллагаанд УИХ-ын гишүүн Э.Бат-Үүл, ҮНС-ийн захирал Х.Чилаажав, МЗХ-ны дарга Г.Мөнхцэцэг нар оролцсон. Уг наадамд зориулан Буриад зохиолчдын бүтээлүүд болон Буриад улсын тухай "Буриад зоны зохиолчдын бүтээлээс…" сэдэвт номын үзэсгэлэн гаргаж сонирхууллаа. Яруу найргийн наадамд ОХУ-ын Москва, Эрхүү, Кижингинский район, Закаменский район, Өвөр Байгалийн хязгаар, Улаанбаатар, Хэнтий, Дорнот, Сэлэнгэ зэрэг ОХУ болон Монголын хот, хөдөөгийн нийт 36 яруу найрагч оролцож эхний 3 байр болон мөн тусгай шагналт байруудын эзэд болсон.
- 2010 оны 09-р сарын 16, 17-ны өдөр "Шри чин мойн төв" ТББ-аас "Хүний дотоод нөөц бололцоог нэмэгдүүлэх нь" сэдэвт бясалгалын лекц нийтийн уншлагын танхимд болов.

- Тэмдэглэлт үйл явдал, цаг үеийн арга хэмжээнд зориулан **сэдэвчилсэн болон шинэ номын үзэсгэлэн** нийт 32 удаа 1892 номоор гарган сурталчилёàà.

<u>**Сэдэвчилсэн номын үзэсгэлэн**</u>

- Үндсэн хуулийн өдөрт – 39 ном
- Д.Сүхбаатарын мэндэлсний 117 жилийн ойд – 42 ном
- Багш нарын баярын өдөрт – 44 ном
- Сар шинийн баярын өдөрт – 46 ном
- “Хоолны ертөнцөөр аялахуй” – 40 ном
- Эх орончдын өдөрт – 54 ном
- Эрдэмтэн зохиолч Л.Түдэвийн 75 насны ойд – 77 ном
- Олон Улсын эмэгтэйчүүдийн баярын өдөрт – 56 ном
- Хятад, Тайванийн уран зохиолоор – 30 ном
- Монголын зэвсэгт хүчний 89 жилийн ойн баярт – 52 ном
- Дэлхийн эрүүлийг хамгаалах өдөрт – 60 ном
- “Англи хэл сурцгаая” – 42 ном
- Ялалтын баярын 65 жилийн ойд – 57 ном
- “Үндэсний бичиг үсгийн дурсгал” – 84 ном
- Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт – 80 ном
- Говь-Алтай аймгийн 70 жилийн ойд зориулан “Говь-Алтай аймгаас төрсөн зохиолчдын бүтээлүүд” сэдвээр – 62 зохиолчийн 286 номоор
- Үндэсний их баяр наадмын 89 жилийн ойд – 80 ном
- “Буриад зоны зохиолчдын бүтээлээс…” – 97 ном /Алтаргана-2010 наадамд зориулав/
- Улс төрийн хэлмэгдэгсдийн өдөрт – 45 ном
- Байгаль орчныг хамгаалах өдөрт – 51 ном
- Соёл, урлагийн ажилтны өдөрт – 64 ном
- Ахмадын өдөрт – 32 ном
- Олон Улсын оюутны өдөрт – 27 ном
- Байнгын ажиллагаатай Парламент үүсч хөгжсөний 20 жилийн ойд зориулсан үзэсгэлэн – 125 ном
- Нийслэлийн өдөрт – 28 ном

- <u>**Шинэ номын үзэсгэлэнг**</u> 7 удаа 254 номоор гаргалаа.

- ✓ **1.2.** Фонд хадгаламжийн ажлын талаар:
- ✓ Төвд номын фонд нь:
- ✓ Компьютерийн каталогт орох сүмбум зохиолууд болон Хүүхдийн номын ордноосзөөж авчирсан ном судрууд нийт 2558ш номыг цэгцэлж ялгасан.
- ✓ Монгол лам нарын зохиолуудаас компьютерийн каталогт орох Сэвжиддорж, Агваандандарлхаарамба, Агваанлувсандондов нарын нийт 2020ш номыг шивж, ерөнхий дансанд 1980 номыг бүртгэсэн. Мөн компьютерийн каталогид орсон номын 3016 номонд карт бичсэн.
- ✓ Эрдэм шинжилгээний танхимаар зөвшөөрлийн дагуу 31 номыг уншуулсан.
- ✓ Төвд номын фондыг гадаад дотоодын 136 хүнд үзүүлэн сурталчиласан.

- ✓ Хандиваар оёсон 1002ш баринтаг хүлээн авч компьютерийн каталогид орсон ном судрыг баринтаглаж, судар бүрт донтор, тавиуруудад 52 ялгагч хийсэн.
- ✓ "Номын яармаг"-ийн хүрээнд зохиогдсон үзэсгэлэнд 14ш ном болон барыг тавьж сурталчилан ховор номын дуудлага худалдааг зохион байгуулах комисст орж ажилласан.
- ✓ МУИС-ийн НШУ-ны сургуулийн шашин судлалын 3-р курсын 14 оюутны дадлагын ажлыг удирдаж, төвд ном судрыг ялгаж цэгцлэх ажлыг хийсэн. эхэллээ.
- ✓ Хэл зохиолын хүрээлэнгээс санал болгосны дагуу Солонгос улсад шинжилгээнд явуулах 10 нэр төрлийн судрын цааснуудыг судлан, бүтэц, онцлог шинж, хэмжээ зэргийг бичиж бүртгэсэн.

- ➢ **Өрнө дахины фонд нь:**
- ✓ 3082 ном уншлагуудаар уншуулж, 10206 ø номыг шинээр ба буцаан байрлуулсан.
- ✓ Солилцоогоор 151 ном гаргасан ба үзэсгэлэнд 51 ном татан гаргасан. шинээр 4360 ном хүлээн авсан.
- ✓ 3-р давхрын фондод байрлах уран зохиолын номуудыг 2-р давхрын фонд руу зөөж нийт 4340 номыг мөн 49, 413-ийн ангийн номуудад ялгагч хийж цэгцэлж байрлуулсан ба одоо 7-ын ангийн номуудыд байрын шалгалт хийж байрлуулж байна. Мөн байрлуулахдаа нийт 140ш ялгагч хийсэн.

- ➢ **Монгол номын фонд нь:** тайлангийн хугацаанд
- ✓ 68241 ном уншлагуудаар уншуулж, 76001 номыг шинээр ба буцаан байрлуулсан.

Шинээр 2204 ном хүлээн авч, шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнд 1988 ш ном, төлбөртэй уншлагын танхимаар 233ш ном гарган үйлчилсэн ба солилцоонд 4470 ном гарган үйлчилсэн.

Шинэ номын мэдээнд 460 ном татан гаргаж үйлчилсэн.

Тайлангийн хугацаанд Монгол бичгийн номын каталогийн карт шинэчлэн цэгцлэхдээ монгол бичгийн номуудыг тавиураас нь каталог руу зөөн номоо карттай нь тулган картыг шинэчиллээ. Буруу шивэгдсэн кодыг засуулан нийт 7738ш номыг нэгбүрчлэн цэгцэлж байрлуулж дуусгасан.

- ➢ **Тогтмол хэвлэлийн фонд нь:**
- ✓ Уншигчдад 23031 нэгж сонин, сэтгүүлээр үйлчилж, 27936 нэгж хэвлэлийг буцаан байрлуулсан бөгөөд 3443 хэвлэл шинээр хүлээн авч картанд бүртгэн картыг каталогт байрлуулав.
- ✓ Солилцоонд 2337 ш сонин, сэтгүүлээр үйлчилж, шинээр ирсэн хэвлэлээр үзэсгэлэн гаргав.
- ✓ Хавтаслагчаас 204 нэгж сонинг хавтаслуулан хүлээн авч байрлууллаа.
- ✓ Хүүхдийн номын ордонд шилжүүлсэн сонин, сэтгүүлийн картыг уншигчийн каталогоос хасч фондын каталогт тэмдэглэлээ.
- ✓ Хэвлэлийн тавиур хүрэлцэхгүй болсон учир Дорно дахины фондын тавиураас таслан авч хаалт хийлгэлээ.
- ✓
- ✓ Монгол судлал, гар бичмэл номын фонд нь:

- ✓ Уншлагаар 10893 ном, диссертаци, 1507 гар бичмэл уншуулж, 11395ш ном, диссертаци, 1507 гар бичмэлийг шинээр ба буцаан байрлуулсан.
- ✓ Шинээр 142 диссертаци, 134 ном хүлээн авч байрлуулав.
- ✓ Үзэсгэлэнд 19 ном, 16 гар бичмэл гаргасан ба буцаан авч байрлуулсан.
- ✓ Эртний ном судрыг электрон хэлбэрт оруулах ажлын хүрээнд монгол судлалын фондоос 325 дэвтэр Юан улсын судрыг сканердуулсан.
- ✓ 80ш хошуу нутгийн зургыг сканердуулсан ба нийт 760 судар, гар бичмэлийг дижитал хэлбэрт оруулаад байна.
- ✓ Фондын шалны засвар дууссан учир номыг байрлуулах, шалгалт хийх ажлаа эхлүүлээд байна.
- ✓ Дорно дахины номын фонд:
- ✓ Нийт 2010ш хятад номын нэрийг орчуулж, 1120ш карт бичиж 885 номыг шинээр дансалсан.
- ✓ Фондод шинээр 695ш ном хүлээн авснаас: хятад ном-449ш, 153ш солонгос, 43ш япон ном хүлээн авсан.
- ✓ Үзэсгэлэнд 60 ном гаргасан ба 100 ном, 96 сонин, сэтгүүлийг эрдэм шинжилгээний уншлагын танхимаар уншуулсан.
- ✓ 3756 ном, 6978 хэвлэлийг шинээр ба буцаан байрлуулсан.
- ✓ Тайваны Үндэсний номын сангаас ирүүлсэн солилцооны 106 номын жагсаалтаас сонголт хийж 55 номыг захиаллаа.

2. Эрдэм шинжилгээ, арга зүйн ажлын талаар:

- ✓ Эрдэм шинжилгээний ажил:
- ✓ Номын сангийн эртний ном судрын хадгалалт хамгаалалтыг сайжруулах, судалгаа шинжилгээний ажлыг эрчимжүүлэх зорилгоор Эрдмийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж, "МҮНС-ийн эрдмийн зөвлөлийн дүрэм"-ийг шинээр боловсруулан ажиллалаа.
- ✓ Номын сан судлалыг хөгжүүлэх асуудалд анхааран ажиллаж, БНСУ-ын Үндэсний номын сан, Номын сангийн Холбоотой хамтран "Ном хэвлэлийн хадгалалт, хамгаалалт" сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулсан бөгөөд Солонгосын талаас 5 илтгэл, Монголын талаас 3 илтгэлийг тус тус тавилаа.
- ✓ Тус номын сангийн мэргэжилтнүүд эрдэм шинжилгээ, судалгааны илтгэл өгүүлэл бичиж, олон улсын болон улсын чанартай э/ш-ний хуралд илтгэл тавьж оролцсон.Тухайлбал:-БНХАУ-д болсон олон улсын эрдэм шинжилгээний хуралд "Цаасан баримтын хадгалалт хамгаалалт" илтгэл / ЮНЕСКО-ийн Монгол дахь Үндэсний Хороотой хамтран/., - БНСУ-ын Үндэсний номын сантай хамтарсан эрдэм шижилгээний хуралд "МҮНС-ийн Үнэт ховор, гар бичмэл ном судрын хадгалалт, хамгаалалт", "МҮНС-ийн сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалтын асуудал"., - Соёл судлалын хөгжлийн асуудлууд олон улсын э/ш-ний хуралд - "Нийтийн уншлагын тулгамдсан асуудлууд", - "МҮНС-ийн ном бүрдүүлэлтийн зангилаа асуудлууд" зэрэг илтгэлүүдийг тус тус тавьж оролцсон байна.
- ✓ ЮНЕСКО-гийн Монгол дахь Үндэсний Хороотой хамтран монголчуудын түүх соёл, бичиг үсгийн дурсгалууд болох "Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан алтан товч оршвой" хэмээх 1651 онд бүтээгдсэн "Лу Алтан товч" болон төвд хэлнээс монгол хэлэнд 1741-1742 онд орчуулагдан барласан Монгол Шунхан Данжуур"-ын судалгааны тодорхойлолтыг бичиж, "Дэлхийн дурсамж" номинацид дэвшүүлсэн бөгөөд "Алтан товч" судар нь ЮНЕСКО-ийн "Дэлхийн дурсамж" хөтөлбөрт бүртгэгдлээ.
- ✓ ЮНЕСКО-гийн Монгол дахь Үндэсний Комисс болон "Дэлхийн дурсамж" хөтөлбөрийн Үндэсний Хороотой хамтран "Баримтат өв: Бүртгэл, судалгаа, хадгалалт, хамгаалалт" төслийг боловсруулан ШУТСангаас санхүүжилтийг

- ✓ авч хэрэгжүүлэхээр ажиллаж байна.Энэ ажлын хүрээнд “дэлхийн дурсамж” хөтөлбөрт бүртгүүлэх ном судрын жагсаалт, хийх ажлын төлөвлөгөө боловсруулах ажлуудыг хийж нүйцэтгэлээ.

Сургалт- арга зүйн ажил:

- ✓ Номын сангийн зөвлөл”-ийн хурлыг тайлангийн хугацаанд 3 удаа хиж,.“Номын сангийн мэрэгжлийн зөвлөл”-ийн 2010 онд хийх ажлын төлөвлөгөө, “Гар бичмэл, барламал ном, диссертаци уншуулах журам”, “Ур чадвар олгох журам”-ыг хэлэлцэж Захиргааны зөвлөлийн хуралд оруулан “Ур чадвар олгох журам”-ыг батлууллаа. Үндэсний номын сангийн ном хэвлэлийг бүрдүүлэх журмыг шинэчлэн боловсрууллаа.
- ✓ Номын сангийн сан хөмрөгийг дижиталчлах бодлогын хүрээнд MCS электроникс компанитай хамтран “МҮНС-ийн нэгдсэн мэдээллийн сан” төслийг боловсруулж дууслаа.
- ✓ Мэдээлэл, шуудан харилцаа холбоо технологийн газар, Оюуны өмчийн газартай хамтран улсын хэмжээний номын сангийн үйлчилгээнд мэдээллийн технологи нэвтрүүлэх зорилгоор “Тоон номын сан” хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн байгуулан ажиллаж байна.
- ✓ Галын болон болзошгүй аюулын үед номын сангийн ажиллах онцгой байдлын үеийн төлөвлөгөөг НОБГ-ын мэргэжилтнүүдийн зөвлөгөөг авч боловсруулж байна.
- ✓ “Зөөврийн номын сан ажиллуулах аргачлал”–ыг боловсруулж, “Номын сангийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, БСШУЯ-нд хүргүүлж батлууллаа. Энэ аргачлалыг боловсруулахдаа ХТНС, Хүүхдийн номын ордон, МУИС-ийн номын сан болон бусад голлох номын сангуудаас санал авсан болно.
- ✓ Солонгос мэдээллийн төвийн үйлчилгээний журам боловсруулж, мэргэжилтнүүдээс санал авсан ба “Номын сангийн зөвлөл”, “Захиргааны зөвлөл”-ийн хурлаар оруулж батлууллаа.
- ✓ Аймгуудын төв номын сангуудын тайланд дүн шинжилгээ хийж, “Аймаг, нийслэлийн тайлан мэдээ -2009”-ийг бэлтгэж хэвлүүллээ.БСШУ-ны сайдын тушаалыг хэрэгжүүлэн 9 дансны 45.225 ш номыг шинэ дансанд хуулж, хуулалтын ажлыг дуусгалаа. Шинэчлэн хуулсан бүртгэлийг хуучин бүртгэлтэй тулган хянах ажлыг эхэлж нийт 9 дансны хуулалтын ажлыг шалгалаа. Сангийн сайд, БСШУ-ны сайдын хамтарсан 2006 оны 357/406 тушаалаар баталсан “Ном хэвлэлийг дахин үнэлэх журам”-д нэмэлт өөрчлөлт оруулан батлуулахаар 1949 оноос өмнөх хэвлэмэл ном, дахин үнэлэх тухай холбогдох материалын судалгаа гарган, үнэлгээний төслийг бэлтгэн ТӨХ-оос зөвшөөрөл авч БСШУЯ-нд хүргүүллээ.
- ✓ Дорнод, Хөвсгөл, Төв, Орхон, Баян-Өлгий, Баянхонгор аймгийн номын сангуудад биечлэн очиж ажиллалаа. / 6 аймаг /

1.“Мөнхийн үсэг” ХК-аас зохион байгуулсан “Номын өрөлт, ангилал” сэдэвт семинарт хичээл заав./9 хүнд/

2.Ховд, Говь-Алтай аймаг, сумдын нийтийн номын сангийн 47 номын санчдын сургалтыг зохион байгуулж, хөтөлбөрийн дагуу хичээл заасан.

3.УБ хот дахь МСҮ-ийн холбоотой хамтран Хот хөдөөгийн МСҮТ-ийн номын санчдын 5 өдрийн сургалт,

4.Өвөрхангай аймгийн БСГ-ын хүсэлтээр тус аймгийн төвийн болон сумдын номын санчдын 5 өдрийн сургалт,

5.Увс, Архангай аймаг сумдын номын санчдын 5 өдрийн сургалт,

6.Орхон аймгийн Номын төвийн хүсэлтийн дагуу очиж “Номзүй судлал, Номзүйн бүртгэл” сэдвээр хичээл заасан.

7.Төв аймгийн номын сангийн хүсэлтээр аймаг, сумдын номын санчдад “Номзүйн бичилт”, “Номын сангийн үйл ажиллагаанд баримтлах эрх зүйн баримтууд” сэдвээр /64 номын санч/ хичээл заасан.
8.Баянхонгор аймгийн Төв номын сан, БСГ-с хамтран зохион байгуулсан аймаг, сумдын номын санчдын сургалтанд 24 цагийн хичээл заасан.
9.Булган аймгийн Төвийн ба сумдын номын санчдад 4 өдрийн сургалт,

/11 удаагийн сургалтаар 290 номын санчид хамрагдсан/

- ✓ Мэргэжлийн онол арга зүйн “Номын санч” сэтгүүлийг 2010 оны №1,2 дугаарыг бэлтгэн гаргалаа.
- ✓ Сувилахуйн сургуулийн номын сан, ШУТИС-ийн Механик инженерийн сургууль, ОУ-ын ЭЗДС, Аврага”ДС, Түүхийн хүрээлэнгийн номын сан, Урлах-Эрдэм ДС, “ Мон-Алтиус” зэрэг 22 номын сангийн үйл ажиллагаатай газар дээр нь биечлэн танилцаж, номын сангийн үндсэн ажил болох данс бүртгэлийн хөтлөлт, ном зүйн бичилтийн стандарт, данс бүртгэлийн хөтлөлт, тооллого зэрэг сэдвээр арга зүйн зөвлөгөө өглөө.
- ✓ Монгол – Японы төвийн номын санч, СДС-ийн 2-р курсын 5 оюутан, Хөвсгөл, Увс аймгийн номын санчид, Баянтэс сумын номын санч, 10 жилийн 65, 67 зэрэг их дээд сургууль, албан байгууллагын нийт 44 номын санчдад мэргэжлийн зөвлөлгөө өгч ажилласнаас гадна 126 ширхэг мэргэжлийн ном сэтгүүлээр номын санчид, оюутнуудад үйлчиллээ.
- ✓ **“Номын сангийн хууль”** боловсруулах ажлын хүрээнд БСШУЯ болон хууль боловсруулах ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, аймаг хотын номын сангуудаас санал авах, Япон, Герман, АНУ-ын Конгрессийн номын сан, ОХУ-ыг Үндэсний номын сан зэрэг гадаад орнуудын хуулийг орчуулах, хуулийн төслийг боловсруулах, номын санчдын хэлэлцүүлгийг зохион байгуулах зэрэг ажлуудыг дээрх байгууллагуудтай хамтран хийж гүйцэтгэлээ.

2. Мэдээлэл – технологийн үйлчилгээ:

- ✓ Төвд фондын номоос каталогт орох номууд болон тоон хэлбэрт оруулах нийт 7230 боть 33270 ш номыг нэгбүрчлэн шалган цэгцэлж, төрөлжүүлэн хуваарилан буцаан байрлуулсан. Электрон каталогт 1697 боть 30935 ш номыг орууллаа. /Нийт каталогт орсон ном 186140 болсон байна./
- ✓ Тайлангийн хугацаанд төвд лам нарын электрон каталогт орсон зохиолуудаас 180 номыг тоон хэлбэрт оруулж,, харданд хадгалж байна. Нийт 72886 файл, 632.17 GB хийлээ. Цаашид эдгээрт боловсруулалт хийж уншигч, судлаачдад ашиглуулах зорилттой ажиллаж байна. Юань улсын судрыг дуусгаж “Дайчин улсын хууль зүйл бичиг”-ийн 1653 хуудас, “Баруун хойд газрыг түвшитгэн тогтоосон бодлогын бичиг”-ийн 1-48 дэвтрийн 3584 хуудас, “Зүүн гарыг түвшитгэн тогтоосон бодлогын бичиг” Өмнөд, 28 хуудас, жинхэнэ зохиолын 1-85 дэвтрийн 4256 хуудас, Дараах зохиолын 1-35 дэвтрийн 2873 хуудас, Шэн Чин Хуй хэмэх Жи Даян богд тойны түүх оршвой” судрын 1-10_ 11542 хуудас, “Хуу Шиян бхэн Ян Жи Гүн юань хэмээх Жи даян богд тойны түүх оршвой” судрын 1412 хуудас нийт **68584** хуудсыг скайнердлаа.
- ✓ Хосгүй үнэт болон ховор үнэт 630 дурсгалын мэдээллийг 13 CD-д хадгалан, УНБМС-д хүлээлгэн өглөө.Дурсгалыг баримтжуулсан гэрэл зургийг 13 CD-д архивлалаа.
- ✓ Үнэт ховор номын музейг 180 хүнд үзүүллээ.
- ✓ БСШУЯ, Соёлын өвийн төвтэй хамтран УНБМСангийн 1119ТНС00001-1119ТНС00630 хүртэл дугаартай 150 дурсгалын зураг авах ажлыг хийлээ.
- ✓ Үнэт ховор номын музейгээс “Чингис хааны угийн бичиг”, “Жадамба”, Жамбалцанжид”, “Хутагт насан очир тогтоох тарни”, “Сандуйнжүд” зэрэг 5

судар АНУ-ын Динодан компанитай БСШУЯ-наас байгуулсан гэрээний дагуу "Чингис хааны Монгол – Их эзэнт гүрний амьдрал" сэдэвт үзэсгэлэнд оролцож байна.

- ✓ Монгол фондод шинээр ирсэн **1364 нэрийн 2366** номын мэдээллийг, 138 эрдмийн зэрэг хамгаалсан бүтээлийг электрон каталогт оруулж уншигч, судлаачдад үйлчилж байна.
- ✓ Вэб сайтын Монгол болон Англи хувилбаруудыг Joomla АУС – руу шилжүүлж дуусгалаа.Номын сангийн вэб хуудсыг тогтмол баяжуулж ажиллалаа. Үүнд:- "Номын санчид" буланд шинээр гарсан дүрэм, журам.,- бусад номын сангууд болон соёл урлагийн байгууллагуудын вэб сайтны хаяг.,- "Шинэ номын мэдээ" сэтгүүлүүд., "Номын сангийн тухай", "Номын санд зочлох" булангуудыг мэдээллээр баяжуулж, - "Library Resources"," Support Us" булангуудыг шинээр нэмэхээр ажиллаж байна.
- ✓ Номын сангийн програмì хангамж, дотоод сүлжээг нарийвчлан судалж, MCS электроникстэй хамтран **"Үндэсний цахим номын нэгдсэн систем"** төслийн боловсруулж дуусаад байна. Энэ төслийн гол зорилго нь олон улсын стандартын шаардлага хангасан мэдээллийн дэвшилтэт технологийг Үндэсний номын сангийн үйлчилгээнд нэвтрүүлж, үйл ажиллагааг нь шинэ түвшинд хүргэх зорилготой юм.
- ✓ БСШУЯ, МШХХТ-ийн газар, Оюуны өмчийн газартай хамтран улсын хэмжээний номын сангийн үйлчилгээнд мэдээлэл технологи нэвтрүүлэх зорилгоор "Тоон номын сан" хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.
- ✓ Номын сангийн вэб хуудсанд өргөтгөл хийж, бусад номын сангийн вэб хуудсуудтай холбох ажлыг хийснээс гадна хандсан зочдын талаарх мэдээлэл, статистик гаргадаг боллоо. 2010 оны 4-р сарын 23-аас 12-р сарын 17 хүртэл шинэ хандалт 3922, нийт хандалт 15519 байна. Хамгийн их хандаж байгаа 3 улс нь Монгол, АНУ, Япон байна. "Санал сэтгэгдэл" буланд хандсан уншигчдын асуултуудад тухай бүр хариулт өгч ажиллалаа.
- ✓ Сүлжээнүүд болон хэрэглээний программуудын найдвартай ажиллагааг хангаж, хэвийн үйл ажиллагаа нь алдагдсан 25 компьютерийг форматалснаас гадна бүх комьпютерт вирусны эсрэг программ суулгалаа.
- ✓ Лавлагаа - ном зүйн үйлчилгээ:
- ✓ **"Шинэ номын мэдээ"** сэтгүүлд зориулан европ болон монгол фондонд шинээр ирсэн номын тодорхойлолтыг бэлтгэн 1-3, 4, 5, 6, 7,8, 9, 10, 11-12 дугааруудыг гаргаж, нийтийн болон их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудад цаасан болон электрон хэлбэрээр түгээлээ.
- ✓ "Монгол судлалын орос хэлээр гарсан бүтээлийн ном зүй", "Монгол судлалын гадаад хэлээр гарсан бүтээлийн ном зүй"-г бэлтгэн гаргаж, хэвлүүлэхээр шилжүүллээ. Эдгээр бүтээлүүдэд монголын тухай орос болон гадаад хэлээр гарсан нийт **22000 номын мэдээлэл** багтсан болно. **"Монголын үндэсний бүртгэн мэдээлэх ном зүй"**- г боловсруулж хэвлүүлэхээр архив фондонд байгаа **31370 ном** нэг бүрийн мэдээллийг компьютерт оруууллаа. Бэлтгэсэн мэдээллээс 1965 он хүртэлх хэвлэгдэн гарсан номын мэдээллүүдийг хянан цэгцлэх, редакторлах ажлыг хийж, "Монголын үндэсний бүртгэн мэдээлэх ном зүй" номын 1-р дэвтрийг бэлэн болгож хэвлэлтэнд шилжүүлээд байна.
- ✓ Íомын санчдад гарын авлага болгох зорилготой "Номын сангийн фонд, зохион байгуулалт" 11.8 х.х номыг бэлтгэн хэвлүүлж байна.
- ✓ Сүүлийн 20 гаруй жил бэлтгэн гаргаж чадаагүй тасарсан лавлагаа ном зүйн чухал гарын авлага болох сонин сэтгүүлийн ном зүйн бүртгэлийг гаргах зорилгоор хийж буй **"1988-2008 он хүртэлх сонин сэтгүүлийн өгүүллийн**

ном зүй”-г хийх ажлын хүрээнд “Утга зохиол урлаг” сонин, “Монголын эмэгтэйчүүд”, “Боловсрол” “Бодрол бясалгал” сэтгүүл зэрэг 10 нэрийн сонин сэтгүүлээс 1734 карт бичлээ.

- ✓ Аман лавлагааг 292 хүнд өгч, уншигч хэрэглэгчид болон албан байгууллагын хүсэлтээр сэдэвчилсэн бичгийн лавлагааг “Хотгойдын Чингүнжав”, “Буриадын ёс заншил”, “Монгол эмэгтэйн хувцас, чимэглэл”, “Парламентын засаглалын тухай Монгол”, Говь-Алтай аймгаас төрсөн зохиолчдын зохиол бүтээлийн тухай” зэрэг нийт 15 сэдэв, 437 номоор бэлтгэж холбогдох байгууллагуудад илгээлээ.
- ✓ Монгол Улсын хуулиуд-151, тогтмол хэвлэлийн өгүүлэл-612 ,Төвд судлал-50, “Номын санч”-28 карт бичиж, уншигч, хэрэглэгчдийг мэдээллээр хангалаа.

2. Ном судрын хадгалалт хамгаалалт:

“Гар бичмэл, барламал ном, диссертацийг уншуулах журам”-ыг шинэчлэн боловсруулж “Номын сангийн зөвлөл”-ийн хурлаар хэлэлцлээ. Мөн энэхүү журмыг боловсруулахдаа соёлын өвийн асуудал хариуцсан хуулийн мэргэжилтнээс зөвлөгөө авч ажилласан болно.

Төвд ном судрыг ялган цэгцэлж, электрон каталогт орсон 23280 номыг ерөнхий дансанд бүртгэлээ.Электрон каталогт орж буцаан байрлагдаж буй нийт 1646 ботид зохиогчийн нэр, дансны дугаар бичиж тулгах, шалгах ажлыг хийлээ.

Соёлын Төв өргөөний подвалийн фондонд байрлаж байсан 5992 ширхэг баринтигтай , 4 хайрцаг төвд судруудыг зөөж үндсэн фондонд байрлууллаа.

1646 ботийн ялгагч, донторыг шинээр хэвлэн, 1002 баринтигийг хандиваар хүлээн авч шинээр баринтиглан хийж байрлууллаа.

6379 номыг үдэж, 1600 ном, 835 нэгж сонин сэтгүүлийг хавтаслалаа

1002 баринтигийг хүлээн авч каталогт орсон номуудыг баринтиглалаа.

Архив, бэлтгэл болон Өрнө дахины фондын 279410 номыг ариутгасан байна.

3. Номын сангийн орчныг сайжруулах үйлчилгээ:

Тайлангийн хугацаанд номын сангийн захиргаа нь номын сангийн орчны нөхцөл, тохижилт үйлчилгээг сайжруулж материаллаг базаар бэхжүүлэх, номын санчид болон уншигч үйлчлүүлэгчдийн тав тухтай байдлыг хангах талаар онцгой анхааран санаачлагатай ажиллаж, олон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүллээ. Үүнд:

- ➢ **БНСУ-ын төмөрлөгийн РОСКО группийн санхүүжилтээр:**
- ✓ Номын сангийн 1,2,3 давхрын ерөнхий засвар, 1 давхрын уншигчийн бүртгэлийн хэсэг болон өлгүүр, мөн Мэдээлэл арга зүйн хэлтсийн өрөөний засварыг тус тус хийж гүйцэтгэлээ.
- ✓ Их уншлагын танхимын цахилгааны иж бүрэн засвар, газардуулагчийг хийж, галын аюулгүй ажиллагааг хангалаа.
- ✓ Номын санчдын аюулгүй ажиллагааг хангах, фондуудын орчин нөхцөл, хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор Гар бичмэл, монгол судлалын фонд, Монгол фонд, Дорно дахины фондуудын давхар шалыг сольж их засвар хийлээ.
- ✓ Үндэсний номын сан нь хувьд 36 хүний багтаамжтай “Сургалтын танхим”-ыг шинээр байгуулан, засвар үйлчилгээ хийж, компьютер, принтер, ширээ, сандал, шүүгээ зэрэг шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж, сургалт явуулахад бэлэн болголоо.
- ➢ **БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар:**
- ✓ Номын сангийн барилгын дээврийн засварыг хийж, номын сангийн аюулгүй ажиллагааг хангалаа.

- ✓ “Үнэт ховор ном судрын хадгалалт хамгаалалтыг сайжруулах нь” төслийн хүрээнд “Үнэт ховор номын музейг хяналтын камер, сурталчилгааны LCD телевизор, агаар, чийгшилт хэмжигч, зориулалтын тавиур, шүүгээ зэрэг техник, тоног төбөөрөмжүүдийг суурилууллаа.

БСШУЯ-ны дэмжлэг, Дэлхийн банкны READ төслийн санхүүжилтээр “Ардын элч” явуулын номын сангийн үйлчилгээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулах, техник тоног төхөөрөмжийг судлах зэрэг бэлтгэл ажлуудыг хийж байна.

Уншигчдын тав тухтай орчин, үйлчилгээний хурдан шуурхай байдлыг хангах зорилгоор цаасан болон электрон каталогийн өрөөг тохижуулж, хайлтын 8, засварын 2 компьютерыг шинээр солилоо.

ТИКА олон улсын байгууллагын төслөөр:

ТИКА олон улсын байгууллагаас 10 компьютер, 2 принтер, 1 канон, 1 сканнерийг хүлээн авч, интернет үйлчилгээ, сургалтын танхим, монгол фондын сүлжээний захиалганд суурилуулан номын сангийн үйлчилгээг өргөжүүлэхэд ашиглаж байна.

Соёл урлагийн сангийн төслөөр:

Соёл урлагийн сангаас “Сургалтын төв”-д зориулан 899.999 төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн болно.

Номын сангийн тохижилт үйлчилгээний ажлыг сайжруулах, ажилчдыг шаардлагатай багаж хэрэгсэл, зөөлөн эдлэлээр хангах ажлыг төсвийн дагуу хийж ирлээ.

Энэ онд номын санчид, ажилчдад бээлий – 176ш, маск – 170ш, малгай – 86ш олгосон байна.

Байгууллагын цэвэрлэгээг тогтмол хэвийн байлгахын тулд шаардаглах угаалгын нунтаг, саван, алчуур, шүүр, бээлий, ариутгалын бодисоор сар бүр хանган 6084 м2 талбай буюу 46 өрөөг хуваарийн дагуу өдөр бүр цэвэрлэгээ хийж ирлээ. номын сангийн халаалт болон бохир цэвэр усны холболтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Энэ хугацаанд гарсан сантехникийн эвдрэл гэмтлийг цаг тухайд нь засварлаж хэвийн ажиллагааг хангаж ирлээ. Өвөлжилтийн бэлтгэлийг ханган зуны урсгал засварыг хийхийн зэрэгцээ бүх нүхийг өрлөг хийж бөглөн, гадна худгийн хаалтыг сольсон.

Номын сангийн урд, хойд жигүүрийн агааржуулалтын винтилятор засварлаж ажиллууллаа.

ДҮГНЭЛТ

2010 он нь Үндэсний номын сангийн хувьд соёл урлагийг хөгжүүлэх төр засгийн бодлогыг хэрэгжүүлж номын санд хуримтлагдсан олон асуудлуудыг амжилттай шийдвэрлэсэн их ажлын жил байлаа. Ялангуяа номын сангийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, үнэт өв соёлоо хадгалж хамгаалах, сурталчлах, номын сангийн тохижилт үйлчилгээг сайжруулж, уншигч үйлчлүүлэгчдийн тав тухтай орчин нөхцлийг бүрдүүлэх, нийтийн болон их дээд сургуулийн номын санчдыг давтан сургах, номын сангийн үйлчилгээнд шинэ техник, технологи нэвтрүүлэх, гадаадын төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалт, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлүүдэд онцгой анхааран ажиллаж, тодорхой үр дүнд хүрсэн юм.

Цаашид БСШУЯ болон Соёл Урлагийн Хороонд уламжилж нэн тэргүүнд шийдвэрлүүлэх асуудлууд:

1. “Үндэсний номын сангийн шинэ барилгын асуудлыг шийдвэрлэх /эхлүүлэх/
2. Үндэсний номын сан болон бусад нийтийн номын сангийн шинэ ном, хэвлэл худалдан авах төсөв, гадаад арга хэмжээний зардал болон шуудан холбооны зардлыг нэмэгдүүлэх
3. Үндэсний номын сангийн орон тоог нэмэгдүүлэх /ялангуяа гар бичмэл ном сэргээн засварлагч болон эрдэм шинжилгээний ажилтан /номын сан судлал, эх

бичиг судлаач чиглэлээр/, үйлчилгээний номын санчийн орон тоо нэн шаардлагатай байна./

4. 2011 онд болох Үндэсний номын сан болон Монгол Улсад орчин үеийн номын сан байгуулагдсаны 90 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх Засгийн Газрын 1998 оны "Түүхт үйл явдал тэмдэглэх төр, нийгмийн зүтгэлтэн, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь хүндэтгэх ажлыг зохион байгуулах журам"-ын дагуу уг арга хэмжээнд шаардагдах төсвийг шийдвэрлэж өгөх
5. Үндэсний номын сангийн барилга болон үнэт ховор, гар бичмэл ном судрыг улсын даатгалд хамруулах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэж өгөх

Д.НАЦАГДОРЖИЙН НЭРЭМЖИТ УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН ТӨВ НОМЫН САН

2011.12.06 Улаанбаатар хот

1. БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙН ЖИЛИЙН ЗОРИЛТ, БИЕЛЭЛТ, ҮР ДҮН

1.1. Байгууллагын тухайн жилд дэвшүүлсэн үндсэн зорилт

Номын сангийн захирлын зөвлөл нийслэлийн төр захиргааны байгууллагаас баталсан “Хөдөлмөр эрхлэлт-Хүний хөгжлийг дэмжих жил” зорилтыг дэмжиж номын сангийн хэмжээнд 2011 онд “Мэдээллийн хангамж, хүртээмжийг сайжруулан хүний хөгжлийг дэмжих жил” зорилт дэвшүүлэн ажиллалаа.

Зорилтын хүрээнд Нийслэлийн нийтийн номын сангуудын үйлчилгээний үнэ тарифыг хямдруулж, төв болон салбар номын сангууд үйлчилгээндээ мөрдөх болсноор уншигч хэрэглэгчдийн тоо өссөн дүнтэй байна.

Мөн Фонд бүрдүүлэлтийн журмыг шинэчлэн боловсруулж, Захиргааны зөвлөл болон Мэргэжил арга зүйн зөвлөлөөр хэлэлцүүлэн баталгаалжуулж, 2011 оны 03 дугаар сарын 17-оос эхлэн мөрдөн ажилласан нь фондын бүрдүүлэлтийг чанартай, сайн хийхэд тодорхой хэмжээнд үр дүнгээ өгсөн байна.

1.2. Нийслэлийн засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтод тухайн байгууллагаас хийж гүйцэтгэх ажлын хэрэгжилт, үр дүн /2.7.11. Алслагдсан дүүрэг, захын хороодын иргэдэд орчин үеийн программ хангамж бүхий номын сангийн үйлчилгээг ойртуулж, номын сангуудыг байгуулна./

Нэг. Нийслэлийн 2011 оны эдийн засаг нийгмийн зорилтод тусгагдсан 1 дүгээр салбар номын сангийн үйл ажиллагаа явуулах хэвийн нөхцөлийг хангаж ажиллах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын орлогч Ц.Цогзолмаа даргад 2011 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 16 тоот албан бичгээр, БСШУЯ-ны Барилга захиалагчийн ажлын албанд 2011оны 03 дугаар сарын 02-ны 22 тоот, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Г.Мөнхбаярт 2011 оны 03 дугаар 09-ний 27 тоот албан бичгээр тус номын сангийн байрны асуудлыг шийдвэрлүүлэхээр албан бичиг хүргүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын орлогч Ц.Цогзолмаад 2011 оны 05 дугаар сарын 26-ны 49 тоот албан бичгээр 1 дүгээр салбар номын сангийн байрыг яаралтай шилжүүлж шийдвэрлүүлэх талаар тус тус хандаад байна.

Үүнээс БСШУЯ-ны Барилга захиалагчийн ажлын албаны нябо Совд 2011 оны 09 дүгээр 20-ны өдөр “Горькийн номын санд 2010 онд засвар хийгдсэн учраас энэ онд дахин төсөв өгөх боломжгүй. Танай албан бичгийн дагуух асуудлыг яамны дунд хугацааны төлөвлөгөөнд тусгаснаар хэргийг хаасан байгаа” гэсэн хариултыг утсаар өгсөн.

Хоёр. Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газартай хамтарч, тус дүүргээс шинээр байгуулж буй “Гэрээт номын сан”-гийн үйл ажиллагааг дэмжиж ажиллаж байна. “Гэрээт номын санд” Хотын нийтийн төв номын сангийн харьяа Баянзүрх дүүрэг дэх салбар номын сангаас гэрээгээр ном өгч ашиглуулж байх бөгөөд эхний ээлжинд 300 гаруй ном ашиглуулан, хамтын ажиллагаагаа эхлүүлээд байна. Мөн бусад дүүрэг, хороодод ажиллаж байгаа гэр номын сангуудын судалгааны дагуу тэдэнтэй хамтран ажиллах талаар төлөвлөгөө гарган ажиллаж байна.

“Ажлаа танилцуулах өдөр”-ийг Нийслэлийн соёл урлагийн газар, Улаанбаатар хотын түүх шинэчлэн байгуулалтын музейтэй хамтран 2011 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр Баянзүрх дүүргийн 23 дугаар хороо Улиастайн Соёлын төвд зохион байгуулсан бөгөөд тус өдөрлөгийн үеэр 250 ном бүхий зөөврийн уншлага явуулж, шинээр уншигчдад карт нээсэн. Мөн ахлах болон дунд ангийн сурагчдын дунд хурдан уншлагын тэмцээн явуулж, түрүүлсэн сурагчийг үнэ төлбөргүй номын сангийн уншигч болох эрхээр шагнасан.

Гурав. Номын сангийн үйлчилгээний чанарыг сайжруулах, үйлчлүүлэгчдийн мэдээлэл олж авах цар хүрээг өргөсгөх, номын сангаар үйлчлүүлж буй уншигч, иргэдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор “Номын сангийн вэб систем, цахим уншлага үйлчилгээ” төслийг 2010 оны 12 сараас эхлэн 6 сарын хугацаанд 31500 ам долларын санхүүжилттэйгээр амжилттай хэрэгжүүлж, энэ оны 05 дугаар сарын 30-нд нээлтээ хийлээ. Тус номын санд 2009 оны 10 сараас ажилласан КОЙКА олон улсын байгууллагын сайн дурын мэргэжилтэн, номын санч Шин Хэ Ён-ы санаачлага, оролцоотойгоор уг төслийг боловсруулж, КОЙКА байгууллагаас 22000 доллар, бусад эх үүсвэрээс үлдсэн санхүүжилтийг авч, Монголын Номын сангуудын консорциумын мэргэжил арга зүйн туслалцаатайгаар энэхүү төсөл амжилттай хэрэгжлээ. Төслийн хүрээнд номын сангийн бүртгэл, үйлчилгээний Windows суурьтай хуучин системийн өгөгдлийн санг Интернэт суурьтай, юникод дэмждэг,

онлайн системд MARC21 стандартыг баримтлан хөрвүүлснээр номын сангийн үйлчилгээний онлайн систем ашиглалтанд орсон.

Номын сангийн үйлчилгээний онлайн систем Коха нь http://koha.pl.ub.gov.mn хаягаар ажиллаж эхэлсэн туршилтын 20 хоногийн хугацаанд Дэлхийн 30 гаруй улсаас 3600 орчим хэрэглэгч хандан ашиглаж байсан нь үр дүнтэй ажил болж чадсаныг харуулсан юм. Энэхүү онлайн каталог буюу http://koha.pl.ub.gov.mn -ийг Google Analytics програмын тусламжтайгаар вэбийн хэрэглээний үзүүлэлтийг тайлант хугацаагаар гаргахад 44.651 хандагч /visitors/ 59.442 удаа зочилж /visits/, 201.889 хуудасны мэдээллийг үзсэн байна.

Мөн номын сангийн уншигчид зөвхөн цаасан ном, хэвлэл, мэдээллийн эх сурвалжийг ашиглах бус хэрэглэгч, иргэдийг мэдээллийн технологи ашиглан бие даан суралцах, мэдээлэл олж авах орчин нөхцөлөөр хангахыг зорьж, Цахим уншлагын үйлчилгээг бага насны хүүхдэд зориулсан 2, цахим сонин хэвлэл, цахим мэдээлэл уншиж, ашиглахад зориулсан 16 компьютер, утасгүй сүлжээтэй үйлчилгээний орчинг бүрдүүлж чадлаа. Цахим уншлага үйлчилгээг шинээр нээн ажиллуулснаар:

- Номын сангийн үйлчилгээний хүртээмж дээшилсэн
- Хэрэглэгчдэд төвлөрсөн нэг цэгийн үйлчилгээ хүрч, үйлчилгээ хөнгөн шуурхай, соёлтой болсон /цахим хэвлэл ашиглах, интернэт ашиглан хүссэн мэдээ мэдээллээ авах /
- Уншигчдад мэдээллийг нээлттэй, чөлөөтэйгээр өөрийнхөө хүсэл сонирхлоор сонгож авах боломжийг олгосон
- Олон улсын нийтийн номын сангийн стандартад нийцсэн зэрэг үр дүнтэй ажил боллоо.

1.3. Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий менежертэй байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээний хэрэгжилт үр дүн /хэдэн хувьтай байгаа/

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Г.Мөнхбаяртай Номын сангийн захирал 2011 оны ерөнхий менежерийн, захирал номын сангийн удирдах ажилтнуудтай шинэчилсэн загварын дагуу менежерийн, тасаг салбарын эрхлэгчид номын санчидтай төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээг тус тус хийж баталгаажуулан хэрэгжилтэнд хяналт тавин ажиллалаа.

1.4. Нийслэлийн соёл урлагийн газраас дэвшүүлсэн зорилт, уриалгын дагуу тухайн байгууллагаас хийж гүйцэтгэх ажлын хэрэгжилт, үр дүн /Нийслэлийн иргэдийн нийтийн соёлыг дээшлүүлэх "Соён гэгээрүүлэх" бүтээлч ажлыг бүх нийтийн хэрэг болгон өрнүүлэх/

Нэг. Номын сан нь соёлын байгууллагынхаа хувьд бүхий л үйл ажиллагаагаа иргэдэд соёл боловсрол түгээх, соён гэгээрүүлэхэд чиглүүлж ажилладаг. Иргэдэд экологийн боловсрол олгох зорилго бүхий “Эко-Үйлс” клубыг номын санчид санаачлан байгуулж, идэвхтэй ажиллуулж байна. Тайлант хугацаанд тус клуб “Цэвэр агаар, цэнгэг ус, ногоон хоттой болоход таны хувь нэмэр” экологийн буланг тогтмол гаргаж, “Байгаль хамгаалахад таны оролцоо яг одоо хэрэгтэй байна” сэдвийн дор энгийн хэрэгжүүлж болохуйц 50 зарчим, Дэлхийн усны өдөр, зэрэг байгаль экологийн холбогдолтой мэдээ, мэдээллийг сурталчилсан.

ШУТИС-ийн багш доктор, профессор Н.Түгжсүрэнтэй “Агаарын бохирдлын нөлөө” сэдэвт уулзалтыг уншигчдын дунд зохион байгуулсан. Мөн Эко клубын гишүүд сар бүр уулзалт зохион байгуулж, цаашид хийх ажлынхаа талаар ярилцаж, оюутан сурагчдыг байгаль дэлхийгээ хайрлах, нийслэл хот болоод сурч, амьдарч буй орчиндоо цэвэр цэмцгэр соёлтой байх уриалгыг хүргэн ажиллаж байна. Мөн интэрнетээр дамжуулан иргэдийг эко үйлст татан оролцуулах зорилгоор Ekoclub.blogspot.com блогийг нээж ажиллуулсан. Уншигчдад байгаль хамгаалах үйлсийг таниулж сурталчлах зорилгоор чөлөөт сонголтын номын фондод байгаль экологийн номуудаар үзэсгэлэн гаргасан. “Номын сан – эко орчин” төсөл бичиж, Сүхбаатар дүүргийн Засаг даргад санал болгон хүргүүлсэн. Номын сангийн гадна талбайд усалгаа хийж, цэцгийн мандал хийсэн.

Эко-Үйлс клубээс санаачлан “Байгаль орчноо хайрлан хамгаалъя – 2011” зуны спорт явган аяллыг Мандширын хийд - Цэцээ гүн гэсэн маршрутаар байгууллагын хамт олны дунд хийж, аялахын зэрэгцээ Цэцээ гүний хогийг түүх ажлыг зохион байгуулсан.

Хоёр. Нийслэлийн соёл урлагийн газар /НСУГ/, “ADRA Монгол” Олон улсын байгууллагаас хамтран гаргасан уриалгыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг тус номын сангийн дэргэдэх “Эко-Үйлс” клубтэй хамтран боловсруулж, НСУГ-ын дарга Ц.Пүрэвхүүгээр батлуулан “Номын сан- Тамхигүй орчин” зорилт тавин ажиллалаа. Уг зорилтын хүрээнд “Адра Монгол” Олон улсын байгууллагатай хамтран “Тамхины эсрэг Эрүүл мэндийн боловсрол” төслийн ажилтан М.Гантөгс тус байгууллагын 72 ажилтанд “Дам тамхидалт”, “Тамхины тухай ташаа ойлголтууд”, “Тамхи эсвэл эрүүл

мэнд”, “Жирэмсэн байхдаа тамхиа хаяж болно”, “Цэвэр эрүүл орчинд амьдарцгаая”, “Эцэг эхийн дуурайл”, “Өсвөр үе, та өвчин худалдан авч байгаа юм биш үү?”, “Дэлхий нийтээр тамхигүй орчин”, “Гэр бүл” зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгууллаа.

Мөн төв болон салбар номын сангийн уншигч, оюутан, сурагч нарт тамхины хор уршгийг сурталчилсан тараах материал, гарын авлагаар үзэсгэлэн гаргаж тараалаа. Тамхины амьдрал болон бие махбодид үзүүлэх хор хөнөөлийн талаар богино хэмжээний киног төв номын сангийн үүдний хэсэгт байрлах LCD телевизээр үзүүлэв.

1.5. Тухайн жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдаагүй ч цаг үеийн ажил төрлийн шаардлагаар /санаачилж хийсэн, удирдлагаас үүрэг болгосон/ хийгдсэн ажил үр дүн

Нэг. “Meeting Room Project”, “Шатрын уншлагын танхим”, “Иргэдийн мэдээлэл сурталчилгааны төв”, “Уулзалтын танхим”, “Хүүхдийг нийгэмшүүлэх нь”, Интернэт-Компьютерийн танхим зэрэг төслүүдийг боловсруулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс, Сүхбаатар дүүрэг, АНУ-ын Элчин сайдын яам болон бусад төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудад санал тавьсан.

Үүнээс Meeting Room Project-ийг АНУ-ын ЭСЯ-нд хүргүүлсэн нь амжилтанд хүрч, улмаар 75000 ам долларын төсөв батлагдсан бол “Шатар уншлагын танхим” төслийг “Өсвөр үе–Залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн санхүүжилтээр Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс санхүүжүүлэн хэрэгжүүлсэн юм.

Оюун ухааны спорт шатрыг хөгжүүлэх, хүүхдэд шатрын боловсрол эзэмшүүлэн тэдний сэтгэн бодох чадавхийг хөгжүүлэх, амралт чөлөөт цагийг зөв боловсон соёлтой өнгөрүүлэх үүднээс Шатрын уншлагын танхим байгуулах төслийг боловсруулж хэрэгжүүлэн, Хүүхдийн уншлагын танхимдаа Шатрын танхимыг 2011 оны 09 дүгээр сарын 16-ны өдрөөс нээн ажиллуулж эхэллээ. Тус төслийг “Өсвөр үе–Залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн санхүүжилтээр Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс, Нийслэлийн Соёл урлагийн газар, Хотын төв номын сан, “Цэцэн нүүдэл” шатрын клуб хамтран хэрэгжүүлж байгаа юм. Шатар уншлагын танхим нээгдсэнээр шатрын спортыг бүх нийтийн хүртээл болгох, тив, дэлхийд алдартай сайн шатарчдыг төрүүлэн гаргахад дэмжлэг болох, үнэ төлбөргүй шатрын спортоор хичээллэх боломжийг хүүхэд бүрт нээж өгч байгаагаас гадна шатар тоглохын зэрэгцээ, ном унших орчинг бүрдүүлж

байгаагаараа онцлогтой. Шатар уншлагын танхим нь 1-5 дугаар ангийн хүүхдэд үнэ төлбөргүй ном уншуулж, шатрын анхан шатны мэдлэг олгох үйлчилгээг явуулж байна. Шатар уншлагын танхим үйл ажиллагаагаа явуулж эхлээд 363 уншигч шинээр бүртгэн, 1304 ирэгсдэд 1115 ширхэг ном олгож үйлчилсэн байна.

Хоёр. Мэдээллийн технологийн мэргэжилтэн Ж.Бэгзсүрэн ЮНЕСКО-ийн Монголын комисс, НҮБ-ийн Залуучуудын хороо зэрэг байгууллагуудад Монголын нийтийн номын сангуудад ЮНЕСКО-ийн тунхаглалыг хэрэгжүүлэхэд хэрхэн хамтран ажиллах боломжтойг асууж, хүсэлтээ хүргүүлсэн. Үүний дагуу 10 дугаар сарын 06-ны өдөр Бээжин дэх ЮНЕСКО-ийн зөвлөх Sayem Mehmood зочилж, Хотын нийтийн төв номын сангийн өнөөгийн байдалтай танилцаж, бидний санал бодлыг хүлээн авсан.

Гурав. Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хот үүсч байгуулагдсаны 372 жилийн ой, нийслэлийн өдрийг угтан “Улаанбаатарчууд уншиж байна” 45 хоногийн аяныг Төв болоод Хан-Уул, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн салбар номын сангуудын хэмжээнд 2 дахь жилдээ зохион байгуулан явууллаа. Тус аяны хүрээнд “Шатар уншлагын танхим”-ыг нээж ажиллуулах, нийслэл хот, дүүргүүдийн түүх соёл, нийтийн соёлыг харуулсан сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргах, Британика нэвтэрхий толийг уншиж сурталчлах хөдөлгөөнийг өрнүүлэх, “Хүүхдэд ном бэлэглэе” сайн санааны аян зохион байгуулах, алслагдсан дүүрэгт зөөврийн уншлага зохион байгуулах, оюутнуудад хөнгөлөлттэй уншигчийн карт нээх зэрэг 18 тодорхой ажил төлөвлөн амжилттай явууллаа.

Дөрөв. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /НЗДТГ/-ын номын санг шинээр байгуулах ажлыг тус номын сангийн Мэдээлэл боловсруулалт авоматжуулалтын тасаг гардан гүйцэтгэлээ. Зургаан хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг нийт 781ш номонд техник ажиллагаа хийж, 440 нэрийн 781ш номын мэдээллийг электрон каталогт оруулж, 781ш баркод, ярликыг тус тус хэвлэн гаргаж наасан байна. Мөн НЗДТГ-ын Хэвлэл мэдээллийн албаны 2010, 2011 оны 14 нэрийн сонинг 55 нэгж, 1992-2011 оны Төрийн мэдээлэл, Хууль эрх зүйн мэдээлэл, Засгийн Газрын мэдээлэл зэрэг 4 нэрийн сэтгүүлийг 45 нэгж, 9 төрлийн Захирамжуудыг тус тус үдэж хавтасласан. Техник ажиллагаа хийсэн номуудыг тавиурт байрлуулж, хаяг ялгагч наан, номын сан болгон тохижуулав.

2. ФОНДЫН БҮРДҮҮЛЭЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН АЖЛЫН ТАЛААР

“Мэдээллийн хангамж, хүртээмжийг сайжруулан, хүнийг хөгжлийг дэмжих жил” зорилтын хүрээнд Фонд бүрдүүлэлтийн ажлыг чанартай сайн зохион байгуулах үүднээс уншигч хэрэглэгчдээс авсан судалгаа, татгалзалыг үндэслэж, төсвийг оновчтой зарцуулан ажиллалаа. Фондын бүрдүүлэлтийг чанартай хийхэд анхаарч ажиллан, уншигч хэрэглэгчдийн дунд мэдээллийн сурталчилгаа, ном хэвлэлийн үзэсгэлэн, картын сан хийж сурталчиллаа.

Энэ жил 247 нэрийн 1829ш 21,252,380 төгрөгийн шинэ ном, 182 нэрийн 1933ш 3,286,994 төгрөгийн номыг хандиваар, 217 нэрийн 719ш 3,143,000 төгрөгийн номыг бэлгээр, 102 нэрийн 221ш 2,655,380 төгрөгийн номыг нөхөн бүрдүүлэлтээр, 54 нэрийн 73ш 405570 төгрөгийн номыг төлбөрт, 193 нэрийн 339ш 3,166,000 төгрөгийн номыг /УИХ-ын гишүүн Г.Алтанхуяг, Д.Батбаяр нарын/ төслөөр, 2 ном хувилан олшруулж тус тус бүрдүүлэн авсан байна. Нийт 33,933,324 төгрөгийн 5116 ширхэг номыг бүрдүүлэн авчээ.

БСШУЯ-аас жил бүр олгодог номын төсөв нь шинэ ном, нөхөн бүрдүүлэлт, тогтмол хэвлэл захиалгад зарцуулагддаг. 2011 онд шинэ ном авахад 31,200,000 төгрөг төсөвлөсөн бөгөөд энэ оны төсвийн зарцуулалтыг өнгөрсөн 2010 онтой харьцуулбал дараах байдалтай байна.

д/д	**Бүрдүүлэлтийн төрөл**	**2010 он**		**2011 он**	
		Номын тоо	**Мөнгөн дүн**	**Номын тоо**	**Мөнгөн дүн**
1	Шинэ ном	257	2,251,400	1829	21,252,380
2	Нөхөн бүрдүүлэлт	44	290,000	221	2,655,380
3	Тогтмол хэвлэл	116	1,342,800	348	3,307,800
4	Нийт	417	3,884,200	2398	27,215,560

2011 оны ном бүрдүүлэлтийг өмнөх онтой харьцуулсныг графикаар үзүүлбэл:



2011 онд ном бүрдүүлэлт өссөн дүнтэй харагдаж байгаа нь өнгөрсөн 2010 онд 2007-2009 онуудад худалдан авсан боловч мөнгө нь шилжээгүй байсан 142 нэрийн 1128ш номын мөнгө 17,207,100 төгрөгийг шилжүүлсэнтэй холбоотой. Энэ 12 дугаар сард 3,984,440 төгрөгт шинэ ном авахаар ном бүрдүүлэлтийн төлөвлөгөөнд тусгагдсан учраас дээрх дүнд нэгтгэгдээгүй болно.

Нийт бүрдүүлэн авсан 5116ш номонд техник ажиллагаа хийж, 3291ш номонд мэдрэгч ялтас нааж, 996 нэрийн 5116ш номын мэдээллийг электрон каталогт оруулан, албаны каталогт 353ш, салбар номын сангуудад 227ш каталогийн хэвлэмэл карт, 5194ш баркод, 5194ш ярлик хэвлэсэн байна. Дээрх бүрдүүлэлтээр болон бэлэг хандиваар авсан бүх номыг тухай бүрд нь төв болон салбар номын сангуудад хүлээлгэн өгч, уншлагад шилжүүлсэн. Мөн 75 нэрийн 82ш ном, 70 нэрийн 143ш CD, 8 нэрийн 28ш брайль номонд тус тус техник ажиллагаа хийж, нэгбүрчилсэн дансанд бүртгэлээ.

Тогтмол хэвлэлийн захиалгыг чанартай хийж, дугаар ирэлт, хадгалалт хамгаалалтанд хяналт тавьж, төвлөрсөн номын сангийн хэмжээнд 36 нэр төрлийн 3,307,800 төгрөгийн тогтмол болон цахим /4 нэрийн/ хэвлэл захиалан уншигчдад үйлчилж байна. Мөн Хятадын ӨМӨЗО-ны гадаадтай соёлоор харилцах нийгэмлэгээс эрхлэн гаргадаг “Солонго” сэтгүүл, НҮБ-ын Хүн Амын Сангийн дэмжлэгтэйгээр “Монгол Зөн” НЭМБ-аас эрхлэн гардаг “Үерхэл” сонин, “Оросын сан” ТББ-аас эрхлэн гаргадаг “Умард хөрш” сэтгүүлүүдийг тус бүр сар тутам 50 ширхэг, ХАА-н ШУА, ХААИС-аас эрхлэн гаргадаг “Монголын хөдөө” сониныг сар тутам 20 ширхэгээр хандиваар авч төв, салбар номын сангийн хэмжээнд хуваарилан уншигчдад үйлчилдэг.

Баримт материалыг ангилж, боловсруулах техник ажиллагаанд нэмэлт өөрчлөлт оруулах зорилгоор Чөлөөт сонголттой фондын хэл шинжлэл, аман зохиол, утга зохиол, шашин, гүн ухаан, сэтгэл судлалын /81,82,83,86,87,88/ ангийн 7437ш номны ярлыкыг төрөл ангиар ялгаж өнгийн цаасан дээр хэвлэж наав.

Хөгжлийн бэрхшээлтэй хэрэглэгчийн судалгаанд үндэслэн Ж.Болд-Эрдэнэ “Анигргүйн цэнхэр аяз”, Стефени Майер “Бүрэнхий”, Г.Аюурзана “Бөөгийн домог”, Дэлхийн сонгомол өгүүллэг, Дэлхийн сонгомол яруу найраг, М.Шолохов “Дөлгөөн Дон” Б.1, Хүний эрхийн төлөө, Жек Лондон “Цагаан соёот” зэрэг 8 нэрийн DAISY номыг бүтээсэн байна. Мөн DAISY ярьдаг номын төвийн “Эх зохиолын дээжис” 1, 2 боть, “Өөртөө туслах ухаан”, “Жангар”, “Шинэ технологи үйлдвэрлэлд”, “Санхүүгийн хөтөч”, “Мастер Маргарита хоёр”, “Япон массажийн гарын авлага”, “Дэлхий дахины

түүх” 1, 2 боть. “Хүний биеийн бүтэц зүйн лекц”, “Монгол улсын түүх” зэрэг 12 ширхэг номын мэдээллийг электрон каталогт оруулав.

Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооноос 14 нэрийн DAISY ярьдаг номыг файл хэлбэрээр хүлээн авч, програмаар дахин хянан үзэж, техникийн болон уншигчийн алдааг засаж байгаа бөгөөд ажлын явц 60%-тай байна. DAISY цахим номын төв нь хараааны бэрхшээлтэй оюутан, сурагчдын бие даалт, хичээлийн шаардлага, тэдний хүсэлтээр студидээ номыг хэсэгчлэн уншиж цахим хэлбэрт оруулж үйлчилдэг.

Алиса програмд бүртгэгдсэн номын мэдээллийн санг Коха програмд хөрвүүлэхэд нийт 107397ш номын мэдээлэл хөрвөсөн байна. Үүн дээр 3583ш номын мэдээлийг нэмж оруулан, 1678ш номын мэдээлэлд редактор хийсэн болно.

Төв болон салбар номын сангуудын урагдаж гэмтсэн нийт 817 ном хэвлэлийг хэвлэлтийн анхны жинхэнэ хэлбэр байдлыг алдагдуулахгүйгээр сэлбэн зассан байна. Чөлөөт сонголттой уншлагын танхимаас сэлбэн засагдсан 504 ширхэг номонд дахин мэдрэгч ялтас наасан. Сэлбэн засагдсан ном хэвлэлийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

№	Тасаг,салбарууд	Их засвар	Дахин засвар	Дунд засвар	Бага засвар	Нийт
1	Чөлөөт сонголттой уншлагын танхим	152	36	20	296	504
2	ХУД дэх салбар номын сан	137		17	55	209
3	БЗД дэх салбар номын сан	28				28
4	СХД дэх салбар номын сан	57			8	65
5	АСМТ	11				11
	НИЙТ	385	36	37	359	817

Төв болон салбар номын сангуудын 2010 оны 3, 4 дүгээр улирал, 2011 оны эхний 3 улирлын сонинг 150 нэгж, сэтгүүлийг 142 нэгж, Төрийн мэдээлэл сэтгүүлийг 29 нэгж болгон тус тус үдэж, салбар номын сан болон санхүү, аж ахуй, архивын 55 баримтыг үдэж хавтасласан. Гэрээр ном олгох 20000ш тасалбарыг 100 багц, Торгуулийн 5000ш хуудсыг 25 багц болгон цуглуулж, үдэж наасан. Мөн уншигчийн карт 8800ш /440000₮/, каталогийн карт 1000ш /7000₮/, формуляр 12600ш /88200₮/ тус тус хэвлэсэн байна.

Төв номын сангийн 2008-2009 оны тооллогын тооцоог бүрэн гаргаж дуусгах зорилгоор төвлөрүүлэлтийн болон төвлөрүүлэлтийн бус монгол, гадаад номын дансны бодолтуудыг нэгтгэв. Ном бүрийн блокны дээд болон хажуу талд номын сангийн нэр бүхий тамга тэмдгийг 3 дугаар улирлаас эхлэн дарж эхэлсэн. Энэ нь хотын нийтийн төв номын сангийн номыг хаанаас ч харсан танигдах, мөн цагдаагийн

байгууллага, номын худалдааны хүмүүстэй хамтран ажиллаж, номыг хулгайлж зардаг явдлыг зогсооход ач холбогдолтой ажил болж байна.

“Хуучин ном худалдаа”-гаар нийтдээ 68000 төгрөгийн ном худалдаж, үлдсэн 625 кг хуучин номыг хоёрдогч түүхий эдэд тушаасан. Акталсан Хүүхдийн номноос “Гармаавaa хийд”-ийн лам хүүхдүүдэд зориулж, нийтдээ 300ш номыг үнэ төлбөргүйгээр шилжүүлэн өгч дэмжлэг үзүүллээ.

3. УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР

Бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээгээр тайлангийн хугацаанд 60,000 байнгын уншигч хэрэглэгч, 210,000 ирэгсдэд, 585000 боть ном, тогтмол хэвлэл бусад материал олгож үйлчлэхээс 66309 байнгын уншигч хэрэглэгч, 230846 ирэгсдэд, 605286 боть ном хэвлэл, бусад материал мэдээллүүдийг олгож үйлчилсэн байна. Үүнийг өнгөрсөн 2010 оны уншлага үйлчилгээтэй харьцуулбал:

		2010 он			2011 он		
д/д	Бүтээгдэхүүний нэр	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь	Төлөвлөгөө	Биелэлт	хувь
1	Уншигч, хэрэглэгч	70000	67074	95.8%	60000	66309	110,5%
2	Ирэгсэд	300000	212179	70.7%	210000	230846	110%
3	Ном олголт	600000	582475	97.0%	585000	605286	103,4%

Үүнээс 2010, 2011 оны биелэлтийг графикаар харьцуулан харуулбал:



Мөн дараах шинэлэг уншлага үйлчилгээнүүдийг явуулсан. Үүнд:

“Амилагийн найзууд”, 22, 92, 99, 160 дугаар цэцэрлэг, “Асралт төв” хүүхдийн асрах газарт очиж номын сангаа танилцуулан, тоглоом тоглуулж, зуны уншлага, “Аав ээж би” сэдэвт гэр бүлийн уншлагыг зохион байгуулсан.

Хүүхэд багачуудын англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Oliver Twist номоор чанга уншлага зохион явуулав. Тус арга хэмжээнд Фулбрайтын багш хадагтай Candace Kaye оролцон хүүхдүүдэд тус номыг уншиж өгч, ойлгосон зүйлийнх нь талаар харилцан ярилцав. Мөн төв болон салбар номын сангууд оюутан сурагчдын шалгалт шүүлгийн ачаалал ихтэй үеэр тусгай хуваариар үйлчилгээний цагийг уртасгаж ажиллалаа.

4. ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ, СОЁЛ ТАНИН МЭДЭХҮЙН АЖЛЫН ТАЛААР

Тайлангийн хугацаанд иргэд олон нийтэд чиглэгдсэн дараах ажлуудыг хийсэн байна. Үүнд:

- Номын сангийн лавлагааны мессенжерээр 1790 хүнд, бичгээр 17, аман лавлагаа 8294 удаа, утсаар 2140, нийт 12241 удаа лавлагаа өгсөн байна.
- Энэ хугацаанд тохиосон түүхэн ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан сэдэвчилсэн номын үзэсгэлэн 216 удаа 3492 ширхэг номоор, шинэ номын үзэсгэлэнг 50 удаа 1228 номоор тус тус гаргасан. Мөн хэвлэмэл материал болон фото зургийн үзэсгэлэн гаргаж уншигчдад сурталчилсан.
- Тухайн жилийн Нийслэлийн төр захиргааны байгууллагын 2011 оны зорилт “Хөдөлмөр эрхлэлт-Хүний хөгжлийг дэмжих жил” болоод Нийслэлийн соёл урлагийн газар, АДРА Олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Соёл урлаг-Тамхигүй орчин” ажлын хүрээнд байнгын үзэсгэлэн сурталчилгааны самбар тус бүр гаргаж, мэдээ мэдээллийг байнга шинэчлэн гаргасан.

Тайлангийн хугацаанд уншигч үйлчлүүлэгчдийн дунд дараах соёл танин мэдэхүйн ажлыг хийсэн байна. Үүнд:

Төв номын санд:

-“Эрх чөлөө” төвийн тэргүүн, лектор Ц.Оюунгэрэлтэй “Миний ажлын ноухау” сэдвээр уулзалт ярилцлага

-21-р зууны “Монгол бадарчин” Амай буюу Ж.Золбаяртай уулзалт

-“Удирдахуйн нууц” сэдэвт уулзалтыг Хилийн цэргийн 0151-р ангийн захирагч хурандаа, төрийн захиргааны менежментийн доктор, проф. Ц.Цэрэндоржтой

-“Агаарын бохирдлын нөлөө” сэдэвт уулзалтыг ШУТИС-ийн багш доктор, проф. Н.Түгжсүрэнтэй

-“Энергийн гайхамшиг” сэдэвт уулзалтыг “Аниргүй чимээ бясалгалын төв”-ийн багш, сэтгэл зүйч Болормаа, Энхжаргал нартай

- “Миний глобалчлал” сэдвээр Буян компанийн захирал Б.Жаргалсайхантай уулзалт зохион байгуулж 150 орчим уншигч хамрагдав.

- Багш, сэтгүүлч С.Цэцэгмаатай “Ном бидний дотны нөхөр” сэдэвт уулзалтыг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 116-р сургууль дээр зохион байгуулав.

-Зохиолч Х.Болор-Эрдэнийн “Мөрөөдлийн цуврал” номын нээлтийг номын санд зохион байгуулж 6 дүүргийн ЕБС-ийн сурагчдад ном бэлэглэсэн.

-АНУ-ын талаар мэдээлэл өгөх, цагийг үр дүнтэй өнгөрөөх зорилгоор АНУ-ын тухай АХА тэмцээнийг зохион байгуулж МУИС-ийн ГХСС-ийн 2 дугаар курсын оюутнууд болон уншигчид оролцож, эхний 3 хүүхдийг байр эзлүүлэн урамшуулав.

-Хилийн цэргийн 0151 дугаар ангийн албан хаагчид, байлдагчдын дунд “Дэлхийн сонгодог утга зохиолын чуулган-50 боть” ном, Томас Костейний “Хаадын хаан, хүн гүрний эзэн хаан Аттил”, Сергей Бородины “Доголон Төмөр хаан” номны танилцуулгыг хийж номын сангаа танилцуулсан.

- Сар бүрийн 3 дахь 7 хоногийн 2 дахь өдөр бүр АНУ-ын зохиолчдын номын уулзалт зохион байгуулж 27 хүн оролцсон байна.

- Уншигч хэрэглэгчдийн англи хэлний мэдлэг, сонсголын чадвараа дээшлүүлэх боломжийг олгодог мэдээлэл сургалт, уран сайхны киног нийт **2518** үйлчлүүлэгчдэд үйлчилсэн. Кино үдэш арга хэмжээгээр 11 кино гаргаж 317 хүн оролцсон.

- “Америкийн тухай ярилцъя” цуврал лекц 30 удаа явуулж 1124 үйлчлүүлэгч хамрагдсан. Бага насны хүүхдүүдэд англи хэл заах 4H хөтөлбөрийг 43 удаа зохион байгуулж 659 хүн хамрагдсан байна.

- Санхүүгийн англи хэлний сургалыг 6 удаа зохион байгуулсан. Сургалтыг 7 хоногийн Мягмар, Лхагва, Пүрэв гаригуудад зохион байгуулж нийт 110 багш оюутнууд идэвхтэй оролцсон.

БЗД дэх салбар номын санд:

Уншигч хэрэглэгчид, олон нийтийг хамарсан уулзалт 5 удаа, уншигчдын идэвх, санаачлагыг дээшлүүлэхэд чиглэгдсэн уралдаан 3 удаа, чанга уншлага 2 удаа, номын сангаар тойрон аялал 1 удаа, номын сан ном зүйн мэдлэгийг сурталчлах яриаг 6 удаа тус тус зохион байгуулсан. Үүнд:

- “Ном хэвлэлийг урж тасдах нь гэмт хэрэг мөн үү?” сэдэвт хууль эрх зүйн талаарх ярилцлагыг БЗД-ийн 1-р хорооны олон нийтийн байцаагч н.Энхтуяатай хийж 29 уншигч оролцсон байна.

- "Монголын өв соёл" сэдэвт уулзалт ярилцлагыг "Суут Монгол" ТББ-ын тэргүүн Ж.Баатархуягтай хийж нийт 51 уншигч оролцсон байна.

- Монголын анхны тулгар төрт улс байгуулагдсны түүхт ойд зориулан "Хүннү-2220 жил" сэдэвт ярилцлагыг ШУА-ийн түүхийн хүрээлэнгийн эртний түүх, сурвалжит судлалын секторын эрхлэгч түүхийн ухааны доктор /Ph.D/ С.Өлзийбаяртай хийж 60 гаруй хүн хамрагдсан байна.

- "Ардын хувьсгал-90" сэдэвт уулзалт ярилцлагыг Цагдаагийн Академийн нийгмийн ухааны тэнхимийн эрхлэгч, түүхийн ухааны доктор, Цагдаагийн хурандаа Ж. Заанхүүтэй хийж 59 хүн хамрагдсан.

- "Үндэсний тусгаар тогтнол-100" сэдэвт уулзалтыг МУИС-ийн Нийгмийн ухааны дээд сургуулийн багш, түүхийн ухааны доктор /Sc.D/ Ж.Урангуатай хийж нийт 58 уншигч оролцсон байна.

- "Багшдаа барих бидний бэлэг" сэдэвт шүлгийн уралдааныг 48 дугаар сургуулийн 4-5 дугаар ангийнхны дунд зарлаж 2011.02.01-нд дүнгээ гаргасан байна. Уг уралдаанд нийт 15 бүтээл ирснээс 48-р сургуулийн 4^{а} ангийн сурагч Т.Номуна тэргүүн байранд орж өргөмжлөлийн эзэн болсон байна.

- Монгол улсын засгийн газрын 2011 оны зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд уншигчдын дунд "Хөдөлмөр эрхлэлт-хүний хөгжил" сэдэвт эссэ бичлэгийн уралдааныг 10 хоногийн хугацаатай зарлаж 2011.03.22-нд дүнг нь гаргасан ба уралдааны тэргүүн байрыг МУИС-ийн сэтгүүл зүйн салбарын магистрант Т.Уранбилэг эзэлж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнуулсан байна.

- Монгол улсад номын сан үүсэж хөгжсөний 90 жилийн ой угтан уншигчдын дунд зарласан "Номын өргөө" сэдэвт шүлгийн уралдаанд 35 хүүхэд оролцсоноос 48 дугаар сургуулийн 7^{ж} ангийн сурагч П.Батбилэг 1-р байр, 2-р байрт мөн ангийн сурагч Ж.Номин нар шалгарч Өргөмжлөл, мөнгөн шагналын эзэн болсон байна.

- "Номын сан- таны сурах орчин" сэдэвт тойм яриа 42 уншигчдад;

- "Ном хэвлэлийг зөв ашиглах нь", "Уншсан номын тэмдэглэлийг хэрхэн хөтлөх бэ?" сургалт яриаг 23 хүүхдэд;

- Шинэ номын тойм яриаг нийт 42ш номын агуулгаар 34 уншигчдад

- "Үлгэрийн цаг" сэдэвт номын сантай танилцуулах аяллыг 22 дугаар цэцэрлэгийн 36 хүүхдийг хамруулж тус тус зохион байгуулсан байна.

ХУД дэх салбар номын санд:

Уншигч хэрэглэгчдийг хамарсан Соёл мэдээллийн ажлыг төрөл бүрийн хэлбэрээр зохион байгуулсан. Үүнд:

- “Багш бидний бахархал” сэдэвт зохион бичлэгийн уралдааныг ЕБС-ийн 7-9 дүгээр ангийн уншигчдын дунд зарлаж 52 дугаар сургуулийн 8-д ангийн сурагч Б. Цэвэлсүрэн тэргүүн байр эзэлсэн. 26 гаруй уншигч хүүхдүүд оролцсон.

- Олон улсын эмэгтэйчүүдийн баярыг угтаж “Миний ээж хөөрхөн”- сэдэвт шүлгийн уралдаанд тэргүүн байр 75-р сургуулийн 4-а ангийн сурагч Б. Жаргалмаа, 2-р байранд 3-в ангийн сурагч Э. Хүслэн, 3-р байранд 114-р сургуулийн 3-в ангийн сурагч А. Дөлгөөн, тусгай байранд 52-р сургуулийн 5-а ангийн сурагч Б. Анударь, 3-б ангийн сурагч Ш. Энхсайхан нар шалгарч тус бүр бэлэг мөнгөн шагналаар тус тус шагнасан. 40 гаруй хүүхдүүд оролцсон.

- Хан-Уул дүүргийн 2 дугаар хорооны засаг дарга Ч. Наранцэцэг мөн “Дэлхийн зөн” Олон улсын байгууллагатай хамтарч “Номын сан-номын баяр”-сэдэвт уулзалтыг хорооны эмзэг бүлгийн хүүхдүүдийн дунд зохион явуулж, бэлэг мөнгөн шагналаар урамшуулсан. 190 гаруй хүүхдүүд оролцож MYOHT,UBS Tv-ээр тус тус сурталчилсан.

- Эх үрсийн баярыг тохиолдуулан “Хүүхэд бидний бахархал”- сэдэвт дуу шүлгийн уралдааныг 2 дугаар хорооны хүүхдүүдийн дунд зохион явуулж хорооны засаг дарга Ч. Наранцэцэгтэй хамтран явуулж 70 орчим хүүхдүүд хамрагдсан

- “Зуны уншлага” хөтөлбөрийн хүрээнд амралтаа үр ашигтай өнгөрүүлэх, уншсан номын тэмдэглэл хөтлөх, минутын уншлага, үлгэрийн номын гол баатруудыг зурах зэрэг олон бүтээлч ажлыг хийсэн байна.

- Хүүхэд багачуудын хамгийн их унших дуртай “Цондоолой, Цүндээлэй хоёр” ба “Динза” зэрэг зохиолыг бичсэн Хүүхдийн зохиолч А. Дэлгэржаргалтай хийсэн “Цондоолой ба түүний найзууд” сэдэвт уулзалт ярилцлагад нийт 49 сурагч оролцсон бөгөөд зохиолч ивээн тэтгэгч “Ирмүүн” байгууллагынхаа гарын бэлгийг хүүхдүүдэд өгсөн.

- “Хүүхдийн эрхийн хамгаалал”- сэдэвт уулзалт ярилцлагыг ХУД-ийн Цагдаагийн хэлтсийн хүүхдийн ахлах байцаагч ахмад Ц.Энхтуяатай хийхэд 85 дугаар сургуулийн ахлах болон дунд ангийнхан, багш нарынхаа хамт хамрагдсан байна.

СХД дэх салбар номын санд:

-Яруу найрагч Н.Баянмөнхтэй хийсэн “Номын ертөнц” сэдэвт уулзалтанд СХД-ийн алслагдсан 65, 67, 104 дүгээр сургуулийн сурагчид, ЕБС-ийн номын санчид оролцсон.

-Ардын боловсролын тэргүүний ажилтан Д.Даваагийн “Хүн эрдэнэ” номын нээлтийг зохион байгуулан, зохиолч-уншигчийн уулзалт хийхэд 50 гаруй уншигч оролцсон.

-“Цэвэр агаар – Эрүүл орчин” сэдэвт эссе бичлэгийн уралдааныг “Төгс сайн” ТББ-тай хамтран оюутан, сурагчдын дунд зохион байгуулсан. УБИС-ийн 2 дугаар курсын оюутан О.Лхагвабаяр, ЭМШУИС-ийн 3 дугаар курсын оюутан Ж.Алтанхуяг, “Ирээдүй” цогцолбор дунд сургуулийн 11 дүгээр ангийн сурагч Г.Мөнхжаргал нар эхний гурван байрыг эзэлж, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан. Мөн хоёр тусгай байр шалгаруулан, мөнгөн шагналаар шагнасан.

5. АВТОМАТЖУУЛАЛТ, ПРОГРАМ ХАНГАМЖИЙН АЖЛЫН ТАЛААР

Номын сангийн http://pl.ub.gov.mn вэб хуудас болон интернэт дэх бусад төлбөргүй үйлчилгээг ашиглан номын сангийн мэдээ, мэдээллийг түгээн ажиллаж ирлээ. Жоомла системд суурилсан тус вэбд зочин, уншигч хэрэглэгч, ажиллагсдад зориулсан 69 мэдээ, мэдээлэл, нийтлэл нэмсэн. Google Analytics програмын тусламжтайгаар вэбийн хэрэглээний үзүүлэлтийг тайлант хугацаагаар гаргахад 600 /source/ эх сурвалжаар дамжин 19449 хандагч /visitors/, 40589 удаа зочилж /visits/, 444827 хуудасны мэдээллийг үзжээ.

Вэбийн сервер руу 2000-2006 онуудад бүтээж байсан Ардын аман зохиолын сан http://pl.ub.gov.mn/aaz/, Хүнс-лавлагаа, мэдээлэл вэб http://pl.ub.gov.mn/huns/, Япон хэлний вэб http://www.pl.ub.gov.mn/ictjapanesecourse/-ийг хуулж, хэрэглээнд оруулсан.

Онлайн каталог буюу http://koha.pl.ub.gov.mn -ийг Google Analytics програмын тусламжтайгаар вэбийн хэрэглээний үзүүлэлтийг тайлант хугацаагаар гаргахад 44.651 хандагч /visitors/ 59.442 удаа зочилж /visits/, 201.889 хуудасны мэдээллийг үзжээ. Нийт 59442 хандагчаас 44651 нь буюу 69,28% нь Интернэт хөтөч/browser/ - Mozilla Firefox ашиглан манай байгууллагын http://koha.pl.ub.gov.mn сайтад ханддаг байна. Нийт 59442 хандагчаас 51,067 нь Гүүгл дээрээс хайлт хийж манай байгууллагын http://koha.pl.ub.gov.mn сайтад ханддаг байна.



Social media: Номын сангийн мэдээ, мэдээллийг байнга хүлээж авч мэдэхийг хүссэн иргэдтэй Twitter, Facebook гэх мэт social media хэрэгслэлээр холбоотой ажиллаж байна. Flickr - http://www.flickr.com/photos/ubpubliclibrary/ буюу онлайн зургийн төлбөргүй альбомд гишүүнээр бүртгүүлж, интернэт хэрэглэгчдэд номын сангийн үйлчилгээ, үйл ажиллагааны шинэлэг мэдээг зургаар хүргэхээр ажиллаж байна. Twitter – http://twitter.com/ubpubliclibrary хаягаар нэгдэж, 99 /following/ олон улсын номын сангийн холбоо болон байгууллага иргэдийн жиргээг хүлээн авч, номын сангийн мэдээ, мэдээллийг хүлээн авч байгаа жиргээчдийн тоо 276 /followers/ болж, нийт 280 мэдээ /tweets/ илгээгджээ. Жиргээний рейтинг #316,167 байна. Facebook - https://www.facebook.com/ubpubliclibrary хуудасны insights тайланг харахад 247 хүн нэгдэж /users-new likes/, 44008 /interactions-post views/ удаа мэдээг уншжээ.

Имэйл: Номын сангийн имэйл – ubplibrary@gmail.com хаягийг тогтмол шалгаж, гадаад дотоодын харилцагч нарт зохих хариу имэйлийг илгээж байна.

Нийслэлийн Мэдээлэл Технологийн газрын бүрэн дэмжлэгтэйгээр номын сангийнхаа домайн нэр дээр суурилсан байгууллагын имэйл хаягийг нээх боломжийг 2011 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр хүлээн авч, албан харилцаанд ашиглаж эхэлсэн. Мөн номын сангийн мэдээ, мэдээллийг уншигчдад имэйлээр илгээх зорилгоор news@pl.ub.gov.mn имэйл листийг зохион байгуулж, үйлчилгээг эхлүүлсэн. Номын сангийн ажиллагсадын дунд мэдээллийг түгээх, харилцан имэйлээр ярилцах боломжийг librarians@pl.ub.gov.mn имэйл листээр гүйцэтгэж байна. Энэ листэнд ажиллагсадын имэйл хаягийг бүртгэх ажлыг хийж, өнөөдрийн байдлаар 31 хаягийг бүртгэж, 26 имэйлийг явуулж, ажиллагсадын санал бодлоо солилцох, шийдвэр гаргах ажилд дэмжлэг болсон.

Номын сангийн товч танилцуулга, үйлчилгээний мэдээлэл, бүртгэлийг дараах вэбүүдэд оруулах, шинэчлэн засварлах ажил хийсэн: http://wikis.ala.org/sisterlibraries/index.php/Mongolia%2C_Ulaanbaatar_Public_Library, http://www.docstoc.com/profile/begzsuren, http://biznetwork.mn/network/topic/show/12759/

Олон улсын номын сангийн холбоо IFLA-ийн public email list-үүдэд info@pl.ub.gov.mn хаягийг бүртгүүлж, мэдээ авдаг боллоо.

Тус номын сангийн 2010 оны 05 дугаар сараас хойш 1 жилийн хугацаатай хэрэгжиж дуусаж байгаа Хараагүй хүмүүст зориулсан DAISY цахим ярьдаг номын төв төслийн багаас бэлтгэсэн case study, impact assessment, тайлан мэдээг Eifl байгууллагад илгээх ажлыг гүйцэтгэсэн.

DAISY номуудыг хуулах DVD-ны хавтасны эхийг бэлтгэж, 150 хувь хэвлэсэн. Архангай, Булган, Завхан, Сүхбаатар, Хөвсгөл, Хэнтий, Эрдэнэт, Өвөрхангай, Увс, Баянхонгор, Өмнөговь, Дархан-Уул, Төв, Говь-сүмбэр аймгуудын Нийтийн төв номын сангийн захирал, ажилтнуудад BookSense-ийг танилцуулж, хүлээлгэж өглөө. Eifl-ийн шинэ вэб системд daisytbcenter нэртэй гишүүнээр бүртгүүлж, PLIP хөтөлбөрийн буланд тавигдсан мэдээллүүдтэй танилцах боломжтой болсон. daisycenter@pl.ub.gov.mn имэйл лист үүсгэж, аймгуудын номын санчдын имэйлийг бүртгэлээ.

DAISY Consortium-ийн ерөнхийлөгч Hiroshi Kawamura тус номын сангийн DAISY студид зочлоход, DAISY цахим номын төвтэй танилцуулав.

Утасгүй сүлжээ WiFi: АНУ-ын ЭСЯ-ны санхүүжилтээр Хотын нийтийн төв номын санд Утасгүй интернэт сүлжээний 2 роутер суурилагдсан байсан. Утасгүй сүлжээг WiMax-ийн сар тутмын төлбөртэй холболтоор шийдэхийн оронд ХТНС-ийн одоогийн Ситинэтийн шилэн кабелийн холболт дээр үндэслэн байгуулах шийдлийг санал болгож, цаашдын тогтвортой байдлыг үндэслэн шийдвэрлэсэн. Мөн Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газраас хэрэгжүүлж байгаа WiFi Hot spot-ийн хөтөлбөрт хамрагдаж, утасгүй интернэтийн сүлжээгээ 2Mb-ийн тусдаа холболттой болгох ажлыг хийж эхлээд байна.

Үйлчилгээний програм хангамж:

Алиса програм: Вэбд суурилсан номын сангийн програм хангамж Коха-г 5-р сарын 1 өдрөөс үйлчилгээнд ашиглаж эхэлсэнтэй холбогдуулан Алиса програмын ашиглалтыг зогсоож, гол хийгдэж байсан уншигч бүртгэх, ном бүртгэх ажлуудыг Коха руу шилжүүлсэн. Алиса програмыг Уншигч бүртгэл, Номын мэдээллийг лавлан

харах байдлаар 2 номын санч дээр ашиглаж байгаа тул Австрали улс руу холбоо барьж, 2012 онд ашиглах эрхийг авсан.

DoorControl програм: Зөрчил гаргасан нийт 83 уншигчид номын сангийн үйлчилгээний журмыг танилцуулах, уншигчдын санал бодлыг сонсож, үйлчлүүлэх эрхийг нээх болон бусад арга хэмжээг авсан. Уншигч бүртгэл дээр гарч байгаа Ялангуяа уншигчийн мэдээллийг сунгах үед буруу Баркодыг санамсаргүй бичиж алдаа гаргаж байгааг багасгах зорилгоор Уншигчийн баркодыг бичсэний дараа шууд зургийг харуулдаг болгож, програмыг хуулж ажиллуулсан. Мөн Гэрээр ном олголтын өдрийн тайланд хураамж, танхимын ном буцаах програмд уншигчийн буцаах номын тоо, буцааж байгаа номын тоог зэрэг харагддаг болголоо.

Мөн Doorcontrol програмын Interbase баазын файлыг хуулж авч нөөцлөх ажлыг ажлын өдрүүдэд, файлын алдааг шалгах, хэмжээг багасгах ажлыг http://www.saleslogix-software-qi.com/databasemaintenance.html зааврын дагуу 2 удаа гүйцэтгэж, шөнийн цагаар өгөгдлийн сангийн файлыг автоматаар хуулж архивладаг болгосон.

Коха програм: Номын сангийн вэбд суурьтай Коха систем ажиллах http://koha.pl.ub.gov.mn домайн нэрийг 124.158.90.10 хаяг дээр бүртгүүлэх хүсэлтийг НМТГазар болон Датацентрт илгээж, домайн нэрийг бүртгүүлсэн. Коха систем нэвтрүүлэхтэй холбоотой Алиса програмаас ном зүйн бичлэгийг MARC форматаар гаргах, болон бусад шаардлагатай лавлагаа, туслалцааг өгч ажилласан.

Цахим уншлагын 12 компьютерт филтер тавьсан ба www.youtube.com www.hi5.com гэх мэт social site болон тоглоом, эротик насанд хүрэгчдийн сайтуудыг хаасан болно. Сүүлд үйлчлүүлэгчдийн хүсэлтээр www.facebook.com сайтыг буцаан ажилд оруулсан.

Төв болон салбар номын сангийн хэмжээнд компьютер, техник хэрэгсэл болон интернет, дотоод сүлжээ ажиллах хэвийн нөхцөлийг хангаж ажилласан.

6. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНД

Нэг. Нягтлан бодох бүртгэл, санхүү, аж ахуйн талаар

2011 онд номын сан нь батлагдсан төсвөөр өөрийн үйл ажиллагааны орлогоос төсөвт төвлөрүүлэх орлого нь 40,148,000 төгрөг байхаас 73,730,300 төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

2012-2014 оны төсвийн төлөвлөгөөгөө БСШУЯ, Нийслэлийн соёл урлагийн газруудад тус тус хүргүүллээ. Түрээсийн болон бусад харилцагч байгууллагуудтай хамтран ажиллах гэрээгээ шинэчлэн хийж тухай бүрт нь тооцоо нийлж ажиллав.

Нийслэлийн төрийн сан, Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, Нийслэлийн татварын хэлтэс, Нийслэлийн өмчийн харилцааны газар, Нийслэлийн Соёл урлагийн газарт мэдээ тайлангуудаа цаг хугацаанд нь тус тус үнэн бодитой гаргаж өгөн ажиллаж байна. Нийслэлийн өмчийн харилцааны газрын өмч эзэмшүүлэх, гэрээ дүгнэх шалгалтаар хангалттай үнэлгээ авч, 2010 оны балансаа өгч нэгтгүүлэв. 2011 оны 1-3 дугаар улирлын баланс, тайлангаа Нийслэлийн төрийн санд нэгтгүүлэн, Нийслэлийн боловсролын газар, Нийслэлийн соёл урлагийн газруудад тус тус нэгтгэн хүргүүлсэн.

2010 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогоор тооллогын комиссын дүгнэлт, саналын дагуу төв номын сангийн үндсэн складыг цэгцэлж тус бүрийг складын бүртгэлтэй болгон дугаарлалаа. 2010 оны санхүүгийн тайланд “Б энд С” ХХК-аас хийсэн аудитын дүгнэлтээр зөрчилгүй дүгнэлттэй, НМХГ-аас хийсэн 2008 он, 2009 он, 2010 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагааны баримтын шалгалтанд амжилттай шалгуулж дууслаа. Өмчийн харилцааны газарт балансаа өгч нэгтгүүлсний дээр тус газрын өмч эзэмшүүлэх, гэрээ дүгнэх шалгалтаар хангалттай үнэлгээ авав. Мөн Санхүүгийн тайланд хийгддэг аудитын явцын шалгалтанд материалуудаа бүрдүүлж өгөн шалгууллаа.

Нийгмийн даатгалын тооцоо, тайланг сар бүр өгч, дэвтэрт бичилт хийж баталгаажууллаа. Мөн үйл ажиллагаатай холбогдолтой өдөр тутмын мэдээ тайланг тухай бүрт хийж, хариу судалгааг гарган холбогдох газруудад өгч, өдөр тутмын гүйлгээг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэлээ. 3 дугаар салбар номын сангийн номын тооллогын тооцоо нийлсэн акт үйлдэж номын нэг бүрчилсэн дансуудыг номын санч нарт нь хүлээлгэн өгөв. Мөн ном бүрдүүлэлтийн үлдэгдэл номыг тоолж тооцоог бодон тулгалт хийж, төв номын сангийн нэг бүрчилсэн данс тус бүрийн үнийн дүнг бодож дуусгалаа.

Төсөвт тодотгол хийлгэх талаар НЗДТГ болон Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд тооцоо судалгааг гарган нийт 4 удаа албан бичгийн хамт хүргүүллээ. Үүний үр дүнд НЗДТГ-аас тавилга, тоног төхөөрөмж худалдан авахад зориулж 30,000,000 төгрөгийн хөрөнгө оруулалт батлагдсан бөгөөд тавилга эд хогшил, тоног төхөөрөмж худалдан авах тендерийн бичиг баримтыг боловсруулан байгууллага компаниудад хүргүүлээд байна.

НЗДТГ-ын дэргэдэх номын сан байгуулахтай холбогдсон төсвийг гаргаж худалдан авах тавилга, тоног төхөөрөмж бусад эд зүйлсийн судалгааг гарган баримтуудыг бүрдүүлэн, гүйлгээг хийж тайланг хүргүүлсэн. Шатар уншлагын танхимтай холбогдсон гэрээ бусад бичиг баримтуудыг боловсруулж бэлтгэн гүйлгээг хийж, тайланг гарган НЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтэст хүргүүлсэн.

Хас банкны мэдээллийн ажилтанг урьж, ажиллагсдад цалингийн зээл болон бусад мэдээлэл өгүүлэв. Мөн Хас банкинд цалингийн зээлийг бууруулах тухай албан бичиг хүргүүллээ.

Байгууллагын нийт ажиллагсад байгалийн гамшигт нэрвэгдсэн Япон улсын ард түмэнд нэг өдрийн цалин болох 959,600 төгрөгийг хандивлав.

Төв болон салбар номын сангуудын уншлагын заал фонд, архивын өрөөнд нийт 8 ширхэг чийг, дулаан хэмжигч 188,000 төгрөгөөр худалдан авч, узель микрофоны үнэ 1,000,000 төгрөгийг шилжүүлэв. Төв номын сангийн гаднах хаягийг шинэчилж, тогтоон байрлуулж, гадна талбайд 2 ширхэг хогийн сав суурилуулсан. Мөн гаднах ногоон байгууламжийг тохижуулан номын сангийн үүдэнд болон сааданд цэцгийн мандал тарьж ургуулан, арчилж тордон цэвэрлэсний дээр зүлэгжүүлсэн 2200 м2 талбайг цэвэрлэн, шарилж зэрлэгийг зулгаав.

Номын сангуудын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангалаа. Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд ЦТП дээр байрладаг халуун усны шаардлага хангахгүй болсон ф50-ийн хаалт хоёрыг сольж тавин, мөн халуун хүйтэн усны шугамын хаалтуудыг тус тус шинэчилж халаалт авах бэлтгэл ажил хангасан. Хоёр давхрын салхивчны 2,5 метрийн урттай солигдоогүй үлдсэн хуучин шугам цоорч, ус гоожиж байсныг шинээр сольж гагнан хэвийн үйл ажиллагаанд нь оруулан ажиллуулж байна. Ажилчдын нийтийн халуун усны цоорсон шугамыг сольж, иж бүрэн засвар хийж тохижууллаа. Мөн нийтийн эрэгтэй ариун цэврийн өрөөний крант, яндан трубо, босоо 00-ийн сипон, халуун усны 00-ийн почкины хөвүүрүүдийг тус тус янзлав. Мөн заалнуудын хагарсан панелиудыг солив.

Өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээг чанартай сайн хийж, 14 хоног тутамд гадаа талбайд их цэвэрлэгээ хийж, сар бүрийн сүүлийн долоо хоногийн 2 дахь өдөр их цэвэрлэгээ тогтмол хийж байна. Төвлөрсөн номын сангийн хэмжээнд “Сүүн болор” ХХК-тай гэрээ байгуулж хортон шавж, ариутгал, халдваргүйтлийн хор цацуулан ариутгал хийлгэсэн.

Төв номын сангийн гэрээр ном олгох, торгуулийн үйлчилгээний оруулсан орлогыг сар бүр нарийн тооцож гарган, төлөвлөгөө биелүүлсэн номын санчдад сар

бүрт орлогын 30%-ийн урамшуулал олгож байна. Нийтийн номын сангийн хэмжээнд ажиллагсдын ээлжийн амралтын цалинг бодож олгов.

Хоёр. Ажилтан, албан хаагчдынхаа мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар хийсэн ажил

Нийт ажиллагсдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор “Богины ам”-д цасны баяр зохион байгуулахад 350,000 төгрөг, Соёл урлагийн ажилтны баярын өдрөөр ажиллагсдыг идэвхтэй амруулахад 1,406,000 төгрөг зарцуулав.

Нийт ажиллагсдын 2010 оны жилийн эцсийн ажлыг дүгнэж А,В,С үнэлгээ авсан 74 ажилтанд 5,800,000 төгрөгийн урамшуулал олгосон. Төрийн албан хаагчдын 2010 онуудын үр дүнгийн гэрээ, ажлыг дүгнэж нийт ажиллагсдын 34.6% буюу 27 хүнд 3,111,470 төгрөгийн ур чадварын нэмэгдлийг олгож байна.

Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль, номын сангийн захирлын зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу нийт 3 хүнд хавсран ажилласны хөлсийг үндсэн цалингийн 30%-иар нэмж бодон 2011 оны 2 дугаар сараас эхлэн олгож байна. /2,426,582/

Номын сангийн захиргаа Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан Хамтын гэрээний дагуу нэг удаагийн буцалтгүй тусламжийг 13 ажилтанд олгосон байна. Үүнд: Түлээ нүүрсний мөнгөний 60 хувийн тэтгэмжийг 4 ажилтанд, 1 өндөр настанд тус бүр 200,000 төгрөг олголоо. Гэр бүлд нь гачигдал гарсан 3 ажилтанд тус бүрт 219,900, өөрөө хурим хийсэн нэг ажилтанд 200,000 төгрөг, хүүхэд нь хурим хийсэн нэг ажилтанд 50,000 төгрөг олгосон. 70 нас хүрсэн 4 ахмадад цагаан сарын баярыг тохиолдуулан тус бүр 50,000 төгрөгийн буцалтгүй тусламж олголоо. Нийт 14 ажилтанд /2,109,700=00/ төгрөгийн буцалтгүй тусламж олгосон байна.

Мөн Хамтын гэрээний дагуу 50 нас хүрсэн 2 ажилтанд тус бүр 50.000 төгрөг, шинэ байранд орсон 3 ажилтан болон шинээр байшин барьсан 1 ажилтанд тус тус урамшуулал олгосон. Эх үрсийн баярыг тохиолдуулан номын сангийн ажиллагсдын 0-16 насны бүх хүүхдэд мөнгөн урамшуулал олгов. /нийт 39 ажиллагсдын 57 хүүхдэд тус бүр 5000 төгрөг, нийт 885,000 төгрөгний урамшуулал олгов.

Сонгинохайрхан дүүрэг дэх салбар номын сан байгуулагдсаны 20 жилийн ойг тохиолдуулж 2 ажилтанг тус бүр 50,000 төгрөгөөр шагнаж, мөн ойн арга хэмжээтэй холбогдох зардалд нийт /800,000/ төгрөг зарцуулав. Мөн 59 ажилтанг эмнэлгийн үзлэгт хамруулахад 1,180,000 төгрөг зарцуулсан байна.

Соёлын хуулийн дагуу мэргэжлээрээ ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан 1 хүнд нэг жилийн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг олгосон. /5,415,668/

Үйлчлэгчид болон төв номын сангийн номын санч нарт ажлын хувцас хийлгэхэд 1,357,000 төгрөг, хотын номын сангуудын хэмжээнд 3 төрлийн спортын тэмцээнийг 300,000 төгрөгөөр зохион байгууллаа. Монгол улсад номын сан байгуулагдсаны 90 жилийн ойд зориулж тэмцээнд оролцсон тамирчдад нийт 270,000 төгрөгний хувцас авсан.

Ажиллагсадын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд нийт 33,823,764 төгрөг зарцуулсан байна.

Номын санчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалт семинарыг сар бүрийн сүүлийн Мягмар гарагт номын сангийн дэргэдэх Мэргэжил арга зүйн зөвлөл, Номын сангуудын консерциумтай хамтран явуулдаг бөгөөд энэ жил “Номын сангийн программ хангамж”, “Цахим, virtual ирээдүйн номын сан”, “Эцэг эх - хүүхдийн хүмүүжил”, “Миний ажлын ноухау”, “Дам тамхидалт”, “Цэвэр эрүүл орчинд амьдарцгаая”, “Эцэг эхийн дуурайл”, “Дэлхий нийтээр тамхигүй орчин”, “Гэр бүл”, зэрэг тодорхой сэдвүүд болон Монгол улсын “Хөдөлмөрийн тухай хууль”, “Төрийн албаны тухай хууль”, Төрийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль”, “Нийгмийн даатгалын багц хууль”-дын талаар нийт ажиллагсдад мэдээлэл, сургалт зохион байгуулан ажилласан.

Ахлах номын санч Д.Энх-Ундрал, номын санч Д.Дэлгэрсүрэн нарыг англи хэлний мэдлэгээ дээшлүүлэн ХУИС-д суралцахад, Номын санч П.Оюунбаяр СУИС-ийн Соёлын сургуулийг ном зүйч-мэдээллийн ажилтан мэргэжлээр сурч төгсөхөд ажлын цагийн зохицуулалт хийх, цалинтай чөлөө олгох зэргээр боломжоор хангаж өгөв. Мөн Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо, Дани улстай хамтарсан “Чадавхижуулах” төслийн хүрээнд номын санч П.Оюунбаяр компьютер, англи хэл, менежментийн хичээлүүдэд оройн цагаар суралцаж байна.

Мөн номын санч Б.Баярцогт, Д.Дэлгэрсүрэн, Мэдээллийн технологийн ажилтан Ж.Бэгзсүрэн нар АНУ-ын элчин сайдын яамны зардлаар Тайваний Тайпэй хотноо болсон сургалтанд хамрагдсан.

Номын санчид номын сангийн үйлчилгээнд нэвтрүүлсэн Коха програм дээр уншигч бүртгэх, каталогт ном оруулах, номын хайлт хийх зэрэг модулиуд дээр ажиллаж сурсан. Мөн тасаг, салбарын эрхлэгч нар номын санчдад өдөр тутам мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилладаг.

Гурав. Албан хэрэг хөтлөлтийн талаар

1. Иргэдийн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэсэн байдал

Иргэд болон ажиллагсдаас нийт 53 хүсэлт өргөдөл хүлээн авч, шууд шийдвэрлэх боломжтойг нь хуулийн хугацаанд нь шийдвэрлэж эзэнд нь амаар болон утсаар мэдэгдэж ажилласан. Үүнээс ихэнх хувь буюу 32 нь тэтгэмж, тусламж хүссэн, үлдсэн хувь нь чөлөө олгох, шилжүүлэн ажиллуулах, ажлаас чөлөөлөхийг хүссэн зэрэг бусад асуудлаар хандсан байна. Өргөдлийн 90,6% нь байгууллагын ажилтан, ахмадуудаас, үлдсэн 9,4 хувь нь гадны иргэдээс ирсэн байна. Үүнээс шууд шийдвэрлэх боломжгүй 40 мянган айлын орон сууцанд хамруулах, гэр хүссэн, орон сууцны урт хугацааны зээлд хамруулахыг хүссэн зэрэг өргөдөл хяналтанд байна. Улирал тутам өргөдлийн тайлан мэдээ гаргаж, удирдлагад танилцуулж ажилласан.

2. Хариутай бичгийн шийдвэрлэлт

Байгууллагын дотоодод үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 21, хүний нөөцтэй холбоотой 50, нийт 71 тушаал гарч тухай бүр мөрдөгдөн хэрэгжсэн байна.

108 албан бичиг явуулснаас 97 нь хариугүй, 11 нь хариутай бичиг байсан бөгөөд 8 бичгийн хариу ирсэн байна. 1 дүгээр салбар номын сангийн байрны асуудлыг шийдвэрлүүлэхээр явуулсан албан бичигт хариу ирээгүй бөгөөд БСШУЯ-ны Барилга захиалагчийн ажлын албаны нябо Совдоос “2010 онд засвар хийгдсэн учраас энэ онд дахин төсөв өгөх боломжгүй. Танай албан бичгийн дагуух асуудлыг яамны дунд хугацааны төлөвлөгөөнд тусгаснаар хэргийг хаасан байгаа” гэсэн хариултыг авсан.

Нийт 33 албан бичиг ирснээс хариу нэхсэн 11 албан бичигт бүртгэл хяналтын карт хөтөлж, хариуг хугацаанд нь өгч, хариу нэхээгүй 22 албан бичгийн шийдвэрлэлтэд нь хяналт тавьж ажиллалаа. Улирал тутам хариутай бичгийн шийдвэрлэлтийн тайлан мэдээ гаргаж, удирдлагад танилцуулсан

Дөрөв. Байгууллагынхаа үйл ажиллагааны үр дүнгийн талаар иргэдийн санаа бодлыг ямар арга хэлбэрээр авч үнэлэлт дүгнэлт хийсэн байдал.

Номын сангийн үйлчилгээ уншигч, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцэж буй талаар болон номын сангийн үйл ажиллагаанд дүгнэлт өгөх зорилгоор санал хүсэлтийн хайрцаг, дэвтрийг танхим тус бүрээр ажиллуулж гарч буй санал бодлыг нь ажил үйлчилгээнд тусгаж ажилласан. Үйлчилгээнд сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлж, зарим нэг дутагдалтай талыг бичсэн байна.

- Баянзүрх дүүргийн номын сангийн хүүхдийн уншлагын танхимын цагийн хуваарийг өөрчлөн амралтын өдрүүдэд ажиллуулах, танхим хүйтэн учир удаан сууж ашиглах боломжгүй, шинэ ном мэдээлэл хомс, өлгүүргүй байгаа,

интернет үйлчилгээ байхгүй гэжээ. Нөгөө талаас үйлчилгээ хурдан шуурхай, төрөл бүрийн сэдвээр өнгө үзэмж сайтай мэдээлэл байнга гаргаж байгаа нь тэдний хэрэгцээг хангасан үйлчилгээ болж байгаад талархлаа илэрхийлсэн байна.

- Хан-Уул дүүргийн номын сангийн уншлагын танхимуудын гэрэлтүүлэг муу, хүүхдийн уншлагын танхимыг хагас бүтэн сайн өдөр ажиллуулах, 2 ээлжтэй болгох, интернетгүй
- Төв номын сангийн чөлөөт сонголттой танхим дуу чимээ ихтэй, уншигчдад шаардлага тавьдаггүй
- Сонгинохайрхан дүүргийн салбар номын сангийн номын нэр төрөл, хүрэлцээ муу, шинэ ном бага авсан гэх мэт.

Үйлчилгээний байгууллагын бодлого төлөвлөлтийн үндэс нь байнгын үйлчлүүлэгчдийн тоог бууруулахгүй байх явдал байдаг учраас тэдгээрийн зан төлөв, хэрэгцээг тогтмол судлан үйлчилгээгээ зохион байгуулах нь бидний гол зорилт юм. Төв номын сангийн Олон нийтэд үйлчлэх тасгаас 200 уншигчийг хамруулсан “Манай үйлчилгээ” сэдэвт 13 асуулттай санал асуулга явуулсан. Судалгаанд оролцогчдыг насны байдлаар ангилахад 17 хүртэл нас 6%, 17-25 нас 77%, 26-35 нас 7,5%, 36-45 нас 3%, 45-аас дээш нас 1,5%

- Хүйс: Эрэгтэй 34.0%, Эмэгтэй 61,0%
- Ажил эрхлэлтийн байдал: Ажилладаг 5%, Сурдаг 84,5%, Ажилгүй 2,5%, Тэтгэврийн насны 3%
- Үйлчлүүлсэн жил: Анхны жил 35,5%, 2-3 жил 44,5%, түүнээс дээш жил 15%
- Ямар зорилгоор ирдэг: Чөлөөт цагаа өнгөрөөх 13%, Хичээл давтах 50,5%, Шинэ мэдээлэл авах 25%, Багшийн өгсөн даалгавар хийх 6,5%

Номын санчдын мэргэжлийн ур чадварыг судалгаанд хамрагсдын 80% сайн, ажлаа хөнгөн шуурхай сайн хийдэг гэсэн байна. 20% нь зан харьцаан дээр анхаарах, 4% нь өлгүүрийн хүмүүсийн зан харьцааг сайжруулах хэрэгтэй гэсэн байна.

Судалгаанд оролцогсдын 80% нь номын фондоо шинэ ном, мэдээ мэдээллээр баяжилт хийх, хүрэлцээ муутай номын тоо хувийг олшруулах, уншлагын танхимын чимээ шуугианыг багасгах, агааржуулалт гэрэлтүүлгийг сайжруулах, интернетийн үйлчилгээг илүү өргөн хүрээтэй болгох, орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон тохь тухтай нийтийн номын сан болгох санал бичсэн байна.

Одоогоор явуулж байгаа үйлчилгээ нь уншигч хэрэглэгчдийн таашаалд нийцсэн үйлчилгээний чанар хамрах хүрээ сайн байна гэж дүгнэжээ. Номын урагдалт, хулгайлалт, номын буруу ашиглалтыг бууруулах тал дээр судалгаанд оролцогчдоос хяналтыг тогтмол тавих, камерыг олноор байршуулах, номоо хэрхэн зөв ашиглах талаар сургалт зохион байгуулах зэрэг санал ирсэн.

Дээрх санал асуулгын мөрөөр бид номын сангийн ном товхимолыг хэрхэн зөв ашиглах талаар тойм яриа хийж, мөн хяналтын номын санчийг 2 ээлжээр ажиллуулсны үндсэн дээр номын урагдалт, мэдээллийг баллах, хулгайлах зэрэг багассан. Үйлчлүүлэгдийн саналыг үндэслэн номын сангийн интэрнэт үйлчилгээг өргөтгөн ажиллуулсан. Мөн номын санчид, үйлчилгээний ажилтнуудын дунд “Инээмсэглэл” сэдэвт сарын аяныг өрнүүлэн ажиллуулсан нь үр дүнгээ өгч байна.

Вэбийн санал асуулгын модулийг ашиглан Номын сангийн үйлчилгээний Зуны цагийн хуваарийн тухай санал асуулга онлайнаар явуулахад 35 хүн саналаа өгсөнөөс 22 хүн цагийн хуваарь зохимжгүй байна, 13 хүн зохимжтой байна гэж хариулжээ.

Баянзүрх дүүргийн номын сан хагас жилд 25 асуулт бүхий “Номын сан-хүний хөгжлийн төв” сэдэвт санал асуулгыг боловсруулан салбар номын сангийн нийт 50 уншигчийн дунд судалгааг явуулсан байна. Судалгаанд оролцогчдын 74% нь ИДС-ийн оюутан, 20% нь ЕБС-ийн 10-12 ангийн сурагчид, үлдсэн 6% нь ажил эрхэлдэг хүмүүс хамрагдсан байна. Санал асуулгад оролцогчид 100% номын сан хүнийг хөгжүүлэх төв мөн бөгөөд үйлчилгээний хураамжийг бууруулсан нь цаг үеэ олсон чухал зүйл байсан гэж үзсэн байна. Оролцогчдын 50% нь шинэ уран зохиолын номоор фондоо баяжуулах нэн түрүүнд шаардлагатай гэсэн бол 55% нь каталогт хайлт хийх талаар мэргэжлийн хүний зөвлөгөө хэрэгтэй гэж үзсэн байна. Оролцогчдын дийлэнх нь уншлагын танхим хүйтэн, е-каталог байхгүй, чөлөөт сонголтгүй, фондын баяжилт хийгдэхгүй байгаа нь үйлчилгээнд сөргөөр нөлөөлдөг гэж хариулсан байна.

Дээрх санал асуулгын мөрөөр шинээр ирсэн ном хэвлэлийн танилцуулгыг агуулгын хамт гаргах, каталогт ном хайх зөвлөмж самбар-1, үйлчилгээний журмыг зургаар илэрхийлж ширээн дээр байрлуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

7. ТАЙЛАНД ӨГӨХ ҮНЭЛГЭЭ БОЛОН ЦААШИД ТАВИХ ЗОРИЛТ.

Тус номын сангийн хэмжээнд 2011 онд дэвшүүлсэн зорилт, төлөвлөгөөт үзүүлэлтүүд тоо, чанар, хэмжээний хувьд ерөнхийдөө төлөвлөсөн хэмжээндээ хүрсэн байна. Энэ жилд 62 багц ажил үйлчилгээ төлөвлөснөөс 60 ажил буюу 96,8% нь биелсэн байна.

Төв номын сангийн байр анх ашиглалтад орсон цагаасаа хойш засвар үйлчилгээ хийгдээгүйн улмаас үндсэн фонд руу бороо, цасны ус орж, хана туурга хөгцөрч муудан, номын хадгалалтад сөргөөр нөлөөлдөг. Мөн уншигчийн сандал, ширээ, номын тавиур нь номын сантай адил 31 дэх жилдээ ашиглагдаж байгаа учраас засвар авахаа больтлоо эвдэрч муудсан байдалтай байна. Иймд дараах ажлуудыг зайлшгүй хийх шаардлагатай байна. Үүнд:

1. Төв номын сангийн үндсэн фондод засвар хийх
2. Чингэлтэй дүүрэг дэх салбар номын сангийн байрны асуудлыг шийдвэрлэж, үйлчилгээг эхлүүлэх
3. Хан-Уул болон Сонгинохайрхан дүүрэг дэх салбар номын сангийн дээврийг засах
4. Төв болон салбар номын сангуудын уншигчийн сандал, ширээ, номын тавиур солих
5. Төв болон 4 салбар, нийт 5 номын сангийн хэмжээнд шинэ ном авахад жилдээ 30 сая төгрөг төсөвлөдөг нь хангалтгүй байдаг тул шинэ ном авах төсвийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

ХҮҮХДИЙН НОМЫН ОРДНЫ
2010 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ: БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН УР ЧАДВАР

Монголын Хүүхдийн номын ордон нь Монгол улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөр, Монгол улсын соёлын тухай хууль, БСШУ-ны сайдтай байгуулсан үр дүнгийн гэрээг мөрдлөг болгон хүүхэд залуучуудад номын сангийн үйлчилгээ үзүүлэх, номтой нөхөрлөх хөдөлгөөнийг өрнүүлэх чиглэлийг өөрийн үйл ажиллагаандаа тусган ажиллаж ирлээ.

Соёл урлагийн салбарын хэмжээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Монгол улсын засгийн газрын мөрийн хөтөлбөрийн 1.2.22-д заасан “Соёл урлагийн салбарыг хөгжүүлэх бодлогыг тодорхойлж, эрх зүйн орчныг нь боловсронгуй болгох, “Соёл урлагийг 2009-2012 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-г боловсруулах ажлын хэсэгт захирал Д.Оюунбилэг орж ажилласан.
- Монгол улсын ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн санаачилсан “Номын сангийн хууль” боловсруулах ажлын хэсэгт мөн орж ажилласан байна.
- Энэ жилийн “Соёл урлагийн ажилтан”-ы баярыг номын сангийн салбарыхан хариуцан хийсэн бөгөөд МУҮНС-тай хамтран манай хамт олон зохион байгуулсан.
- “Номын яармаг-2010” –ын үйл ажиллагааг Соёл урлагийн хороо, МУҮНС-тай хамтран зохион байгуулсан. Энэ ажлын хүрээнд яармагт оролцогч байгууллагуудад байр талбай хуваарилах, ярилцлага, уулзалт бусад арга хэмжээний танхим бэлтгэх, зөөврийн номын сан ажиллуулах, зохиолч уншигчдын уулзалт зохион байгуулах ажлуудыг манай хамт олон хийж гүйцэтгэсэн.
- 2010 онд БСШУ-ны сайдтай 35 бүтээгдэхүүн, тусгай захиалгат 3 бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ хийсэн бөгөөд Хүүхдийн номын ордон нь гэрээний биелэлтээ хугацаанд нь чанартай сайн хийж гүйцэтгэсэн болно.

Байгууллагын үйл ажиллагааг тогтмолжуулах, чадваржуулах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

- Номын сангийн үндсэн ажлын цөм болох хөмрөгийн бүрдүүлэлтэнд онцгойлон анхаарч 2010 онд төсвөөс олгосон 22 сая 500 мянган төгрөгнөөс гадна дотоод гадаадын хандивлагч байгууллага, хэвлэлийн газар , хувь хүмүүсийн хандив тусламжаар 17 сая 801 мянга 589 төгрөгний ном нэмж бүрдүүллээ. Нийт энэ онд 40 сая 301 мянга 589 төгрөгний номоор хөмрөг баяжилт хийгдлээ. Шинээр ном хэвлэлийн бүрдүүлэлт хийхдээ өөрийн номын сангийн онцлог, уншигчдын бүрэлдэхүүн, тэдний санал хүсэлтийг харгалзан ажиллаж байна. Ингэснээр жилээс жилд уншигчдын ирц болон олгосон номын тоо өссөөр байна.
- БСШУ-ны сайдын баталсан \2004 оны 31 дугаар тушаалаар\ Хүүхдийн номын ордны дүрмийн 2.1.5-д зааснаар “Ерөнхий боловсролын сургуулийн номын санг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах” үүргээ биелүүлж энэ онд Завхан, Говь-Алтай, Ховд, Говь-Сүмбэр, Увс, Архангай, Булган, Хөвсгөл, Сэлэнгэ зэрэг 9 аймгийн сумдын сургуулийн 184 номын санчдад тус бүр нь 40

цагийн, нийт 360 цагийн сургалт семинарыг зохион байгууллаа. Мөн нийслэлийн номын санчдад 3 удаагийн семинар, 1 удаагийн үзүүлэх сургууль зохион байгуулсан. Монголын номын сангууд дундаас анх удаа “Номын санчдын сургалтын төв”-ийг албан ёсоор зохион байгуулж цаашдаа 8 модульт сургалтаар ЕБС-ийн номын санчдад сургалт явуулж мэргэжил мэдлэгийг нь дээшлүүлэх төлөвлөгөөтэй байна.

- Хүүхдийн номын ордон байгуулагдсан цагаасаа эхлэн хүүхдийн зохиолчдын бүтээлээр ном зүйн бүртгэл гарган, төрөлжсөн мэдээллийн сантай болох асуудал дээр анхааран ажиллаж ирсэн бөгөөд одоогоор 1921-1970 он хүртлэх хугацааны мэдээллийн санг бүрдүүлэн 2 боть ном болгон хэвлүүлээд байгаа билээ. 2010 онд 1971-1990 оны хугацаанд хүүхдийн ном зохиол бичиж хэвлүүлсэн бүтээлүүдийг төрөлжүүлэн хэвлэлтэнд өгөхөд бэлэн болоод байна. Төрөлжсөн мэдээллийн сангийн эхний хэсэг нь ХНО-ны вэб дээр нээлттэй хэлбэрээр тавигдсан байгаа болно.
- Байгууллагын үйл ажиллагааг чадваржуулахад зөвхөн төсвийн хөрөнгөөр бус гадаад, дотоодын хандивлагч байгууллага, хувь хүмүүсийн туслалцаа дэмжлэгийг авах нь чухал байдаг. Энэ онд дараах байгууллагууд ХНО-д хөрөнгө оруулалт хийсэн байна. Үүнд:

✓ БСШУЯ-наас алслагдсан дүүргийн хүүхэд залуучуудад ном хэвлэл хүргэх, зөөврийн номын сан ажиллуулах зорилгоор 20 сая төгрөгний машин, 5 компьютер.,

✓ Германы Гёте Институтийн газраас Герман уншлагын танхимд телевизор, хөгжим, DVD зэрэг 3 сая 700 мянган төгрөгний техник тоног төхөөрөмж авч өгсөн. Мөн танхимын танилцуулгыг шинээр хэвлэж өгөв. Энэ онд тус танхимд 932 ном болон аудио визуал материал.,

✓ Монгол улсын номын сангуудаас "Олон улсын номын сангийн холбоо”-ны гишүүн хоёр номын сангийн нэг нь манай номын сан бөгөөд Азийн сангийн “Ном” хөтөлбөрөөс манай номын сантай байгуулсан гэрээний дагуу ОУНСХ-ны хураамж болох 365 еврогийн төлбөрийг хийж өгсөн. Мөн тус хөтөлбөрөөс англи хэл дээрх 1943050 төгрөгний 5 фактурын 86 ширхэг ном, 11 ширхэг аудио визуал материал,

✓ Японы Фукуй аймгийн Ротари клубээс 768 мянга 360 төгрөгний 25 ном.,

✓ Тайваний Үндэсний номын сангаас 6 сая 560 мянга 204 төгрөгний 514 ном, 105 CD, DVD материал

✓ Солонгосын Койка байгууллагаас 1 компьютер.,

✓ Зохиогч хэвлэлийн газруудаас 5 сая 306 мянга 587 төгрөгний ном тус тус бэлэг хандиваар өгсөн байна.

Энэ онд гадаад дотоодын байгууллага, хувь хүмүүсээс 17 сая 801 мянга 589 төгрөгний ном, 25 сая 164 мянган төгрөгний техник тоног төхөөрөмж нийт 42 сая 965 мянга 589 төгрөгний хөрөнгө оруулалт ХНО-д оруулжээ.

ХОЁР: АЖИЛЧДЫН АЖЛЫН ХАРИУЦЛАГА, САХИЛГА ДЭГ ЖУРАМ, ӨӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Байгууллагын ажилтан албан хаагч бүрийн үр дүнгийн гэрээг дүгнэж “Хөдөлмөрийн гэрээ”-г шинэчлэн хийв.
- Хагас жил, жилийн эцэст хийсэн ажлын тайланг хүн бүр “Power Point” программ ашиглан тайлагнадаг ажил хэвшсэн болно. Тайлангийн хурлаар төлөвлөгөөт ажлаас гадна тухайн ажилтаны ёс суртахуун, үйлчилгээний

соёлын талаар авч хэлэлцэн урамшуулалт цалин өгөх эсэх, цаашид ямар зүйл дээр анхааран ажиллах тал дээр харилцан ярилцдаг болно.

- 2010 онд ХНО-ны захиргааны зөвлөлийн хурлаар ажилтнуудад олгодог "Ур чадварын нэмэгдэл" олгох журамд нэмэлт өөрчлөлт оруулллаа. Тухайлбал: 9-р заалтанд: "Хөдөлмөрийн сахилгын зөрчил, ажлын дутагдал гаргасан, ажлын байрны тодорхойлолтонд заагдсан үүрэгт ажлыг дутуу хийж гүйцэтгэсэн, ажлын үр дүн нь буурсан, ажлын цаг ашиглалт хангалтгүй ажилтанд ур чадварын нэмэгдэл олгохгүй" *гэснийг "Ажлын байран дээр харилцааны ёс зүйн хэм хэмжээг мөрдөөгүй, ёс суртахууны аливаа зөрчил, хөдөлмөрийн сахилгын зөрчил, ажлын дутагдал гаргасан, ажлын байрны тодорхойлолтонд заагдсан үүрэгт ажлыг дутуу хийж гүйцэтгэсэн, ажлын үр дүн нь буурсан, ажлын цаг ашиглалт хангалтгүй ажилтанд ур чадварын нэмэгдэл олгохгүй"* гэж өөрчлөн энэ талаар ажилтнуудад мэдээллийг хийж, тус заалтанд хамрагдах ёс зүйн зөрчил дутагдлын талаарх тайлбарыг өгсөн нь үр дүнтэй ажил болж чадсан. Үүний үр дүнд ажилтнуудын хоорондын харьцаа, хамт олны уур амьсгал илүү сайжирч, ажлын хариуцлага сайжирсан. Тухайлбал *"Ур чадварын нэмэгдэл авч буй ажилтан 9-р заалтанд дурдагдсан зөрчил гаргасан тохиолдолд ур чадварын нэмэгдлийг түдгэлзүүлнэ"* гэсэн "Ур чадварын нэмэгдэл" олгох журмын 10-р заалтын дагуу 2009 онд 1 ажилтны нэмэгдлийг түдгэлзүүлж байсан бол 2010 онд ийм шалтгаан гараагүй.

Шагнал урамшууллын хүрээнд:

- Тус онд эхний болон сүүлийн хагас жилийн ажлын үр дүнг үндэслэн давхардсан тоогоор 17 ажилтанд үндсэн цалингийн 10-25 хүртэлх хувийн ур чадварын нэмэгдэл олгосон.
- Зэргийн нэмэгдэл 6 хүнд цалингийн 10-15 хувиар олгосон байна.
- Нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийг ХНО-ны "Дотоод журам"-д заасны дагуу ар гэрт нь гачигдал тохиолдсон болон насны ойг нь тохиолдуулан 50 мянган төгрөгийг 7 хүнд, сарын цалинтай тэнцэх мөнгөн тусламж 4 хүнд, өвчний учир нас барсан 2 ахмад ажилтанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй дүйцэх мөнгөн тусламжийг тус тус байгуулагын зүгээс олгосон байна.
- ХНО-ны ахмад ажилтнуудад ахмадын өдөр болон сар шинийн баярт зориулж 2 удаа хүндэтгэл үзүүлжээ.
- 2010 оны ажлыг дүгнэж, ажилтнуудын тайлан хамгааллыг үндэслэн ажилтан тус бүрийг 78000 төгрөгөөр урамшуулсан.

Шийтгэлийн талаар: Захиргааны зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн

- Ажлын байран дээр хариуцлага алдсан жижүүрт сануулах арга хэмжээ
- Үүрэгт ажлаа дутуу хийж гүйцэтгэсэн 1 номын санчид цалингийн 20 хувийг 3 сарын хугацаатай хасах.,
- Үндсэн цалингийн 20 хувийн нэмэгдэл авдаг номын санч үүрэгт ажлаа хангалтгүй биелүүлсэн тул 20 хувийн нэмэгдлийг хагас жилээр хасах шийтгэл тус тус оногдуулсан байна. Ийнхүү тухай бүр нь шагнал, эсвэл ноогдох шийтгэлийг оногдуулан ажиллаж байснаар ажлын цагийн ашиглалт, ажлын үр дүнгийн гүйцэтгэл хэвийн хэмжээнд байна.

ГУРАВ: БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ- ҮНЭЛГЭЭ

Байгууллагын ажил үйлчилгээ зохих түвшинд байгаа эсэх, уншигч хэрэглэгчдийн сэтгэл хангамж ямар байгаа, байгууллагын тухайн жилийн болон мастер төлөвлөгөөний хэрэгжилт зохих түвшинд байгаа эсэхэд дүгнэлт хийхэд байгууллагын дотоод хяналт шинжилгээ чухал үүрэгтэй. ХНО-ноос энэ ажлын хүрээнд 2010 онд дараах ажлуудыг хийсэн байна. Үүнд:

- ХНО-ны захиргааны зөвлөлийн хурлыг 24 удаа хийж цаг үеийн болон төлөвлөгөөт ажлын талаар ярьж хэлэлцсэн байна.
- Байгууллагын "Ур чадварын нэмэгдэл олгох журам"-д зарим нэмэлт өөрчлөлтүүдийг тусгаж өгсөн.
- Байгууллагын танилцуулгыг шинэчлэн, танилцуулгыг "Болор судар" хэвлэлийн газраас 500 хувь үнэ төлбөргүй хэвлэж өгсөн.
- Захирлын 59 тушаал гарсныг төрөлжүүлэн авч үзвэл: шагнал, урамшуулал-7, ур чадварын нэмэгдэл олгох-2, ажилд томилох-9, буцалтгүй тусламж-12, ахмад өндөр настанд хүндэтгэл үзүүлэх-5, хариуцлагатай жижүүр томилох-3, соёлын арга хэмжээ зохион байгуулах-5, сургалт зохион байгуулах-5, ажлаас чөлөөлөх-3, цалингийн шатлал ахиулах-1, сахилгын арга хэмжээ авах -2, цалин шинэчлэн тогтоох тухай-1, тооллогын комисс томилох-4, томилолтоор ажиллуулах тухай-1 тушаал тус тус гаргажээ.
- Хүүхдийн номын ордны өмчийн тайланг файлаар болон хэвлэмэл хэлбэрээр Төрийн өмчийн хороонд гарган өгч 2010 оны гэрээ хийж дүгнүүлсэн.
- ХНО-ны болон Соёлын Төв Өргөөний эд хөрөнгийн тооллогыг хийж картыг 2 хувь үйлдэж ажилтан тус бүрээр гарын үсэг зуруулан нэгдсэн товчоог гаргасан.
- Уншигчдын санал хүсэлтийн хайрцгийг тогтмол ажиллуулж байна. Санал хүсэлт нь голдуу шаардлагатай ном хэвлэлийн талаар, мөн үйлчилгээний ажлын цаг ашиглалт, харилцааны соёлын талаар байлаа. Иймд хамт олны болон уншлагын хэлтсийн хурал хийж нийт ажилтнуудад цаг ашиглалт, зан харьцааны талаар анхааруулан үйлчилгээний соёлын талаар 2 удаагийн лекцэнд хамрууллаа.
- Мөн уншигчдыг хэрэгцээтэй номоор хангах, эрэлттэй номоор фонд бүрдүүлэх чиглэлээр танхим бүрт "Номын санал авах хайрцаг" аялуулж байна. Хэрэгцээт номын талаарх саналын хайрцагт ирсэн номын нэрсийн жагсаалтыг гарган ямар ном, хэдэн хүний санал авсан зэргийг тэмдэглэн, танилцуулж ном бүрдүүлэгчид нэрсийг хэвлэн өглөө. Уншигчдын саналт дүгнэлт хийхэд багш нарын гарын авлага болох сүүлийн үеийн шинэ сурганы чиглэлийн ном, С. Энхболд, Б.Энхболд нарын Retorika-г байлдан дагуулах урлаг, Баясгалангийн "Залуу хүний ширээний ном", Ц.Сэлэнгийн "Англи хэлний бүтэц зүйн дүрмийн бүрэн сурах бичиг", "Санхүү бүртгэл"-1,2 дэвтэр, "Санхүүгийн дунд шатны бүртгэл" 1,2 дэвтэр, "Нягтлан бодох бүртгэл", Солонгос хэл, биеийн тамир, анагаах ухаан, 1995 оноос хойш гарсан сурганы заах арга зүй, сэтгэл судлалын номнууд ховор байгаад дүгнэлт хийж нөхөн бүрдүүлэх номын жагсаалтанд оруулаа.

ДӨРӨВ: СТАТИСТИК МЭДЭЭНИЙ ЧАНАР, БАЙГУУЛЛАГА ИРГЭДИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, СУРТАЛЧИЛГАА

Лавлагаа номзүй, мэдээ мэдээлэл, сурталчилгаа:

2010 онд **"Шинэ номын мэдээ"** товхимолыг бүх уншлагын танхимуудад шинээр ирсэн 348 номоор гаргаж уншигчдын хүртээл болгохоос гадна хөдөө орон нутгийн ЕБС-ийн номын санч нарын гарын авлага болж ирсэн.

Уншигчдад лавлагааг амаар болон бичгээр өгөх: 2010 онд доорх лавлагааг бичгээр өгч үйлчилсэн. Үүнд:

- М. Догмид "Мэнд эгч" өгүүллэг, Ч.Ойдовын намтар уран бүтээл, Эрдэнэт үйлдвэрийн тухай, Мянганы хөгжлийн зорилтод хүүхдийн боловсролын талаар тусгасан тухай, О. Дашбалбар Ану хатанд зориулж бичсэн шүлэг, БСШУ-ны сайдын 2005 оны 441 тушаал, Шинэ гэр бүлийн ерөөлийн талаарх 4 мөрт шүлгүүд, Байгууллагын идэвхжүүлэлт, Интернэт-мэдээллийн хэрэгсэл болох нь, 2008 оны 134, 241 тоот ерөнхийлөгчийн зарлиг, Татварын хуулийн сүүлийн өөрчлөлт, С. Надмидын уран бүтээл, Д. Цоодол. Хуучин дэр модны дууль, Герман, Швейцарь улсуудын номын сангийн талаар монгол хэлээр, ЗГ-ын 1997 оны 88-р тогтоол, Хүүхдийн хүмүүжил төлөвшилд багш, сургалтын байгууллагын үүрэг, Монгол номын үүсэл хөгжил, МУҮНС-гийн захирал Г.Акимын "Ном хэвлэлийн талаар ерөнхийлөгчид бичсэн захидал", Монгол ардын аман зохиолын Дом шившлэгийн тухай, Цагаан дарь эхийн домог, Эндүүрэл хааны домог, Нараны-Гэрэл дагины тууж, Монгол хэлний гажуудлын талаар тогтмол хэвлэлд нийтлэгдсэн 5 нийтлэл, Хэрэглэгчийн онол, Пүүсийн онол, Холдинг, Корпораци, Хувцас үүссэн түүх, 1921 оны хувьсгалын гол төлөөлөгч болох Б. Шанзодва, Чимэддорж, Лувсанцэрэн, Б. Цэрэндорж нарын хөрөг зураг, Ардын төрийн түүх, Хиагтын гэрээ зэрэг болно. Эдгээр бичгийн 45 лавлагааг өгөгдсөн лавлагааны архивт архивлаж авсан.
- Каталогч нар 3785 аман лавлагаа, мэдээллийг уншигчдад өгч ажилласан байна. Үүнд: каталогийн тухай, номын сангаар үйлчлүүлэх, электрон каталогоос хайлт хийх, каталог ашиглах, захиалгын хуудас бичих, номоо хэрхэн сонгох талаар зөвлөгөө өгөх болон ахлах ангийн сурагчдын заавал унших зохиолууд, эртний зохиолууд, олон улсын байгууллагууд, төсөл хэрхэн бичих, зохиолчдын намтар болон бусад шинжлэх ухааны чиглэлээр уншигчдын асууж ирсэн төрөл бүрийн лавлагаанд хариу өгч ажилласан.
- 2010 онд ХНО-ны танхимуудын үйл ажиллагааг СДС-ийн дадлагын 2 оюутан, эчнээгийн 18 оюутан, 1-р сургуулийн 28 сурагч, УБИС-ийн 2 оюутан, Логим хэвлэлийн газрын менежер, Завхан, Говь-Сүмбэр, Өвөрхангай, Архангай, Увс, Сэлэнгэ, Говь-Алтай, Ховд, Хөвсгөл, Булган аймгуудын сургуулийн болон сумдын номын санчид, 4-Н төрийн бус байгууллагын 4 ажилтан, 24-р сургуулийн 2 багш 24 сурагч, Эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн 8 ажилтан, Хүүхэд хөгжил хамгаалал ТББ байгууллагын 2 ажилтан, Хүүхдийн эрхийн төвийн 4 ажилтан нийт 450- гаад хүмүүст танилцуулсан. Мөн хүүхдийн баярын арга хэмжээ, зөөврийн номын сангийн нээлт, "Хөдөөгийн боловсролыг дэмжих "Read" төслөөс хэрэгжүүлж буй "Ангийн номын сан" –гийн ном гардуулах ёслолын үеэр тус тус ХНО-ны танилцуулгыг 900-гаад уншигч, үйлчлүүлэгч, хүүхэд багачуудад тараасан.
- Мөн электрон шуудангаар хэрэгцээт мэдээ мэдээллээ авдаг үйлчлүүлэгчдийн тоо энэ жилийн хувьд урьд оныхоос 30% өссөн.

- 2003 оноос эхлэн ХНО-ны тогтмол хэвлэлд нийтлэгдсэн материалыг бүрэн эхээр нь шивж тайлбартай номзүйн жагсаалтыг хийж байна. Энэ онд энэхүү ажлыг үргэлжлүүлэн хийлээ.

Телевизүүдэд өгсөн ярилцлага, сурталчилгаа:

- 2010-01-17-нд Монгол улсын Ардын жүжигчин Сосорбарамтай хийсэн уулзалтын тухай TV-9-д “Боловсрол хөгжил” танхимын ажилтан Н. Адьяа ярилцлага өгсөн.
- UBS-ийн мэдээний албанд “Хуучин пянз”- ны үзэсгэлэнгийн талаарх болон танхимын танилцуулгыг Тайвань номын танхимын ажилтан Алимаа ярилцлага өгсөн.
- 2010-04-02 TV-9 телевизэд “Олон улсын хүүхдийн номын баяр”–ын арга хэмжээний тухай ярилцлага өгсөн.
- 2010-04-05-нд Хүүхдийн нэрт зохиолч, нийтлэгч, сэтгүүлч Ч. Аръяасүрэнгийн 70 насны ойд зориулсан уран бүтээлийн нээлтийн ажиллагаа болж, TV-9 телевизэд С. Тунгалаг ярилцлага өгсөн.
- “Хөдөөгийн боловсролыг дэмжих “Read“ төслөөс хэрэгжүүлж буй “Ангийн номын сан”–гийн ном гардуулах ёслолын ажиллагаа MNTV, TV-9, TV-8, ISBN, UBS телевизүүдэд тус тус ярилцлага өгсөн.
- 6-р сарын 1-ний баярын дугаарт “Хүүхдээ ном унших болгонд нь урамшуулж байгаарай” ярилцлага хийсэн.
- 2010-06-18-нд Герман мэдээллийн танхимаас зохион явуулсан кино өдөрлөгийн талаар танхимын ажилтан “Эх орон” телевизэд ярилцлага өгсөн.
- 2010-09-23-нд “Зөөврийн номын сан”- гийн нээлтийг Баянхошуунд байрлах Хүүхдийн төлөө газрын харьяа Олон Нийтэд Түшиглэсэн Хүүхэд Хөгжил Хамгааллын 3-р төв дээр хийлээ. Нээлтийн үйл ажиллагааг MNTV, TV-9, TV-8, ISBN, UBS, “Би” TV, C1 телевизүүдээр сурталчилсан.
- “Номын Яармаг”-ын хүрээнд ОНТХХХ-ын 3-р төв, “Сод номун” төвүүдэд хүүхдийн зохиолч Н.Мандал, Доржсүрэн, Г.Ганболд нартай зохиолч уншигчийн уулзалтыг хийж зөөврийн номын санг сурталчилах зорилгоор TV-9 телевизийн нэвтрүүлгийн бичлэгт н\с Баярмаа оролцлоо.
- 2010-11-23-нд Хүүхдийн нэрт зохиолч, нийтлэгч, сэтгүүлч Ч.Аръяасүрэн “Сүүлэнхүү 45 дахь жилдээ” үзэсгэлэнгийн талаар мэдээлэл бэлтгэж, 5 сонинд өгсөн.
- Олон Улсын хүүхдийн номын баярын мэдээг МОНЦАМЭ-д “Мөрөөдөл” танхимын ажилтан Батцэцэг, “Ардчилал”, “Үнэн” сонинд, сэтгүүлд Дарьсүрэн нар тус тус мэдээлэл өглөө.
- 2010-12-24-нд нийслэлийн 5-р сургуулийн 5-р ангийнханд “Англи зурагт том ном” бэлэглэх үеэр ХНО-ны явуулж байгаа арга хэмжээний талаар Монголын радиод ярилцлагыг Г. Дарьсүрэн өгсөн.
- Хүүхдийн номын ордон дээр болж байгаа үйл ажиллагааны тухай MNT, UBS, TV -5, TV-8, Монголын радиогийн Хурд агентлагт захирал Д.Оюунбилэг 6 удаа ярилцлага өгсөн.

Тогтмол хэвлэлд нийтлүүлсэн ярилцлага, сурталчилгаа:

- 2010-04-02-ний Олон Улсын хүүхдийн номын баярын мэдээг МОНЦАМЭ сонинд “Мөрөөдөл” танхимын ажилтан Батцэцэг, “Ардчилал”, “Үнэн” сонинд Дарьсүрэн нар тус тус мэдээлэл өгсөн.

- 2010-04-05-нд Хүүхдийн нэрт зохиолч, нийтлэгч, сэтгүүлч Ч. Аръяасүрэнгийн 70 насны ойд зориулсан уран бүтээлийн үзэсгэлэнгийн нээлтийн ажиллагааг "Зууны мэдээ" сонинд;
- 2010-04-22-ноос 26-нд болсон Увс, Архангай аймгийн ЕБС-ийн номын санчдын "ЕБС-ийн номын сан сургуулийн мэдээллийн төв болох нь" сургалтын талаар Үнэн сонинд захирал Д. Оюунбилэг, Увс, Архангай аймгийн номын санч нар ярилцлага өгсөн.
- 2010-09-23-ний "Зөөврийн номын сан"- гийн нээлтийг Баянхошуунд байрлах Хүүхдийн төлөө газрын харьяа Олон Нийтэд Түшиглэсэн Хүүхэд Хөгжил Хамгааллын 3-р төв дээр хийсэн. Зөөврийн номын сангийн нээлтийн үйл ажиллагааг МОНЦАМЭ сонинд;
- Сүүлэнхүү 45 дахь жилдээ үзэсгэлэнгийн талаар мэдээлэл бэлтгэж, МОНЦАМЭ, Үнэн, Зууны мэдээ, Ардчилал зэрэг 5 сонинд;

ТАВ: БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХАНГАМЖ, АШИГЛАЛТ

Хүүхдийн номын ордныг 2015 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөөний үндсэн хэсгийн нэг нь хүний нөөцийн асуудал юм. ХНО нь жил тутам өөрийн номын санчдыг шат дараалалтай мэргэшүүлэн бэлтгэх, давтан бэлтгэх, хэлний сургалтанд хамруулах асуудлыг анхааран авч үздэг. 2010 онд хүний нөөцийн асуудлаар дараах ажлуудыг хийлээ.

- Хүүхдийн номын ордны 2010 оны "Хүний нөөцийн судалгаа"-г шинэчлэн хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системд оруулж БСШУЯ-нд гаргаж өгсөн.
- Улсын хэмжээнд 756 ерөнхий боловсролын сургуулийн номын сан байдаг бөгөөд түүнд ажиллагсадын 80 орчим хувь нь мэргэжлийн бус хүмүүс ажиллаж байна. ХНО нь улсын хэмжээний бүх ЕБС-ийн номын сангийн заах арга зүйн төвийн хувьд тэдгээрийг сургалт семинарт хамруулах асуудал чухал байдаг. Иймд бид ХНО-ны мэргэжлийн ажилтнуудаа өөрсдийнх нь ажлын чиглэлээр мэргэшүүлэн дээрх номын санчдад сургалт явуулж байна. Хичээл заах болсноор тэд, өөрсдийн мэргэжлийн сэдвүүдээ гүнзгийрүүлэн үзэж, мэргэжлийн ур чадвар өсөх болсон. Одоогоор 8 ажилтан сургагч багшаар ажиллаж байна. Тэдгээрийн 4 нь магистр багш нар байгаа бөгөөд цаашид бусад багш нарыг магистр цолтой болгох асуудал дээр анхааран ажиллаж байна.
- **2010** онд арга зүйч Л.Батболор "Монголын ЕБС-ийн номын сангуудыг арга зүйгээр удирдах нь", ном зүйч С.Тунгалаг "Хүүхдийн уншлагыг удирдахуй" сэдвээр магистрын зэрэг хамгааллаа.
- Удирдлагын Академийн магистрийн сургалтанд Б.Хажидмаа суралцаж байна.
- Соёлын дээд сургуулийн бакалаврын зэрэг олгох зайн сургалтанд номын санч Д.Гантулга, Б.Аръяа, Т.Батцэцэг нар суралцаж байна.
- Архивын Ерөнхий газраас зохион байгуулсан "Архив, албан хэрэг хөтлөлтийн онол, арга зүй" 193 цагийн сургалтанд бичиг хэргийн эрхлэгч Б.Баяржаргал суралцаж төгссөн.
- Байгууллага хамт олны багаар ажиллах чадварыг сайжруулах зорилгоор нийт хамт олныг 5 багт хуваан харьцааны соёл, танин мэдэхүйн сэдвээр лекц тавих үйл ажиллагааг 2009 оноос эхлүүлсэн юм. Энэ онд өнгөрсөн жилийн Шилдэг багаар шалгарсан "Далд ухамсар" баг "Нууц" хэмээх өөртөө бүх нууцыг агуулсан гайхамшигтай номоор бэлтгэж хамт олноoo оролцуулсан. 2 дугаар багийнхан эрүүл ахуй, зөв хооллолтын сэдвээр "Амьдрахын тулд идэх үү, идэхийн тулд амьдрадаг уу" сэдэвт лекцийг бэлтгэж. 2010-04-30 нд ХНО-

ны бүх ажилтан, албан хаагчид болон Архангай, Увс аймгийн сургуулийн номын санчдад тавьсан.

Гадаад арга хэмжээ, сургалт

- 8-р сарын 9-нөөс 9-р сарын 25-нд герман уншлагын танхимын номын санч Г.Буянцэцэг ХБНГУ-ын Маннхайм хотын Гёте-Институтэд герман хэлний сургалтанд.,
- Захирал Д.Оюунбилэг АНУ-ын Нью-Иорк хотноо болсон "Номын яармаг"-ийн үйл ажиллагаанд.,
- Ажилтан Г.Дарьсүрэн, Г.Оюунтунгалаг нар Бээжин хотод болсон сургалтанд тус тус оролцсон.

Түүнчлэн энэ онд дараах сургалт семинаруудад ажилтан албан хаагчид хамрагдсан. Үүнд:

- **2010-01-19** "Татварын өөрчлөлтийн тухай сургалт"-нд нягтлан бодогч Г.Оюунтунгалаг
- **2010.01.26** "Хамт олны хөгжил", "Мөнгөн хуримтлалын бүлэг байгуулах" сэдвээр хийсэн "Хүний эрх хөгжил" төвийн ажилтан Л.Хонгорзулын лекцэнд байгууллагын ажилтнууд бүгд оролцлоо.
- **2010.01.27** Гёте-Институт дээр зохион байгуулагдсан "Номын чимэглэлийн урлагаар уншигчдын эгнээг өргөжүүлэх нь" сэдэвт сургалтанд хэлтсийн эрхлэгч Г.Буянцэцэг, ном зүйч С.Тунгалаг, арга зүйч Л.Батболор, хэлтсийн эрхлэгч Г.Дарьсүрэн нар оролцлоо.
- **2010.03.02** Монгол-Японы соёлын IV чуулганд Япон танхимын ажилтан Аръяа оролцов.
- **2010.04.25** Сэргээн засварлагч Б.Эрдэнэцэцэг, ном зүйч С.Тунгалаг нар Үндэсний номын сан дээр явагдсан "Цаасны бүтэц, фондын хадгалалт хамгаалалт" сэдэвт 1 өдрийн сургалт семинарт хамрагдсан.
- **2010.09.26-27** Гёте-Инстутээс зохион байгуулсан "Герман номын сан, түүний Дорно Азийн хадгалж хамгаалах хэрэглэх туршлага" сэдэвт семинарт сэргээн засварлагч Б.Эрдэнэцэцэг оролцов.
- **2010.09.28-29** Гёте-Институтын төлөөлөгчийн газраас зохион байгуулсан "Монголын нийтийн болон сүм хийдийн номын сан, музейн сан хөмрөгийн хуучин ном судрыг сэргээн засварлах, хадгалж хамгаалах нь" сэдэвт 2 өдрийн сургалт семинарт арга зүйч Л.Батболор, сэргээн засварлагч Б.Эрдэнэцэцэг нар оролцов.
- **2010.12.17** БСШУЯ, Соёл урлагийн хорооноос хамтран зохион байгуулсан "Монгол Улсан засгийн газраас бараа худалдан авах ажиллагаа" сэдэвт сургалтанд Б.Баяржаргал нар тус тус хамрагдсан байна.

ЗУРГАА: ИРГЭДЭД ҮЗҮҮЛСЭН УРЛАГ СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ, ЧАНАР ҮР ДҮН

Нийт 4300 уншигчдад шинээр үнэмлэх нээж, 63916 ирцэд 147793 ном олгож танхимуудаар үйлчилсэн.

- Зөөврийн номын сан ажиллаж эхэлсэнээс хойш одоогийн байдлаар 9 төвд 3 удаа 21-45 хоногийн хугацаатайгаар нийт 1425 ширхэг номыг хүргэж өгснөөр төвүүдэд зөвхөн ном уншихаар 2837 хүүхэд ирж, 2456 ширхэг номыг уншсан байна. Мөн соёл олон нийтийн дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Хүүхдийн Номын Ордноос 2010 онд уншигчид болон иргэдэд соёлын үйлчилгээний нэг болох ном сурталчлахдаа шинэ номын болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг сонирхолтой хэлбэрээр зохион байгууллаа. Мөн ХНО-оос зохион байгуулагддаг соёл олон нийт, мэдээлэл сурталчилгааны хүрээнд номтой холбоотой зохиолч, уншигчдын уулзалт, номын санг хамт олон болон хувь хүмүүст танилцуулах арга хэмжээ, номын баяр, залуу эцэг эхэд зориулан бага насны хүүхдэд уншуулах номыг сонгох заавар зөвлөмж танилцуулах, оюутан залууст зориулсан төрөл бүрийн лекц, уулзалт, бага насны хүүхдүүдийн дунд уран уншлага, гар зургын уралдаан тэмцээн зэрэг олон ажлыг явууллаа. Үүнд:

Номын үзэсгэлэн сурталчилгаа: Шинэ номын үзэсгэлэн сурталчилгаа болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн сурталчилгаа гэсэн 2 чиглэлээр үйл ажиллагаа явууллаа. Тухайлбал:

1. 2010 онд ХНО-нд ирсэн шинэ номуудаар танхимын ажилтнууд цаг тухайд нь “Шинэ номын үзэсгэлэн”-г 13 удаа 287 ш ширхэг номоор гаргаж хүүхэд залууст сурталчилж танилцуулсан.

№	Он сар өдөр	Сэдэв	Тоо ширхэг \ном\	Танхим
1	2010 . 01. 20	Шинэ ном	10	“Япон”
2	2010.1 сар	Шинэ ном	20	Герман
3	2010.01.28.	Шинэ ном	25	” БХ”, “Фонд”
4	2010.03.22.	Шинэ ном	41	“Монгол фонд”
5	2010.2 сар	Шинэ ном	15	Герман
6	2010.3 сар	Шинэ ном	21	Герман
7	2010.03.26.	Шинэ ном	10	“Орос”
8	2010.04.09	Шинэ ном	41	“БХ”, Фонд
9	2010.06.18	Шинэ ном	48	“БХ”, Фонд
10		Шинэ ном	12	“Их мэдэх”
11	2010.08.19.	Шинэ ном	14ш ном, 2DVD 2CD	Герман
12	2010.09.18	Шинэ ном	16ш	Герман
13	2010.11.03-19.	Шинэ ном	14ш	Тайвань
Бүгд		**Шинэ ном**	**287 ширхэг**	**8 танхим**

2. Сэдэвчилсэн номын үзэсгэлэнг тухайн үеийн үйл ажиллагаатай холбогдуулан зохион байгуулахаас гадна хүүхдүүдэд шинэ мэдээ мэдээлэл өгөх, мэдлэгт нь нэмэр болгохуйц хэмжээнд зохион байгуулахыг зорилгоо болгон ажилласан. 21 удаа 590 номыг үзүүлэн сурталчилсан байна. Үүнд:

№	Он сар өдөр	Сэдэв	Тоо \ном\	Танхим

1	2010.01.03.	“2009 оны хамгийн их уншигдсан ном”	16	” БХ”, “Фонд”
2	2010.01.04	Монгол Улс,БНХАУ-тай дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойд	40	” БХ”, “Фонд”
3	2010.01.16	ЕБС-ийн талаар	190	” БХ”, “Фонд”
4	2010 . 01. 20.	Монгол ардын үлгэр	30	“Их мэдэх”
5		Хүний хөгжилд	12	” БХ”, “Фонд”
6	2010.01.31.	“Багш та”	19	” БХ”, “Фонд”
7	2010.2.29-3.19	“Японы хүүхдийн зохиол”	16	““Япон”
8	2010.02.15.	Бага насны хүүхдэд зориулан “ Үргэлжилсэн үгийн зохиол”	20	“Их мэдэх”
9	2010.02.07	Сундуй зохиолчийн уран бүтээлээс	12	“Их мэдэх”
10	2010.03.21.	Олон улсын театрын баярт	32	” БХ”, “Фонд”
11	2010.03.22.	Монгол хүн сансарт ниссэний ойд	14	“БХ”
12		Ардын уран зохиолч, СГЗ, Яруу найрагч Д.Цоодолын уран бүтээлээс	9 ш	
13	2010.03.13.	Пянзны үзэсгэлэнд зориулсан	28	“Орос”
14		Хүүхдийн зохиолч Даваанямын уран бүтээлээс	12	“Мөрөөдөл”
15	2010.04.05	Хүүхдийн зохиолч Аръяасүрэнгийн 70 насны ой	6	“БХ” Фонд
16	2010.05.12	Ерөнхий шалгалтанд бэлтгэгчдэд зориулж	27	“БХ” Фонд
17	2010.06.05	А.С.Пушкины 211 жилийн ойд зориулан		
18	2010.08.03	“Номын анд” клубын номын үзэсгэлэнд	15	БХ
19	20106	Tofle-ийн шалгалтанд бэлтгэхэд туслах	18	Швейцарь
20	2010.09.03	“Соёл урлагийн ажилтны өдөрт”	28ш	БХ
21	2010.10.16	Дэлхийн хүнсчдийн өдөрт ” Эрүүл хүнс”	24 ш	БХ
22	2010.11.26	Улс тунхагласны 86 жилийн ойд“	28 ш	БХ
23	2010.12.16	“Ч.Арьяасүрэнгийн бүтээлийн үзэсгэлэнд”	12 ш	БХ
Бүгд		**Сэдэвчилсэн номоор**	**590**	

Соёлын ажил: ХНО дээр явагддаг соёл олон нийтийн, мэдээлэл сурталчилгааны ажлыг “Сургалт - танин мэдэхүйн лекц, хичээлээс гадуурх сургалт, үзүүлэнт танилцуулга”, “ХНО-оос уламжлал болгон явуулдаг ажлууд”, “Тэмдэглэлт үйл явдалтай холбоотой ажлууд” гэсэн 3 чиглэлээр явуулаа.

1. **Сургалт-танин мэдэхүйн лекц, хичээлээс гадуурх сургалт, үзүүлэнт танилцуулга**

2010 оноос 7 хоног бүрийн ням гаригт Монголын Сурагчдын Холбоотой хамтран уншигч залууст зориулан үлгэр жишээ болохуйц нэр хүнд бүхий хүмүүсээр лекц уншуулсан. Энэ онд нийт 20 удаа лекц зохион байгуулж 1400 гаруй уншигчид оролцсон байна. Лекторуудын гаргасан ном зохиол, уран бүтээл, намтар түүхээр нь танилцуулга буюу үзэсгэлэнг тухай бүрд нь гаргаж ирлээ. Лекцэнд оролцсон лектор, сэдвийг огноогоор харуулбал:

№	Сар өдөр	Сэдэв	Оролцогчид	Лекторууд
1	1 сарын 10	“Амьдрал өөрөө гайхамшиг”	86	МҮЭХ-ны тэргүүн Ганбаатар
2	1 сарын 17	“Уншихуйн гайхамшиг” “Залуу хүний ширээний ном”	100	МУГЖ Д.Сосорбарам ЭМШУИС-ийн оюутан Баясгалан
3	1 сарын 24	“Эрхэм баян эрдэм ном”	86	Шүүдэрцэцэг
4	1 сарын 31	“ Далд ухаан “	80	МСХ багш Даваажавын Гэрэлт-Од
5	2 сарын 01	“Багш “	52	МУТШ ардын уран зохиолч Ш Сүрэнжав
6	2 сарын 02	“Номын мөр”	56	МЗЭ шагналт хүүхдийн зохиолч О Сундуй
7	2сарын 28	“ Уран уншлага”	100	МУГЖ, СУДС багш Л .Чаминчулуун
8	3 сарын 7	“Ээждээ шивнэх үг” захидлын уралдаан “Далд авьяасаа хөгжүүлцгээе”	90	ТВ коктейль хамтлаг Өөскөө, Цоомоо нар
9	3 сарын 14	” Дэлхийн соёл “	80-85	МҮОНТ-ийн “Аялалын цаг” нэвтрүүлгийн хөтлөгч Г.Бадамсамбуу
10	3 сарын 28	“Яруу найраг”	80	Ардын уран зохиолч, СГЗ, Яруу найрагч Д.Цоодол
11	3сарын 29	“ Илтгэх урлаг”	75	Монголын оюутанд ээлтэй төвийн тэргүүн А. Гэрэлт –Од
12	3арын	Уран уншлага гэж юу вэ?	120	Соёлын гавьяат жүжигчин Равдан
13	4сарын4	“Би Монголдоо юу хийж бүтээх вэ?”	80	МСХ-ны тэргүүн С.Сэлэнгэ
14	4арын18	“Уран ухаан”	75	Зураач сийлбэрч, уран барималч Н.Оргил

15	4сарын 25	“Өөрийгөө хөгжүүлэх ба амьдрах ур чадвар”	75	МУГБагш Ц.Түвшинтөгс
16	5сарын 5	“Номын эрүүл ахуй”	75	Г. Дарьсүрэн
17	5сарын 05	“Номтой яаж нөхөрлөх болон дэлхийн шилдэг зохиолууд”	80	ЭМШУИС-ийн оюутан П.Баясгалан
18	8 сарын 2	“Амьддаа бие биенээ хайрлая” лекц	80	МСХ-ны тэргүүн С.Сэлэнгэ
19	8 сарын 2	Сэлүүн орчлонгийн сиймхий	40	Зохиолч Б. Лхагвасүрэн
20	8 сарын 5	“Мэдлэг хүлээн авах арга барил”	60	ХНО-ны номын санч Н.Адъяа, Номын нөхөр клубын ахлагч Эрдэнэцацрал нар
20 удаа			**1490 орчим**	**23 хүн**

2010 оноос эхлэн явуулж байгаа: “Герман номын сан-герман номтой танилцах” сэдвийн хүрээнд танхимын үйл ажиллагааг сурталчлах үзүүлэн таниулах арга хэмжээг дараах ЕБСургууль, оюутан сурагчдыг хамран сард 2 удаа, бүгд 21 удаа зохион байгуулж, 265 оролцогч /үүнээс сурагч 148, бусад 117/, давхардсан бус тоогоор 14 багш нийт 279 хүн хамрагдлаа**.** Үүнд :

№	**Он сар өдөр**	**Сургууль анги**	**Хамрагдсан тоо**	**Багш**
1	1 сарын 12	18-р сургуулийн 2в анги	8 сурагч	Герман хэлний багш Г.Алтантуул
2	1 сарын 20	Гёте Институтийн герман хэлний курс	Анхан шатны 20 оролцогч	Герман хэлний багш Скипио И. Жем
3	2 сарын 10	18-р сургуулийн 8б, 9а, 10в анги	герман хэлийг сонгон суралцаж буй 15 сурагч	Герман хэлний багш Гритт Ханн
4	2 сарын 20	18-р сургуулийн 11б анги	15 сурагч	Герман хэлний багш Гритт Ханн
5	3 сарын 11	38-р сургуулийн 10-р анги	10 сурагч	Герман хэлний багш Ш. Цэрэндолгор
6	3 сарын 22	Гёте Институтийн герман хэлний курс	Анхан шатны 19 оролцогч	Герман хэлний багш Скипио И. Жем
7	4 сарын 13	18-р сургуулийн 7г анги	герман хэлийг сонгон суралцаж буй 9 сурагч	Герман хэлний багш Г.Алтантуул

8	4 сарын 27	18-р сургуулийн 9в анги	герман хэлийг сонгон суралцаж буй 7 сурагч	Герман хэлний багш Г.Алтантуул
9	5 сарын 14	“Extra Tour” сургалтын төв	8 оролцогч	Герман хэлний багш Ц.Болорчимэг
10	5 сарын 26	Гёте Институтийн герман хэлний курс	Анхан шатны 15 оролцогч	Герман хэлний багш Скипио И. Жем
11	6 сарын 4	“Гёте” сургууль	Зуны сургалтанд оролцогч 8 сурагч	Герман хэлний багш Ж.Үнэнбат
12	6 сарын 17	Ховдын Их Сургууль	герман хэлний 3-р курсийн 8 оюутан	Герман хэлний багш М.Өлзийсайхан, Руди Паули
13	6 сарын 30	18-р сургуулийн 10б анги	18 сурагч	Герман хэлний багш Г.Алтантуул
14	8 сарын 11	Гёте-Институтийн герман хэлний курс	Анхан шатны 8 оролцогч	Герман хэлний багш н. Мөнхтуяа
15	9 сарын 22	МУБИС-ийн герман хэлний 2-р курс	Дунд шатны 9 оролцогч	Герман хэлний багш Франк Рихтер
16	9 сарын 29	38-р сургууль	8-ийн “5” анги.	Герман хэлний багш Ц.Оюунхишиг
17	10 сарын 4	ХУИСургуулийн герман хэлний ангийн 2-р курс	7 оюутан	герман хэлний багш Б.Болормаа
18	10 сарын 20	“Гёте” дунд сургуулийн 7а анги	16 сурагч	Герман хэлний багш Н.Эрдэнэцэцэг
19	11 сарын 04	18-р сургуулийн 9г анги	17 сурагч	Герман хэлний багш Г.Алтантуул
20	11 сарын 17	38-р сургуулийн 2-5 анги	6 сурагч	Сайн дурын ажилтан Elene Berndt
21	12 сарын 3	Гёте-Институтийн герман хэлний курс	25 оролцогчид	Герман хэлний багш Леане

Их мэдэхийн “Үлгэрийн цаг” 2010.09.18-аас эхлэн хагас сайн өдөр болгон хүүхдүүдэд үлгэрийн цагаар 1-р ангийн програмд орсон үлгэрүүд ярьж өгөхөөс гадна зургийг нь зуруулах үлгэрийг буцаан яриулах, тэмдэглэл хөтлүүлэх зэрэг бүтээлч ажлуудыг хийлгэж ирлээ. 8 удаа 80 гаруй хүүхдэд танилцуулсан. Танилцуулсан үлгэрүүдээс үзүүлбэл:

Монгол ардын үлгэр

Ухаантай туулай

Эвтэй 4 амьтан

Алтан өндөгт тахиа

В. Сутеев “Тахиа”



Манжин

2. **ХНО-оос уламжлал болгон явуулдаг ажлууд:**

2010.01.17. ХНО ны хамт олон жил бүрийн 12 сард ХНО-оос зохиогдсон ажилд идэвхтэй оролцсон, хамгийн олон удаа ирж ном уншсан хөдөлмөрч идэвхтэй уншигч хүүхдүүдээ шалгаруулдаг уламжлалтай билээ. Энэ жилийн арга хэмжээг улсын хэмжээгээр гахайн ханиад гарсантай холбогдуулан шинэ жилийн баяр хийхийг хориглосон учраас 2010 оны 1 сарын 17 нд шилдэг уншигчийн шагналыг гардуулах ёслолын арга хэмжээг явууллаа. 2009 онд Манай хүүхдийн номын ордон 2009 онд 9 танхимтайгаар үйл ажиллагаагаа явуулж ирлээ. Нийт 62849 ирцэд 135853 ширхэг ном олгож үйлчилжээ. Хүүхдийн Номын ордны шилдэг уншигчдад шагнал гардуулах ёслолын ажилд Монгол улсын гавьяат жүжигчин Д.Сосорбарам уригдан ирж хүүхэд бидэнд сонирхолтой лекц хийхийн ялдамд Нацагдоржийн нэрэмжит "Тэргүүний уншигч" цол тэмдэг болон Хүүхдийн Номын ордны тэргүүний уншигчийг шалгаруулан шагнал гардууллаа. "**Боловсрол хөгжил" танхимаас** Пүрэвсүрэнгийн Баясгалан ЭМШУИС-ийн оюутан Нацагдорж тэмдэгтэн, шилдэг уншигчийн өргөмжлөл, 1 жил үнэ төлбөргүй гэрээр ном авах эрхийн батламж, Мягмардоржийн Ганзориг МУИС-ийн ЭЗС-ийн 3-р курсын оюутан Нацагдорж тэмдэгтэн, Шилдэг уншигчийн өргөмжлөл, хагас жил ном авах эрх, Нагаан Эгшиглэнт Монгени сургуулийн 10е ангийн сурагч Шилдэг уншигчийн өргөмжлөл, 1 улирал үнэ төлбөргүй гэрээр ном авах эрхийн батламж, Ганбаатарын Дуулим 5-р сургуулийн 8 а ангиийн сурагч Шилдэг уншигчийн өргөмжлөл, 1 улирал үнэ төлбөргүй гэрээр ном авах эрхийн батламж 5 оюутан, сурагч **Герман Уншлагын танхим:** Бат-Эрдэнийн Мөнхзул Орхон Их Сургуулийн 3-р дамжааны оюутан Шилдэг уншигчийн өргөмжлөл, Нацагдорж тэмдэг, 1 жил үнэ төлбөргүй гэрээр ном авах эрхийн батламж, номын шагнал, Батсайханы БатбилэгШУТИС-ийн 3-р дамжааны оюутан Шилдэг уншигчийн өргөмжлөл Нацагдорж тэмдэг, Хагас жил үнэ төлбөргүй гэрээр ном авах эрхийн батламж, Олзвойн Хатанбаяр ШУТИС-ийн 3-р дамжааны оюутан Шилдэг уншигчийн өргөмжлөл, 1 улирал үнэ төлбөргүй гэрээр ном авах эрхийн батламж, номын шагнал зэрэг 5 оюутан, **Мөрөөдөл танхимаас**: 3 сурагч, "**Их мэдэх" танхимаас** 3 сурагч, Орос, Япон, Швейцарь танхимаас тус бүр 1 оюутныг шалгаруулан шагналаа. Манай ХНО-ы шагнал нь тэргүүний уншигчийн өргөмжлөл , хагас жил үнэ төлбөргүй гэрээр ном авах эрхийн батламжаар шагнадаг юм.

2010.04.02. "Олон Улсын Хүүхдийн баяр"-ыг ХНО-ы хамт олон жил бүр уншигчидтайгаа хамтран тэмдэглэдэг уламжлалтай билээ. Энэ жилийн Номын

баярыг бид өдөрлөг хэлбэрээр зохион байгуулсан юм. Номын баяраар дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. 5 сарын эхний 7 хоногт болох уншлагын 7 хоног аяны зарыг түгээж, танхим бүр номын тухай танилцуулга хийлээ. Мөн танхимын уншигчид өөрсдийн урлагийн номероо сонирхуулав. Жишээ нь: Япон танхимаас япон хэлний сурах бичиг "Minng no Nihongo" –г танилцуулж 46-р сургуулийн 7-р ангийн сурагч Хулан япон дуу, "Их мэдэх" танхимын бяцхан уншигчид дуу шүлгийн дээжээсээ, "Lehr und Uebungsbuch der deutschen Grammatik. Aktuell" номын 3 хувилбарыг CD-ROM-ын хамт танилцуулж, уншигч Баясгалан герман шүлэг уншлаа. Гар зургийн уралдааныг 2 насны ангиллаар явуулсан. Мөн хүүхдүүд тэдний эцэг эхэд зориулсан ном унших, уншуулах аргын тухай лекц зохион байгуулсан.



2010оны 05 сарын 1ээс 7 ныг дуустал "Уншлагын 7 хоног" аяныг явууллаа. Хөтөлбөрийн дагуу : 2010.05.01-2 Монгол бичгийн уралдаан

Бичиг соёлын хишиг өдрийн хүрээнд Хүүхдийн Номын Ордон, Сод Номун Төв төрийн бус байгууллага хамтран "Үндэсний бичиг мину" улсын 5-р уралдааныг 5 дахь жилдээ амжилттай зохион явууллаа. Уралдаанд хот хөдөөгийн 350 гаруй хүүхэд залуус оролцлоо. Уралдаанд нийслэлийн сургуулиудаас гадна Булган, Архангай, Хэнтий, Төв, Хөвсгөл зэрэг аймгийн ЕБС-ийн сурагчдаас ирж оролцсон. Насны онцлогоор нь 4-5 анги, 7- 8 анги , 9 -11 анги , оюутан залуус гэсэн 4 ангилалаар 2 үе шаттайгаар амжилттай явуулсан. Шагналыг Нас тус бүрт 5 хүүхэд шалгарууллаа.

С. Алтанцэцэг Хүмүн бичиг сонины эрхлэгч

Б. Тогооч Доктор. профессор. ХИДС-ийн багш

Ш. Алтанцэцэг Улсын архивын архивч

И. Өнөрзул. Док дэд профессор Гурван-Эрдэнэ дээд сургуулийн багш

Т. Нармандах. Док дэд профессор Их Монгол дээд сургуулийн багш

Д. Лхагважав. Соросын сангийн мэргэжилтэн

Мөнхцэцэг. Магистр Орхон Их Сургуулийн багш нарын 7 шүүгч ажиллаа.

Аяны 2 дахь өдөр. 2010.05.04. "Их мэдэх" танхимд: Цэцэрлэг болон бага сургуулийн сурагчдад номын санг танилцуулах 74-р цэцэрлэгийн сугар багштай ахлах ангийн хамт олон, 24-р сургуулийн 4-р ангийн хамт олныг эцэг эхийн хамт урин номын сан, их мэдэх танхимын тухай танилцуулсан.

Оросын алдарт хүүхдийн зохиолч Сутеевын Хоёр үлгэр зохиолыг Power point програмаар бэлтгэн үзүүлж номын тухай ярилцав. Ном үзүүлсэний дараа хүүхдүүд муур зурж, тахиаг будаж сурав. Энэ үзүүлэнт ажилд 75-р цэцэрлэгийн Сугар багштай 30 хүүхэд 24-р сургуулийн Отгонцэцэг багштай 4-р ангийн 28 хүүхэд нийт 58 хүүхэдэ оролцлоо. Гарын доорх материалыг ашиглан номын хавчуурга хийхийг сайн дурын ажилтан Цацаа хүүхдүүдэд зааж өгч хийлгэв. Арга хэмжээ дуусахад япон танхимаас жижиг хэмжээний 1 ном өөрсдийн хийсэн номын хавчуургатай нь хамт бэлэглэв.

Аяны 3 дахь өдөр 2010.05.05. " Шидэт номын найзууд" уран үгсийн чуулганыг Хүүхдийн Номын Ордон Хүүхдийн Зохиолчдын Пэн төвтэй хамтран 2010 оны 5 сарын 5 нд анх удаа Хүүхдийн Номын Ордонд зохион байгууллаа. Уралдааныг ХНО, ХЗын Пэн төвөөс гадна "Аз хур" компаний "Болор судар" хэвлэлийн газраас ивээн тэтгэж явууллаа.

Энэ уралдаанд Хүүхдийн 15 зохиолчийн 32 бүтээлийг хүүхдүүд урнаар уншиж уралдсан юм. 32 бүтээлээс шүлэг 20, дуу 4, өгүүллэг 8 бүтээлийг хүүхдүүд урнаар уншиж сонирхууллаа.

Энэхүү тэмцээний өгүүллэгийн төрөлд: Б.Пүрэвсүрэнгийн "Дүрсгүйчүүд" өгүүллэгийг уншсан 2-р сургуулийн Энхтөр, Д.Батжаргалын "Ганц улаан гамбир" өгүүллэгийг уншсан Ганбаатар, Доржсүрэнгийн "Том чих"өгүүллэгийг уншсан

Хандмаа, Мандалын “Түнтүүш” өгүүллэгийг 14-р сургуулийн 7 е ангийнхан уншиж эхний 4 байрыг эзэллээ.

Шүлгийн төрөлд: Батноовын “Хотын охин” шүлгийг 116-р сургуулийн сурагч **,** Дашдондогийн “Энэ хэний ээж вэ?” сурагч Эрдэмтэн **,** Доржсүрэнгийн “Олзны амт” шүлгийг Сайнжаргал**,** Наранцэцэгийн “Хэцүү хувцас” шүлгийг Хонгорзул**,** Мандалын “Гэрийн даалгавар” шүлгийг 14-р сургуулийн сурагч Ганбаатар нар урнаар уншиж түрүүлэв.

Дууны төрөлд: “Сод эрдмийн өргөө” дууг дуулсан 28-р сургуулийн сурагчид, “Дүрсгүйчүүд” дууг дуулсан Анар, Тамир 2 тус тус эхний байрыг эзэллээ.

Аяны 4 дахь өдөр. 2010 оны 5 дугаар сар 6. “Боловсрол хөгжил” танхимд

ХНО-ы идэвхтэн уншигч ЭМШУИС-ийн оюутан Баясгалангийн “Ном унших ач тус”, “Боловсрол хөгжил” танхимын ажилтан Баярмаа ном унших эрүүл ахуйн сэдвээр лекц уншлаа.

Аяны 5 дахь өдөр: Япон танхимд: 2010. 05. 07-нд Япон танхимд Японы хүүхдийн баярыг Сурагчдын холбооны япон хэлний дугуйлангийн хүүхдүүдтэй хамтарч мөрөг загас хийж тэмдэглэж “Уншлагын 7 хоног”аян өндөрлөлөө.

2010.06.01. Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт Баянзүрх дүүргийн Бадамлянхуа асрамжийн төвийн хүүхдүүд болон ХНО-ы уншигчид 80 гаруй хүүхэд багачууд оролцов. Баярын энд өдрийг ХНО, “Болор судар” хэвлэлийн газрын хамт олон, “Black Morgan ink” компаний хамт олон ивээн тэтгэж хүүхдүүдэд ном бэлэг бэлэглэж ICE TOP –ийн залуус хувцас бэлэглэлээ. Мөн хүүхдийн зохиолчид уран бүтээлийн дээжээсээ уншиж сонирхуулсанаас хамгийн сонрхолтой нь 12 настай Нэмүүцэцэг охин байлаа. Авьяаслаг бяцхан охин маань шүлэг зохиодог. 9 настайдаа “Хэний ч мэдэхгүй ордон” номоо гаргасан юм байна. Бяцхан уран бүтээлч Батжаргалын Нэмүүцэцэг охин өөрийн бүтээлийн дээжээсээ үеийн олон найз нартаа уншиж сонирхуулсан юм.

Баярт оролцож байгаа хүүхдүүдийн дунд гадна талбайн гар зургийн уралдааныг С.Тунгалаг, Б.Баяржаргал, Б.Баярмаа, Батцэцэг нар хамтран зохион байгуулж 30 хүүхэд оролцлоо. 2 насны ангиллаар оролцсон тэмцээнд нас тус бүрт 2 хүүхэд шалгаруулан урамшууллаа.

Монгол Улсын Гавьяат багш Түвшинтөгс өөрийн бүтээл Монголын Хүүхдийн байгууллагын 85 жилийн ойд зориулсан “Хойчийг залгамжлагчид” шинэ номынхоо дээжээс ХНО-д 5 хувийг бэлэглэлээ.

2010.11.11-13 “Номын Яармаг - 2010” ажлын хүрээнд “Шидэт Номын Найзууд” арга хэмжээг 2010 оны 11 сарын 19 өөс эхлэн 1 сарын хугацаанд “Их мэдэх” танхимд зохион явууллаа. Азийн сан, ХНО-оос хамтран явуулсан **“ Англи том номын өдөрлөг”-**т Нийслэлийн 20 сургуулийн 5-7 ангийн сурагчдыг хамруулж тусгайлан нэг номыг сонгож танилцуулснаас гадна арга хэмжээнд оролцсон сургуулиудын англи хэлний танхимд 15 нэр төрлийн 15 ш номыг бэлэглэв. Энэхүү ажлын хүрээнд англи том номын үзэсгэлэнг гаргаж, номын санч С.Туяа, “Их мэдэх” танхимын номын санч Г.Дарьсүрэн нар хамтран ажиллаа. Дээрх арга хэмжээнд 20 сургуулийн 360 сурагч, 20 багш оролцлоо.

Тэмдэглэлт үйл явдалтай холбогдсон ажлууд:

2010.01. 06. Монгол улс Хөрш БНХАУ-тай дипломат харилцаа тогтоосны нэгэн жарны босгон дээр хоёр улсын харилцааны 60 жилийн хөгжил, өрнөлийг харуулсан "НАЙРАМДАЛ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ НЭГЭН ЖАРАН" номыг Хөдөө орон нутгийн номын сан, нийтийн номын сан, Их дээд сургууль болон ЕБС-ийн 400 гаруй номын санд бэлэглэх "Ном гардуулах ёслол"-ын ажиллагаа хүүхдийн номын ордны "Боловсрол хөгжил" танхимд болсон. Энэхүү ном нь Монгол улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны хамт олноос дипломат харилцааны 60 жилийн түүхт ойд зориулсан гарсан бэлэг юм. "Ном гардуулах ёслол"-ын ажиллагаанд Монгол–Хятадын харилцааны 60 жилийн ойн арга хэмжээний номоор зургийн үзүүлэн гаргав.

2010.02.17- 03.02. ХНО-нд зохион байгуулсан Германы өнөө үеийн хүүхдийн номын зургийн үзэсгэлэнгийн бэлтгэл ажилд ХНО-ы ажилтнууд оролцлоо. Тус үзэсгэлэнд тавигдсан герман зурагт номыг орой бүр танхимд оруулан хянаж, сурталчлав. Үзэсгэлэнгийн үеэр танхимын хүүхдийн номноос сонгож танин мэдэхүйн болон хүүхдийн уран зохиолын зэрэг номнуудаар бүх танхимуудаас үзэсгэлэн гаргав.

2010.03.10. "Black Morgan Ink" компаний залуустай хамтран "Хүүхдэд буруу байхгүй" сэдвийн хүрээнд "Бадамлянхуа" асрамжийн төвийн хүүхдүүдэд ном гардуулах ажилд ХНО-ыг төлөөлөн "Их мэдэх" танхимын ажилтан Дарьсүрэн оролцлоо. Бадамлянхуа асрамжийн төвд 150 гаруй хүүхдүүд амьдардаг бөгөөд 80 гаруй хувь нь бүтэн өнчин хүүхдүүд байлаа. Энэ буяны ажлаар TV-9 телевизийн "Хоолондоо" нэвтрүүлгийн Энхээтэй хамт, дуучин Ану нартай хамтран хүүхдүүдийг тоглуулах, хоол хийж өгөх, Magic game тоглоомын газарт тоглууллаа. TV-9, NTV телевизээр тус бүр 2 удаа нэвтрүүлэг цацагдлаа.

2010.03.10. Тайвань танхимд 2010 оны 3-р сарын 10-наас 4-р сарын 2 хүртэл "Хуучин пянзны үзэсгэлэн" гаргалаа. Үзэсгэлэнг хувиараа пянз цуглуулагчтай хамтарч ХНО -ы фондонд байгаа оросын болон социалист орнуудын хөгжмийн зохиолчдын бүтээл, сонгодог хөгжим, дуурийн дуу зэрэг нийт 1000 гаруй пянз, хөгжмийн зохиолчдын намтар, уран бүтээлийн талаарх орос хэл дээрх нийт 28 ш номоор гаргасан. "Хуучин пянзны үзэсгэлэн"-гийн талаар "N" music, "S" music, "B" цэг ТҮ-гийн хөгжмийн нэвтрүүлэг, C-1-ийн хөгжмийн нэвтрүүлэгт орсон. Мөн UBS-ийн мэдээний албанд үзэсгэлэнгийн талаарх болон Тайвань танхимын танилцуулгыг бэлтгэж өглөө.

2010.03.18. Мөрөөдөл танхимд МУСГЗүтгэлтэн, МЗЭ-ийн шагналт хүүхдийн зохиолч Д,Даваанямтай уншигч сурагчдыг уулзуулж "Зохиолч уншигчийн уулзалт" зохиов. Д. Даваанямын 12 ш бүтээлээр номын үзэсгэлэн гаргав. Даваанямын намтар уран бүтээлээс "PowerPoint" программ ашиглан хийсэн үзүүлэнг уулзалтын үеэр уншигчдад танилцуулав.

2010.03.20. "Германы боловсролын яармаг"-т ГМНС, Швейцарь танхимууд оролцож танхимын үйл ажиллагааг сурталчиллаа. Герман, Швейцарь танхимын танилцуулгыг тус бүр 250 хувь хэвлэж оролцогчдод тараав.

2010.04.05 Мөрөөдөл танхимд Хүүхдийн зохиолч Аръяасүрэнгийн 70 насны ойд зориулсан үзэсгэлэн гарлаа. Мөрөөдөл танхимын номын санч Батцэцэг зохиолчийн намтар уран бүтээлийн үзэсгэлэнгийн 20 хуудас сонингийн хайчилбар, 13 хуудас фото зургийн үзэсгэлэнг гаргав. "Боловсрол хөгжил" танхимд 7 хоног Хүүхдийн зохиолч, эрдэмтэн Аръяасүрэнгийн фото зургийн үзэсгэлэн, номын үзэсгэлэн, хэвлэмэл материалын үзэсгэлэнг тус тус гаргасан.

2010.04.24. ХНО, "Адмон" ХХК тай хамтран Эцэг эхчүүдэд зориулан номын тухай, бага насны хүүхдийн насны онцлогийн талаар чөлөөт ярилцлагыг явуулав. Энэ ярилцлагад 30 гаруй эцэг эх, Адмон компаний захирал Энхбат, "Их мэдэх" танхимын номын санч Дарьсүрэн нар оролцлоо. Эцэг эхчүүдээс санал асуулга авлаа. Мөн эцэг эхчүүд хүүхдээрээ ном уншуулахдаа юуг анхаарах, ямар номыг сайн гэдэг, эрүүл ахуйн талаас нь юуг анхаарах, номын ач тусын тухай товчхон үзүүлэн гаргаж мэдээлэл хийлээ.

2010.06.06. НҮБ-аас 6 сарын 06-ны өдрийг Орос хэлний өдөр болгон зарлалаа. Энэ өдөр Оросын аугаа их яруу найрагч А.С.Пушкины мэндэлсний 211 жилийн ой билээ. Энэ тэмдэглэлт өдрийг тохиолдуулан Орос номын уншлагын танхимаас сургуулийн бага ангийн сурагчдын дунд "Алтан загасны үлгэр"- ийн баатруудыг хэн сайн зурах вэ?" гар зургийн уралдаан зарлаж сайн зурсан 2 сурагчийг шалгаруулан дурсгалын зүйл өргөмжлөл гардуулж урамшууллаа. Уралдаанд ирүүлсэн бүтээлээр "Боловсрол хөгжил" танхимд үзэсгэлэн гаргасан нь хүүхдүүд, эцэг эхчүүдийн талархалыг хүлээлээ.

Энэхүү ажлыг цаашдаа жил бүрийн 5 сарын 09-ны өдөр орос хэлний сургалттай сургуулиудын дунд явуулж байхаар боллоо.

2010. 7 сар: МСХ-той хамтран Номын нөхөр клубын Зуны уншлага эхэллээ. Энэ ажлын хүрээнд БХ танхимд: **7 сарын 5 нд** МХЗохиолч О. Сундуй, Г. Ганболд , Б. Лхагвасүрэн нартай хамтран уран зохиолын номоор дүр бүтээх тоглолт, шүлэг зохиох, өөрийн зохиосон дөрвөн мөртөөр жүжигчилсэн тоглолт хийх зэрэг арга хэмжээг зохион явуулсан. МҮОНР-ийн Боловсрол нэвтрүүлэгт зуны лекцын талаар болон нүүдлийн номын сангийн үйлчилгээний талаар товч ярилцлага 2 удаа өгсөн. Зуны уншлагын үеэр явуулсан ажлуудыг төрөлжүүлэн харуулбал:

Лекц:

- **8 сарын 2 .**МСХ-ны тэргүүн С.Сэлэнгэ "Амьддаа бие биенээ хайрлая" лекц,
- **8сарын 5.** "Мэдлэг хүлээн авах арга барил" лекц хийлээ. ХНО-ны номын санч Н.Адъяа, Номын нөхөр клубын ахлагч Эрдэнэцацралтай хамтран

Уралдаан тэмцээн:

- **7 сарын 24.** Өсвөрийн 333 сургагч багш бэлтгэх үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулагдсан "Уран уншлага"-ын тэмцээн
- **8 сарын 4.** "1000-англи үгийн" уралдаан
- **8 сарын10** Америкийн 4-Н хүүхдийн хөгжлийн байгууллагын Монгол дахь салбараас зохион явуулсан "Номын анд" уралдаанд 3 хүүхэд бэлдэж амжилттай оролцуулснаас А.Цэрэндолгор 1-р байранд шалгарсан.
- **8 сарын18** "Уран зохиолын дүр"ийн жүжигчилсэн тоглолтонд 8 хүүхэд бэлдэж оролцуулсан.
- **8 сарын 25** МСХ-оос ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдаж байгаа өсвөрийн 333 сургагч багш бэлтгэх хаалтын үйл ажиллагаанд оролцсон.

Ном танилцуулах ажил:

- Б.Лхавгасүрэнгийн "Сэлүүхэн орчлонгийн сиймхий"
- Дэлхийн сонгодог 50 ботиос Алтан буман дахь лишийн цэцэг, Тансан лам баруун этгээдээд зорчсон нь зэрэг номоор шинэ номын мэдээлэл хийсэн.

- 4Н ТББ-ын “Номын анд” уралдаанд оролцож байгаа “Сод Номун төв”-ийн 21 хүүхдүүдэд хүүхдийн зохиолч П.Хорлоогийн намтар уран бүтээлээс танилцуулж түүний уран бүтээл болох “Алт мөнгө 2“ үлгэрийг уншиж өгч харилцан ярилцлсан зэрэг ажлуудыг энэ онд хийж гүйцэтгэжээ.

ДОЛОО: АЖИЛЧДЫН НИЙГМИЙН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТАЛААР ХИЙСЭН АЖИЛ, ҮР ДҮН

ХНО-ны ажилтан албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар энэ онд дараах ажилуудыг хийлээ.

- Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн 5.1.3-ийн хүрээнд “Ур чадвар нэмэгдэл”–ийг нийт 17 ажилтанд, зэргийн нэмэгдэл 6 хүнд олгосон байна.
- Дэлхийн банкны “READ” төслийн хүрээнд ном түгээх ажилд хамтран ажиллаж ХНО-ны 12 ажилтанд нэмэгдэл цалин олгуулсан.
- Нийт 23 ажилтанд буцалтгүй тусламж, урамшуулал олгосон.
- Байгууллагын дотоод журмын дагуу 14 хүнд буцалтгүй тэгтэмж олгосон байна.
- Мөн жилийн эцсийн ажлын үр дүнг үнэлэн 4 ажилтанд мөнгөн шагналын урамшуулалт цалин олгосон.
- Цагаан сар, ахмадын өдрөөр номын сангийн ахмад ажилтнуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүллээ.
- Энэ жил Соёл урлагийн ажилтны өдрөөр үйлчлэгч Ч.Нэргүй “Соёлын тэргүүний ажилтан” цол тэмдгээр, Т.Батцэцэг МҮЭ-ийн байгууллагын “Соёлын тэргүүний ажилтан” цол тэмдгээр, номын санч З.Алтанцэцэг “МҮЭ-ийн хүндэт тэмдэг”-ээр шагнагдсан.
- Зун хамт олноороо Хэнтийн аймгийн байгалийн үзэсгэлэнт газруудаар явж амарсан.
- Баянзүрх дүүргийн Налайх тосгонд газар тариалангийн зориулалтаар ажилчдын хэрэгцээнд 2 га газар авсан.
- “Сориг интеграц” эмнэлгийн их эмч Загдсүрэнгээр “Зохистой хооллолт, урт наслахын нууц” лекцэнд бүх ажилтнууд, МҮНС, ХТНС болон ЕБС-ийн 100 гаруй номын санчдын оролцуулан зохион байгуулсан зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

НАЙМ: БАЙГУУЛЛАГЫН ОРЧИН, ХАНГАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Энэ ажлын хүрээнд энэ онд дараах ажлуудыг хийсэн байна. Үүнд:

- Герман уншлагын танхимд Гёте институтээс 3 сая 700 мянган төгрөгний хөрөнгө оруулалт хийсний үр дүнд техник тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийж чадлаа.
- Мөн энэ онд БСШУЯ-наас ашиглагдаж байсан 5 компьютер, Койка байгууллагаас 1 компьютер шинээр авч өгснөөр ажлын бүтээмж, мэдээллийн эрэлт хэрэгцээ тодорхой хувиар өссөн.
- Байгууллагыг цэвэр, өнгө үзэмжтэй байлгах зорилгоор бүх нийтийн их цэвэрлэгээг 2 удаа хийлээ.
- Хөдөлмөр хөнгөвчлөх, ариун цэвэр хангах зорилгоор сар бүр бичиг хэргийн материал , нормын ариун цэврийн материалуудыг ажилтан албан хаагчдад олгож байна.
- Бүх ажилтан албан хаагчдын нормын хувцсыг шинэчлэв.
- Уншигчдын тав тухыг хангах үүднээс өлгүүрийг төсвийн хөрөнгөөр шинэчлэв.

- Түвд номыг МУҮНС-д шилжүүлэн, танхимыг цэвэрлэж хүлээн авсан.
- Танхимуудын гэрэлтүүлгийн асуудлыг анхааран цаг тухайд нь сольж шинэчлэж байлаа.
- Бие засах өрөөний 1 суултуур, тоос сорогч 1-ийг шинээр авсан.
- “Их мэдэх” танхимын үүдний хэсгийг зориулалтын биеийн тамирын танхимын хулдаасаар шинэчлэлээ.

ЕС: БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮГИЙН ЧАДАВХИ

- Байгууллагад нэн тэргүүн шаардлагатай байгаа зөөврийн номын сан ажлуулахад хэрэгтэй тээврийн хэрэгсэл мөн түүнийг дагалдах, бензин, номын санчийн шинэ орон тоо, байрын түрээс, танхимуудад шаардагдах бичиг хэрэг, аж ахуйн материал, урсгал засвар, ном хэвлэл, шуудан холбооны зардлуудыг оновчтой төлөвлөсөн.
- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулан ажилласан. 2009, 2010 оны санхүүгийн баримтанд “Сүлд” аудит ХХК ажилласан бөгөөд санхүүгийн ямар нэгэн зөрчил гараагүй болно.
- Нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам зааврыг чанд мөрдөн санхүүгийн тайлан мэдээг тухай бүрд нь холбогдох газруудад нь өгч ажиллаж байна.
- Үндсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, эд хөрөнгийн тооллого тооцоо бүртгэлийг үнэн зөв хийж ирлээ. Энэ онд БСШУЯ-аас зөөврийн номын сангийн үйлчилгээнд зориулж 20 сая төрөгний фургон машин, Койка байгууллагаас 1 комюьютер авч өгсөн. Төсөв болон хандив бэлгээр ирсэн эд хөрөнгө, машин, ном зэргийг үндсэн хөрөнгөндөө тусган ажиллаж байна.

АРАВ: ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Хүүхдийн номын ордон нь үндэсний хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

“Монгол бичгийн үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд Бичиг соёлын хишиг өдрөөр “Сод Номун” төрийн бус байгууллагатай хамтран “Үндэсний бичиг минү” улсын 5 дугаар уралдааныг 5 дахь жилдээ амжилттай зохион явууллаа. Уралдаанд хот хөдөөгийн 350 гаруй хүүхэд залуус оролцлоо. Уралдаанд нийслэлийн сургуулиудаас гадна Булган, Архангай, Хэнтий, Төв, Хөвсгөл зэрэг аймгийн ЕБС-ийн сурагчдаас ирж оролцсон. Насны онцлогоор нь 4-5 анги, 7-8 анги, 9-11 анги, оюутан залуус гэсэн 4 ангилалаар хоёр үе шаттайгаар амжилттай явуулсан. Шагналд нас тус бүрээс 5 хүүхэд шалгаруулж тэмцээнд оролцсон хүүхэд бүрт гарын бэлэг гардуулсан.

“Залуучуудын хөгжлийг дэмжих үндсэний хөтөлбөр”-ийн хүрээнд хүүхэд залуучуудын оюуны хөгжлийг дэмжих төрөл бүрийн 89 ажлыг зохион байгуулсан байна. Үүний заримаас тодотговол.,

- 2010 оноос 7 хоног бүрийн ням гаригт Монголын Сурагчдын Холбоотой хамтран сурагчдын холбооны лидер сурагчид болон уншигч залууст зориулан лекц уншуулж байна. Энэ онд нийт 20 удаа лекц явуулж ойролцоогоор 1400 гаруй залуус оролцсон байна. Тус лекцэнд Монголын сурагчдын холбооны идэвхтэн хүүхдүүд, ХНО-ны уншигч хүүхдүүд тогтмол оролцдог. Мөн уулзалтанд лекторын гаргасан ном зохиолоор номын үзэсгэлэн гаргаж зохиол бүтээл, намтар уран бүтээлтэй нь танилцуулах зэрэг олон ажлуудыг хийж ирлээ.
- Олон Улсын Хүүхдийн баярыг ХНО-ны хамт олон жил бүр уншигчидтайгаа хамтран тэмдэглэдэг уламжлалтай билээ. Энэ жилийн хүүхдийн номын

баярыг “Уншлагын 7 хоног” аян болгон тэмдэглэн танхим бүр өөр өөрийн онцлогийг харуулсан олон ажил хийж өнгөрүүллээ.

Өнгөрсөн зуны турш явуулсан Номын нөхөр клубын Зуны уншлагыг мөн энэ онд үргэлжлүүлэн зохион байгуулсан. Энэ ажлын хүрээнд хүүхдүүд зохиолч ах, эгч нартайгаа хамтран уран зохиолын номоор дүр бүтээх тоглолт, шүлэг зохиох, өөрийн зохиосон дөрвөн мөртөөр жүжигчилсэн тоглолт хийх зэрэг арга хэмжээг зохион явуулснаар тэдний зуны амралт үр дүнтэй өнгөрсөн юм.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд

- ШУТИС-ийн нийгмийн ухааны ангийн оюутнуудын төсөлд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй 5 хүүхдийг номын сантай танилцуулж, чанга уншлага хийж өгч номын бнлнг гардуулсан.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох, мэдээллээр хангагдах орчин бий болгох үүднээс зөөврийн номын сангийн үйлчилгээг тэдэнд хүргэх зорилго тавин ажиллаж судалгааг гаргаж эхлээд байна.

АРВАН НЭГ: МЭДЭЭЛЛИЙН ДОТООД СҮЛЖЭЭ, УДИРДЛАГА МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН БҮРДЭЛТ, ВЭБ ҮЙЛЧИЛГЭЭ

ХНО-ны удирдлага тайлангийн хугацаанд мэдээллийн технологийн ажлаар доорхи 4 чиглэлийг удирдлага болгон ажилласан.

- Байгууллагын компьютерийн дотоод сүлжээ болон техник тоног төхөөрөмжүүд
- ХНО-ны мэдээллийн сангууд
- ХНО-ны интернэт болон вэб үйлчилгээ
- Байгууллагын мэдээллийн аюулгүй байдал

1. Байгууллагын дотоод сүлжээ болон техник тоног төхөөрөмжүүдийн байнгын найдвартай ажиллагааг хангаж ажиллалаа. Үүнд:
   - ✓ ХНО-ны компьютерийн дотоод сүлжээ нь 1 сервер компьютер бүхий 5 дэд сүлжээнд холбогдсон 30 компьютераас бүрддэг бөгөөд компьютерууд болон тэдгээрийн дагалдах төхөөрөмжүүдийн найдвартай ажиллагааг тайлангийн хугацаанд хангаж ажиллахдаа нийт 17удаагийн эвдрэл гэмтлээс засвар үйлчилгээг 11 удаа, шинэчлэн сайжруулалт 6 удаа хийж гүйцэтгэв
   - ✓ Компьютеруудад гарсан програм хангамжийн шинэчлэлтүүдийг хэрэгцээт програмуудаар нь 30 удаа шинэчлэн сэлбэж сайжруулж ажиллав.
   - ✓ Байгууллагын хэмжээнд дотоод сүлжээний тополог болон бүх компьютеруудын тохируулга тохиргооны нэгдсэн гарын авлага зэрэг баримт бичгүүдийг бий болгож ажилдаа нэвтрүүлсэн
   - ✓ Номын сангийн автоматжуулалтад хэрэгцээ шаардлага бүхий бусад техник хэрэгслүүдэд гарсан 10 удаагийн эвдрэл гэмтлүүдийг засварлаж, шинэчлэн ажиллагаатай болгов.
2. ХНО-ны мэдээллийн сангууд ерөнхийдөө 3 төрөл байдаг бөгөөд энэ талаар хийсэн ажлууд нь:
   - ✓ ХНО нь номын сангийн автоматжуулалтын “Lib4U net” сүлжээний програм хангамжийг ашигладаг бөгөөд 8 хэсэгтэйгээр \7 танхим, 1үнэмлэх нээлт\ уншигчдад зориулсан ном болон визуаль материалын мэдээллийн сан үүсгэн үйл ажиллагаагаа явуулж байна. Тайлангийн хугацаанд нийт 4480 ширхэг ном болон визуаль материалаар электрон каталогоо баяжуулав.

- ✓ ХНО-оос эрхлэн гаргасан Монголын хүүхдийн уран зохиолын ном зүйн нэгдсэн мэдээллийн сангийн 1921-1940 он ба 1941-1970 оны материалуудыг online, offline хэлбэрт бий болгосон.
- ✓ ХНО-ны вэб сайтад нийтлэгдэж байсан мэдээ мэдээллээр сан үүсгэн CD бичлэг хийж хадгалсан.

3. ХНО-ны интернэт болон вэб сайтын үйлчилгээний хувьд хийгдсэн ажлууд:
   - ✓ ХНО нь интернэт үйлчилгээг “Magicnet” компаниас авдаг бөгөөд энэ жилийн хувьд интернэт тасалдалт 3 удаа гарсныг тус компаний инженерүүдээр 1-2 хоногийн хооронд засварлуулсан. Байгууллагын сүлжээний талаас интернэт саатал, эвдрэл гэмтэл гаргалгүй ажиллав.
   - ✓ Тайлангийн хугацаанд ХНО-ны вэб сайтын мэдээллийг шинэчлэх олон удаагийн ажиллагаа явагдаж ирлээ.
   - ✓ Байгууллагын вэб сайтыг шинээр өөрчлөн хийхэд бүрэн динамик вэб болгох, вэбийн агуулга, бүтэц зохиомж, хэлбэр дизайн сонгох, вэб бүтээх ямар програм хангамж ашиглах зэрэг шаардлага, төлөвлөлтүүдийг гаргалаа.
   - ✓ ХНО-ны вэб сайтыг бүтээхэд вэб програмчлалын нэг төрөл болох агуулга удирдлагын систем Joomla!-г ашиглахаар тогтож, байгууллагын мэргэжилтэнд даалган нарийвчлан судлуулахдаа Joomla!-гийн ном болон аргачлал заавар, загвар, хэлний орчуулга, хэрэгцээндээ тохируулан эзэмших, интернэтэд байршуулах зэрэг арга ажиллагааг эзэмшүүлж улмаар байгууллагын вэбийн агуулга, бүтэц зохиомж, хэлбэр дизайн хэрхэн байхыг зохиох болон мэдээллийн баяжилтуудыг хэн хэн хэрхэн хийхийг төлөвлөн гүйцэтгэлийг богино хугацаанд чанартай гаргахыг шаардан ажиллалаа.
   - ✓ ХНО-ны мэйлийн тохиргоо үйлчилгээний зааварчилгааг Magicnet – ээс авч бүх хэрэглэгчдийн мэйл бүртгэлийг дахин шинэчлэсэн ба мэйл ашиглалтаар сургалтын материал бэлтгэж бүх ажиллагсдад сургалт явуулсан.
4. Байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын талаар хийгдсэн ажил:
   - ✓ ХНО-ны мэдээллийн аюулгүй байдлыг хангахад шаардлага бүхий 3 төрлийн баримт бичгүүдийг бий болгосон ба түүнд сүлжээний статик IP хаяглалт, Gateway, DNS, дотоод сүлжээний ажлын групп, сүлжээн дэх компьютеруудын нэрс, файл болон принтерүүдэд хандах эрх, тохируулга зэргийг багтаасан. Байгууллагын сүлжээний топологт төхөөрөмжийн нэр ба хэрэглэгчийн нэр, компьютерийн марк ба дагалдах төхөөрөмжүүд, үйлдлийн систем ба автоматжуулалтын програм зэргийг багтаасан .
   - ✓ LIB4U Net програмд шаардлага хэрэгцээ бүхий нэмэлт өөрчлөлтүүдийг тусгасан бичгийг гаргаж “Wolves LLC” компанид хүргүүлэн улмаар 2 удаагийн шинэчлэлтийг сервер компьютерт хийлгүүлсэн ба LIB4U client 1.9.6 хувилбарыг байгууллагын бүх компьютеруудад суулган өгөгдсөн зааврын дагуу нэмэлт download-ыг хийж ажиллав. Мөн Lib4U програмыг Windows 7 үйлдлийн систем дээр ажилладаг болгох санал өгөөд байна.
   - ✓ Байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хангахад вирусын эсрэг /Free/ програмуудыг 30 компьютерийн ашиглалтанд нэвтрүүлж ажилласан ба мэдээллийн аюулгүй байдал болон вирусийн эсрэг хэрхэн тэмцэх талаар сургалтын материал бэлтгэж, нийт ажилчдад 1 удаа сургалт явуулсан ба хэрэглэгч бүрт заавар өгч ажиллалаа.
   - ✓ ХНО-ны ажиллагсдын компьютер дахь мэдээллүүдийг CD, DVD-д хадгалж авсан.

АРВАН ХОЁР: УРАН БҮТЭЭЛ, ФОНД, ҮЗМЭРИЙН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ

Номын хөмрөгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах, байгууллагын бичиг баримтын стандарт байдлыг хангах талаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Байгууллагын архивын баримт бичиг хадгалах 2 шүүгээ шинээр авч хадгалалтын аюулгүй байдлыг сайжруулсан.
- Байгууллагын үндсэн хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавихад номын тооллого хийх нь хамгийн чухал ажил байдаг. Танхимын номын санчид өөрчлөгдсөнтэй холбоотойгоор ажил хүлээлцэх тооллогыг Мөрөөдөл болон англи номын уншлагын танхимуудад хийж гүйцэтгэлээ. Тооллогыг 2010 оны 11 сарын 16-аас 22-ны хооронд ажлын 5 өдөрт багтаан тооллоо. Тооллогоор компьютерт орсон 3382 ширхэг ном, гараар 820 ширхэг номыг байрнаас нь татан шалгаж нийт 4202 ширхэг ном тоолж дүнг гарган захиргааны хуралд танилцуулсан.
- Солилцоогоор аваад удаан хугацаанд хүний гар дээр байгаа номыг шүүж, номын нэрсийг нь ажилтан тус бүрд өгч номыг хөмрөгт эргүүлэн тушаах ажлыг эхлүүлээд байна.
- ''Lib4U net'' програмаар серверт хийгдсэн нийт номын мэдээллийн баазыг 3 удаа нөөцөлж CD-д бичиж авсан. /улиралд 1 удаа/
- Монголын хүүхдийн уран зохиолын ном зүйн нэгдсэн мэдээллийн сангаар CD бичлэг хийж нөөцлөв.
- ХНО-оос эрхлэн гаргасан Монголын хүүхдийн уран зохиолын ном зүйн нэгдсэн мэдээллийн сангийн 1921-1940 он ба 1941-1970 оны материалуудыг online, offline хэлбэрт бий болгосон.
- ХНО-ны вэб сайтад нийтлэгдэж байсан мэдээ мэдээллээр сан үүсгэн CD бичлэг хийж хадгалсан.

АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2010 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2010-12-22

Аймгийн нийтийн номын сан-Мэдээллийн төв нь 2010 онд доорх ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1.Уншлага үйлчилгээний талаар

Нийтийн номын сан нь уншигч хэрэглэгчдэд соёлын үнэт өв оюуны бүтээлийг хүртээмжтэй болгох, мэдээлэлийн технологи асар хурдацтай хөгжиж тэдний мэдээлэл авах цар хүрээ өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй өнөөгийн нөхцөлд уншигчдын эрэлт хэрэгцээ, хүсэл сонирхолыг судлан тэдэнд хэрэгцээтэй мэдээ материалыг цаг тухайд нь хүргэж үйлчлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

2010 онд Номын сан –мэдээллийн төв нь насанд хүрэгчдийн болон хүүхдийн уншлагын танхим, зөөврийн номын сангийн үйлчилгээгээр нийт 14470 иргэсдэд 44562 ширхэг ном хэвлэлээр үйлчиллээ. Насанд хүрэгчдийн уншлагын танхимын ном хэвлэлийг 100%, хүүхдийн номын сангийн уншлагын танхимын номын 100%-ийг

электрон каталогт бүртгэсэн бөгөөд нийт номны бар кодыг нааж электрон үйлчилгээг хүргээд байна. Номын сангийн үйлчилгээ электрон хэлбэрт шилжсэнээр уншигчид хэрэгцээт мэдээллээ түргэн шуурхай өргөн сонголттой хайх, лавлагаа авах боломж бүрдэж байна. Хүүхдийн 8-р цэцэрлэгт номын булан байгуулан өгч хүүхэд багачуудыг бага наснаас нь номтой нөхөрлүүлж тэднийг оюунлаг иргэн болж төлөвшихөд нь хамтран ажиллахаар боллоо. Мөн 8-р цэцэрлэгийн бэлтгэл бүлэг, Улаан Загалмайн Нийгэмлэгийн дэргэдэх “Сэргэлэн” цэцэрлэгийн ахлах бүлгийн 21 хүүхдэд, Эрдэнэбулган сумын 3-р цэцэрлэгийн ахлах, бэлтгэл хоёр бүлгийн 36 хүүхдэд нас сэтгэхүйн онцлогт нь тохирсон үлгэрийн зурагт номоор тус бүр 3 удаа чанга уншлага хийн урилгат үйлчилгээг хүргэлээ. Цагдаагийн хэлтэс, БСГ, ЗДТГ, Монгол банк, Шүүх, Аймгийн иргэдийн хурал, Эүүл мэндийн газар, Улсын бүртгэлийн газар, Хүүхдийн төлөө төв зэрэг байгууллагуудад зөөврийн номын сангийн үйлчилгээг явууллаа. Санал хүсэлтийн дэвтрийг тогтмол ажиллуулж уншигчдын хүсэлтийг хүлээн авч зарим боломжтой асуудлыг цаг тухай бүрт нь шийдвэрлэж өглөө. Хэрэглэгчдийн хүсэлтийн дагуу ажлын 6 өдрөөр номын сангийн үйлчилгээг уншигч хэрэглэгчдэд хүргэж байна.

2.Мэдээлэл сурталчилгаа СОТА-н талаар

Номын сан нь шинээр ирсэн ба фондод байгаа ном хэвлэл, мэдээллийг уншигч хэрэглэгчдэд хүргэх зорилгоор төрөл бүрийн мэдээлэл сурталчилгааны болон СОТА-г зохион байгуулан явуулж ирлээ. Үүнд:Цагдаагийн хэлтэстэй хамтран нийт бие бүрэлдэхүүний дунд “АХА” тэмцээн, ”АСК” тэмцээн, Эх орончдын өдөр буюу 4-р сарын 2-нд ЦХ-ийн сэтгэл зүйч, лектор Нэргүйбаатарыг урьж “Үндэсний эх оронч үзэл ба залуучууд” мөн Ахмадын хороотой хамтран “Монгол ёс заншил”, “Гэр бүлийн уламжлалт ёс заншил” сэдвүүдээр оюутан сурагчдад лекц-ярилцлага зохион байгууллаа.

Эрдэнэбулган сумын Хүмүүн Цогцолбор 3-р сургуулийн нэрэмжит “Өдтэй бичиг” монгол бичгийн олимпиадыг тус сургуультай хамтран зохион байгууллаа.Тус олимпиадад Эрдэнэбулган сумын ЕБС-иудын 8, 9-р ангийн сурагчид оролцож эрдэм мэдлэг оюун ухаанаа сорьсноос 9-р ангид сурагч Ж. Саруулбуян \Хүмүүн 1\ Ц. Болорцэцэг \ Хайрхан сум \ Э. Сувд-Эрдэнэ \Хүмүүн 3\ 8-р ангид Э. Түвшинжаргал, Халиунаа \Хайрхан сум\ Ө. Долгорсүрэн \Хүмүүн 3\ нар шалгарч алт, мөнгө, хүрэл медалийн эзэд боллоо. МУ-ын ерөнхийлөгчийн зарлигийн дагуу жил бүрийн 5-р сарын 8-ны өдөр “Үндэсний бичиг соёлын өдөр”- ийг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан Монгол түмний түүхэн бичиг хүмүүн бичгээ хойч үедээ уламжлан үлдээх “Үндэсний бичиг үсгийн өдөр”-ийг аймгийн Номын сан-Мэдээллийн төв, МУ-ын Соёлын гавьяат зүтгэлтэн Г. Жамцтай хамтран 5-р сарын 8-нд өргөн хүрээнд тэмдэглэлээ.

Ахмад сэтгүүлч, багш, оюутан сурагчид энэхүү өдөрт ач холбогдол өгч, хуучин монгол бичгээр бичигдэн хадгалагдан үлдсэн хуучны үнэт ховор номуудын үзэсгэлэн, БК-ийн оюутнуудын монгол бичгийн уран бичлэгийн үзэсгэлэнг гаргалаа.

“Зөв сайхан бичигтэн” уралдаанд нийт 45 хүн оролцсоноос БК-ийн багш Ц.Оюунчимэг, сурагчдаас Хүмүүн цогцолбор I сургуулийн Билгүүнсаран, III байрыг хүмүүн III сургуулийн багш П. Жавзансүрэн, тусгай байрыг хүмүүн III сургуулийн багш Д. Наранхүү, хүмүүн II сургуулийн багш Н. Хандсүрэн нар монгол бичгийн зөв сайхан бичигтнээр тодорч, хамгийн сонирхолтой төрөл болох “Уран бичигтэн”-ий уралдаанд 32 оролцогч мэдлэг оюун, ур чадвараа сорьсоноос Хүмүүн цогцолбор I сургуулийн монгол хэлний багш Амгаланбаатар “Хайр”, Хэвлэл мэдээллийн төвийн

оператор Д. Сундуйжав ”Нүд”, Хүмүүн цогцолбор I сургуулийн захирал М. Шагдарсүрэн ”Ленин” гэх үгийг монгол бичгээр уран зохиомжтой бичиж шалгарлаа. Аймгийн Засаг даргын ивээл дор зохиогдсон “Хангайн намар” сэтгүүлч, яруу найрагч, зохиолчдын чууллыг 2010 оны 9 сарын 17- ны өдөр Аймгийн СНЭ, УЗН- тэй хамтран зохион байгуулж, Засаг даргын тамгын газар, аймгийн Иргэдийн хурал ивээн тэтгэн оролцлоо. Чуулалд МУ-ын соёлын гавьяат зүтгэлтэн, зохиолч, орчуулагч Л.Хуушаан, Монголын зохиолчдын эвлэлийн гишүүн, ахмад зохиолч Д.Баасанжав, МЗЭ- ийн шагналт, Монголын СНЭ- ийн гүйцэтгэх зөвлөлийн гишүүн “Утгын чимэг” наадмын эзэн, яруу найрагч Б.Баярсайхан, МОНЦАМЭ мэдээ сонины нийгэм улс төрийн хэлтсийн дарга, сэтгүүлч, яруу найрагч Ж.Батсайхан, МЗЭ-ийн шагналт, МУЗН- ийн “ Нигүүлсэл ” сонины хариуцлагатай нарийн бичгийн дарга, “Болор цом”- ын эзэн, яруу найрагч Ш.Лхамноржмаа, МЗЭ- ийн шагналт, “ Утгын чимэг ” наадмын дэд байрын шагналт, “Их монгол” дээд сургуулийн багш П.Батхуяг, МЗЭ- ийн шагналт, зураач, яруу найрагч М.Амархүү, Улаанбаатар дээд сургуулийн декан Ц.Эрдэнэбат, залуу яруу найрагч Ч.Өсөхболд зэрэг Архангайгаар овоглосон уран бүтээлчид нутаг нуга, уншигч олон түмнээ хүндэтгэн иржээ.

“Хангайн намар” чуулалд Номын сан–Мэдээлийн төв нь 3 том ажлыг хариуцан голлон зохион байгууллаа. Үүнд:

<u>“ Хангайн уянга “ номын нээлт</u>

Архангай аймгийн уугуул номын мэргэд зохиолчдын шилмэл бүтээлийн дээж зохиолч яруу найрагчдын эмхэтгэл “Хангайн уянга“ шинэ номын нээлтийг хийв.

<u>Зохиолч уншигчдын уулзалт</u>

Зохиолч, сэтгүүлч, яруу найрагчид уншигч олонтойгоо уулзах уулзалтыг зохион байгууллаа. Уншигчид унших дуртай роман, тууж, өгүүллэг, шүлгийнхээ ээздтэй нүүр тулан уулзаж тэдний шинэ болоод сэтгэлд ойр явдаг бүтээлээс сонсон, сонирхсон асуултандаа хариулт авлаа.

<u>“Хангай цом – 2010“ яруу найргийн наадам</u>

“Хангай цом–2010“ яруу найргийн наадмын эхний шатны шүлгийг бичгээр хүлээж аван, 2-р шатанд 34 найрагчийн бүтээл шалгарч үлдсэн. Үүнээс 3-р шатанд 10 яруу найрагч тунаж “Хангай цом–2010”-ын эзнээр Тариат сумын уугуул, яруу найрагч Г.Баяр тодорч “Болор цом” яруу найргийн наадамд оролцох эрх авч, Ихтамир сумын харьяат, залуу яруу найрагч Ч.Өсөхболд, 3-р сургуулийн нийгмийн ажилтан П.Жавзансүрэн нар хоёр гуравдугаар байр эзэллээ.

“ Хангайн намар” чууллын хүрээнд нийт 670 гаран хүн хамрагдлаа

БСШУЯ-ны харъяа Архангай аймаг дахь МСҮТ-ийн 40 жилийн ойн арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан “Ном-Миний найз” 2 сарын аян амжилттай болж өндөрлөлөө. Аяны зорилго нь МСҮТ болон Номын сан-Мэдээллийн төвийг сурталчилах, монгол туургатны түүх, утга соёл, үгийн гайхамшиг болсон “МНТ”-г эрхэмлэн дээдлэх, хүүхэд залуусыг номтой нөхөрлүүлж, амьдрах ухаанд суралцуулах, тэдний хөгжил, оролцоог дэмжих, авъяас чадварыг нээн хөгжүүлэх, БСШУЯ-ны сайдын 2006 оны 6-р сарын 8-ны өдрийн 211 дүгээр тушаалаар баталсан “Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн” шалгаруулах журмыг сурталчлахад чиглэлээ.

“Ном-Миний найз” 2 сарын аяны хүрээнд их, дээд сургууль, МСҮТ-ийн оюутнууд, ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд дараах ажлыг зохион байгууллаа. Үүнд: “АХА” тэмцээн, “Сурах орчны нөлөөлөл” илтгэлийн уралдаан, “МНТ”-ны 770 жилийн ойг холбогдуулан МУ-ын “МНТ” сэдвийн дор бүтээлийн уралдаан, “Гэрэлт Ирээдүй”

сэдэвт Дэвжээ тэмцээн, “Миний сургууль-Миний бахархал” эсээ бичлэгийн уралдаан, “Найрагчийн сэтгэгдэл” зохиолч, уншигчдын уулзалтыг оюутан, сурагчдын дунд тус тус зохион байгууллаа

“Найрагчийн сэтгэгдэл” яруу найргийн уузалтад зохиолч, яруу найрагч С.Бараанасан, “Хангайн уянга” номын эмхэтгэгч, сэтгүүлч, яруу найрагч Д.Батдэлгэр, МУСГЗ сэтгүүлч, зохиолч Г.Жамц нарыг МСҮТ-ийн оюутан, сурагчидтай уулзуулан сэтгэгдэлийг сонсох бүтээл тус бүр 15 оюутан нийтдээ 285 оюутан оролцов.

“АХА” тэмцээнд 1-р байранд МСҮТ-ийн оюутан Д.Сэргэлэн

2-р байранд III-р сургуулийн сурагч Г.Төмөрчөдөр

3-р байранд I-р сургуулийн сурагч Г.Баасансүрэн нар шалгарсан.

“Миний сургууль-Миний бахархал” эсээ бичлэгийн

1-р байранд Х.Рэгзэдмаа

2-р байранд Э.Пүрэвдорж

3-р байранд Ба.Бат-Өлзий нар шалгарав.

“Сурах орчны нөлөөлөл” илтгэлийн уралдаан

Аймгийн ЕБС-н сурагчид МСҮТ-н оюутан сурагчдын дунд зохион байгуулан

1-р байранд III-р сургуулийн 11в ангийн сурагч Б.Батзаяа

2-р байранд I-р сургуулийн 11б ангийн сурагч Ж.Пүрэвдорж

3-р байранд МСҮТ-ийн тогооч 1а ангийн оюутан Б.Сайнжаргал

Тусгай байранд I-р сургуулийн сурагч Д.Булгантамир нар шалгарав.

Их дээд сургууль, МСҮТ-үүд, ЕБС-дын сурагчдын дунд зохион явуулсан **“ГЭРЭЛТ ИРЭЭДҮЙ”** сэдэвт дэвжээ тэмцээнд нийт 7 баг оролцсноос

Тэргүүн байранд I-р сургуулийн “1-н зүрх” баг

2-р байранд МСҮТ-н “MGL” баг

3-р байранд МСҮТ-н “NEW FOLDER” баг

Тусгай байранд Булган МСҮТ-н “Ирээдүйн одод” зэрэг

багууд шалгарлаа.

“МНТ” сэдэвт бүтээлийн уралдаанд

- Уран хайчилбар
- Уран зураг
- Уран бичлэг
- Зураасан хар зураг зэрэг төрлөөр бүтээлүүд роцсон бөгөөд

Бүтээлүүдээс 1-р байранд I-р сургуулийн 11г ангийн сурагч Д.Галсанжамц

2-р байранд МСҮТ-н 3-р курсын оюутан Ч.Мандахтуяа

3-р байранд III-р сургуулийн сурагч Д.Мөнх-очир

Тусгай байранд Хайрхан сумын сургуулийн сурагч Т.Жавзанпагма зэрэг хүүхдүүдийн бүтээлүүд шалгарлаа. Мөн зохион байгуулсан бүх ажлуудтай холбогдуулан шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн нийт давтагдсан тоогоор 24 удаа гарган

сурталчилсан ба орон нутгийн “Архангай амьдрал”, ”Архангай толь”, ”Оюунд туссан гэгээ” сонингуудад зохион байгуулсан ажлуудыг мэдээллийг гарган “Тамир“ телевизэд “Номын ертөнц” булангаар шинэ номууд, зохион байгуулсан бүх СОТА-г аймгийн иргэдэд тогтмол сурталчиллаа. Номын сангаас зохион явуулсан нийт СОТА-д 1500 гаруй уншигчдыг хамруулсан бөгөөд орон нутгийн болон хууль тогтоомжийн картын санг байжуулан бүртгэлээ.

3.Номын фондын баяжилт хадгалалт хамгаалалтын талаар.

2009 онд захиалсан тогтмол хэвлэлийн үдэж хавтаслан сонин сэтгүүлийн дансанд бүртгэн үндсэн фондод авлаа. Ажиллагсдын ажил дүгнэх үзүүлэлт, үр дүнгийн гэрээнд тусгагдсаны дагуу нийт урагдаж гэмтсэн **3275** ширхэг номонд сэлбэн засалт хийж уншлага үйлчилгээнд ашиглаж байна. Сан хөмрөгийн тооллогыг хийж дуусган тооцоог хийн ашиглах боломжгүй ном хэвлэлийг актлаж данснаас хаслаа. Сумдын болон ЕБС-н номын сангуудад 462 ширхэг 3015,6 мянган төгрөгийн монгол ном, Азийн сангийн 1130 ширхэг 3390,0 төгрөгийн Англи номоор сан хөмрөгийн баяжилт хийлээ. Аймгийн төв номын сан нь 407 ширхэг 3723,0 төгрөгийн номоор фондоо баяжууллаа. Шинээр авсан номуудыг техник ажиллагааг хийн дансанд авч электрон катологт оруулан уншигчдын хүртээл болголоо. Сумдын болон ЕБС-н номын санчдын сургалт семинарыг 2010 оны 4-р сарын 26-30-ны өдрүүдэд МҮНС, ХНО, БСГ-тай хамтран Улаанбаатар хотод зохион байгуулан явууллаа. “Сумдын болон сургуулийн номын сан нь мэдээллийн төв болох нь” сэдэвт 5 өдрийн сургалтанд хамрагдлаа. Тус сургалтын хүрээнд нийт 40 цагийн, мэргэжлийн 13 нэрийн хичээлд хамрагдаж, дадлага ажил хийж, ХНО болон ШУТИС-ийн орчин үеийн жишигт нийцсэн загвар номын сан, СБД-ийн Цогцолбор 1-р сургуулийн номын сангийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцаж, туршлага судаллаа. БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар Хангай, Хашаат, Өлзийт, Эрдэнэмандал, Жаргалант сумуудад тус бүр уншигчийн 5 ширээ, 10 сандал ба нийт 25 ширээ, 50 сандал шинээр өглөө.

Бусад зүйлийн талаар.

Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан шинээр номын сан барих ажлын хүрээнд “Хатанбаатар” ХХК-р шинээр барих нийтийн номын сангийн барилгын зураг төсвийг хийлгэн хүлээн авч хуучин барилгыг буулгахад бэлэн болгож 2010-2011 онд номын сангийн үйлчилгээг хэрэглэгчдэд чирэгдэлгүй хэвийн явуулах боломжийг бүрдүүлж ажиллалаа. Номын сангийн ажиллагсдын 2009 оны үр дүнгийн гэрээг дүгнэж зарим ажилтанг шагнаж урамшууллаа. Мөн ажиллагсдын ажил дүгнэх үзүүлэлтийн дагуу ажлыг нь дүгнэж 768.0 мянган төгрөгийн тэтгэмж, нэмэгдэл урамшуулалт цалин бодож олголоо. Мөн номын сангаас тэтгэвэрт гарсан ахмадуудыг Ахмадын баяраар хүлээн авч 2 ахмадыг МУСТА цол тэмдэгээр, 1 өндөр настанг БСШУЯ-ны “Жуух бичиг”-ээр тус тус шагнуулж урамшууллаа. Ажиллагсдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх болон бие бялдрыг чийрэгжүүлэх зорилгоор аймгийн Биеийн тамир спортын хорооноос зохион явуулсан албан байгууллагуудын дундах буухиа тэмцээнд хамт олноо оролцууллаа. Батлагдсан төсөв орон тоонд багтааж үйл ажиллагаагаа явуулан цаг тухай бүрт нь санхүүгийн мэдээ тайланг Төрийн сан, Татварын хэлтэс, НДХ болон бусад газруудад гарган өгч номын сангийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллалаа. Бичиг хэргийн ажилтанг аймгийн ЗДТГ-с зохион байгуулсан сургалтанд хамруулан сургаж бичиг хэрэг Архивын “ORG-AMS”

программ"-ыг суурилуулан 1985-2004 оны баримтуудыг аймгийн Архивын газарт хүлээлгэн өгч сүүлийн 5 жилийн материалыг байгууллагын архивт хадгаллаа.

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2010 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Эрхэм зорилго: Уншигчдын ном хэвлэл унших, мэдээлэл авах цар хүрээ өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй өнөөгийн нөхцөлд тус номын сан нь уншигчдын эрэлт хэрэгцээ хүсэл сонирхлыг нь судлан тэдэнд хэрэгцээтэй мэдээ материалыг цаг тухайд нь хүргэж үйлчлэхэд гол анхаарлаа чиглүүлж: "Мэдээллийн орчин зуунд номын сангийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, номын санг мэдээллийн төв болгон хөгжүүлэх нь бидний эрхэм зорилго" юм.

1. Удирдлага, зохион байгуулалтын ажил

Монгол Улсын соёлын тухай хууль, тогтоомжууд болон төрөөс баримтлах Соёлын бодлого, Засгийн газар болон Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор байгууллагын үр дүнгийн гэрээг БСГ-ын даргаар батлуулан 2010 оны ажлын төлөвлөгөөг боловсруулан, байгууллагын дотоод журамд тусгагдсаны дагуу ажилчин албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээ, ажил байдлын тодорхойлолт хүн бүрийн хийж гүйцэтгэх бүтээгдэхүүний гэрээний заалт бүрийг хийсэн.

- 2010 онд 47831500 төгрөгний төсөв өгч төсвийг зүй зохистой зарцуулсан.
- Номын сангийн фондыг хадгалж хамгаалах зорилгоор барилгыг бариулах тухай Монгол Улсын ерөнхий сайдад хүсэлт тавьж 2011 онд 300,000 сая төгрөгний хөрөнгийн асуудлыг шийдүүлсэн.
- Ажилчин албан хаагчдын өвчтэй байсан хугацааны цалинг төсөвт зогсож хэвээрээ олгож байна.
- Удаан хугацаагаар эмчилгээнд явсан, ар гэрийн гачигдлыг байгууллагын зүгээс анхаарч нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгож байна.
- Бүх номын санчдын ажлыг жигд болгохын тулд ахлах номын санчаар толгойлуулсан ажлын хэсэг зохион байгуулж, нэг өдөрт хийх ажлын норм нормативаар сар, улирал, жилээр хийсэн ажилд хяналт шинжилгээ хийсэн.
- Ерөнхийлөгчийн санаачилан гаргасан номын сангийн хуулийн төслийг боловсруулахад биерээ оролцож өөрийн аймаг, оронд ажиллаж байгаа номын санчдын эрхийг хамгаалах хэд хэдэн чухал асуудал оруулсан.
- Номын санг 2010-2014 хүртэлх хөгжүүлэх хэтийн төлөвлөгөө хийж тусгагдсан ажлуудын 40%-ыг хийж гүйцэтгэв.
- Номын сангийн MNS 5742/2007 стандартыг хангахгүй байранд үйл ажиллагаагаа тогтмол хэвийн ажиллагаагаар хангаж ажиллаж байх хугацаанд байгууллагын зүгээс өдөрт 2 удаа хөнгөн цай өгч байна.
- Энэ жил ном авах төсөв хасагдаж 2500,000 төгрөг ирсэн тул урсгал засвар болон халаалтын зардлын хэмнэлтээс 636049 төгрөгийн хандиваар 93 номыг 742200 төгрөгөөр 523 ширхэг номыг төсвөөр бүгд 423049 төгрөгний 643 ширхэг ном авч фондоо баяжуулсан. 1,2,3,4-р улиралд 14 төрлийн сонин сэтгүүлийг 352200 төгрөгөөр захиалан уншуулж байна.
- Номын сангийн дотоод журмыг бүх ажилчдын хурлаар батлан мөрдөж ажиллаж байна.

- Аймгийн 70 жилийн ойг угтаж байгууллагын гадны тамбур хаяг реклам, бүх танхимуудыг бүрэн засварласан ба үндсэн фондонд шинээр гэрэл хийлгэсэн.
- Мөн байгууллагын самбар хаягийг шинээр бичүүлсэн.
- Эд хогшил худалдаж авах зардлаас хүчин чадалтай 1 ширхэг ком компютер авсан.
- Уншлагын танхим, гэрээр ном олгох тасаг, үндсэн фондын номыг электрон каталогт нэгэн зэрэг оруулж цаасан каталогийг хамт бичиж, ангиллын дагуу байрлуулж байна.
- 2008 онд бүртгэл мэдээллийн номын санчын орон тоо нэмэгдсэн боловч 2 жил дараалан цалингийн сан дутуу ирж оны сүүлчээр төсөв дутуу ирсэн.
- Манай номын сан улсын 2-р зэрэглэлтэй фондонд 114940 ширхэг ном хэвлэлтэй орчин үеийн электрон каталогт орсон дотоод сүлжээнд холбогдсон, нутгийн хүн ам ихтэй төв газраас алслагдсан өвөрмөц хэллэгтэй аймаг тул номын сангийн бүх ажиллах ёстой номын сангийн стандартын дагуу орон тооны жишигт хүрэхгүй байна.
- Номын санч нар маань бүгд 2 хүний ажлыг давхар хийж байна.

Үүнд: 1.Төвөөс алслагдсан аймаг хүн ам ихтэй өвөрмөц хэллэгтэй, олон ястан үндэстэн амьдардаг.

- Ажиллаж байгаа байр, ажилчдын болон номын эрүүл ахуйн нөхцөл хангахгүй байранд үйл ажилллагаагаа явуулж байгааг анхааран нэг номын санч 2 хүний ажлыг давхар хийж байгаа тул номын сангийн ажилчин албан хаагчдын ур чадварын нэмэгдэл төсөвгүй учир дараа дараагийн жил нэмэхийг хүсэж байна.
- Одоо номын санд дөнгөж 7 хүн номын сангийн бүх ажлыг гардан хийж байна.
- Иймд манай номын сан улсын 2-р зэрэглэлтэй тул ном ба номын санчдын эрүүл ахуйг харж үзэж ажиллах ёстой 18 хүний орон тоог дараагийн жил нэмж өгөхийг анхааруулж байна.
- Энэ асуудлыг жил болгон тайланд дурдаж бичих боловч, жил дараалан биелэлээ ололгүй өдий хүрсэн.
- Харин ийм шаардлага хангахгүй газарт манай хамт олон хэвийн үйл ажиллагаагаа явуулж ирлээ.
- Төвийн болон сумдын номын сангуудын хоорондын ном солилцооны гэрээ байгуулан өөрийн фондонд байхгүй ховор номыг солилцооны журмаар олж уншигчдын санал хүсэлтийг барагдуулсан.
- 70 жилийн ойгоор Өлгийн зохиолчдын бүх номонд ном зүйн бүртгэлийг ном болгон хийж байна.
- Аймгийн 70 жилийн ойг угтаж тусгай төлөвлөгөө зохиож, төлөвлөгөөнд тусгагдсан, аймгаас төрж гарсан нэрт зохиолчдын уран бүтээлийг өргөн хүрээтэй сурталчилснаар олон уншигчдын талархал хүлээсэн.
- Байгууллагын хүний нөөцийн хангамж ашиглалтын тухай 2 хүнийг Соёлын дээд сургуулийн бакалаврын зэрэгтэй төгссөн. Хөдөө болон төвийн номын санчид, ЕБС-ийн номын санчдын сургалт семинарыг УБ хотын үндэсний номын сангийн арга зүйн хэлтэстэй хамтран явуулж Сертификат олгосон.
- МХГ-ын соёлын хяналтын чиглэлээр **"Итгэлтэй түнш"** байгууллага шалгаруулах болзолт уралдаанд үзүүлэн таниулах материалыг фото зургаар эвхмэл самбар хийж сурталчилснаар эхний байр эзэлсэн.
- Үндсэн фондын өрөө болон бүх танхимуудад хортон шавьжны уусмал тогтмол хийж, зарим өрөө тасалгааны хөшгийг сольсон.
- Гэрээр ном олгох танхимын номын санч 3 жил 7 сар ажилласан учир ном зүйч, операторч хийж байсан номын санчийг гэрээр ном олгох танхимд,

хуучин ажиллаж байсан номын санчыг ахлах номын санч, номзүйчийн ажлыг хавсруулан хийлгэж байна.

- Үндсэн фондын 90,000 ширхэг номыг сэргээн засварлаж 3513 ширхэг номыг сэлбэн зассан.
- Үндсэн фондын эргэлтийг сайжруулах зорилгоор Алтанцөгц, Алтай, Баяннуур, Дэлүүн, Улаанхус, Цэнгэл, Сагсай сумуудад салбар номын санг тогтмол ажиллуулж номыг сард нэг удаа сольж ажиллуулж байна.
- Номын сангаас ховордсон номын жагсаалт гаргаж, хөдөө болон төвийн номын сангаас солилцооны журмаар авч уншуулж байна.
- ЕБСийн номын санч нартай гэрээ хийж, гэрээний дагуу хамтарч ажиллаж байна.
- Номын сангийн барилгын зураг төслийг батлуулах экспертизд оруулахад Засаг Даргын захирамж гаргуулж 5 сая төгрөг гаргуулж өгсөн.

2. Уншлага үйлчилгээ.

Энэ жил 3500 уншигчдад шинээр карт нээж, 12500 ирэгсдэд 40,000 ном олгон уншуулж, аймгийн албан байгууллага, сургууль, сумдад салбар болон нүүдлийн номын санг тогтмол ажиллуулж, бага насны хүүхдүүдийг ном унших сонирхолтой болгох зорилгоор янз бүрийн зурагт хуудас, дүрийн тоглолт, бага хурал, бод сэтгэ, үлгэрийн ертөнцөөр аялцгаая нэртэй бяцхан ном хийж сурталчилснаар сурагчдыг номын сангийн байнгын уншигч болгосон байна.

Бүх багийн өндөр настан, ажилгүй хүмүүс, эмзэг бүлгийн хүмүүст шинээр ирсэн номуудыг зөврөөр уншуулж 454 хүнийг номын санд карттай болгосон байна.

- Өөрийн орлого болох нэг сая төгрөгийг биелүүлсэн.
- Насанд хүрэгчдийн уншлагын танхимаас 915 шинэ уншигч ба ирэгсэдэд 9503 ширхэг ном уншуулсан байна.
- Гэрээр ном олгох танхимаас 800 шинэ уншигчдад карт нээж 6000 ном хэвлэл уншуулж байна.
- Салбар номын санг бүх сургууль, ясли цэцэрлэг, Хэвлэл мэдээллийн газар, ХААН банк, Халамж, Баяннуур, Ногооннуур, көк мойнақ зэрэг сумууд болон 2,6-р багын өндөр настангуудад шинээр ирсэн казак шинэ уран зохиолын номуудыг уншуулснаар уншигчдын тоо өсөн нэмэгдэж байна.
- Хүүхдийн сонирхлын дагуу ”Уран зургийн бүтээл”, “Ном бол миний үнэнч нөхөр мөн”, “Артық болмас білгенің” сэдэвтэй 3 төрлийн дугуйланг сурагчдын дунд тогтмол явуулж байна.
- Төвийн болон сумдын номын санч нартай хамтарч фондноос ховордсон 221 ширхэг ном хэвлэлийг эрэн сурвалжилж, уншигчдын санал хүсэлтийг барагдуулан ажиллаж байна.
- Уншлагын танхим, гэрээр ном олгох, хүүхдийн уншлагын танхимаас чөлөөт сонголтоор 645 ширхэг номыг уншуулсан байна.
- «Сургуулийн номын сангийн үйл ажиллагааны хэрэгжилт» сэдэвтэй сургуулийн номын санчдын мэргэжлийг дээшлүүлэх зорилгоор сургуулийн номын санчдад 2 өдрийн сургалт явуулав.

ЕБС-ийн номын санчдад нэгдсэн ба нэгбүрчилсэн

бүртгэлүүдийн хөтлөлтийн тухай зөвлөлгөө өгч байгаа нь

- Гэрээр ном олгох танхим, уншлагын танхимуудын номын санч нар лавлагааны дэвтэр, татгалзлын карт ажиллуулж, уншигчдын захиалсан лавласан ном хэвлэлийг цаг алдалгүй олж өгч байна.
- Фонднoос ховордсон нэг хувьтай номыг канондаж уншигчдын хүртээл болгосноор давхардсан тоогоор 461 уншигчдад 230 ширхэг ном уншуулсан байна

3.Соёл олон түмний ажил

Уншигчдыг сурч боловсроход нь ном хэвлэл, мэдээ мэдээллийг түгээх, түргэн шуурхай, шинэлэг хэлбэрээр сурталчлах зорилгоор бүх номын санчдын бүтээгдхүүний гэрээнд тусгагдсан ажлууд мөн аймгийн 70 жилийн ой угтаж соел олон түмний ажлын төлөвлөгөө хийж төлөвлөгөөний дагуу бүх ажлуудыг хийлээ.

Үүнд:

- Аймгийн нэрт зохиолч Ж.Какейн уран бүтээлээс “Естен өшпес- есім” нэртэй уншигчдын бага хурал явуулсан.

- Чингис хааны дэлхийн академийн академич, ШУ-ны доктор, угсаатны зүйч Камалашийн Биқумарийг дурсан санах “Жақсының аты-ғалымның хаты өлмейді” нэртэй эрдэм шинжилгээний бага хурал.

- Зохиолч М.Мақатаевийн **“**Аққулар ұйықтағанда” номноос уншигчдын бага хурал
- “**Оюуны гэгээ сан**”-гийн багш нартай хамтран “Діни тәрбие” сэдэвт уншигчдын бага хурал
- “Тілге құрмет- елге құрмет” басылымдардың үздігі “Шұғыла” сэтгүүлээр тус сэтгүүлийн ерөнхий редактортой хамтран уншигчдын бага хурал
- 70 жилийн ойг угтаж 1-р ахлах сургуулийн Сауле багштай 4”б” ангийн сурагчид “Алдар Көсе және Шық бермес Шығайбай” номноос дүрийн тоглолттой бага хурал
- 2-р ахлах сургуулийн Ариунзул багштай 4”г” ангийн сурагчид Орос ардын үлгэр “Өнхрүүш” номоор дүрийн тоглолт
- 7-р ангиудын дунд математикийн тестийн ном болон “iQ-гээ хөгжүүлье” сэдэвт
- Бастама ахлах сургууль болон 3,4,5-р ахлах сургуулиудын 3,4,5-р ангиудын сурагчдын дунд яруу найрагч их зохиолч Д.Нацагдоржийн 104 жилийн ойг угтаж “Нацагдоржийн шүлгийг хэн уран унших вэ?” сэдэвт шүлгийн уралдаан явуулж 1,2,3-р байр эзэлсэн хүүхдүүдэд гарын бэлэг өгөв.
- 3-р ахлах сургуулийн сурагчдын дунд “АХА” тэмцээн 3 үе шаттайгаар уншлагын танхим болон хүүхдийн танхимын номын санч нартай хамтран явуулав
- Их зохиолч Абайн уран бүтээлээс “Асыл сөздің атасы” нэртэй уншигчдын бага хурал,”Абайдың қара сөздері”.”Абайдың өлеңдері, Абайдың әндері” нэртэй сэдвүүдээр Дарын цогцолбор сургуулийн 8-р 9,10-р ангийн сурагчдын дунд тэмцээн явуулж радиогоор сурталчилав.

- Ікейн нэржэмжит 1-р ахлах сургуулийн багш Жайнатай хамтран 3-р ангийн сурагчдын дунд “Ойлан тап” нэртэй уралдаан зохион явуулсан.

- 1-11 ахлах сургуулийн 7-р ангиудын дунд математикийн тестийн ном болон I Q-гийн номуудаар багш Айтолхынтай хамтран «I Q-гээ хөгжүүлье» сэдэвт ажил явуулав.

- 2-р ахлах сургуулийн 4,5-р ангиуудын дунд «Ярьдаг тэмээ буюу хойд айлын үлгэрүүд» номноос тойм яриа
- 4-р ахлах сургуулийн 5-р ангийн сурагчдын дунд “Алтын бесік” номноос” Сақау бәтеңке” сэдвээр тойм яриа
- 3,4-р ахлах сургуулийн 1,2-р ангиудын дунд “Толағай” номноос чанга уншлага
- 2-р ахлах сургуулийн 2-р ангийн сурагчдын дунд Монгол ардын үлгэрээс чанга уншлага
- 3-р ахлах сургуулийн 7-р ангиудын дунд “Қобыланды батыр” номноос тойм яриа
- Зохиолч Мақатаевийн төрсөн өдөрт зориулж уран бүтээлээс нь Багшийн коллежийн оюутнуудын дунд тойм яриа
- Багш эмч, философч Абу Насыр Әл фарабийн төрсөн өдөрт зориулж “Әл Фарабийн мэндэлсний 1140 жил” сэдэвтэй тойм яриа

Түүхт ой, баярын өдрүүдэд зориулж номын үзэсгэлэн тус-тус гаргаж ажилласан.

Үүнд:

- Багш нарын баярыг угтаж “ Багшдаа барих бидний бэлэг” сэдэвт 26 ш номоор
- “Англи хэл сурцгаая” сэдэвтэй үзэсгэлэн 22 ш номоор
- “Ұстаз ұлағаты” сэдэвтэй үзэсгэлэн 22 ш номоор
- ОУЭ-ийн баярыг тохиолдуулан ”Ару ана” сэдэвтэй 23 ш номоор
- “Қадыр Мырзаәлиевийн 75 жилийн ой” сэдэвт үзэсгэлэн 13 ш номоор
- Яруу найрагч, их зохиолч Д.Нацагдоржийн мэндэлсний 104 жилийн ойд зориулж “Д.Нацагдоржийн уран бүтээлээс” 19 ш номоор
- Әл-Фарабийн төрсөн өдөрт зориулж «Әл-Фарабийн мэндэлсэний 1140 жил сэдэвээр 10 ш номоор
- Цагаан сард “Монголын ёс заншил” сэдэвт 26 ш номоор
- Цэргийн баярт зориулж”Цэрэг эрс” сэдэвт 19 ш номоор
- Наурыз баярт зориулж 30 ш номоор
- Дэлхийн номын өдөрт зориулж шилдэг номын үзэсгэлэн 25 ш номоор
- Инээдмийн өдөрт зориулж ”Бір сәт халайық күліпте алайық” сэдэвт 28 ш номоор

- Өлгийн зохиолч, ШУ-ны доктор, угсаатны зүйч К.Биқумарын уран бүтээлээс 22 ш номоор
- Шинэ номын үзэсгэлэн 75 ш номоор
- «Хаврын шалгалтаас амжилт хүсье» сэдэвт 27 ш номоор
- Байгальтай танилцах амьтдыг таньж мэдүүлэх зорилгоор "Амьтдын ертөнцөөр аялцгаая" сэдэвт 20 ш номоор
- "Чөлөөт сонголт" сэдэвт 150 ш номоор
- Хүүхдийн танхимаас нэн ядуу хүүхдүүдийн дунд "Номын богц аян" сэдэвт цүнх аялуулж, нэг хүүхдэд 2-3 ширхэг номыг бэлгэнд өгөв.
- Төрийн албан хаагчдын шалаглтанд зориулж «хууль зүйн булан» нэртэй 19 ш номоор номын үзэсгэлэнгүүдийг тус тус гаргаж уншигчдад сурталчилж байна.

4. Ажилчдын нийгмийн асуудал

Хөдөлмөрийн гэрээ болон үр дүнгийн гэрээг хагас бүтэн жилээр дүгнэж ажлын амжилт гаргасан ажилчин албан хаагчдад улиралаар бодож ур чадварын нэмэгдэл өгсөн.

- Аймгийн 70 жилийн ойг угтаж бүх ажилчдад парадны хувцас
- Шинэ жил, ОУЭ-ийн баяр, Наурызын баяр, Хүүхдийн баяраар урамшуулан шагнал өгсөн.
- Аймгийн 70 жилийн ойгоор 1 хүн «Алтан хадас» одонгоор,
- 1 номын санчийг байгууллагын аваргаар шагнасан
- Удаан хугацаагаар эмчилгээ хийлгэсэн 1 хүнд, ар гэрийн гачигдалтай 2 хүнд нэг удаагийн буцалтгүй тэтгэмж өгсөн.
- Ажилчин албан хаагчид 5-6 хоног эмнэлэгт хэвтэж эмчилгээ хийлгэсэн үед цалинг бүтэн өгч байна.

5. Цаашид хийх ажил

- Компьютер авсан боловч бүх ажилчдад хүрэлцээ муу электрон каталогт нэгэн зэрэг орж чадахгүй байна.
- Мөн интернэтэд холбогдох хүчин чадалтай 5 ширхэг компьютер, принтер, скайнер канон зэрэг орчин үеийн тоног төхөөрөмж шаардлагатай байна.
- Ажилчин албан хаагчдын 2010 онд өөрийн орлого болох 1 сая төгрөг олох эх үүсвэргүй тул НДШ-ээс өөрийн орлого биелүүлсэн.
- Төсвийн тухай яам агентлагт асуудал тавьсан боловч 2010 онд ур чадварын төсөв хасагдсан.
- Ном авах төсвийг 2009 оноос БСШУЯ-нд төвлөрүүлсэн учир уншигчдын хэрэгцээ хангасан казак уран зохиолын болон мэргэжлийн ном авч чадахгүй байна. Уг асуудлыг хавар бүх аймгийн номын сангийн захирал нар яаманд хүсэлт тавьсан 2011 онд 3.500.0 төгрөгийн төсөв өгсөн боловч бүх сауудад хувааж өгсөн тул нэг зэрэг шинэ ном авч чадахгүй байна.
- Төвийн номын санчид УБ-хотод очиж сургалт семинарт оролцох, сургалтын зардлыг жилийн төсөвт суулгаж өгөх тухай санал болгож байна. Номын сангийн байрны үлдсэн төсвийг орон нутгийн удирдлага болон УИХ-ын гишүүдэд мөн БСШУЯ-д оруулж 2011оны 6-р сарын төсвийн тодотголд оруулах.

БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН
2010 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. Удирдлагын үйлчилгээ

Байгууллагын 2010 онд дэвшүүлсэн эрхэм зорилго, зорилтоо хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа.

Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээг Боловсрол Соёлын газрын даргатай байгуулан ажиллаж, гэрээний дагуу Боловсрол Соёлын газрын даргад 2010 онд нийт 43 бүтээгдэхүүн нийлүүлэхээр төлөвлөсөн бөгөөд жилийн хугацаанд 43 бүтээгдэхүүнийг нийлүүллээ. Тухайн үед ач холбогдолтой гэж үзсэн тусгай захиалгат бүтээгдэхүүн 8-ийг төлөвлөж хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Аймгийн Нийтийн номын сангийн ажилтан, албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээг сунган ажиллаж, энэ онд захиргааны зөвлөлийн хурлыг 11удаа, бүх ажилтны хурлыг 5 удаа хийж, Номын сангийн ном хэвлэлийн тооллого тооцоо, данс бүртгэл шинэчлэх тайлан, алдагдсан ном хэвлэлийг төлүүлэх, ном актлах, цалин урамшуулал болон боловсон хүчний асуудлыг хэлэлцэж тухай бүр шийдвэр гарган ажиллаа.

Захиргааны зөвлөлийн хурлын шийдвэрээр тушаал гаргаж ажил хосолсон нэмэгдэл, ур чадварын нэмэгдлийг цалингийн сандаа багтаан 5 ажилчдад олгож байна. Өмч эзэмшигчийн гэрээг ажилчидтай байгуулан ажилласан.

Хүний нөөц, нийгмийн халамжийн талаар дараах арга хэмжээнүүдийг авч ажиллаа. Үүнд:

Тайлангийн хугацаанд Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтаж номын санчид, ажилчидын дунд “Харилцааны соёл” “Би бидний авьяас чадвар”, “Орон нутгийн номын санчдын уулзалт ярилцлага”, “Багаар ажиллах”, “Цагийн менежмент”, “Тайлант өдөрлөг” зэрэг арга хэмжээг хөтөлбөр төлөвлөгөөтэйгээр зохион байгуулж 535000 төгрөг зарцуулсан.

Нийт ажилчдад цалинтай чөлөөг 1-2 удаа, цалингүй чөлөөг 1 удаа, эмнэлэгт хүн асрахад цалинг бүтнээр олгон, акт авсан үед цалинг 1 удаа олгож, үр дүнгийн гэрээг хагас бүтэн жилээр дүгнэн урамшуулал олголоо.

Номын санчдыг мэргэшүүлэх, туршлага судлуулах, мөн БСШУЯ, МУҮНС бусад байгууллагуудаас зохион байгуулж байгаа сургалтанд номын санчидаа хамруулж, мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх асуудалд номын сангийн захиргаа ихээхэн анхаарч ажиллаж байна.

Номын санчид, ахмадуудын нийгмийн асуудалд онцгой анхааран ажиллаж, төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн хуулийн дагуу хөдөлмөр бүтээлээрээ бусдыг манлайлан ажиллагсад, өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудыг нийтдээ 1.765.0 төгрөгийн шагнал, урамшуулал, нэг удаагийн тэтгэмжийг олголоо.

Хамтын ажиллагаатай Баянлиг сумын хөгжил, өвөлжилт хаваржилт малчдад 200000төгрөг, Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийн өдрөөр Аймгийн эмэгтэйчүүдийн зөвлөлтэй хамтран “Эхчүүд эмэгтэйчүүд”-ийн гоцлол дууны уралдаан, Ном эрдэм аяны хүрээнд “Шилдэг номын санчид, багш нарын” уулзалт, Хүүхдийн байгууллага үүсэн хөгжсөний 85 жилийн ойд 110000 төгрөгний шагнал зэргийг тус тус олголоо.

Мөн номын санчдын чөлөөт цагаар номын сангаас төлбөрийг нь хариуцан заал авч волейбол, сагсан бөмбөгийн тэмцээнийг 3 удаа зохион байгуулсан.

Гадаад харилцаа

Аймгийн нийтийн номын сан нь Нээлттэй нийгэм форум, Мянганы сорилын сан, Азийн сан зэрэг гадаадын байгууллагатай хамтран номын фондыг баяжуулан ажиллалаа.

Санхүүгийн мэдээллийн үйлчилгээ

Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн хуулийг хэрэгжүүлэн мэдээг сар бүр төсвийн гүйцэтгэлээр гаргаж төсвийн статистик мэдээллийг Төрийн санд өгч дараа сарын санхүүжилтийн эрхээ авч ажиллалаа. Нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам зааврыг мөрдлөг болгож санхүүгийн тайлан холбогдох мэдээг хугацаанд нь Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэс, Төрийн санд тус тус гарган өгсөн.

Аймгийн Татварын хэлтэстэй хүн амын орлогын татварын тооцоо болон цалингийн сангийн тооцоог сар бүр хийж ажилласан. Төсвийг зарцуулалтын дагуу зарцуулж 1420.0 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого олж нийт 66.959.9 мянган төгрөгийн зардал гаргаж байна.

Тайлангийн хугацаанд байгууллагын менежментийг боловсронгуй болгоход үйл ажиллагааны төлөвлөгөөг жил, сараар баталж, тайланг хагас бүтэн жил, сар бүр тайлагнаж үр дүнг тооцож, зорилго зорилт үйл ажиллагаатай холбоотой өдөр тутмын шийдвэр гаргаж, мэдээллийн зөв байдлыг хангах үүднээс стандартын хэрэгжилтэнд хяналт тавьж гарсан ололт амжилт, алдаа дутагдлыг дүгнэн ажлын шаардлага тавьж, ажилчдад ажил хийх сэдэл өгөх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэн ажилчдаас гарсан саналыг дэмжин хамтран хэрэгжүүлэн ажиллалаа. Өөрөө өөртөө дүгнэлт хийх, бусдыг үнэлэх, хүндэтгэлтэй хандахад ахиц дэвшил гарсан.

Амжилт хүсэн өөрийн хариуцсан ажлаас өөр ажил өгөх, үүрэг даалгавар хүлээлгэх, манлайлах чадварыг үнэлэх, Ном зүйч, бичиг хэргийн ажилтан Б.Түвшинчимэг, фондоч Я.Гэрэлтуяа, номын санч Б.Должин, номзүйч Ц.Сарантуяа нарт Улаанбаатар хотод ажлаар явахад ажлаа төлөөлүүлэн 5 ажил гүйцэтгүүлэн тус бүр сайн гүйцэтгэн илтгэх хуудсаар тайлагналаа.

Цагийн менежментийг сайжруулахад хүн бүр ажлын цагаа сайн баримталж, ажилдаа үр бүтээлтэй ажилласан. “Цаг зөв зохицуулах 20 алхам”, “Цагийн менежмент” гэсэн зөвлөмжийг хүн бүрт танилцуулж хувилан тарааж өрөөнүүддээ байрлууллаа.

Байгууллагыг өөрчилж шинэ үйлчилгээ бий болгоход номын сангийн автоматчлагдсан цахим шинэ үйлчилгээг нэвтрүүлж 2.250.0 төгрөгөөр техник хэрэгсэл, компьютер, өнгөт хэвлэгч, процессорын шинэчлэлт хийлээ.

Байгууллага хамт олноороо баг бүрдүүлж, “Баг болж ажиллах” сургалтыг зохион байгуулж, үр нөлөөтэй баг, үр нөлөөгүй багийн талаар багаар ажиллах тэмцээнийг зохион байгуулж 6 ажилчид 2 баг болон оролцож Я.Гэрэлтуяа ахлагчтай баг тэргүүлж, Ц.Сарантуяа ахлагчтай баг удаалж дээрх сургалт арга хэмжээний шагналд 486000 төгрөг зарцууллаа.

Хүний нөөцийн хувьд мэргэжил боловсролтой ур чадвартай боловсон хүчнээр хангагдаж нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дотоод журмын дагуу шат дараалсан арга хэмжээнүүдийг авч ажилласан.

Соёлын тухай хууль, төрөөс баримтлах соёлын бодлогыг хэрэгжүүлэн сангийн сайд БСШУЯ-ын хамтарсан 2006 оны 357 дугаар тушаал ном хэвлэлийг дахин үнэлэх журмаар 45056 ширхэг 43.930.129 төгрөгийн номыг дахин үнэлэн БСШУЯ-ын 2007 оны 415 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт "Аймгийн нийтийн номын сангийн үлгэрчилсэн журам"-ыг шинэчлэн боловсруулан мөрдөж, БСШУЯ-ны 2007 оны "Алдагдсан ном хэвлэлийг төлүүлэх журам"-ыг хэрэгжүүлэн "Их мэдэх" уншлагын танхимын номын санчийн ойрын фондонд тооллого хийж дутсан номыг төлөх талаар арга хэмжээ авч албан бичиг өгсөн ч хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Соёлын өвийг хамгаалах хуулийг хэрэгжүүлэхэд үнэт, ховор номын бүртгэлд 4 номыг бүртгэж, БСШУЯ-ны 2005 оны 441 дүгээр тушаалаар Номын сангийн данс бүртгэлийг шинэчлэх ажлыг хийж дуусган монгол номын 1-17 данс, орос англи номын 1-2 данс нийт 19 дансанд 45056 ширхэг номыг дахин шинэчлэн бүртгэсэн.

Монгол улсын стандарт "Архив номын сангийн өв соёлыг хадгалж хамгаалах стандарт" MNS-11799-2007-г хэрэгжүүлэн фондны 900, лавлагаа арга зүйн танхимын 40, хүүхдийн уншлагын танхимын 55 номыг сэргээн засварлаж, ном сэргээн засварлах жижиг булан, лабораторийг фондонд байгуулж 5597. номыг формолины 0.3%-ийн уусмалаар ариутган үйлчилгээнд гаргалаа.

Номын сангийн орчин нөхцөлийг сайжруулах үйл ажиллагаанд тавигдах шаардлага MNS 5742:2007 стандартаар номын сангийн норматив, номын санчдад тавигдах шаардлага, формуляр,захиалгын хуудас, өдөр тутмын бүртгэл татгалзал, өгөгдсөн ном зүйн бүртгэлийг хөтөлж тогтмолжуулсан.

Архив бичиг хэргийн стандартын дагуу бичиг баримтыг нэгж тасгийн номын санчид өөрсдөө шивэн гаргаж, бичиг хэргийн ажилтнаар хянуулж байгууллагын захиргаанд сар бүр өгч 7 ажилчдыг архив бичиг хэргийн сургалтанд сургасан.

Байгууллагын дотоод журмыг хамт олны хурлаар хэлэлцүүлэн саналыг авч, саналыг тусган захирлын тушаалаар батлан мөрдөж ажиллалаа. Ажиллагсдын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулан ажлын хэсэг томилон боловсруулж баталгаажуулллаа. Төрийн албан хаагчийн ёс зүй, номын сангийн ёс зүйг баримтлан ажилласан ч "Их мэдэх уншлагын танхим"-ын номын сангийн ёс зүйтэй холбоотой 2 санал уншигчдаас ирсэнийг өөрт нь зөвлөж ёс зүй сайжирсан.

Ерөнхий менежер ажилчидтай үр дүнгийн гэрээг байгуулж, хагас бүтэн жилээр хэрэгжилтийг гаргуулан дүгнэн мөнгөн урамшуулал олголоо.

Аймгийн засаг даргын 2009-2012 оны мөрийн хөтөлбөрт тусгагдсан 3 заалт бүхий 4 арга хэмжээ, 2010 оны Аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх 3 заалт бүхий 5 арга хэмжээг заалт бүрээр хэрэгжилтийг гаргалаа.

Аймаг, байгуулагын сахилга хариуцлагын зөвлөгөөнөөс гарсан ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж, 1 хүнд сахилгын арга хэмжээг цалингийн 20%-иар авсан.

Номын сангийн үйл ажиллагааг сурталчлахад "Нийгмийн салбарын нээлттэй өдөр" 11сард, жилийн хугацаанд хийж ирсэн үйл ажиллагааны тайлант өдөрлөгийг 12 сарын 10-нд 2 удаа удирдамж хөтөлбөртэйгээр явуулж, Баянхонгор телевизээр сурталчилсан. Хэрэглэгчидээс сэтгэл ханамжийн судалгааг 9удаа 161уншигчдаас хүлээн авч гарсан саналыг дүгнэн хамтарч ажиллан үйл ажиллагааг суртачлах

нугалбар мэдээлэл 3 төрөл 100 ширхэг, сонин 2 төрөл 90 ширхэг, мэдээлэл 1 төрөл 30 ширхэг тус тус боловсруулан хэвлэн уншигчдад тараасан.



Нээлттэй нийгэм форумаас хэрэгжүүлсэн “Хичээлээс гадуурх хүүхэд хөгжүүлэх хөтөлбөр”-ийг 2009 оны 2 сараас 2010 оны 3 сарын 1 хүртэл жилийн хугацаатай Багийн ахлагч, гишүүд 20 хүүхдүүдтэй хамтран хэрэгжүүлсэн.

Морин хуур ,бий биелгээ, уртын дуу, хөөмийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гарын авлага бэлтгэн сургалт зохион байгуулсан.



LIB4U программын сургалтанд 5 номын санчийг сурган 5 номын санч LIB4U программд ном оруулж байна. Ажилтан бүр ажлын байрны тодорхойлолтын мэдлэг чадварын түвшинд компьютерийн Word-2007 программ дээр бичиг баримтаа

боловсруулах чадварыг бүрэн эзэмшиж англи хэл, хууль эрх зүйн мэдлэг чадвараа дээшлүүлсэн.

Бичиг хэрэг, цэвэрлэгээ үйлчилгээний материалын хангалтыг тухай бүх хийж 880,000 төгрөг зарцуулсан.

Мэдээллийн ажилтан М.Мөнхдалай Соёлын дээд сургуулийн эчнээгийн ангид 03.15-06-01-ны хоорондох хугацаанд суралцан бакалавр зэрэгтэйгээр мэргэжлийн номын санч,мэдээллийн ажилтан болон бэлтгэгдлээ.

2010.02.03-04-ны өдрүүдэд хамтын ажиллагаатай Баянлиг сумд ном зүйч Б.Түвшинчимэг очиж, тус сумын малчдын зөвлөгөөнд оролцож, байгууллагын ажилчдын зүгээс цуглуулсан 16ш нэмнээ, 10 толгой шүдэнз, 3ш лаа, 8ш саван зэрэг эд зүйсийг, 200.000 төгрөгний хамт сумын засаг даргад гардуулан өглөө.

Монгол улсын Үндэсний номын сан, Соёл урлагийн хорооноос хамтран зохион явуулсан "Үндэсний бичиг үсгийн баяр" арга хэмжээнд захирал М.Мянган, номын санч Б.Должин, ном зүйч Б.Түвшинчимэг, мэдээллийн ажилтан М.Мөнхдалай нар 2010.05.07-09-ны өдрүүдэд хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаанд оролцож, 2010.05.10-11-ны өдрүүдэд Хотын төв номын сан, Хүүхдийн номын ордон, ШУТИС-ын номын сангуудын үйл ажиллагаатай танилцаж, туршлага судаллаа. Туршлага судалсаны үр дүнд: Фондын өрөөнд тавиур бүрийн хооронд түмпэнд ус хийж тавих, сонинг сар бүрээр нэгж болгон үдэх материалын тооцоог гаргасан. Уншлагын танхимуудад суудлын тоогоор энгэрийн зүүлт хийсэн.Тасаг нэгж бүрт өөрсдийн танилцуулга, номын татгалзал авах хайрцаг ажиллуулж байна.

Монгол үндэсний номын сан дээр Солонгос, Монголын хамтарсан "Соёлын өвийг хадгалан хамгаалалт" семинарт фондоч Я.Гэрэлтуяа 2010 оны 6 сарын 29-нээс 7 сарын 2 хүртэл 4 хоног, Соёл урлагийн хороо, БСШУЯ, Үндэсний номын сан, Хүүхдийн номын ордоноос зохион байгуулсан "Номын яармаг 2010" сургалт арга хэмжээнд 2010 оны 11 сарын 11-13-ны өдрүүдэд номын санч Б.Должин, захирал М.Мянган нар оролцож мэргэжлээ дээшлүүлсэн. 5 хүний мэргэжил дээшлүүлсэн томилолт, замын зардалд 453500 төгрөг байгууллагаас зарцууллаа.

Хөдөө орон нутгийн номын санчид,соёлын төвийн эрхлэгч нар,аймгийн төвийн сургуулийн номын санчдад Монгол улсын үндэсний номын сантай хамтран "Үндэсний бичиг үсгийн баяр" сургалт арга хэмжээг зохион явуулж, аймгийн төв, сумдын нийт 25 номын санчид оролцож сургалтыг МУҮНС-ийн ахлах арга зүйч Б.Энхжаргал зохион явуулсан. Монгол Улсын засгийн газрын 140-р тогтоолоор БСШУЯ-наас "Шилдэг ном" шалгаруулан бэлгийн 18 нэр төрлийн 342 ширхэг 2.086.0 төгрөгийн шинэ номоор 19 сумын номын сангийн фондыг баяжууллаа. Мөн БСГ-аас зохион байгуулсан соёлын ажилтны 1 өдрийн сургалтанд хамт олноороо оролцлоо.

Номын сангийн үйл ажиллагааг сурталчлахад "Нийгмийн салбарын нээлттэй өдөр" 11 сард, жилийн хугацаанд хийж ирсэн үйл ажиллагааны тайлант өдөрлөгийг 12 сарын 10-нд 2 удаа удирдамж хөтөлбөртэйгээр явуулж, Баянхонгор телевизээр суртчилсан. Аймгийн Нийгмийн салбарын 14 хоногийн аяны хзрээнд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан, нээлтийн ажиллагаа "Нээлттэй өдөрлөг"-ийн арга хэмжээнд хамт олноороо оролцож,"Ухаан далай номоос эхтэй" номын үзэсгэлэн, шинэ номын худалдаа, "Ном-эрдэм" аяны 2010 оны шилдэг бүтээлүүдийн үзэсгэлэн, хүүхдүүдийн дунд хонжворт сугалаа зэрэг олон арга хэмжээг зохион явууллаа.Мөн "Ном-эрдэм" аяны нээлтийн ажиллагааг зохион байгуулж, шилдгүүдийн шагналыг гардуулсан.

Хэрэглэгчдээс сэтгэл ханамжийн судалгааг 9 удаа 161 хүнээс номын сангийн үйл ажиллагаа,зохион явуулж буй ажлуудын талаар авахад, судалгаанд 15-25 насны залуус 23-35,55 насны иргэд хамрагдсан. Судалгааны дүнг нэгтгэн үзэхэд номын сангийн орчин нөхцөл, үйл ажиллагаа сайжирсан гэсэн санал нийт оролцогчдын 83 нь буюу 73.8%, номын санчдын зан харилцаа сайн байна гэсэн санал нийт оролцогчдын 80 нь буюу 71,2%, номын сангаа улам илүү тохижуулах, цайны газартай болох, ТҮЦ ажиллуулах, цагаа уртасгах, хагас бүтэн сайны аль нэгэнд ажилладаг болох зэрэг саналууд нийт оролцогчдын 43%-ийг эзэлж байна.

Уншигчидаас хүлээн авч гарсан саналыг дүгнэн хамтарч ажиллан үйл ажиллагааг сурталчлах нугалбар мэдээлэл 3 төрөл 100 ширхэг, сонин 2 төрөл 90 ширхэг, мэдээлэл 1 төрөл 30 ширхэг тус тус боловсруулан хэвлэн уншигчдад тараасан.

2.Номын сангийн үйлчилгээ

Лавлагаа арга зүй, каталог картын сан

Тайлангийн хугацаанд нийт 139 лавлагааг уншигчдад өгч, өгөгдсөн номзүйн лавлагааны бүртгэлийг стандартын дагуу хөтлөн ажиллалаа. Каталог ашиглалтад хяналт тавьж, 39 уншигч каталог ашигласныг каталог ашиглалтын бүртгэлд хөтлөн, каталогийн картыг цэгцлэн, МСҮТ-ийн оюутнуудад зориулан мэргэжлийн 110 номоор картын санг хийж, каталог, картын санг баяжууллаа.

Лавлагаа арга зүйн танхимд Ш.Лувсанвандангийн 100 жилийн ойд зориулсан түүний 4 ном, намтрын товчоон, уран бүтээлийн жагсаалтыг гарган буланг байгууллаа. Мөн лавлагаа аргазүйн 1197 номыг 0.3%-ийн формалины уусмалаар ариутгасан.

Фондын ажил

Фондонд Соёл урлагийн сангийн хөрөнгөөр шинээр 164 нэр төрлийн 359 ширхэг 2.533.0 төгрөгийн ном, бэлэг хандиваар ирсэн 34 нэр төрлийн 103 ширхэг 212522 төгрөгийн номоор тус тус фондыг баяжуулж, номуудыг ангилалтын дагуу тавиурт байрлуулж, электрон каталогт орууллаа. Ховор номын бүртгэл мэдээллийн санд “Монгол үндэсний хувцас”, ”Монгол хэлний хураангуй тайлбар толь бичиг”, “Монгол костюм”, “Монгол улсын үндэсний атлас”, зэрэг 4 номыг бүртгэн баяжууллаа.



Номын фонднoос урагдаж гэмтсэн 433 номыг сэргээн засварлаж, номын фондонд электрон 60 ширхэг, хэвлэмэл бус материалын санг 75 материалаар бүрдүүлэн жагсаалт гаргасан. Эхний хагас жилийн сонингуудыг 28 нэгж болгон үдэж, гялгар цаасан хавтас хийж, сонин сэтгүүлийн нэгбүрчилсэн бүртгэлд бүртгэн тэмдэг дарж баталгаажуулан фондонд байрлууллаа. Формалины 0,3%-ийн уусмалаар 4400 номыг ариутгасан. Алдагдсан ном хэвлэлийг төлүүлэх журмын дагуу уншигчын алдсан Баастын “Алтан дөлт цэцэг” номыг номоор нь төлүүлсэн.

Уншлага үйлчилгээ.

Байнгын 3800 уншигчдад карт нээж, 20000 ирцээр 55000 ном олгож үйлчиллээ. Гэрээр ном олгох тасаг, уншлагын танхимуудаар захиалгаар 22500 ном олгож, тооцоо нийлж, олгосон номуудыг буцаан тавиурт байрлууллаа.

Номын сан хоорондын ном солилцооны гэрээг МСҮТ-ийн номын сан, Эрдэм ахлах сургуулийн номын сангуудтай хийж, ном солилцоог МСҮТ-д хоёр удаа 12 ном, Эрдэм ахлах сургуульд 3 удаа 32 ном, нийт 5 удаа 44 ном олгож, хугацаанд нь буцааж авч тооцоо хийсэн, Баян- Ойт сургуулийн багш нарын дунд явуулын номын сан 15 номоор ажиллуулсан.

Номын үзэсгэлэнг “Иргэний нийгэм хүний эрх”, “Эх үрс”, “шинэ ном”, “Үндэсний бичиг минү”, “Уншихгүй байж болохгүй номууд”, “Үндэсний бичиг үсгийн баяр”, “Нээлттэй хаалганы өдөр“, “Ухаан далай номноос эхтэй”, “Хүүхэд, хүүхэддээээлтэй”, “Монгол ёс заншил” хичээлийн шинэ жилд “Морин хуур, уртын дуу, бий биелгээ”, Нацагдоржийн ойд “Тусгаар тогтнол” “Шинэ ном” зэрэг үзэсгэлэнгүүдийг 309 номоор гаргаж 650 уншигчдад уншуулж сурталчиллаа.

“Их мэдэх” уншлагын танхимаас Эрдэнэмандал ахлах сургуулийн 1-р ангийн 25 сурагчдын дунд ”Хэлтэй бол хөлтэй” сургалтыг 2 үе шаттайгаар зохион байгуулан явууллаа.1-р шатанд англи үсэг ,тоонуудыг цээжлүүлэх зорилгоор тарааж өгөх материал бэлдэн тарааж, 2-р шатанд цээжилсэн үсэг тоонуудыг шалгаж,аваргуудыг тодруулллаа.1-р байранд А.Дөлгөөн, 2-р байранд Э.Номин, 3-р байранд Базархүү нар тус тус шалгарч, дурсамжаар шагнууллаа.

Электрон үйлчилгээг 6-р цэцэрлэг, 7-р цэцэрлэг, Баянойт цэцэрлэг, Номгон ахлах сургуулийн 1а,1в,1г Номундалай цогцолбор сургуулийн1е,1а, Эрдэнэмандал ахлах сургуулийн 1д,1е ангийн нийт 720 сурагчдыг номын сандаа хамруулан “Алтан загасны үлгэр”,”Болдоггүй бор өвгөн”, ”Царцаа намжил”, “Аргат өвгөн”, “Увидаст мод” гэх мэт үлгэрүүдийг сонсгож ойлгосноо бусаддаа ярьж харилцан ярилцах замаар зохион явуулсан.

Нийтийн уншлагын танхим электрон мэдээллийн үйлчилгээнд шинээр 250 уншигч хамрагдаж Х.Дэмбэрэлийн дууны CD, орчин үеийн дуулаачдын CD-г бэлтгэн электрон мээдээллийн сангаар үйлчиллээ.

Уншигчдын эрэлт хэрэгцээг татгалзлаар захиалга авахад бүртгэлд 61 ном бүртгэн авч, номын захиалганд оруулж Дэлхийн түүх, Ламын гэгээний номууд, шатар даамны номууд Цүндээлэгийн найзууд, Урианхайн сүүлийн үеийн зохиолын номуудыг худалдан авч уншигчдын хэрэгцээг хангаж ажиллалаа.

Соёл олон түмний ажил

“Их мэдэх” хүүхдийн уншлагын танхимаас “Шинэ номын үзэсгэлэн”, “Үлгэрийн орноор аялцгаая”, “Нээлттэй хаалганы өдөр”, “2010-2011 оны хичээлийн шинэ жилд”, Хүүхдийн зохиолч Ж.Дашдондогийн “Алтан үлгэр” 108 номын баяр, “Шинэ номын үзэсгэлэн”-г 190 номоор гаргаж, ЕБС-ийн Эрдэнэмандал, Эрдэм, Баянойт,

Номгон ахлах сургуулийн 1-р ангийн 239 сурагчдын дунд урилгат захиалгат үйлчилгээг 4 удаа явуулж, хүүхдийн үлгэрийн номуудаар үйлчиллээ.

СХУ-ны доктор Ш.Чимгээгийн нэрэмжит “Ном эрдэм” аяны 11 дах жилийн үйл ажиллагааг аймгийн ХДТ-т 2010.01.08-ны өдөр зохион байгуулан явууллаа. Болзлыг шинэчлэн боловсруулж бүх албан байгууллагууд, аймгийн төвийн 7 баг, цэцэрлэгүүд, ЕБС-иуд,сумдуудад тараан хүргэсэн. Аяны нээлтийн ажиллагаанд 800 гаруй уншигч хүүхдүүд оролцож, доктор Ш.Чимгээгийн “Бурханаас ерөөсөн амьдрал минь” номын нээлтийн ажиллагааг мөн зохион байгуулсан. Аяныг эрчимжүүлэн зохион байгуулах ажлын хүрээнд 6-р цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн бяцхан оролцогчид, уншлагын танхимын уншигчдад удирдамжийг танилцуулж, идэвхтэй оролцдог, номын санчид, багш нарын дунд уулзалт ярилцлага, 5-р багтай хамтран тус багийн 22ахмад настантай СХУ-ны доктор Ш.Чимгээг уулзуулж, ”Бурханаас ерөөсөн амьдрал минь” номоор зохиогч уншигчдын уулзалтыг зохион байгууллаа.

Хаалтын үйл ажиллагааг Эх үрсийн баяр буюу 6 сарын 1-ны өдрөөр зохион явуулж номинаци бүрээр нь шалгаруулж шагналуудыг нь гардуулж өгсөн.

“Номын мэргэд” дугуйланг нийт 6 хүүхдийн бүрэлдэхүүнтэйгээр явуулж, эхний ээлжинд дугуйлангийн хүүхдүүдийг өрөө тасгийн үйл ажиллагаатай танилцуулж, анкет, эмблемийг хийж, цаашид хийх ажлын талаар төлөвлөгөө гаргасан мөн уншилтанд хамрагдаж байгаа уншигчдын дэг журамтай байхад нь ихээхэн анхаарч өөрийн сургуулийн номын санд хамрагддаггүй хүүхдүүдийг номын санд хамруулах, номын сангийн талаар мэдээлэл хийсэн.

ОУ-ын эмэгтэйчүүдийн баярыг угтаж “Ээждээ барих бидний бэлэг” гар зургийн уралдааныг зохион явууллаа. Уралдаанд 3-р сургуулийн 7-Б ангийн сурагч Э.Цэнд-Аюуш түрүүлж,дурсамж, медалаар шагнуулсан.

“Би ном бүтээж чадна” уралдааныг явуулж, 2-р сургуулийн 5-А ангийн сурагч Гантогтох түрүүлсэн. Их мэдэх уншлагын танхимаас хүүхдийн зохиолч Ж.Дашдондогийн “Алтан үлгэр” 108 номын баярыг зохион явуулсан. Үүнд: 2-р сургуулийн 5-б ангийн Норовсамбуу, Лодойсамбуу, Гантулга нар тус тус шагналт байр эзэлсэн.

“Ардын уламжлалаа эрхэмлэн дээдлэе” уралдааныг 2-р сургуулийн 7-а,в,г ангиудыг хамруулан зохион явуулсан. Үүнд: 7-а Монголын ирээдүй баг хошуучлан 1-р байр эзэлж 2-р байрт 7-в Эрч хүч баг, 3-р байрт 7-г Отгонтэнгэр багууд тус тус оролцлоо.

Нийтийн уншлагын танхимаас “Байгаль эхээ хайрлан хамгаалъя” сэдэвт сургалт, “Ногоон байгууламж ба аялал экскурс лекц”-ийг БОАЖГ, ХТХ-ийн мэргэжилтэн Оюунжаргал, Өнөржаргал Баянзул, МСҮТ-ийн ХАА 1-а ангийн оюутнууд ивээн тэтгэж сургалтанд оролцсон 3 хүнд дурсгалын зүйл гардуулан өгсөн, Мөн “Бичиг үсгийн үндэсний баяр”-ыг угтан МҮНС, АННС, БСг хамтран хөдөө орон нутгийн соёлын төвийн дарга нар номын санч нарын дунд сургалт зохион явуулсан.

3. Мэдээллийн үйлчилгээ.

Тухайн номын санд ашиглагдаж байгаа 8 компьютерүүдийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллалаа. (вирустсэн компьютерүүдийн вирусийг устгах үйлдэлийн системд доголдол гарсан компьютерүүдийг засах ба форматлах мөн клийнап, депрамэнт, ресент гэх мэт үйл ажиллагаа 26 удаа хийн, байгууллага шинэ байранд орсонтой холбогдуулж дотоод сүлжээг шинээр тавьж тохиргоог бүх компьютерт хийсэн .

Номын сангийн LIB4U цогц программыг шинээр тавьсан сүлжээнд тохируулан холбож нийт номын 66 хувь буюу 26150 номыг электрон каталогит оруулж, техник ажиллагаа хийж, хайлтын компьютерт байрлуулан цахим үйлчилгээг явуулж ирлээ. Байгууллагын дотоод сүлжээний гэмтлийг 4 удаа засаж янзалсан.

Байгууллагын вэб сайтыг боловсруулан байгууллага, тасаг нэгжийн мэдээллийг оруулсанаас гадна бусад номын сан, Дэлхийн нийтийн мэдээллийг оруулж шинээр 4 модул нэмлээ.

Байгууллагын автоматжуулалтыг цогцоор нь шийдвэрлэхэд Аймгийн Нийгэм эдийн засгийг хөгжүүлэх 2010 оны үндсэн чиглэлд орсон 2.1.1.-г заалтыг хэрэгжүүлэхэд Аймгийн Засаг даргад санал тавьж халаалтын хэмнэгдсэн хөрөнгөөс хөрөнгө гаргах шийдвэрийг шийдвэрлүүлж, дохиолол хамгаалалтын систем, камер, номын сангийн цогц LIB4U программын шинэчилсэн хувилбар, интернэтийн өрөөний компьютер, компьютерийн ширээ зэргийг цогцоор нь шийдэж Сансар сафети, Волвес ХХК-тай гэрээ хийж 11.500.0 төгрөгний төсвөөр автоматчлагдлаа.

Хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд дааж авсан 2 хүүхдийг англи хэлний сургалтанд сургасан.

Сард нэг удаа интернэтээс тухайн үед нийгэмд болж байгаа шинэлэг мэдээллүүдээс авч мэдээллийн самбарт гаргасан. Жнь: ”Соёл ба хөгжил” “Оюутолгойн гэрээний явцтай танилцлаа” 80 хоногт дэлхийг тойрох мотоцикль бүтээлээ”, “Дарс хөргөгч автомат машин бүтээлээ”, ”Номын яармаг 2010”, “Дэлхийд

манлайлагч хамгийн найдвартай толь бичиг", "Баянхонгор аймагт хөгжих боломж байна", "2010 оны дэлхийн топ 10 үнэтэй машин", "Бидэнд хэрэгтэй байгаа топ 10 технологийн дэвшил", "Английн ББС агентлагаас гаргасан дэлхийн шилдэг 100 ном", "Дэлхийн хамгийн үнэтэй Хаус", "Бие биелгээчдийн улсын уралдаан" "2010 оны топ 10 улс төрч" гэх мэт мэдээллүүд Байгууллагын ажлын амжилтын Амжилт сонинг боловсруулан бэлтгэж 40 ширхэгийг хэвлэн гаргасан .

"Гучин жилийн дараах Монгол улс /прогноз/", "Олон улсын энхийг сахиулах үйлсэд монголын оролцоо", "АНУ-ын Конгрессийн номын сан", "Дэлхийн томоохон хотууд", "Майкл Дэлл" сэдвүүдээр гарын авлага хийж мэдээллийн санг баяжуулсан





Номын сангийн лавлагаа арга зүйн танхимын үйл ажиллагааг цахимжуулах лавлагааны жижиг программ зохион компьютерт нь суулган үйлчилгээ явуулж ирлээ.

Байгууллагын товч танилцуулгыг тасаг нэгж бүрээр нь 40 ширхэгийг хийж уншигчдад тарааж үйлчилсэн. Мэдээллийн хадгалалт хамгаалалтыг сайжруулахад Бэкап ашиглан мэдээллээ нөөцөлсөн.

Улаанбаатар хотын төв номын сан, Дорнодын номын сан, Соёлын дээд сургуулийн номын сангуудтай и-мэйлээр харилцан туршлага солилцсон.

Интернэтийг мэдээллийн шинэ хэрэглүүр болгон ашиглахад хүүхэд залуучуудыг сургах зорилгоор 240 хүүхдэд интернэтээр үйлчилж арга зүйн зөвлөгөө өгсөн.

Байгууллагын вэб хуудасын мэдээллийг боловсруулж "Ид шид чиний хувьд", "Сэрж буй Монгол" гэсэн сэдвүүдээр мэдээлэл байрлуулсан.

"Хөгжлийн даяарчлал ТББ–тай хамтран "Сэтгэлгээний ногоон гэрэл", "Хүн байхын учир" гэсэн сэдвүүдээр лекц зохион байгуулж, англи хэлний анхан шатны сургалт зохион байгуулан, байгууллагын ажилчдад хуулийн сургалт явуулсан.

Мэдээллийн самбарт “Дэлхийн хамгийн шилдэг Санта хэн бэ”, ”Соёл ба хөгжил” сэдвээр мэдээлэл гаргасан.

“Олон улсын энхийг сахиулах үйлсэд монголын оролцоо”, “Компьютераа хэрхэн сайн ашиглаж сурах вэ”, ”Гадаад хэл хэрхэн хурдан сурах вэ?”, ”IQ гэж юу вэ”, “Баянхонгор аймгийн уртын дуучид болон морин хуурчдын амжилт, бүтээл” намтраар тохимол, ” Морин хуурын үүсэл, хөгжил”, “Уртын дууч Норовбанзадын намтар уран бүтээл”, ”Эв эеэр бүтээцгээе”, “Баяр наадмын манлай”, ”Баянхонгор аймгийн уртын дууны үүсэл хөгжил”, “Анхаарлаа хөгжүүлцгээе”, ”Дагаад хийгээрэй”, “Би бодож чадна”, “Шагай, шагайны үүсэл хөгжил”, “Улаан малгайт”, “Хаан артур ба шидэт илд”, СӨНХ-ийн буланд “Хэл яриагаа хөгжүүлье”, “Интернэт гэж юу вэ” çýðýã гарын авлагóóä лавлагаа арга зүйн танхимаас номын санчдад зориулан “Номын сангийн мэдлэгт” ном зүйн бүртгэлийг ном болгон хэвлэж гарган орон нутгийн 19 номын санчдад тараан өгсөн.

4.Номын сангийн орчныг сайжруулах үйлчилгээ

Цэвэрлэгээ үйлчилгээ

Байгууллагын цэвэрлэгээ үйлчилгээг ажлын байрны тодорхойлолтын дагуу стандартын түвшинд хийж ажиллаж байна. Тогтсон хугацаанд их цэвэрлэгээг чанартай хийж, нийт 98 сандлын бүрээс,109 улавчийг сар бүр угаан, нийт өрөөнүүдийн 78 цэцгийг 2 өдөр өнжин услан арчилж, 21 цонхыг сар бүр угаан цэвэрлэж, өдөр бүр оо-ийн өрөө, бусад танхимуудад чийгтэй цэвэрлэгээг хийж ирлээ.

Монгол номын фондын өрөө, лавлагаа арга зүйн танхимд ууршуулагч, номтой 5 өрөөнд 10 түмпэнд ус хийж тавин, усыг өдөр бүр сольж ажиллаж байна. Компьютерийн хорт нөлөөнөөс хамгаалж, хүүхдийн уншлагын танхим, лавлагаа,арга зүйн танхимд кактус, мөлхөө цэцгийг тарьсан. Уншлагын танхимуудад гутлын улавч 39 ширхэг, сандлын бүрээс 44 ширхэгийг хийж, улавчны хайрцаг 2 ширхэгийг зааланд шинээр байрлуулсан. Номын фонд, гэрээр тасгийн номын санчийн сандалд сандлын бүрээсийг шинээр хийлээ. Лавлагаа мэдээллийн танхимд цэцгийн суурь тавьж, цэцэг тавьж тохижуулсан.

Эрдэмтдийн хэлсэн үгээр 30 ширхэг санамж хийн, тавиурын хажуу хэсэгт наан фондын өрөөг тохижууллаа. Өдрийн ажлын цагийг нягт баримтлан, уншигч ажиллагсадтай харилцааны өндөр түвшинд харьцан, өрөө тасгуудын цэвэрлэгээг тогтмол чанартай гүйцэтгэн, номын тавиурын тоосыг тогтмол арчин ажиллалаа.

Их цэвэрлэгээг сар бүр буюу 6 удаа бүх өрөө тасгуудад хийн, цонх болон сандлын бүрээсийг угаан, чанартай хийж хэвшлээ. Цэвэрлэгээний ариутгалын бодис болох хивс цэвэрлэгч, плита цэвэрлэгч, шил толь арчигч, fairy , боок зэргийг зааврын дагуу хэрэглэж хэвшлээ. Уншлагын танхимуудад нийт 11 улавчийг шинээр хийсэн. 00-ийн өрөөнд хувин, алчуур хийх тавиурыг хийсэн.

Байгууллагын цэвэрлэгээ үйлчилгээнд хэрэглэгдэх шалны модыг шинээр хийсэн. Мөн 7 ширхэг цэцэг шинээр суулгах, амралтын өрөөнд хөшиг, цоож хийх зэрэг шинэ бүтээлч ажлуудыг хийж ирлээ. Хүүхдийн уншлагын танхимын ширээ сандлыг гамтай эдэлж,хайрлах талаар санамж бичиж наасан.

Өрөөнүүдэд16 ширхэг, 390.000 төгрөгний цонхны хөшгүүдийг шинээр хийж, байгууллагын болон өрөө тасгуудын хаягийг шинээр хийсэн.

Харуул хамгаалалтын ажил.

Өдрийн ажлын цагийг нягт баримтлан, 3 байгууллагын ажилчдын цагийг үнэн зөв бүртгэн ажиллалаа. Байгууллагын гадна болон дотор үүдний нийтийн эзэмшлийн талбай, үүдний шат, довжооны цэвэрлэгээг өдөрт 2 удаа хийж, үүдний хаалганы шилийг ээлж бүр дээрээ арчин цэвэрлэж байна.

Байгууллагын гадна талбайгаар авто машин явахыг хатуу хориглох, зөвхөн зориулалтын талбайд тавиулах талаар хяналт тавьж ажиллалаа. Жижүүр харуулын ажлын хүлээлцэх дэвтэрт тогтмол тэмдэглэл хөтлөн ажиллаж хэвшлээ.

Байгууллагын цахилгаан, сантехникийн аюулгүй байдлыг чанд мөрдөн, шаардлагатай үед цахилгаанчин, слесарь дуудаж, зохих арга хэмжээ авч ажиллах асуудал одоогийн байдлаар гараагүй байна.

Хамгаалж буй эд хөрөнгө, объектын бүрэн бүтэн байдал, өрөө тасгуудын лац ломбыг шалган хүлээн авах, хүлээлгэж өгч хэвшлээ.

Хамгаалж байгаа эд хөрөнгө, объектод хяналт тавьж, орой үдэш байгууллагын гадна орчныг тойрч шалган, аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Байгууллагын аюулгүй байдалтай холбоотой асуудал гарсан тохиолдолд удирдлагуудад мэдээлж, арга хэмжээг түргэн шуурхай авах асуудал одоогийн байдлаар гараагүй байна.

Хамгаалж байгаа эд хөрөнгийн хадгалалт ,хамгаалалтыг сайжруулахтай холбогдсон саналыг уншигч хүүхдүүд, үйлчлүүлж байгаа иргэдэд тухай бүр тавьж ажиллалаа. Бүтээлч ажлаар “Их мэдэх” хүүхдийн уншлагын танхимд 34 ш сандлын бүрээс,10 ширхэг гутлын улавчийг шинээр оёсон. Мөн 2 ширхэг гутлын гүвүүр, байгууллагын гадна хаалганд санамж, ажилчдын гэрийн хаяг, утасны жагсаалтыг нэгтгэн гаргаж, эд хөрөнгийн бүртгэлийн жагсаалтыг шинээр боловсруулан бүртгэн ажиллалаа.

5.Архив бичиг хэргийн ажил

Байгууллагын захиргаанаас гаргасан тушаал, төлөвлөгөө, тайлан, удирдамж, албан тоот зэрэг баримт бичгийг стандартын түвшинд шивж гарган ажиллалаа. 2010 оны ажлын жилд байгууллагад ирсэн бичиг 59 явуулсан бичиг 21 байлаа. Эдгээрээс хариутай бичиг 17 байсны хариуг бичгээр болон и-мэйлээр хугацаанд нь явуулан ажиллалаа. Шуурхай болон захиргааны зөвлөлийн хурлын тэмдэглэлүүдийг стандартын түвшинд өдөрт нь шивж гарган, удирдлагаар хянуулан ажиллаж байна.

Мөн байгууллагын архив, бичиг хэргийн ажлыг сайжруулахад техник хэрэгсэл бусад тоног төхөөрөмж, материалаар хангаж, бичиг хэрэгт хэрэглэдэг 4 дардас тэмдэг архивын газарт захиалж 3-н дардас хүлээн авч бичиг хэрэгт ашиглаж 1-нь ирээгүй байна. 4 дардас хийлгэхэд 96000 төгрөг зарцуулсан. Мөн хурлын тэмдэглэл, захирлын тушаал, том тоот тус бүр 100 ширхэг, албан бичгийн дугтуй 10 ширхэг захиалж нийт 27000 төгрөг зарцуулсан

2009 оны байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу ажилчдаас баримт бичгүүдийг хүлээн авч, нийт 30 баримт болгон үдэж, хавтасласан. Мөн архивын газраас кортон авч, архивын дардас захиалсан. Байгууллагын архивын программыг компьютерт суулган, архив бичиг хэргийн 3 хоногийн сургалтанд хамрагдсан. Мөн байгууллагын ажилчдын дунд аймгийн архивын тасгийн дарга В.Эрдэнэчимэгээр сургалт явуулсан

6. Няравын ажил.

Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу ажиллаж ирлээ. ОУННБ-ийн стандартын дагуу санхүүгийн үйл ажиллагаанд ТБУСХ-н батлагдсан төсвийн дагуу хуваарийг зарцуулж байгууллагын ажилчдын цалин болон бэлэн мөнгөний чехийг тухай бүрд нь авч баримтаар холбогдох ажилтнуудад олгогдож ирсэн.

2010 оны өмч эзэмшигчийн картыг хүн бүрээр шинэчлэгдэн хийж байгууллагын захирлаар баталгаажуулан хүн бүрд өгч аудит, улсын хяналтын шалгалтанд хүлээлгэн өгсөн. Байгууллагын кассын тайлан агуулахын бүртгэл, орлого, зарлага шаардах зэрэг материалуудыг дор бүрд нь баримтаар баталгаажуулан тайлан гаргахаад нягтлантай нийлж тайлан балансыг гаргаж эхний хагас жилийн тайланг гаргахад бэлэн болгоод байна. Байгууллагын 1 улиралд актласан хөрөнгөнд 40000 төгрөг аймгийн хотын захиргааны Амаржаргалд хүлээлгэн өгсөн. Байгууллагын үндсэн гүйлгээний 1-11 сарын орлого 1.265.800 төгрөгийг банкинд тушаасан.

Дүгнэлт

Тайлангийн хугацаанд тус номын сан нь номын сангийн үйл ажиллагааг автоматжуулан, менежментийг боловсронгуй болгох, сан хөмрөгийг шинэ номоор баяжуулах, БСШУЯ-ны Сайдын 2005 оны 441 дүгээр тушаал, Сангийн сайд, БСШУЯ-ны сайдын хамтарсан 2006 оны 357/406 тоот тушаалыг хэрэгжүүлэн эрчимжүүлэн, нэгтгэсэн тайлан мэдээллийг гаргах, нийт номын 66% буюу 26150 номыг электрон каталогит оруулж, номын хадгалалт хамгаалалтыг сайжруулах, интернэтийн үйлчилгээгээ үйлчлэх мэдээ мэдээллийг төрөл бүрийн гарын авлага, товхимол, Амжилт сонин зэрэг хэвлэлийн бүтээгдэхүүнийг өөрсдөө боловсруулан хэвлэх, уншигчдын хүрээ хүртээмжийг нэмэгдүүлэхэд СХУ-ны доктор Ш.Чимгээгийн нэрэмжит ном эрдэм 3 сарын аяныг зохион байгуулах ажлуудыг хийж тодорхой амжилтанд хүрлээ.

Улсын хэмжээний номын санд ашиглаж байгаа “Номын сан, номзүйн ангилал”-ын дагуу электрон каталогит 26150 номоо ангилж, өдөр тутмын ажилдаа ашиглаж байна.

Аймгийн хэмжээний арга зүйн төвийн үүргээ гүйцэтгэж энэ онд ЕБС, Их дээд, МҮСТ-ын 9 номын сан, орон нутгийн Шинэжист сумын номын санд аргазүйн зөвлөгөө өгч, номын санчдад гарын авлага, болгож “Ном зүйн бүртгэл“ ном, “Ном хэвлэлийн хадгалалт хамгаалалт” товхимолыг хэвлэн гаргалаа.

Орон нутгийн 24 номын санчдад МУҮН сантай хамтран “Үндэсний бичиг үсгийн баяр” сургалт зохион байгуулсан.

БСШУЯ-ны сайдын 2005 оны 441 дүгээр тушаал “Номын сангийн анхан шатны бүртгэлүүд хөтлөх аргачлал”-аар номын сангийн анхан шатны бүртгэлийг шинэчлэн нэгтгэсэн дүнг гаргалаа. Эдгээр ололт амжилт байгаа ч хүн бүр өөрийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх, ажлын үр дүн ахиц дэвшлийг сайжруулан, бие биенээсээ суралцах, багаар ажиллах тал дээр анхаарч ажиллах, номын санчид болон захиргааны зөвлөлийн гишүүдийн ажлын хариуцлагыг өндөржүүлэх, ялангуяа үнэт ховор ном, ганц хувьтай ном номын хадгалалт, хамгаалалт, тооллого тооцоонд хяналт тавих асуудалд номын сангийн захиргаа онцгой анхаарах шаардлагатай болсон байна.

Цаашид нийт номыг 100% электрон каталогит оруулж, үнэт ховор, гар бичмэл номын бүртгэл мэдээллийн санг бүрдүүлэх тоон цахим хэлбэрт оруулж, эх хувийг зориулалтын технологийн дагуу хадгалах нөхцлийг бүрдүүлэн ажиллах зорилт тавьж байна.

Нийт 103 ажил төлөвлөснөөс ор биелээгүй ажил 3, хагас биелэгдсэн 4, бүгд 96 ажил биелэгдэж төлөвлөгөөний нэгдсэн дүнгээр 98.2 хувьтай ажлаа гүйцэтгэсэн байна.

БУЛГАН АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН
2010 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2010.12.15.

Энэ онд Монгол улсын хууль, Соёлын бодлого, Засгийн газар, АЗД-ын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Номын сангийн ажлыг автомажуулах, электрон катологт оруулах, эрх зүйн мэдээлэл сурталчилгааг олон нийтэд хүртээмжтэй болгох, үйлчилгээний хүрээ хүртээмжийг өргөжүүлэх, уншигчдад үйлчлэх таатай орчныг бүрдүүлэх, хөнгөн шуурхай байдлыг сайжруулахад үйл ажиллагаагаа чиглүүлж, бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээгээ биелүүллээ.

Нэг.Удирдлага зохион байгуулалт, аж ахуйн ажлын талаар:

- Ажилчдын үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн дотоод журам, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсрууллаа.
- Уншигчдын дунд зохион байгуулах “Соёл олон нийтийн ажил”, “Эрүүл мэндийг дэмжих жил”-ийн хүрээнд хйих ажил, ОУ-ын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, Хүүхдийн номын баярыг угтаж хийх ажлын төлөвлөгөө гаргаж ажиллалаа.
- Байгууллагын бүх ажилчдад “Номын санчийн ёс зүй”, ”Номын санчдад тавих шаардлага”, ”Номын санчдын үйл ажиллагаандаа баримтлах зарчим”-ыг боловсруулан өдөр тутам мөрдүүлж ажиллахад анхаарч гарын авлага болон мэдээллийн самбараар сурталчилж байна.
- Номын сангийн ажлыг автомажуулах бэлтгэл ажил хийгдэж интернет болон уншлагын танхимууд дотоод сүлжээнд холбогдлоо.
- Үндсэн фондны 90%-ыг электрон катологт оруууллаа.

- Орон нутгийн сум, сургуулийн номын санчдын сургалт семинарыг УБ хотноо зохион байгуулж, номын санчдыг Төрийн ордон, МҮНС, ХНО, Мэдээллийн төвийн номын сангийн үйл ажиллагаатай танилцуулж, туршлага судалж, БСШУЯ-ны сайд Ё.Отгонбаяр, мэргэжилтэн Б.Баяраа, Соёл урлагийн газрын мэргэжилтэн Б.Ариунаа болон МҮНС, ХНО-ны удирдлагуудтай уулзалт ярилцлага зохион байгууллаа.
- АЗД-тай гэрээ байгуулан АЗД-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх "Эрх зүйн мэдээлэл, сурталчилгааг олон нийтэд хүртээмжтэй болгох зорилгоор НУТ-ын дэргэд "Хууль зүйн булан"-г тогтмол ажиллуулж, хууль эрх зүйн хэлэлцүүлэг хийх хуулийн номоор үзэсгэлэн гаргаж сурталчилж байна. Энэ ажлын хүрээнд АЗД хуулийн 4 боть, хуулийн гарын авлага номоор баяжилт хийж өглөө.
- Үндсэн фонд, НУТ, ХУТ, болон бусад өрөө тасалгаанд хортон шавьжны устгал хийсэн.
- Гадна талын цэцгийн мандлыг сольж 12 ширхэг жимсний бут сөөг тарьсан.
- Байгууллагын их цэвэрлэгээг улиралд 1 удаа хийж, фондны номны тоосыг арчиж, тоосжилтоос хамгаалж түмпэнд ус хийж тавьж байна.
- Ажилчдын амрах өрөө, чийрэгжүүлэлтийн өрөө гарган засвар хийж тохижууллаа.

Хоёр.Номын сангийн уншлага үйлчилгээ:

Энэ онд 2550 уншигчдад 10000 ирэгсдэд 32000 боть ном хэвлэл олгож үйлчиллээ.

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Уншигч	2500	2550
Ирэгсэд	9200	16400
Ном олголт	30500	35601

- ❖ Нүүдлийн номын санг ШШГГ, 1-р 11жил, Халамжийн сувилал, АЗЗА, Хөдөөгийн бригад, Цагдаагийн хэлтэс, УЦУОШГ, Чулуун ахлагчтай "Малчны бүлэг" ажиллуулж 265 хүнд 2815 ном олгож үйлчилсэн байна.
- ❖ Уншигчдаас сэтгэл ханамжийн судалгаа авах, лавлагаа өгөх, хэрэгцээт номын захиалга авах, санал сэтгэгдлийн хайрцаг аялуулах зэрэг арга хэмжээг өдөр тутам авч ажиллаж байна.

Гурав.Номын фонд баяжилт, номонд хийх техник ажиллагааны талаар:

- ✓ Нийт 225 нэр төрлийн 617 ширхэг ном 3398,100 мянган төгрөгний номоор фонд баяжилт хийж үүнээс 13 нэр төрлийн 308,3 төгрөгний тогтмол хэвлэл, 45 нэр төрлийн 81 ширхэг 491800 төгрөгний ном авсан байна
- ✓ 617 ширхэг номыг хүлээн авч дансалж, формулярын уут наах, формуляр бичих, 3,17-р хуудсанд тамга тэмдэг дарах, электрон католог оруулж, тасаг танхимуудад хувиарлаж уншлаганд гаргасан.
- ✓ "Шилдэг номын дээж"-ээр ирсэн 300-д номыг орон нутгийн номын сангуудад хувиарлан хүргүүлсэн.
- ✓ Уншигчдын гар дамжин элэгдэж хуучирсан 2000 гаруй номыг сэлбэн засварлаж уншлага үйлчилгээнд гаргасан.

Дөрөв.Уншигчдын дунд зохиох Соёл олон нийтийн ажил:

Цаг үе тэмдэглэлт өдрүүдтэй холбогдуулан "Багшдаа барих бидний бэлэг", "Ном чиний дотны найз", "Монгол зан заншлаа дээдлье", "Үлгэрийн орноор

аялцгаая", "Гэр бүл- ном шүтээн", "Монгол хүн сансарт", "Бичиг соёлын хишиг өдөрт" зэрэг ном уншлагын 7,10,14,21,30,45 хоногийн уншлага явагдаж "Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр" хүүхдийн номын баяраар хүүхдүүдийн дунд номын өдөрлөг, танин мэдэхүйн "АХА", "Миний хайртай үлгэрийн баатрууд" дүрийн тоглолт, гар зураг, шатар, даамны тэмцээн зохион байгуулж, МЗЭ-ийн гишүүн хүүхдийн зохиолч Ц.Чинбатын "Аарцны чулуу" CD-ны баярыг тэмдэглэж, тэргүүний уншигч 10 хүүхдэд "Д.Нацагдорж тэмдэг" олгосон юм.

СӨН, цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд явуулын номын сангаар үйлчилж 500 гаруй хүүхдэд үлгэрийн уншлага явуулах, гар зураг, дүрийн тоглолтын зохион явууллаа.

АТНС-ийн нэрэмжит жил бүр оны шилдэг "Оюунлаг хүүхэд" тодруулдаг уламжлалт танин мэдэхүйн уралдаант цэнгээнт "Алтан хонх" теле наадмыг "Анар" үйлчилгээний төвд зохион байгуулан орон нутгийн 11 сум, номын санчид 49 хүүхэд хамрагдаж, Сэлэнгэ, Хутаг-Өндөр, Могод, ЭӨЦС-ийн сурагчид шалгарч цом өргөмжлөл хүртсэн юм. Энэ арга хэмжээг "Уран хоршоо-Нүүдэлчин клуб", "Сайхан Монгол урсгал" ТББ жил бүр ивээн тэтгэж /450,000 төгрөгөөр/ БСГ, ОНС Музей, ХТХ, ХЖТ зэрэг байгууллагууд хамтран зохион байгууллаа.

Тав.Номын үзэсгэлэн мэдээлэл сурталчилгаа:

- "Шинэ номын дээжээс", "Багшийн алдар", "Хүнсний ногоо тариалагчдад тусламж", "Хуулиа дээдлье", "Амьдрах ухаан", "Монгол хүн сансарт", "Хичээлийн шинэ жилд", "Гэрийн эзэгтэйд", "Хууль таны мэдлэгт", "Өсөхөөс сурсан үндэсний хэл-Мартаж болошгүй соёл", "Эх орончдын өдөрт", "Ардын армийн өдөрт" зэрэг сэдэвт номын сэдэвчилсэн үзэсгэлэнг 28 удаа 2105 номоор гаргаж сурталчиллаа.
- Мэдээллийн ханын самбараар "Ном унших соёл", "Мэдэхэд илүүдэхгүй", "Бусадтай харилцах алтан дүрэм", "Залхуу зантайгаа тэмцэлдье", "Зорилгодоо хүрэх энгийн арга", "Уралдаант шалгалтанд хэрхэн бэлдэх вэ", "Өөртөө цаг гарга", "Өдөр тутам санаж явах 25 зарчим", "Хүнтэй ярихаас ичээд байвал", "Нарнаас 35 дахин халуун од илрүүлжээ", "Хүн төрөлхтөн 2 төрөлд хуваагдана", "Сэтгэлээ жолоодож сурах 7 арга", "Харилцагчаа хүндэтгэж байгаагаа илэрхийлэх 10 арга", "Өнгө нь хүнд гүн ухаан онцгой анхаарал мэдрэмжийг өгдөг", "Ухаантай болох есөн арга", "Хүүхдийг ном унших сонирхолтой болгох аргууд", "Хүүхдээ хэрхэн номонд дуртай болгох вэ", "Яагаад хүүхдийн уншлагад аавууд оролцох ёстой вэ", "Сонин уншиж байхдаа хүүхдийн уншлагыг дэмж", "Хорвоогийн сониноос" зэрэг мэдээллийг давхардсан тоогоор 43 удаа гаргаж сурталчилж байна.
- Шинэ ирсэн номыг удирдах ажилтны мэдээллийн цагаар 2 удаа сурталчилсан.
- Аймгийн Төв номын сангаас зохиогдож байгаа ажил, шинэ номын сурталчилгааг Булган телевиз-ийн мэдээгээр 3 удаа Кабелийн телевизийн зараар 5 удаа сурталчиллаа.

Зургаа. Ном зүйн ажлын талаар:

"Хүнсний ногоо тариалагчдад тусламж", "Уралдаант шалгалтанд бэлтгэгчдэд тусламж", "Хуулийн ажилтанд тусламж", "Соёл урлагийн ажилтан ямар ном унших вэ" зэрэг санамж өгөх ном зүйн бүртгэлийг гаргаж мэргэжлийн номыг мэргэжилтэнд хүргэж үйлчилж байна.

Долоо.Орон нутгийн номын сангийн талаар:

- 18 нэр төрлийн 269 ширхэг 2691,0 мянган төгрөгний номоор фонд баяжилт хийгдэж хувиарлан хүргүүлсэн.
- Аймгийн хэмжээнд 36 номын сан үүнээс нийтийн 17, сургуулийн 19 номын санд 42 номын санд, мэргэжлийн 14, курсээр 13, мэргэжлийн бус 15 номын санчид ажиллаж байна.
- Орон нутгийн номын санчдад мэргэжлийн “Номын сангийн ангилал, үндсэн анги”, “Номын католог, түүний зохион байгуулалт”, ”Уншигчдад үйлчлэх үйлчилгээний соёл”-ын талаар зөвлөмж 2 удаа 30 номын санчдад хүргүүлсэн.
- Бүрэгхангай, Орхон, Сайхан, Хялгант, Сэлэнгэ сумдад ширээ сандал хөрөнгө оруулалтаар олгосон.
- Хишиг-Өндөр сумын номын санч Ц.Цолмон ”Ном хэвлэл дахин үнэлэх”, ”Нэгдсэн бүртгэл” хөтлөх
- Рашаант сумын номын санч Эрдэнэбаяр ”Ном ангилах, өдөр тутмын бүртгэл” хөтлөх
- Могод сумын номын санч Г.Оюунчимэг “Ном хэвлэл дахин үнэлэх” талаар асууж, утсаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.
- Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр суманд зөөврийн номын сан ажиллуулж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлсэн.
- Бүрэгхангай, Орхон, Сайхан, Могод сумдын номын сантай ном солилцоотой ажиллаж байна.

Найм.Хамтын ажиллагааны хүрээнд:

Бид хүн амд хүргэх мэдээллийг үйлчилгээг сайжруулах, хүний хөгжлийг дэмжих, аймгийн төр захиргаа, төрийн бус байгууллага, иргэдийн дэмжлэгийг авч хамтын ажиллагаагаар шинэлэг ажил зохион байгуулахад АЗДТГ, Булган сумын ЗДТГ, ЕБС-иуд, БСГ, Цагдаагийн хэлтэс, МХГ, ХЖТ, Хас банк, ОНСМ, Булган хоршоо ТББ, ”Нүүдэлчин клуб”, ХТХ, ААСЭХ, Булган телевиз, “Анар” ХХК, ”Сайхан урсгал Монгол” ТББ-тай хамтран аймгийн шилдэг ”Оюунлаг хүүхэд -2010” тодоруулах танин мэдэхүйн “Алтан хонх”, “АХА” тэмцээнийг зохион байгуулахад 450000 /дөрвөн зуун тавин мянган төгрөг/-өөр ивээн тэтгэж, хүүхдүүдийг урамшуулсан. Дэлхийн зөн ОУБ-тай хамтран Салбар номын сан ажиллуулж байна.

Ес. Хүний нөөц нийгмийн асуудлын талаар:

- Орон нутгийн номын санчдын мэргэжил дээшлүүлэх сургалтыг УБ хотноо зохион байгуулж, 35 номын санчид хамрагдаж сертификат олгосон.
- Соёлын ажилтаны өдрөөр үндсэн фондны номын санч Б.Батжаргал, мэдээллийн ажилтан Г.Энхбилэг нар МАЗХ-ны “Хөдөлмөрийн алдар”, “Тэргүүний залуу” алтан медаль, Сайхан, Орхон сумын номын санч Ч.Оюунтунгалаг, Б.Амарцэцэг нар “Аймгийн тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнагдсан.
- Ахмад настанд жилд 2 удаа хүндэтгэл үзүүлсэн
- Ажилчдын үр дүнгийн гэрээг дүгнэж 7 хүнд цалингийн урамшуулал олгосон.
- Байгууллагын аварга ажилтнаар үндсэн фондны номын санч Б.Батжаргал шалгарч өргөмжлөл, тууз, мөнгөн шагналаар урамшуулсан
- Ажилчдад түлээ нүүрсний хөнгөлөлт үзүүлсэн.
- Хүүхдийн баяр, шинэ жилээр өрхийн дунд 1 бэлэг өгсөн
- Номын санчдаа байгалийн үзэсгэлэнт газар Бүрэгхангай сумын нутагт дахь “Бодь мод” үзүүлж амраасан.

- Бүх ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, бие бялдарын түвшин тогтоох, “Эмэгтэйчүүдийн өвчин”, ”Нөхөн үржихүй”, ”Архи тамхины хор хөнөөл”-ийн талаар мэргэжлийн байгууллагатай хамтарч сургалт зохион байгуулж, зөвлөгөө өгүүлсэн.
- Хөвсгөл аймагт болсон залуучуудын чуулга уулзалтанд номын санч Б.Батжаргал оролцсон.
- Эдгээр ажилчдын нийгмийн асуудлын талаар нийтдээ 1734,5 мянган төгрөг зарцуулагдсан.

ДҮГНЭЛТ

Манай номын сангийн ололттой тал:

- Номын фондын 90%-ыг электрон катологт орсон.
- Хамтын ажиллагааны хүрээ өргөжсөн.
- Аймгийн Төв номын сангийн нэрэмжит шилдэг ”Оюунлаг хүүхэд” тодруулдаг уламжлалт ажил болсон.
- ДЗОУ-ын байгууллага дээр салбар номын сан ажиллуулсан.
- Орон нутгийн номын санчдыг сургалтанд хамруулж, УБ хотын номын сангуудын үйл ажиллагаатай танилцуулж, туршлага судалсан.
- Зөөврийн номын сан ажиллуулахад зориулан фургон машинтай болж Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр суманд зөөврийн номын сан ажиллуулсан.

Цаашид 2011 онд авах арга хэмжээ:

- Номын сангийн өргөтгөлийн асуудлыг шийдвэрлэх
- Мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, мэргэжил олгоход анхаарах
- Номын сангийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг сайжруулах
- Уншигчдад үйлчлэх үйлчилгээний орчныг сайжруулах
- Номын фонд баяжилтанд анхаарах
- МҮНС-ийн 90 жилийн ой угтаж бүтээлч ажлуудыг зохион байгуулж ажиллана.

АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГААС 2010 ОНД БАЙГУУЛСАН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

2010-12-21

№	Нийлүүлэх тусгай захиалагт бүтээгдэхүүн	Хэрэгжүүлэлт	Биелэлт
1	Оны шилдэг “Оюунлаг хүүхэд” шалгаруулах	11 сумын номын санчид нийт 49 хүүхэд хамрагдсан	100%
2	Фондны номын 80%-ыг электрон хэлбэрт оруулах	5,6,7,8,9,10 сарын хугацаанд фондны 90% электрон	100%

		хэлбэрт оруулсан	
3	Орон нутгийн номын санчдын сургалтыг Улаанбаатар хотод зохион байгуулах	Сум сургуулийн 35 номын санчдын 5 хоногийн сургалт УБ хотноо зохион байгуулагдсан	100%
4	АЗД-тай гэрээ байгуулан "Хууль зүйн булан" тогтмол ажиллуулах, нийгмийн эрүүл мэндийг дэмжих жилийн хүрээнд амрах өрөө, чийрэгжүүлэлтийн өрөөг гаргаж тохижуулах	• АЗД-тай гэрээ байгуулан "Хуулийн булан"г тогтмол ажиллуулж, хуулийн гарын авлага, зөвлөмж, хэлэлцүүлэг зохион байгуулахад хамтран оролцсон. • Ажилчдын амрах, чийрэгжүүлэлтийн өрөө гарган тохижуулсан	90%
	Нийт бүтээгдэхүүн		
1	Удирдлагын үйлчилгээ	✓ Номын сангийн үйлчилгээний зарим журам, дүрмийг шинэчилэн боловсруулсан ✓ Номын санчдыг сургалтанд хамруулж туршлага судлуулсан ✓ Нийгмийн асуудлын талаар анхаар нийт 1700 мянган төгрөг зарцуулсан ✓ БСШУЯ-ны сайдын 2006 оны 441-р тушаал, сангийн сайд, БСШУЯ-ны сайдын хамтарсан 357/406 тоот тушаалыг хэрэгжүүлж данс бүртгэлийг шинэчилж номоо дахин үнэлгээнд оруулах ажлыг зохион байгуулсан ✓ Санхүүгийн мэдээ	90%

		тайланг хугацаанд нь гаргаж өгсөн	
2	Номын сангийн үйлчилгээ	✓ Номын сангийн фондыг 523 ширхэг ном 3395,5 мянган төгрөг үүнээс 13 нэр төрлийн 308,5 мянган төгрөгний тогтмол хэвлэлээр фонд баяжуулж,орон нутгийн номын сангуудыг 300-д номоор баяжуулалт хийгдсэн. ✓ 510 ширхэг номонд техник ажиллагаа хийж дансанд авч, каталог бичиж, фондонд байрлуулж,тасаг танхимуудад хувиарлан өгч уншлага үйлчилгээнд гаргасан. ✓ Уншигчдад захиалгын дагуу фондноос ном олгож,гэрээр ном олгох тасгаар үйлчилж байна. ✓ Уншигчдын дунд зохиох СОТ ажлын календарчилсан төлөвлөгөө гаргаж ажилласан.	95%
3	Арга зүйн удирдлага	Номын санчдад: ”Номын сангийн үндсэн ангилал”, ”Каталог зохион байгуулалт”, ”Уншлага үйлчилгээний соёл”, ”БСШУЯ-ны сайдын тушаал”-ыг хэрэгжүүлэх зөвлөмж бүх сумдад 2 удаа гарын авлага зөвлөмж, Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр	90%

		сумдын номын номын сангийн үйл ажиллагаатай танилцаж мэргэжлийн зөвлөгөө, утсаар зөвлөмж өгч ажилласан.	
4	Лавлагаа ном зүйн үйлчилгээ	Ном зүйн бичилтээр картын сан зохион байгуулж, мэргэжлийн номыг мэргэжилтэнд хүргэх, шинэ номын мэдээ гаргах, уншигчдад лавлагаа өгөх, санамж өгөх, бүртгэн мэдээлэх, ном зүйн бүртгэлүүдийг гаргаж, шинэ номын мэдээг орон нутгийн нэвтрүүлэг болон Булган хангай сонингоор сурталчилсан нийт /8 удаа/	85%
5	Ном хэвлэлийн хадгалалт хамгаалалт	Фондонд хортон шавьжны устгал хийж, номын тоосыг улиралд 1 удаа арчиж, уншигчдын гар дамжин элэгдэж хуучирсан 2000 номыг сэлбэн засварлаж уншлага үйлчилгээнд гаргасан.	90%
6	Номын сангийн орчныг сайжруулах	Уншлагын танхимыг цэцэгжүүлэх, өрөө тасалгааг тохижуулан уншигчдад үйлчлэх, үйлчилгээний орчныг сайжруулах, гадна талын цэцгийн мандлаа шинэчилсэн, жимсний 12 ширхэг	90%

		бут сөөг тарьсан.	
7	Мэдээлэл технологийн үйлчилгээ	✓ 5,6,7,8,9,10 сард номын санчдын дунд уралдаан зарлан фондны номын 90%-ыг электрон каталогт оруулсан. ✓ Интернет, дотоод сүлжээнд холбогдсон.	95%
8	Статистик мэдээ	Мэдээг цаг тухайн үед нь гаргаж байна.	100%

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2010 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. Удирдлага зохион байгуулалтын талаар:

Боловсрол соёлын гэзрын даргатай байгуулсан Менежерийн бүтээгдэхүүнийг ханган нийлүүлэх гэрээг үндэслэн Говь-Алтай Аймгийн Нийтийн номын сангийн үйл ажиллагааны төлөвлөгөөг 14-н зүйл заалттайгаар боловсруулан баталгаажуулж ажиллалаа.

Аймгийн номын сан нь Монгол Улсын хууль , бусад хууль тогтоомжууд, УИХ, Засгийн газар, БСШУЯ-ны сайдын тушаал СУБГЗ-ын заавар, зөмлөмжүүдэд үндэслэн өөрийн үйл ажиллагааг зохион байгуулж ирлээ. Орон тоо бүтэц зохион байгуулалтын хувьд 10-н орон тоотойгоор үйл ажиллагаа явагдаж байна.

Жилийн болон улирлын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг зорилтуудыг ханган биелүүлэх зорилгоор ажлын зохион байгуулалтыг сайжруулж ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж бүтээгдэхүүн нийлүүлэлтийг ханган биелүүлэх үр дүнгийн гэрээг байгуулж ажиллалаа. Ажилтнуудын үр дүнгийн гэрээ дүгнэх шалгуурыг хамт олны хурлаар хэлэлцэн баталж жилийн эцэст дүгнэн ажиллалаа.

2. Номын сангийн үйлчилгээний талаар:

2010 онд 977 шинэ уншигч бүртгэн 23680 ирцэд 47500 ширхэг ном олгож үйлчилсэн байна. Зөөврийн номын санг нийт 10 байгууллагатай гэрээ хийн ажиллуулж 550 ирцэд 2100 ном олгож үйлчилсэн байна. Фондын нөхөн бүрдүүлэлт хийх, номын хүртээмжийг нэмэгдүүлэх, уншигчдад шинэ мэдээллийг хүргэх зорилгоор нөхөн бүрдүүлэлтээр 53 ширхэг ном, 315 ширхэг шинэ ном 763 ширхэг хандивын номоор фондоо баяжууллаа. Түүнчлэн 10-15 нэр төрлийн 651600 төгрөгийн тогтмол хэвлэл захиалан нэгж ном болгон үйлчилгээнд гаргалаа.

Уншигчдын эрэлт хэрэгцээг хангах мэдээ мэдээллээр түргэн шуурхай үйлчлэх зорилгоор 403 аман болон бичгийн лавлагаа өгч үйлчилсэн байна. Фондын номын 2 % буюу 1000 ширхэг ном сэлбэн зассан. Шинэ номын тойм 4, шинэ номын зурагт хуудас 4 гаргаж шинэ номоо сурталчилсан. Мөн мэдээллийн хэрэгслээр 2 удаа

шинэ номоо сурталчилсан байна. Цагаан сар /1896-2009/, Д.Норов, Т.Очирхүү, З.Гүнсэнгийн амьдрал уран бүтээлээр ном зүйн бүртгэл, Монгол үндэстний хувцаснуудын онцлог ном зүйн бүртгэл болон Алтайн зохиолчдын амьдрал уран бүтээлээр бүртгэн мэдээлэх ном зүйн бүртгэл гаргасан байна. 2010 оны Үнэн, Монголын мэдээ, Зууны мэдээ, Өдрийн сонин, Өнөөдөр сонингуудад гарсан материалыг түүвэрлэн каталоги бичиж картын санг баяжуулав. Хуулийн картын санг Зууны мэдээ, Төрийн мэдээлэл сэтгүүлүүдээс баяжуулав. Тайшир, Гуулин, Дэлгэр, Чандмань, Эрдэнэ, Бигэр, Халиун, Цээл, Цогт, Бугат, Алтай зэрэг сумдын Соёлын төв, сургуулийн номын санчдын ажлыг шалган тусалж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв. Шинэ номын болон сэдэвчилсэн үзэсгэлэн 4 удаа гаргав. Фондын номын 100 % буюу 51.993 номыг электрон каталогт оруулаад байна.

3.Сургалт семинарын талаар

2010 оны 09 сарын 20-25-ны хооронд бүх сум сургууль нийтийн номын сангийн номын санчдыг хамруулсан мэргэжил дээшлүүлэх 40 цагийн сургалт семинарыг Монголын Үндэсний номын сан, Хүүхдийн номын ордон, Говь-Алтай аймгийн боловсрол соёлын газар, Нийтийн номын сан хамтран зохион байгууллаа. Энэ сургалтанд нийт 42 номын санч хамрагдлаа. Сургуулийн номын санчид хүүхдийн номын ордонд, соёлын төв, нийтийн номын сангийн номын санчид МҮНСанд сургалтаа зохион явууллаа. Мөн энэ үеэр Төв аймгийн номын санд очиж туршлага судлан 1 өдөр ажиллалаа. Хүүхдийн номын ордон, Үндэсний номын сан тус тусдаа хөтөлбөр боловсруулан чанартай сургалтыг явуулсан. Номын санчид маань мэдэхгүй зүйлээ мэдэж мэдлэгээ бататган өөрсдийн үйл ажиллагаандаа дүгнэлт хийсэн ач холбогдолтой сургалт явагдлаа. Энэ үеэр ШТУС, СДС, Хотын номын сан, Нээлттэй нийгэм форумын номын сантай танилцан туршлага судалсан сайхан сургалт боллоо

4. Мэдээлэл сурталчилгааны ажлын талаар :

2010 онд нийт 8 соёл танин мэдэхүйн ажил явуулахаар төлөвлөсөн.

1. Д.Норовын зохиолоор яруу найргийн өдөрлөг, АХА тэмцээн, ЭССЭ бичлэгийн уралдаан зохион явуулж 110 уншигч, сурагчдыг хамруулав. Энэ үеэр төрийн шагналт зохиолч Д.Норовын зохиол бүтээлээр Утгын чимэг богино өгүүллэгийн наадам зохион явууллаа. Утгын чимэг богино өгүүллэгийн наадамд

   - 1-р байрыг 1-р сургуулийн 10-р ангийн сурагч С.Амартүвшин “ Хонзон” өгүүллэгээр

   - 2-р байрыг 2-р сургуулийн 10-р ангийн сурагч Ш.Даваабал “ Талын таван толгой” өгүүллэгээр

   - 3-р байрыг 5-р сургуулийн Г.Хосбаяр “ Нүнжиг” өгүүллэгээр тус тус эзэллээ.

   ЭССЭ бичлэгийн уралдаанд

   - 1-р байрыг Г.Хосбаяр
   - 2-р байрыг Б.баасанжаргал
   - 3-р байрыг Лхагвасүрэн нар тус тус эзэллээ.

2. “ Хэн олон ном унших вэ” уралдааныг сурагчдын дунд зохион явуулж 2 ангийн 68 сурагчдыг хамруулалаа.

   1-р байрыг 3-в ангийн сурагч Т.Лхаахүү

   2-р байрыг 3-в ангийн сурагч Э.Лхамноржин

   3-р байрыг 3-в ангийн сурагч Б.Лхамжаргал нар тус тус эзэллээ.

3. Хүүхдийн баярыг тохиолдуулан хүүхдийн номын үзэсгэлэн худалдааг төв талбай дээр гаргаж 100 гаруй уншигчийг хамруулалаа.

4. “Хүрэл тулга“ яруу найргийн наадмыг орон нутгийн хэмжээнд 2 үе шаттайгаар 6-8 –р анги, 9-11-р анги гэсэн 2 ангиллаар Хүүхдийн төлөө хэлтэстэй хамтран зохион явуулж 58 гаруй хүүхдийг хамруулалаа. 1-р шатыг сум сургууль дээр нь 2-р үе шатыг аймгийн хэмжээнд зохион явууллаа. Энэхүү наадмыг 2010.03.30-нд аймгийн нийтийн номын санд зохион байгуулж явуулснаас 6-8-р ангийн насны ангилалд 11 хүүхэд оролцсоноос Бугат сумын 9 жилийн сургуулийн 8-а ангийн сурагч Пүрэвнямын Хасагбаатар түрүүлж , МУГ багш Гомбын нэрэмжит 11 жилийн 1-р сургуулийн 8-а ангийн сурагч Б.Булгантамир 2-р байр эзэлж , 3-р байрыг Тонхил сумын 11 жилийн сургуулийн 8-а ангийн сурагч Г.Содбаяр эзэллээ. Тусгай байрт Жаргалан сумын Э.Сүхбат орсон байна. 9-11–р ангийнхнаас 18 хүүхэд оролцсоноос Дэлгэр сумын 11 жилийн сургуулийн 10-а ангийн сурагч Б.Цэрэндондов түрүүлж , хоёрдугаар байрт 11жилийн 2-р сургуулийн 10-б ангийн сурагч Ш.Доржбал, 3-р байрыг 1-р сургуулийн Н.Халиунаа орсон байна. Тусгай байрт МСҮТ-ийн Ш.Чанцалдулам орсон байна.

5. З.Гүнсэнгийн уран бүтээлээр “Утгын чимэг“ богино өгүүллэгийн наадам зохион явуулж 60 гаруй уншигчийг хамруулалаа. Уг наадам нь 2010 оны 10сарын 27 нд нийтийн номын санд зохион явуулав. Уралдаанд 1-р сургуулийн 11-р ангийн сурагч Д.Пунсалмаа тэргүүн байр эзэлж, 1-р сургуулийн 11-р ангийн сурагч Б.Батчимэг дэд байр, 5-р сургуулийн 10-р ангийн сурагч Б.Мөнхбаатар, 2-р сургуулийн 11-р ангийн сурагч Ж.Ганхөлөг, 5-р сургуулийн 10-р ангийн сурагч Ц.Эрдэнэсувд нар тусгай байр эзэллээ.

6. Сум сургуулийн номын санчдын сургалт семинарыг 2010 оны 05 сарын 10-наас 13–ны хооронд зохион явуулж 34 номын санчийг хамруулалаа. Энэ сургалтаар номын сангийн мэргэжлийн 4 номын санч мэргэжлийн дагуу хичээлээ зааж 2009 оны шилдэг ном, хандивын ном гардуулж шилдэг номын сан, шилдэг номын санч шалгаруулалаа. Шилдэг номын сангаар дэлгэр сумын соёлын төвийн номын сан шалгарлаа. Шилдэг номын санчаар Д.Байгаль шалгарч бусдыгаа хошуучиллаа. Шилдэг сургуулийн номын сангаар Цээл сумын номын сан, шилдэг номын санчаар Х.Ганчимэг шалгарлаа. Энэ үеэр номын санчдын нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж МНТҮ-ээр үйл ажиллагаагаа сурталчиллаа.

7. Говь-Алтай аймаг байгуулагдсаны 70 жилийн ойг угтан “Алтай -70“ номын үзэсгэлэн яармагийг аймгийн хэмжээнд зохион явууллаа. Уг яармагийн хүрээнд дараах ажлуудыг зохион байгууллаа.

   1. Номд ээлтэй хамт олноор Аймгийн Шүүхийн хамт олон шалгарлаа.
   2. Ховор номын дуудлага худалдаа зохион байгуулж шилдэг худалдан авагчаар АЗЗА компанийн Х.Ганзориг шалгарлаа.

3. Азын сугалаа зохион явуулж 200 гаруй ирцийг хамрууллаа. Аймгийн Шүүхийн шүүгч С.Ганболд супер шагналыг хожлоо.

Энэ яармагт нийт 3 сургуулийн 150 гаруй уншигч хүүхдүүд, 4 байгууллагын 30 иргэн хамрагдлаа. Яармагаас орсон орлогын 10%-ийг төрөлх нутгийнхаа 70 жилийн ойд хандивлалаа.

8. Говь-Алтай аймаг байгуулагдсаны 70 жилийн ойн үеэр Говь-Алтай аймгаас төрөн гарсан 70 зохиолчийн уран бүтээлээр үзэсгэлэн гарган баярын 3 хоног нээлттэй ажилласан. 70 зохиолчийн зургийг жаазлан ном зүйн бүртгэлийг гарган хананд байрлуулан нийтэд сурталчиллаа. Насанд хүрэгчдийн заалыг 70 зохиолчийн нэрэмжит болгон тохижууллаа.

9. Говь-Алтай аймаг байгуулагдсаны 70 жилийн ойг угтан зохион байгуулагдсан аймаг сурталчлах өдрүүд Улаанбаатар хотод 2010 оны 06 сарын 24-нөөсс 06 сарын 30-ныг дуустал зохион байгуулагдсан. Энэ үеэр Монголын Үндэсний номын сантай хамтран Говь-Алтай аймгаас төрөн гарсан нутгийн зохиолчдын уулзалт цэнгүүнийг зохион байгуулж 160 гаруй зохиолч уншигчдыг хамрууллаа. Энэ уулзалтанд УИХ-ын эрхэм гишүүн Ж.Энхбаяр, МУ-ын ардын уран зохиолч, хөдөлмөрийн баатар, төрийн шагналт зохиолч Л.Түдэв, Нутгийн зөвлөлийн дарга Ж.Билэгт, Говь-Алтай аймгийн засаг дарга Г.Бямбажав, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Ш.Эрдэнэбат, МУҮН-ийн сангийн захирал Х.Чилаажав болон олон сайхан зохиолч, яруу найрагч, сэтгүүлчид оролцлоо. Энэ үеэр нутгийн зохиолчдын үзэсгэлэн гаргаж уншигчдад үйлчиллээ. Мөн төрөлх нутгийн зохиолчид маань өөрсдийн бүтээлээсээ аймгийн нийтийн номын санд хандивлалаа . МУ-ын ардын уран зохиолч, хөдөлмөрийн баатар , төрийн шагналт зохиолч Л.Түдэв өөрийн бүтээл болох цуврал ботиудаас аймгийн нийтийн номын сан болон хөдөө орон нутгийн номын санд хандивлалаа. Нутгаа гэсэн сэтгэлтэй олон хүн цугларч Алтай нутгийнхаа ирээдүйн хөгжлийг хэлэлцэн дурсамж яриагаар дүүрэн сайхан уулзалт боллоо. АДБ-ийн Алтай чуулгын дуучин МУГЖ Ц.Оюунцэцэг “Засагт ханы хөх харчууд“ дуугаараа нутгийн зохиолчиддоо ая дууны цэнхэр хадаг өргөлөө.

5. Төсөл хөрөнгө оруулалтын талаар :

1. Нийтийн номын сан нь 2007 оноос эхлэн цахим номын сантай болох төсөл бичиж олон газар хандаж байсан. Ингэснээр 2009 онд тогтвортой амьжиргаа -2 төслийн газарт “Мэдээллийн эринд залуус бид“ төсөл бичиж уг төсөл нь олон нийтийн багийн хурлаас дэмжигдэн 2010 онд хэрэгжих санал авч шалгаран хэрэгжих шатандаа орсон. 2010 оны 04 сард тендерээ зарлан 5 компаниас Электрон–Алтай компани шалгарч төслийг гүйцэтгэхээр болсон. Ингээд 2010 оны 07 сарын 04 нд гүйцэтгэгч байгууллага маань төслийн хугацаанд нийлүүлэх бүтээгдэхүүнээ нийлүүлж хүлээлгэн өгсөн.

Төсөл 10,920,000 төгрөгний санхүүжилттэй.

Төсөлд: Цахим номын программ -1ш

5ш компьютер

Сервер комьпютер -1ш

3 үйлдэлтэй хувилагч -1ш гэсэн тоног төхөөрөмжүүдийг нийлүүлсэн.

Дотоод холбоонд суурилуулан номын сангийн насанд хүрэгчдийн заалыг интернет танхим болгон тохижуулан уншигчдад үйлчилж байна. Электрон каталогитой цахим номын сан болсноор уншигч цаг хугацааг маш их хэмнэж байна. Цаг алдалгүй түргэн шуурхай хэрэгцээт мэдээллийг олж авч байна. Бид урд нь цаасан каталогиос номоо шүүж хугацаа их алддаг байсан. Мөн аль нэг аймаг хотын номын сангийн мэдээлэлтэй танилцан хайж буй номын талаар бүх мэдээллийг олж авах давуу талтай. Мөн интернет ашиглан ном унших боломжтой болсон. 2010 онд тус номын сан нь 23680 ирцэд 47500 ном олгож үйлчилсэн байна. Фондын бүх номынхоо каталогийг цахим хэлбэрээр шивээд байна. Оны эцэст шинэ стандартын дагуу бүх фондын номын ном зүйн ажиллагааг шинэчлэх ажил өрнөөд байна.

2. УИХ-ын гишүүн, Алтай эрин сангийн тэргүүн Ж.Энхбаярт хандаж номын фондоо баяжуулж, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл бичсэнээр уг төсөл маань хэрэгжиж 3,000,000 төгрөгний санхүүжилт олгосон. Номын фондоо баяжуулах зорилгоор 2,500,000 төгрөгний үнэ бүхий 193 нэр төрлийн 239 ширхэг ном худалдан авсан. Мөн дижитал аппарат, компьютер зэрэг тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгч бидний ажлыг маш их дэмжсэн үйл ажиллагаа болсон.

3. Ярьдаг ном төсөл

Мерси Кор, Алтай –Швейцарь сан төрийн бус байгууллага, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн дэмжлэгтэйгээр тус номын санд “Ярьдаг ном“ төсөл 2010 оны 05 сарын 20-ноос эхлэн хэрэгжиж байна.

Төслийн зорилго нь :

Хараагүй болон сул хараатай иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх , амьдрах итгэл үнэмшлийг бий болгох, ном сэлбэн засах, даавуун ном хийх арга барил дадлыг бий болгоно. Энэ төсөл нь 1000000 төгрөгний санхүүжилттэй. Уг төсөлд хараагүй болон сул хараатай 5 иргэд хамрагдаж байна.

Ч.Амарсанаа -28 настай , /Баяншанд баг/

А.Болд – 20 настай , /Жаргалант баг/

Х.Бүрэнбилэг -33 настай /харзат баг/

Х.Төмөрболд -30 настай / харзат баг/

Б.Жанлавмаа -37 настай /Баянхайрхан баг/

Төслийн хүрээнд :

Нийтийн номын сангийн хүүхдийн уншлагын заалыг тохижуулан үйл ажиллагаагаа эхэлсэн.

Номын тавиур -2ш

Систем хөгжим -1ш

Брайл ном -10 ш

Ярьдаг ном -7ш

аудио ном -5ш

Дохионы үзүүлэн -1ш гэх мэт хэрэглээний материалыг ашиглаж байна.

Бүлгийн гишүүдийн гол хийх ажил маань ном сэлбэн засах . Бүлгийн гишүүдтэйгээ сургалтын төлөвлөгөөний дагуу ном сэлбэн засах, аудио хэлбэрийн хичээл, амьдрах ухааны хичээлийн сургалтаа зохион байгуулж явууллаа. Уг сургалтыг нийтийн номын сангийн мэргэжлийн ажиллагсад Д.Ундармаа, Б.Оюун нар зааж бүлгийн

гишүүдэд ном сэлбэн засах онолын мэдлэг олгож арга барилыг зааж өглөө. Нийт 9 өдрийн сургалт явууллаа. Бүлгийн гишүүд маань ямар ч номыг сэлбэн засаж чаддаг болсон. Бид 7 хоногийн 3 дахь өдөр болгон ном эмчилж байна.

Төслийн үр дүнд :

1. Хараагүй болон сул хараатай иргэд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, мэдээ мэдээллийг түргэн шуурхай хүртэх боломж бүхий уншлагын заалтай боллоо.
2. Ном эмчилж сурлаа.
3. Багаар ажиллаж хамт олонтой боллоо.
4. Өөрсдийн хөдөлмөрөө үнэлүүлж урамшил авдаг боллоо.
5. Мэдлэг чадвар дадлаа нэмэгдүүллээ.
6. Нийгэмтэйгээ хөл нийлүүлэн алхах урам зоригтой боллоо.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2010 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Байнгын 682 уншигчдад шинээр карт нээж, програмд оруулж уншигчийн соронзон үнэмлэхийг олгож, 7505 ирэгсэд буюу нийт 8286 уншигчдад 15789 ширхэг ном хэвлэл олгож үйлчиллээ.

Өөрийн үйл ажиллагааны орлого нийт 685,6 мян төгрөг бүрдүүлсэн. Өмнөх оныхоос

- Нийт уншигчийн тоо 3,5 %
- Ном олголт 37,8%
- Өөрийн орлого 45%-иар өссөн байна.

Гэрээр ном олгох журмын дагуу бүртгэл хөтлөж, 1600 уншигчдад 3512 ширхэг ном олгосон. Өмнөх оныхоос 200 уншигчаар, ном олголт 312 номоор өссөн үзүүлэлттэй байна.

Интернэт танхимын компьютерт дотоод сүлжээний бааз үүсгэж, интернэт удирдлагын программ суулгаж, нийт 80 хүнд интернэт мэдээллийн үйлчилгээ үзүүлсэн. Номын сангийн үйлчилгээг автоматжуулан мэдээлэл технологийн үйлчилгээ нэвтрүүлж, фондын номыг электрон каталогт оруулан электрон каталогийг үүсгэн ном тус бүрийн нэр, зохиогч, хэвлэсэн он, зэргээр хайж, мэдээллийг чөлөөтэй олж авах боломжийг нэмэгдүүлж, электрон хайлтын компьютерийг уншигчдад ашиглуулж, мэдээлэл технологийн үйлчилгээг чанаржуулсан. Ойрын фондонд байгаа 4315 ширхэг номыг электрон каталогит 100% хамруулсан.

Номын фондын сан хөмрөгийг төсвийн хөрөнгөөр 2,995,500 төгрөгийн 300 ширхэг шинэ номоор, Соёл урлагийн хорооны хандиваар 9 нэр төрлийн 23 ширхэг 149 мян төгрөгний нийт 323 ширхэг 3,144,500 төгрөгний номоор фондоо баяжуулсан.

Цахим номын сангийн фондыг төрийн шагналт зохиолчдын ном 11, хөрөг намтар 31, хүүхдийн зохиол 21, зургийн цомог 12, Д.Нацагдоржийн түүвэр 9, видео бичлэг 4, гадаадын болон дотоодын 30 ширхэг зохиолоор баяжуулсан. Баян тал, Шивээговь сумын соёлын төвийн номын сангийн номын фондын сан хөмрөгийг тус бүр 14 ширхэг 157.7 мянган төгрөгийн 2009 оны шилдэг номын уралдаанд шалгарсан шинэ номоор баяжуулсан.

Сүмбэр сумын 11 жилийн 1-р ахлах сургуулийн 1в ангийн 33, 3в ангийн 37, 4а ангийн 30, 5г ангийн 36, 1а ангийн 32, 2б ангийн 29, 3б ангийн 26, 3г ангийн 30, 4б ангийн 28, 2а ангийн 29, 3а ангийн 32, 1б ангийн 25, 5а ангийн 33, 3б ангийн 26, 2г ангийн 30,нийт 15 бүлгийн 466 сурагчдад, Хөгжөөнтэй туужууд, Учиртай бүлэг, Аавын цээжит чулуут, Бүтэлгүй илбэ, Монгол ардын 25 шилдэг үлгэр, Мөнгөний ертөнц, Тогоруу, Тоглож болохгүй тоглоом, Ойн парк, Дэлхийн үйлгэрийн цоморлиг Цүндээлэй, Цондоолойгийн шинэ цуврал, Домогийн цуврал, Зааны бяцхан тугал зэрэг 15 нэр төрлийн номоор тод уншлага зохион байгуулж харилцан ярилцлага хийлээ. Бага ангийн сурагчдын ном унших идэвхи сайжирч өмнөх оныхоос 166 уншигчдаар өссөн.

Боловсрол соёлын иж бүрэн үйлчилгээг хөдөөгийн багын малчдад хүргэх төслийн үргэлжлүүлэн Сүмбэр сумын 1,2,5-р цэцэрлэг Шивээговь, Баянтал сумын 3,4–р цэцэрлэг, нийт зуны сургалтын 78 хүүхдэд болон хөдөөгийн багын 192 малчдад үнэгүй карт нээн 480 гаруй зөөврийн номоор үйлчилсэн. Хөдөөгийн багийн уншигчдаас хэрэгцээт номын судалгаа авч , зуны сургалын хугацаанд хамгийнг олно ном уншигчийг шалгаруулсан. Хамгийн олон ном уншигчаар 4-р багийн Гашуун хэмээх нутагт гарсан 2-р цэцэрлэгийн сургалтанд хамрагдсан 4-р багийн малчин Н.Отгонжаргал шалгарлаа. Хөдөөгийн багийн 279 уншигч хамрагдаж, хэрэгцээт номоор хангагдсан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг номын сангийн үйлчилгээнд хамруулах зорилгоор уншлагын үйлчилгээг зөөврийн хэлбэрээр зохион байгуулж 40 иргэнд үнэ төлбөргүй уншигчийн карт нээж 130 номоор үйлчилгээ үзүүлсэн.

Шинэ номын болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 19 удаа зохион байгууллаа. Үүнээс шинэ номын үзэсгэлэнг 7 удаа, 453 ширхэг номоор, сэдэвчилсэн нотын үзэсгэлэнг 19 удаа 700 ширхэг номоор тус тус гаргасанаар номын эргэлт сайжирч 1634 хүн хамрагдаж уншигчдын ирц нэмэгдсэн. Үүнд:

- “Үлгэрийн орноор аялацгаая”
- “Англи хэл сурцгаая”
- “Уламжлалт зан заншил”
- Оюуны өмчийг хамгаалах өдөрт зориулсан “Ухаан далай номоос эхтэй”
- Уралдаант шалгалтанд бэлтгэгчдэд
- “Ээзгтэй таньд тусламж” гэх мэт.

“Ном эрдэм” 2 сарын аяны хугацаанд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг боловсруулан удирдамж чиглэлийг төрийн болон төрийн бус байгууллагуудад, номын сангуудад хүргүүлэн зохион байгууллаа.

Энэ ажлын хүрээнд нийтийн номын сангийн ажил үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, эх хэл бичиг үсэг, түүхийг хадгалан хөгжүүлэх зохион байгуулж буй үйл ажиллагаанд байгууллага иргэдийг өргөнөөр оролцуулах зорилгоор “Тэргүүний уншигч”,” Шилдэг бүтээл”, “Үндэсний бичиг соёлыг түгээн дэлгэрүүлэгч”, “Оюунлаг байгууллага”, “Оюуныг дэмжигч байгууллага” зэрэг 5 номинацын хүрээнд нийт уншигчид оюутан сухагчид иргэдийнхээ дунд БСГ-тай хамтран зохион байгуулж “Ном –Эрдэм аян”-ы хаалтын ёслолын ажиллагааг 2010 оны 15 дугаар сарын 20нд зохион байгуулсан. Үүнд:

“Тэргүүний уншигч” /бага нас/

1-р байр: 1-р сургуулийн 5г ангийн сурагч Г.Сайнжаргал нь тус аяны хугацаанд 104 ном уншсанаас 42 нь үргэлжилсэн үгийн тууж, романууд зонхилж байсан.

2-р байр: 1-р сургуулийн 3г ангийн сурагч Дөлгөөнмөрөн нь аяны хугацаанд 94 ном уншиж номын сангаар тогтмол үйлчлүүлсэн ба тэмдэглэл хөтөлсөн.

3-р байр: 1-р сургуулийн 5а ангйин сурагч д,Оюунгэрэл 88 ном уншсанаас 33 нь үргэлжилсэн үгийн тууж, романууд зонхилж байсан.

“Тэргүүний уншигч” /Өсвөр нас/

1-р байр: 1-р сургуулийн 8г ангийн сурагч А.Нандинсувд нь 224 ном уншсанаас 112 нь үргэлжилсэн үгийн тууж, романууд зонхилж байсан.

2-р байр: 1-р сургуулийн 11б ангийн сурагч Л.Лхагвасүрэн 93 ном уншиж тэмдэглэл хөтөлсөн байна.

3-р байр: 2-р сургуулийн 8-р ангийн сурагч Ц.Пүрэвсүрэн 94 ном уншиж тэмдэглэл хөтөлсөн.

“Тэргүүний уншигч”/Насанд хүрэгчид/

1-р байр: Д,Дэлгэрмаа Нэгдсэн эмнэлгийн ажилтан 55 ном уншиж тэмдэглэл хөтөлсөн.

2. “Шилдэг бүтээл”

1-р байр:Аймгийн Утга зохиолын нэгдлийн гишүүн М.Батбаясгалан 2010 онд “Морьт сүмбэр аялгуу” яруу найргийн номоо хэвлүүлсэн. Уг номыг аяны хугацаанд үзэсгэлэнд тавьж нийт 33 уншигч уншсан байна.

2-р байр: Аймгийн Утга зохиолын нэгдлийн гишүүн Б,Энхтөр 2010 онд
“Өөр өнцөгийн нүд” яруу найргийн номоо хэвлүүлсэн.
Уг номыг аяны хугацаанд үзэсгэлэнд тавьж нийт 26 уншигч уншсан байна.
3-р байр: Аймгийн Утга зохиолын нэгдлийн гишүүн Б. Аасүрэн 2009 онд “Бусдаас өөр чамд” яруу найргийн номоо хэвлүүлсэн. Уг номыг аяны хүрээнд үзэсгэлэнд тавьж нийт 19 уншигч уншсан байна.

3.” Үндэсний бичиг соёлыг түгээн дэлгэрүүлэгч” уран бичлэг /каллиграфийн/ төрөлд

1-р байр: 1-р сургуулийн багш Б.Мөнх-Өлзий уран бичлэг каллиграфийн төрөлд хавар, намар, өвөл, зун, монгол төр, гэсэн 5 бүтээлээр оролцож Тэргүүн байр эзэлсэн.
2-р байр: 1-р сургуулийн багш Э.Олонцэцэг уран бичлэг/ каллиграфийн/ төрөлд Хувьсал, Ном дор мөргөмү, монгол, толь, цонх, морь, чихний чимэг болсон, насар хавар, хүрд, цагаан сарын ёс, монгол улс, монгол хэл, эрх чөлөө, үндэсний соёл зэрэг 15 бүтээлээр оролцож Дэд байр эзэлсэн.
3-р байр: Сүмбэр сумын 3-р багийн иргэн Б.Батмөнх уран бичлэг /каллиграфийн/ төрөлд Бор, Тал гэсэн 2 бүтээлээр оролцож Гутгаар байр эзэлсэн.

“Үндэсний бичиг соёлыг түгээн дэлгэрүүлэгч”
“Ховор ном судар”ын төрөлд:

1-р байр:
1-р сургуулийн 11в ангийн сурагч Ж.Баясгаланбаатар нь зүүн чойрын хийдэд шавилан сууж байсан өндөр өвөө Ч.Жамбасамбуугийн эдэлж хэрэглэж байсан судар ном, шашны зүйлсийг өвлөн хадгалж хийморийн дарцаг, чунт, хүүхдийн дарцаг, хүүхдийн сан зэрэг модон бараар ном хэвлэх аргад суралцаж, Манзуширийн магтаал бүтээлийг төвд уйгаржин монгол бичгээр дуурайлган бичиж хадгалсан. Мөн Ч.Жамбасамбуугийн төвд монгол хадмал судруудыг хадгалж хуулбарлан бичсэн.
2-р байр:

Сүмбэр сумын 3-р багийн өндөр настан Н,Жуужаагийн Ёсөн эрдэнээр уралсан "Доржзав" хэмээх судар нь 3 үе дамжин өвлөгдөж ирсэн бөгөөд уг судрын онцлог нь: монгол технологи болох хонины тархиар пайту дээр хар өнгө оруулан нягтан маягаар урласан судар болно.

3-р байр: Сүмбэр сумын 2-р сургуулийн 10-р ангийн сурагч Г.Батнаст нь Хуучин монгол бичгээр муутуу цаасан дээр баралсан 3.5х2.5см хэмжээтэй бичил номоор оролцсон. Энэ ном нь араб үсгээр бичигдсэн ямар нэгэн судар болно. Энэ номын онцлог нь үзэсгэлэнд орсон бүтээлүүдээс хамгийн жижиг нь болсноороо онцлогтой.

4."Оюунлаг байгууллага, хамт олон"

Оюунлаг байгууллага, хамт олон шалгаруулах номинацид 11 байгууллага, хамт олон оролцсоноос 5-р цэцэрлэгийн хамт олон 9 уншигч аяны хугацаанд 169 ном уншиж "Оюунлаг байгууллага"-аар 1-р сургуулийн Батцацрал багштай 5г ангийн хамт олон 36 хүүхэд 1064 ном уншиж "Оюунлаг хамт олон"-оор тус тус шалгарлаа

5. "Оюуныг дэмжигч байгууллага"

Дэлхийн зөн олон улсын байгууллагын Говьсүмбэр аймаг дахь төлөөлөгчийн газар нь Ном – Эрдэм аяныг зохион байгуулахад хамгийн их санхүүгийн дэмжлэг үзүүлж ,"Оюуныг дэмжигч байгууллага"-аар шалгарлаа.

Аяны хугацаанд нийт 1651 уншигч үйлчлүүлж 4463 ном уншсан.

"Ном Эрдэм" аянд оролцогчдийн бүтээлийн үзэсгэлэнг 2010 оны 15 дугаар сарын 20нд Дуу бүжгийн Боржигин чуулгат зохион байгуулсан. Уг үзэсгэлэнд 17 оролцогч 36-н бүтээлээр оролцсон. Иргэдийн гар дээр 14 ш ховор ном судар, бар, хэв хадгалагдаж байгааг илрүүлэн нийтэд сурталчилсан.

575 лавлагааг амаар болон бичгээр өгч, лавлагааны дэвтэр хөтөлж, шинээр ирсэн номын мэдээг гаргаж, лавлагааны мэдээллийн санг өргөжүүлж, 230 лавлагааны материал бэлтгэсэн. Уншигчдын лавлагаанд зориулан

- ❖ Эдийн засгийн шинжлэх ухааны 18 ширхэг
- ❖ Түүхийн шинжлэх ухааны 51 ширхэг
- ❖ Шашны шинжлэх ухааны 20 ширхэг
- ❖ Хэл шинжлэх ухааны 29 ширхэг
- ❖ Хууль эрх зүйн 18 ширхэг
- ❖ Анагаах ухааны 36 ширхэг, Нийт 172 ширхэг номоор тус тус төрөлжсөн картын сан хийсэн.

Тодорхой сэдэв төрөл ангиар санамж өгөх болон бүртгэн мэдээлэх ном зүй хийсэн. Үүнд:

- Таны хэлний боловсролд /гадаад хэлний мэдлэгт зориулсан/
- Зах зээл эдийн засаг Маркетинг менежмент сэдвээр та юу унших вэ
- Бурхан шашин зурхайн холбогдолтой ном зохиолоор
- Түүхийн холбогдолтой ном зохиол
- Хуулийн талаар та юу унших вэ? Тус тус санамж өгөх ном зүй хийсэн.

Монголын уран зохиолын дээж 108 ботийн тууж, өгүүлэлээр бүртгэн мэдээлэх ном зүй хийсэн. Орон нутгийн зохиолчдын гаргасан номноос 25 ширхэг картын сан хийсэн. Компьютер сурцгаая, орон нутгийн зохиолчдын шинэ ном, 2010 онд гарсан шинэ ном зэрэг гарын авлага зөвлөмжийг хийлээ.

"Номын яармаг 2010" үзэсгэлэн худалдааг "Адааст ном" ХХК-тай хамтран 172 нэр төрлийн 239 ширхэг шинэ номоор зохион байгуулсан. Сүмбэр сумын 3-р багийн иргэн Ф.Болорцэцэг уран зохиолын болон мэргэжлийн 40 ширхэг номоор оролцож

худалдаалсан.100 гаруй иргэд уншигчид хамрагдаж хэрэгцээт шинэ номоор хангагдсан.

“Боржигоны өв соёл-Ховор ном”-ын үзэсгэлэнг Боржигин сумдын дунд АЗДТГ, БСГ-тай хамтран зохион байгуулсан. Уг үзэсгэлэнд 150 гаруй хүн хамрагдсан.

- ❖ Боржигоны түүх судалгааны чиглэлийн ховор номын төрөлд: Н.Баттөмөр Боржигоны судалгааны гарын авлага 40 гаруй ном, өөрийн судалгааны бүтээлээр оролцож 1-р байр эзэлсэн.
- ❖ Эртний түүх уран зохиолын ховор номын төрөлд:Төв аймгийн Баянжаргалан сумын иргэн Д.Цэрэннадмид “Эртний 100 билгийн дээж“, “Эрт эдүгээгийн гайхамшигт сонин содон үзэгдэл оршвой”, “Саган сэцэний Эрдмийн товч”, гэх мэт 28 ширхэг номоор оролцож 1-р байр эзэлсэн.
- ❖ Шинжлэх ухааны мэргэжлийн номын төрөлд: Б.Мөнх-Өлзий Уран зураг, Зураасан зураг, Хөрөг зураг гэх мэт 21 номоор оролцож 1-р байр эзэлсэн.

Номын сангийн үйл ажиллагаа болон шинэ номын сэдэвчилсэн номын үзүэсгэлэнг нийт 1634 хүнд тайлбарлан сурталчилж, “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг угтан зохион байгуулсан Ном-Эрдэм аяны үйл ажиллагаа, ЕБС-ийн сурагчдын элсэлтийн шалгалтанд зориулж уртасгасан цагаар ажиллах график, “Номын яармаг 2010” үзэсгэлэн худалдаа, “Боржигины өв соёл–Ховор ном”-ын үзэсгэлэнг FM радио болон телевизээр 9 удаа, ГСА-ийн 1 удаа, 27 хүн и-майл хаягаар, нийт 37 удаа тус тус сурталчилсан байна.

Шивээговь, Баянтал сумын соёлын төв, 1,2,3,4-р сургуулийн номын сангуудын номын санч нарт ‘’ЕБС-ийн номын сан нь сургуулийн мэдээллийн төв болох нь” сэдэвт

- ❖ Номын сангийн анхан шатны бүртгэлүүд
- ❖ Номын сангийн ном зүйн ангилал
- ❖ Каталоги зохион байгуулалт
- ❖ Номын сангийн ном бүрдүүлэлт
- ❖ Ном сэргээн засварлах
- ❖ Номын сангийн програм Lib4U

Ном хэвлэлийг дахин үнэлэх зэрэг хичээлээр онол практик хосолсон сертификаттай 40 цагийн сургалтыг Хүүхдийн номын ордонтой хамтран зохион байгууллаа.

Номын санч нарт өдөр тутам хэрэглэгдэх номын сангийн анхан шатны бүртгэл хөтлөх аргачлал, зохиогчийн 3 тэмдэгт, номын сангийн үйл ажиллагааны үндэс, ном зүйн ангилал зэрэг номуудаар хангагдаж ур чадвар сайжирсан.

Төсвийн буюу мөнгөн хөрөнгө, санхүүгийн ил тод байдлыг хангах “Шилэн түрийвч ”аяныг ажилчдад танилцуулан байгуулагын төсөв, сарын мэдээ, зарцуулалтыг танилцуулгын самбарт байрлуулсан.

Ажилчдын санхүүгийн талаарх мэдээлэл сайжирч, санхүүгийн ил тод байдал хангагдсан. 2009 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж, илэрсэн дутагдлыг арилгах талаар зөвлөмж ирүүлсний дагуу дараах арга хэмжээг авч ажиллалаа.

1. Байгууллагынхаа дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулан дарга ажиллагсадад ярианы карт олгох, шуудан холбооны зардлын лимит тогтоосон.

ХХОАТ-ын дагуу шимтгэлийг давхар хөнгөлсөн 35.0 мянга, гар утасны төлбөр 91.2 мянга, нийт 126.2 мянган төгрөгийг 1-р улиралд багтаан орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлж, төлбөр тооцоог барагдуулсан.

БСШУЯ-ны сайдын 2008 оны 154-р тушаалын хавсралтын дагуу байгууллагын үйл ажиллагаандаа тоон болон чанарын хяналт шинжилгээ үнэлгээг хийсэн.

Үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулах, уншигчдын ном унших таатай орчин бүрдүүлэх зорилгоор уншлагын танхимд пар нэмж, цахилгааны монтажийг сольж, уншлагын танхимын гэрэлтүүлгийг сайжруулан номын сангийн гадна хаяг, уншигчдын хувцас өлгөх өлгүүртэй болсон.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр ахуй үйлчилгээний зориулалттай барилгыг 2 давхар болгон өргөтгөж, Номын сан, Музейн байрны асуудлыг шийдвэрлэн барилгын өргөтгөлийн ажлыг УБ хотын “МД” констракшнаар гүйцэтгүүлж байна.

БСШУЯ-ны хөрөнгө оруулалтын газар хүсэлт гарган хандиваар

Уншигчийн ширээ –40

Уншигчийн сандал - 80

Номын тавиур - 1 ком

Албан тасалгааны ширээ 7 ширхэг, Нийт 6.165.6 төгрөгийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэн.

Мэргэжлийн боловсон хүчнээр номын санг бэхжүүлэх, ажилчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд анхаарч уншлага үйлчилгээний номын санч А.Чимэгмааг Соёлын дээд сургуульд Номын санч, мэдээллийн ажилтан мэргэжил эзэмшүүлж, Номзүйч Д.Бадамтуяаг Соёлын дээд сургуулийн Номын сан судлал- мэдээллийн ажилтаны Бакалаврын эчнээ ангид суралцуулж мэргэжлийг нь дээшлүүлсэн.

Ангилагч фондчин У.Эрдэнэтуяа “Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль”-ийн Боловсрол судлалын Магистрийн эчнээ ангид суралцаж төгслөө.

Мэргэжилтэй боловсон хүчний хангалт 75%-д хүрлээ.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2010 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Эрхэм зорилго: Төрөөс соёлын талаар баримтлах бодлогыг аймаг, орон нутгийн түвшинд хэрэгжүүлэхэд, номын сангийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, уншигч бие даан боловсрол эзэмших, номын санг иргэдийн мэдээллийн төв болон хөгжүүлэхэд оршино.

Нэг. Удирдлагын менежментийн талаар.

Дархан-уул аймгийн Төв номын сан нь ТБУС-ийн тухай хууль, орон нутгийн засаг захиргаанаас дэвшүүлсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа эрхлэн явуулж байна.

2010 онд Аймгийн төв номын сан нь 15 ажиллагсадтай, харъяа 1 салбар номын сантай орон нутгийн уншигч иргэдэд үйлчлэв.

Номын сангийн нийт жилийн төсөв 63214.7 мян. төгрөг батлагдсанаас

- Цалин хєлс 47749.1
- НДШ бусад тэтгэвэр тэтгэмж 5232.5
- Ном авах зардал 3025.5
- Бараа үйлчилгээний бусад зардал 12803.6
- єєрийн үйл ажиллагааны орлого 2000.0 тєгрєг батлагдаж зарцуулагдав.

Байгууллагын ашигтай үйл ажиллагааны орлого 2651.8 .1 мян. тєгрєгний ашигтай ажилласан байна.

Аймгийн тєв номын сан нь "2009-2012 онд хэрэгжүүлэх хєгжлийн хєтєлбєр"-өө боловсруулж, номын сангийн хэтийн зорилго, тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүнгээ тодорхойлон ажиллаж байна. Номын сангийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд удирдлагын менежментийн үйл ажиллагаа нь:

- Номын сангийн материаллаг баазыг бэхжүүлэх
- Номын санд мэдээллийн технологи нэвтрүүлэх
- Олон нийттэй харилцах харилцааг өргөжүүлэх
- Уншлага- үйлчилгээний хүрээг нэмэгдүүлэх
- Хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэхэд чиглэгдэж байна.

Аймгийн Тєв номын сангийн дэргэд БСШУ- ны сайдын 2001 оны 180-р тушаал /Номын сангийн үйл ажиллагаанд олон улсын ДДС ангилал нэвтрүүлэх тухай/, 2005 оны 441-р тушаал/ номын сангийн данс, маягт шинэчлэн батлах тухай/, Сангийн сайд, БСШУ-ны сайдын хамтарсан 357/406 тоот тушаал /Ном хэвлэлийг дахин үнэлэх тухай/-ыг хэрэгжүүлэх, номын сангийн цахим програм "Lib-4U"-д ном хэвлэлийн бүтээгдэхүүн, каталогийг цахим хэлбэрт оруулах "Ажлын хэсэг" байгуулагдан ажиллаж байна.

Төв номын санд аймгийн БСГазрын ээлжит удирдах ажилтны зөвлөлгөөн зохион байгуулагдаж соёлын байгууллагуудын 2010 оны үйл ажиллагааны явц, соёл боловсролын байгууллагуудын хамтын ажиллагааны талаар хэлэлцлээ.

Тайлангийн хугацаанд ажиллагсадын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тэтгэвэр тэтгэмж, шагнал урамшуулалд 957.2 мян, төгрөгийг байгууллагын захиргаа болон ҮЭ-ийн татвар хуримтлалын сангаас зарцуулав.

2010 онд Тєв номын сангийн материаллаг баазыг бэхжүүлэх, мэдээллийн шинэ техник, технологи нэвтрүүлэх ажлын хүрээнд номын сангийн "Lib-4U" програмыг нэвтрүүлэн дотоод сүлжээгээр ажиллаж 2755 нэр төрлийн 9349 номын мэдээллийг электрон хэлбэрт оруулаад байна. Мөн санхүүгийн Acoulos, архив бичиг хэргийн ORG-AMS програмуудыг суурилуулан үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Дэлхийн банкны санхүүжилтээр www.darlib.mn веб сайттай болж дэлхий нийтээр өөрийн үйл ажиллагаагаа сурталчлах өргөн боломжтой боллоо.

Гадаадын их, дээд сургууль, TOEFL-ийн шалгалтын талаар мэдээлэл авах, гадаад, дотоодын их дээд сургуульд онлайнаар бүртгүүлэх, хууль эрх зүйн актууд болон бусад сонирхсон сэдвүүдээр эрэл хайлт хийж 2665 хүн интернетээр үйлчлүүлсэн байна.

Интернетийн үйлчилгээг ашиглан Дэлхийн банк, Америкийн боловсролын байгууллага, АНУ-ын ЭСЯам, УБ хотын Боловсролын зөвлөгөө мэдээллийн төв,

БСШУЯам, Үндэсний номын сан, бусад аймгуудын номын сантай хамтран ажиллаж үйл ажиллагаагаа явуулж байна.

.

Хоёр. Номын сангийн уншлага үйлчилгээний талаар

2010 онд:

- Байнгын уншигч 5085
- Ирэгсэд 61694
- Ном олголт 109010

- Номын сан нь уншлага үйлчилгээндээ ном хэвлэлээ тогтмол сурталчилж, шинэ номын мэдээллийн сангаар үйлчлэх, ном хэвлэлийн тойм, ашигтай зөвлөмж материалуудыг хувилж уншигчдын хүртээл болгох, эрэл хэрэгцээг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

- 2010 онд Төв номын сангийн үйл ажиллагаатай танилцуулах, хүүхэд багачуудыг номтой ойртон нөхөрлүүлэх, үйлчилгээний хүрээг өргөтгөх зорилгоор цэцэрлэгийн болон ЕБС-ын бага ангийн 1841 хүүхдэд үнэ төлбөргүй карт нээж, ном хэвлэл олгож үйлчилсэн байна. Мөн зөөврийн номын сангаар 254 ном олгож үйлчилсэн байна.

Аймгийн Төв номын сангаар үйлчлүүлж байгаа уншигчдын 40 гаруй хувь нь ЕБС-ийн сурагчид, 60-аад хувь нь их, дээд сургуулийн оюутнууд, насанд хүрэгсэд, өндөр настнууд байна. Нийт ном олголтын 60-80 хувийг нийгэм, улс төр, эдийн засаг, хууль эрх зүй, гадаад хэл, уран зохиолын номнууд, 20-иод хувийг тогтмол хэвлэл эзэлж байна.

Төв номын сан нь 40 гаруй нэр төрлийн цахим хэвлэлийн бүтээгдэхүүнтэй болж байна. Үүнд:

- Монгол улсын хуулийн сан
- Монголын зохиолчдын шилдэг 50 бүтээлийг нэгтгэсэн цахим номын сан
- Монголын Үндэсний номзүйн бүртгэл мэдээллийн сан
- Анагаах ухааны номын сангийн эрдэм шинжилгээний бүтээлүүд
- Монголын нууц товчоо г.м.

Гурав. Номын сангийн фонд, номзүйн лавлагаа мэдээлэл, каталог зохион байгуулалтын ажлын талаар

Төв номын сангийн фондын зохион байгуулалт, бүрдүүлэлт, номзүйн мэдээлэл, каталог картын санг мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулж, уншигчдын хэрэгцээ шаардлагыг хангахуйц шинэ ном хэвлэлийн бүтээгдэхүүнээр фондоо баяжуулж байна.

- 2010 онд Аймгийн Төв номын сан нь БСШУ-ны сайдын 2001 оны 180, 2005 оны 441-р тушаал, “Аймгийн төв номын сангийн хөгжлийн хөтөлбөр” /2009-2012/ -ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд номын санд мэдээллийн технологи нэвтрүүлэх, номын сангийн “Lib-4U” програмд номын фондоо оруулах урьдчилсан нөхцөл хангагдаж дараах ажлуудыг гүйцэтгэв.

Одоогийн байдлаар 31250 боть ном хэвлэлийн бүтээгдэхүүн номын сангийн анхан шатны шинэчилсэн бүртгэлд бүртгэгдэж, олон улсын DDC ангиллаар ангилалагдсан байна. Үүнээс 2010 онд 2755 нэр төрлийн 9349 боть ном номын сангийн Lib-4U програмд цахим хэлбэрт шилжив. Мөн номын санд нийтдээ 80.0 мянга орчим цаасан каталог шинээр бичигдэж, уншигчдын хэрэгцээнд ашиглагдаж байна.

Төв номын сан нь 2010 онд 5354.2 мян. төгрөгний 649 боть ном хэвлэлийн бүтээгдэхүүн авч фондоо баяжуулан уншигч олны хүртээл болголоо. 2010 онд 370 гаруй уншигчдад амаар болон утсаар лавлагаа єгч 70 татгалзал бүртгэсэн байна.

Урагдаж гэмтсэн 7800 номыг сэлбэн засварлаж, тогтмол хэвлэлийг сар улирлаар нь боть болгон үдэж хавтаслан уншигчдын хүртээл болгов.

Дєрєв. Номын сангийн СОТАжлын талаар

Дархан хот байгуулагдсаны 50 жилийн ой угтаж "Дархан миний хот", "Монгол уламжлал, ёс заншлаа дээдлэе" аймаг, сумын зорилтын хүрээнд Төв номын сангаас уншигчдын дунд зохиох соёл олон түмний ажлуудыг зохион байгуулав.

- Аймаг байгуулагдсаны түүхт 50 жилийн ой угтаж "Бидний бахархан дуурайх үйлстэн" сэдвийн дор Дархан хотын бүтээн байгуулалтанд оролцож, үлгэр дуурайлтай амьдарч буй "Дархан дээжис" ХХК-ний дэд захирал, хүнсний үйлдвэрийн ахмад ажилтан Х.Үзмээтэй "Амьдрах ухаан" сэдэвт уулзалт зохион байгуулж, орон нутгийн их, дээд сургуулийн 130 гаруй багш, оюутан сурагчид, төв номын сангийн 10 гаруй номын санчид оролцов. Уулзалтын үеэр TV-9, Лха, DBS телевизийн / орон нутгийн/ мэдээ, мэдээлэл, ярилцлага авав.

- Дархан-Уул аймгийн "Оюуны-Ирээдүй" цогцолбор сургуулийн ахлах ангийн сурагч Ч.Содбилэг "Монголын их Юань улсын түүх" номын зохиогчтой оюуны анхны том бүтээлийг нь сурталчлах уулзалт зохион байгуулав. Уулзалтанд төр захиргаа, хэвлэл мэдээллийн байгууллага, багш, оюутан сурагчид 50 гаруй хүн оролцов. Тэргүүний сурагч Ч.Содбилэгийн намтар, уран бүтээлийн үзэсгэлэн гаргаж сурталчлав.

- Л.Бадарчийн "Хүжийн гал" зохиолоор дүрийн тоглолттой уншигчдын бага хурлыг 18 дугаар сургуулийн сурагчдын дунд зохион байгуулж 48 сурагч оролцов.

- "Буян ба нүгэл" сэдвээр 16,18,9 дүгээр сургуулийн сурагчдын дунд Хараагийн Дарь эхийн хийдтэй хамтран зохион бичлэгийн уралдаан зохион байгуулав.

- Орон нутгийн зохиолчид Мөнхбаатар, Чойжиндорж, Уянсүх, Цэвээнгэрэл, Амаржаргал нартай, 1 дүгээр сургуулийн сурагчдын дунд "Зохиолч-уншигчдын уулзалт" зохион байгуулж 400 гаруй сурагчид оролцов. Уулзалтанд орон нутгийн зохиолчид уран бүтээлээсээ уншиж танилцуулан, номын сангаас тэдний бүтээлээр номын үзэсгэлэн гарган сурталчлав.

Дархан сумын ЗДТГазар, аймгийн БСГазар, Аймгийн Төв номын сан, Аймгийн музей, Хүүхдийн номын ордонтой хамтран Ерөнхийлөгчийн 2003 оны зарлиг, Засгийн газрын 196 дугаар тушаалаар батлагдсан "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр", Аймаг, сумын 2010 онд дэвшүүлсэн зорилтын хүрээнд Үндэсний бичиг соёлоо сурталчлах, дэлгэрүүлэх ажлын хүрээнд "Монгол бичгийн уралдаан"-ыг зарлаж дүгнэв.

Уралдаанд 38 багш, сурагчид бүтээлээ ирүүлснээс 3-7 ангийн сурагчдаас 6, 8-11 ангийн сурагчдаас 6 сурагч, 3 багш эхний 3 байранд тус тус шалгарав.

Уралдааны шагналыг Аймгийн төв номын сан дээр зохиогдсон "Үндэсний бичиг үсгийн баярын өдөр"-өөр Аймгийн ИТХурлын дарга Л.Гүнчин, Сумын Засаг дарга Ч.Цэндсүрэн, БСГазрын орлогч дарга Баярбилэг, Дархан-Уул аймаг дахь ОХУ-ын консул А.И.Лавров нар оролцож гардуулав.

"Үндэсний бичиг үсгийн баярын өдөр"-т оролцогчдын дунд хуучин монгол бичгийн "Хурдан уншлага", "Уран бичлэг", "Түргэн бичлэг"-ийн тэмцээн зохион байгуулж, тус бүр эхний 3 байр эзэлсэн сурагчдад дурсгалын зүйл гардуулав.

"Номтой нөхөрлөе" аяны хүрээнд "Үлгэрийн орноор аялцгаая" сэдэвт өдөрлөгийг 5,15,22, "Улиасхан" цэцэрлэгүүд дээр зохион байгуулж, "Залуучууд" театрын дэргэдэх Хишигсүрэн багштай драмын дугуйлангийн сурагчдын жүжигчилсэн тоглолт үзүүлж, цэцэрлэг тус бүр дээр 60 гаруй хүүхдийн уран зохиолын номоор үзэсгэлэн гарган чанга уншлага хийж, мөн тэднийг номын сангийн үйл ажиллагаатай танилцах экскурсийг зохион байгуулав. Энэ арга хэмжээнд нийт 900 гаруй багш, хүүхдүүд оролцсон байна. Дархан-Уул аймгийн нийт цэцэрлэгүүдэд "Монголын шилдэг бүтээл" цахим номын санг компьютерт нь суурилуулав.

Түүхт ой, тэмдэглэлт өдрүүд, соёл олон түмний ажлын хүрээнд сэдэвчилсэн номын үзэсгэлэн 29 удаа 1379 боть номоор, шинэ номын үзэсгэлэн 5 удаа 580 боть номоор тус тус гарган өөрийн фондын номоо сурталчилсан байна.

ТҮ-9 болон орон нутгийн телевиз, радио, сонингоор өөрийн үйл ажиллагааг 34 удаа сурталчиллаа.

Тав. Сургалт-семинар аргазүйн ажлын талаар

2010 онд номын сангийн ажилтнууд дараах сургалтуудад хамрагдлаа. Үүнд:

- Номын сангийн "Lib-4U" програмыг төв номын сангийн үйл ажиллагаанд нэвтрүүлэхтэй уялдан програмтай танилцах, ажиллаж сурах 3 өдрийн сургалт Аймгийн төв номын сан дээр зохион байгуулав. / УБ. "Волвес" компаний ажилтан Ганхуяг, Гантулга/

- "Номын чимэглэлийн урлаг", "Уншигчдын эгнээг өргөжүүлэх арга замууд"-сургалтанд 1 номын санч / Монгол улс дахь Германы ЭСЯам. Гетёгийн институт/,

- "Сүм хийд болон архивын ном хэвлэлийг хадгалж хамгаалах" сургалт – 1 номын санч / Германы ЭСЯам. Гетёгийн институт/

- "Үндэсний бичиг үсгийн баяр"- сургалт-семинарт - 2 номын санч / УБ хот. ҮННС/

- "Монгол туургатны уулзалт" "Монголын мэдээллийн төв"-ийн нээлтэнд- 2 номын сангийн ажилтан /Улан-Үдэ Үндэсний номын сан

- "ХҮ-Книжный салон" арга хэмжээнд "Орчин үеийн монголын номын сангийн өнөөгийн байдал" илтгэлтэй–2 номын сангийн ажилтан / Буриад улсын соёлын яам, Үндэсний номын сан/

- "Дэлхийн банкны PIC-ийн хамтын ажиллагаа" сэдэвт сургалт-семинарт- 3 номын сангийн ажилтан / УБ хот. Дэлхийн банк/

- "Зохицуулагч нарын онлайн сургалт"–2 мэдээллийн ажилтан/ УБ хот. Боловсролын зөвлөгөө мэдээллийн төвд/

- “Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх нь” сэдэвт сургалтанд- 1 ажилтан /Дархан-Уул аймаг. ЗДТГазар/

- УБ хотын соёлын дээд сургуулийн номын сангийн ангийн бакалаврын “Онлайн” сургалтанд 1 хүн суралцаж байна.

- “ Бие бялдрын түвшин тогтоох сорил авах” сургалт- 1 номын санч /Дархан-Уул. ЗДТГазарт/

Төв номын сан нь Дархан-Уул аймгийн нийт номын сангийн арга зүйн төв нь болж ажилладаг бөгөөд 2010 онд:

- Шарын голын 10, 8 жилийн сургууль, Сэлэнгэ аймгийн Баянхараат, Жавхлант сумын номын сангуудад арга зүйн зөвлөгөө тус бүр 1 удаа
- “Дархан” дээд сургууль, “Шинэ Дархан”, “Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Дархан дахь салбар”, “Техникийн коллеж”, “Дархан-Өргөө” сургуулийн номын сангуудад тус бүр 1 удаа. Нийт 9 удаа дээрхи номын сангуудын үйл ажиллагаатай танилцах болон номын санчдын хүсэлтээр арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.
- Аймгийн төв номын сангийн номын санчид, их, дээд сургууль, ЕБС-ийн номын санчид оролцсон Монгол улсын “Номын сангийн тухай хууль”-ийн төслийн хэлэлцүүлэг зохион байгуулж 30 гаруй номын санчид саналаа явууллаа.
- УБ хотын Соёлын дээд сургуультай хамтран орон нутгийн номын санчдын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх, номын санчаар ажиллах сонирхолтой хүмүүсийг мэргэшүүлэх сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулав. Үүний үр дүнд номын сангийн эчнээ ангид 1 хүн, “Онлайн” сургалтанд 6 хүн суралцаж байна. Номын сангийн орон нутгаас мэргэжлийн боловсон хүчин бэлтгэгдэж, зардал төсөв багатай суралцах боломж нээгдэж байна.

Зургаа. Шинэлэг үйлчилгээ- бүтээлч ажил.

Төв номын сангийн дэргэдэх Боловсролын зөвлөгөө мэдээллийн төв /БЗМТ/ нь Дэлхийн банк, ННФорумаас зарлагдсан

- “Байгаль орчин”,

- “Мониторингийн төсөл ”,

-“Залуу удирдагч” зэрэг төслийн сэдвүүдийг иргэний нийгмийн байгууллагууд, иргэдэд сурталчлан 13 удаа уулзалт, лекц зохион байгуулж 893 хүн хамруулсны үр дүнд:

- FM радиогийн “ Иргэний хяналт”,

-“Нийгмийн дэвшил-эмэгтэйчүүдийн хөдөлгөөн” ТББ-ын “ Орон нутгийн иргэдийн оролцоон дээр түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ”,

-“Хүчирхийллийн эсрэг үндэсний төв”-ийн “Мониторингийн төсөл”,

-Иргэн Хумбагай ахлагчтай бүлгийн “Хараа голоо хамгаалъя” 4 төсөл шалгарсан нь орон нутгийн хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр болж байна.

Тус төв нь Соросын сан, АНУ-ын ЭСЯамнаас зарлагддаг :

- “Тэтгэлэгийн хөтөлбөр”,
- “Магистрийн тэтгэлэгт хөтөлбөр”,
- “Болгар дахь Америкийн их сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр”,
- “Оюутан солилцооны хөтөлбөр”,

- “Англи хэлний багш нарын хөтөлбөр”,
- “USAP-ийн тэтгэлэгт хөтөлбөр”-үүдийг ЕБС-ийн сурагчид, их, дээд сургуулийн багш, оюутнууд, эдийн засгийн мэргэжилтнүүдэд сурталчлан 14 удаа лекц зохион байгуулж 3470 гаруй хүн хамрагдсанаар:
- БНХАУ-ын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрт 1 сурагч,
- АНУ-ын дээд сургуульд 1сурагч,
- Болгар дахь Америкийн их сургуульд 1 сурагч тус тус тэнцэн суралцаж байгаа нь Дархан-Уул аймгийн хүүхэд, залуучуудад гадаадад 100 хувийн тэтгэлэгээр суралцах таатай боломжийг бүрдүүлж байна.

2010 онд БЗМТ нь англи хэлний анхан, дунд, гүнзгий шатны болон TOEFL-ийн сургалтыг 28 удаа явуулж 198 оюутан, сурагчид хамрагджээ.

Оюутан, залуучуудын англи хэлний ярианы чадварыг сайжруулах зорилгоор гадаад мэргэжилтнүүдтэй хамтран “Англи хэлний ярианы клуб”- ыг долоо хоног бүр тогтмол ажиллуулж 287 хүн хамрагдсан.

ЕБС-ийн сурагчдын дунд англи хэлний олимпиадыг III дахь удаагаа зохион байгуулж 60-аад сурагч хамрагдан 5 сурагч 32-41 оноогоор эхний байруудыг эзэллээ.

Долоо. Бусад ажлын талаар

Аймгийн Тєв номын сан нь 2010 онд орчноо тохижуулах, ажилтнууд, уншигч-хэрэглэгчдийн ая тухтай орчинг бүрдүүлэх дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Байгууллагын гадна орчинг тохижуулах, ногоон байгууламжийг бий болгох зорилгоор 25 чимэглэлийн мод тарьж, 15 тасалгааны цэцэг тарьж ургууллаа.

- Хуучин Дарханы салбар номын сан, Дэвшил дэх архивын фондонд 800.0 гаруй мян. төгрөгний сантехникийн урсгал засвар хийсэн.

- Аймгийн БСГазар болон УБ хотын Боловсролын зөвлөгөө мэдээллийн төвийн хандив, төсвийн хэмнэлтээр 2 ажлын компьютер, 2 нотебук тус тус авч ажилтнуудын албан хэрэгцээнд ашиглаж байна.

- Номын сангийн ажилтнуудад төсвийн хөрөнгөөр 250.0 мян. төгрөгний формын хувцас хийлгэв.

Найм. Цаашид тавих зорилт.

Монгол улсын Соёл урлагийн ажилтны анхдугаар зєвлєгєєн, Аймгийн соёл урлагийн ажилтны анхдугаар зєвлєгєєн, “Номын сангийн хєгжлийн хєтєлбєр”-т тусгасан зорилтыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх,

“Номын сангийн анхан шатны бүртгэл маягтыг шинэчлэх тухай” БСШУ-ны сайдын 441,180, Сангийн сайд, БСШУ-ын сайдын хамтарсан 357/406 тоот тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд анхан шинэчилсэн маягтыг хєтлєх, ном хэвлэлээ дахин үнэлэх, олон улсын ДДС ангиллаар ангилах ажлыг бүрэн дуусгах,

Номын сангийн программд монгол фондын номыг оруулж дуусгах,

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2010 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны “Сахилга, дэг журам, хариуцлагыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 03 тоот албан даалгаврыг хэрэгжүүлж номын санч, уншигч, үйлчлүүлэгчдийн хариуцлага, сахилга дэг журмыг өндөржүүлэх, иргэдэд үзүүлэх үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй, хүртээмжтэй хүргэх, албан бичиг хэргийн стандартыг хангах, боловсруулалт, хөтлөлтийг сайжруулах , номын сангийн үйл ажиллагаанд CDIS/ISIS программ нэвтрүүлэх ажлын бэлтгэлийг хангах зэрэг зорилт тавин дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Байгууллагын удирдлага зохион байгуулалт, дотоод ажлын талаар

1. Аймгийн Засаг даргатай байгуулсан Байгууллагын ерөнхий менежерийн 2009 оны үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дүгнүүлж 81.9 оноо авч “Сайн” гэсэн үнэлгээ авсан болно.
2. Аймгийн Төв номын сангийн 2009 онд хийсэн ажлын тайланг БСШУЯ-ны сайдын 2008.12.24-ний өдрийн 154 тоот тушаалын хавсралт “Соёл урлагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх үнэлэх журам”–ын дагуу 20 үзүүлэлтээр боловсруулан 12 хуудас, Су -10, Су -5 Су -3 мэдээг 4 хуудас, Аймгийн Засаг даргатай байгуулсан Байгууллагын ерөнхий менежерийн 2009 оны үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 10 хуудас тус тус бичиж, аймгийн БСГазарт 01 сарын 15 –ны дотор хугацаанд нь өгсөн.
3. Аймгийн Төв номын сангийн 2009 онд хийсэн тайланг тасаг танхим бүрээр дэлгэрэнгүйгээр 11 хуудас бичиж, МҮНСанд явуулж, байгууллагын мэдээллийн самбарт тавьж ажилчдад танилцуулсан.
4. Аймгийн төв номын санд 2009 онд худалдаж авсан болон хандив тусламжаар нийлүүлсэн 299 нэр төрлийн 7 хуудас ном хэвлэлийн нэрсийн жагсаалт, Су -10, Су -5 Су -3 мэдээг 4 хуудас тус тус бичиж МҮНСанд явуулсан.
5. Аймгийн Төв номын сангийн үйл ажиллагааны хүртээмж, үр нөлөө өнөөгийн байдал тайланг 8 үзүүлэлтийн дагуу боловсруулан 8 хуудас, Аймгийн номын сангийн удирдлагын анкет, зураг, ажилчдын харилцах утас mail хаягийн жагсаалт 1 хуудас материал боловсруулж Соёл урлагийн хороонд явуулсан.
6. Аймгийн Төв номын сангийн 2010 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан 3 хуудас, Аймгийн Төв номын сангийн “СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ-2008-2012”-г боловсруулан 10 хуудас бичиж, Аймгийн ЗДТГазрын Нийгмийн бодлогын хөгжлийн хэлтэст хүргүүлсэн.
7. “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого”-д номын сангийн талаар тусгуулах саналыг Аймгийн ЗДТГ–ын нийгмийн бодлогын хэлтсээр дамжуулан албан тоотоор хүргүүлсэн болно.
8. Байгууллагын захиргаанаас холбогдох удирдах байгууллагуудад бүгд 91 хуудас тайлан мэдээ судалгаа материалуудыг боловсруулан компьютерт шивж явуулсан тоо гарч байна.
9. Монгол–Францын хамтарсан Коже говь ХХК –ын ерөнхий захирал Erice de Seze , дэд захирал Г.Луузан нар биечлэн ирж Иргэдийн хөгжил төвийн нээлтийн

ажиллагаа хийж, “Хандивийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, компьютер хүлээлцсэн баримт” - ыг баталгаажуулан хүлээлгэн өгсөн.

10. ЗТБХБЯамны дэд сайд А.Гансүх Иргэдийн хөгжил төвийн үйл ажиллагаатай танилцан 120ш ном хандивласаныг аймгийн төвийн болон сумдын номын сан ЕБС-ийн номын санд хуваарилан хүргүүлж уншлага үйлчилгээнд гаргасан болно.
11. Байгууллагын төрийн үйлчилгээний 8 албан хаагчийн үр дүнгийн гэрээг дүгнэж үнэлгээ өгч дүгнэх хуудсыг баталгаажуулсан.
12. Байгууллагын ажилчдын 2010 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, 01 - 12 сард хийх ажлын төлөвлөгөөгөө баталж, биелэлтэнд нь хяналт тавин ажилчдын хийсэн ажлыг сар бүр 12–16 үзүүлэлтээр хагас, бүтэн жилээр дүгнэж, сайн үнэлгээ авсан номын санч А.Гансүрэн, Б.Эрдэнэтуяа, Г.Баттогтох, үйлчлэгч Ганчимэг, жижүүр Ө.Өлзийбат, Б.Зориг нарт мөнгөн урамшуулал олгосон болно.
13. Аймгийн Засаг даргын 2007–2009 онд мөрийн хөтөлбөр, аймгийн үндсэн чиглэлд аймгийн Төв номын сангийн талаар тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт, номын сангийн 2007–2009 оны ажлын график үзүүлэлт, уншигч, ирц, ном олголт, фондын өсөлт, фондын эргэлт зэргийн график үзүүлэлт, фото зургаар гаргасан танилцуулга тайланг 8 хуудас материалыг компьютерт бэлтгэх Соёл урлагийн газарт явуулав
14. Соёл урлагийн хүрээлэнгээс ирүүлсэн “Монголын ном хэвлэлийн нэвтэрхий толь”-д оруулах материал судалгааг сүүлийн 3 жилээр 13 маягтаар гаргаж, танхим тасаг бүрээр нэгтгэн гаргаж, 14 сумын номын сан, ЕБС –ийн 20 номын санд 442 хуудас маягт материалыг хувилан тараасан болно.
15. Аймгийн Орон нутгийн өмчийн албанд “Орон нутгийн өмч эзэмшүүлэх гэрээ”-ний биелэлтийн 3 хуудас тайланг бичиж хүргүүлсэн.
16. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2001 оны 180 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор Номын сангийн нэгдсэн сүлжээг бий болгоход зориулан ЮНЕСКО-гоос эрхлэн гаргасан CDIS/ISIS программыг номын сангийн үйл ажиллагаанд 2010 оны 05 сарын 01–ний өдрөөс эхлэн нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг томилон бэлтгэл ажлыг хангаж, холбогдох танхим тасгуудад программуудыг суулгаж, 2000 гаруй ном электрон мэдээллийн санд оруулж эхлээд байна.
17. Улаанбаатар хотын ЭМШУИС–ын Анагаахын номын сантай хамтран ажиллаж, программ хэрэгжүүлсэн туршлага, гарын авлага аргачлал, арга зүйн зөвлөгөө, туслалцаа, нэмэлт syspar, 10 data программуудыг CD–гээр хуулан авчирч суулгасан болно.
18. Монгол Улсын Засгийн газрын 2009 оны “Сахилга, дэг журам, хариуцлагыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 03 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор энэ албан даалгаврын биелэлтийн байдлыг ажилчдын сар бүрийн ажил дүгнэх нэг үзүүлэлт болгон оруулж, энэ албан даалгаврын биелэлтийг сар бүр авч, номын санч, уншигч, үйлчлүүлэгчдийн хариуцлага, сахилга дэг журмыг өндөржүүлэн, иргэдэд үзүүлэх үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй, хүртээмжтэй хүргэх зорилтыг ажилчин бүр дэвшүүлэн ажиллаж багагүй үр дүнд хүрсэн.
19. Байгууллагын захиргаанаас ашиглагдаж байгаа 20 ширхэг компьютерын ашиглалт, хадгалалт хамгаалалт, бүрэн бүтэн байдал, лацны байдалд үзлэг хийж, бүх компьютерт хувийн хэрэг паспорт шинээр хөтөлж картжуулан

хариуцсан хүн бүрт нь хүлээлгэн өгч гарын үсэг зуруулж баталгаажуулан, захиралын гарын үсэгтэй лац наасан болно.

20. Байгууллагын 2009 оны архив бичиг хэргийг цэгцэлж, тушаал, тайлан төлөвлөгөө, ирсэн явсан бичиг, ном дахин үнэлгээний материал, барилгын хувийн хэрэг зэрэг 16 ширхэг хадгаламжийн нэгжийг үзэж хавтаслан, хаяг дотоод товъёог бичиж стандартын дагуу байнгын ба түр хадгалах архивын 150 ш хадгаламжийн нэгжийн бүртгэл жагсаалтыг шинээр хийж баталгаажуулан 150 ш хадгаламжийн нэгжид хаяг адресс, товъёог бичиж, архивыг бүрдүүлж хадгаллаа.
21. Байгууллагын ирсэн, явсан бичиг, цагийн бүртгэл, тушаалын бүртгэлүүдийг стандартын дагуу шинэчлэн хөтөлж байна
22. Байгууллагын ажилчдаас ирүүлж байгаа албан хэрэг бичгийг стандарт хангуулан Arial-12–р бичүүлж авдаг журмыг хэрэгжүүлж байна
23. Байгууллагын 11 ажилчны төрийн үйлчилгээний албан хаагчийн хувийн хэрэг, хөдөлмөрийн дэвтэр, НДаатгалын дэвтэрт үзлэг хийж, дутуу материалыг бүрдүүлж, хаяг, дотоод товъёогийг шинэчлэн бүрэн бүрдүүлэлт хийж, архивт хадгалж байна.
24. Байгууллагын 2006-2009 оны санхүүгийн баримтад татварын шалгалт, 2009 оны баримтанд аудитын шалгалт орж, гарсан зөрчил дутагдал гаргаагүй ажилласан
25. 2010оноос эхлэн байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого олдог ажилтнуудыг Баасан гариг бүрт тогтмол хугацаанд орлого төвлөрүүлж, сард 2 удаа тооцоо нийлж, акт үйлдэж гарын үсэг зуруулан санхүүгийн баримтад хавсарган ажилласнаар танхим, тасгуудын төлбөрт үйлчилгээнд 1550.1 мянган төгрөгний орлого оруулж, орлогын төлөвлөгөөг 103.3%-иар биелүүлсэн нь уншлага үйлчилгээний чанар хүртээмж сайжирч, үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэж байгаагийн илрэл мөн.
26. Байгууллагын захиргаанаас ажилчдын 2010 онд ажиллаагүй хугацаанд цалинг 100% олгосон болон урамшууллын тооцоог гаргахад бүгд 1396600 төгрөг зарцуулсан дүн гарч байна.

Үүнд:

№	**Ажилчдын нэрс**	**Олгосон цалин 100%-иар, урамшууллын дүн**
1.	Номын санч Д.Алтанчимэг	347700 төгрөг
2.	Номын санч Б.Батчимэг	247400 төгрөг
3.	Номын санч А.Гансүрэн	217700 төгрөг
4.	Мэдээллийн ажилтан Э.Цэндсүрэн	185300 төгрөг
5.	Номын санч Б.Эрдэнэтуяа	80000 төгрөг
6.	Үйлчлэгч Ш.Ганчимэг	80000 төгрөг
7.	Номын санч Г.Баттогтох	60000 төгрөг

8.	Жижүүр Ө.Өлзийбат	99000 төгрөг
9.	Жижүүр Б.Зориг	99000 төгрөг
10.	Номын санч Г.Цэндсүрэн	=
11.	Ня-бо Ц.Баярнэмэх	=
12.	Жижүүр Ч.Намнансүрэн	=
	БҮГД ДҮН	**1396600 төгрөг**

.

27. Үйлчлүүлэгч, уншигчдаас ирүүлсэн санал хүсэлт гомдлыг барагдуулах талаар авах арга хэмжээ, хийх ажлын төлөвлөгөө гаргаж, хариуцах эзэн бичиж ил тод хадсанаар номын санчид энгэрийн тэмдэгээ тогтмол зүүж, танхим тасгуудад чанга ярьж шуугиж уншигчдын тав тух алдагдуулдаг явдал үгүй болж, танин мэдэхүй, суут хүмүүсийн амьдрал сэдвүүдээр номын үзэсгэлэн гаргаж санал гомдлыг барагдуулан ажилласан.
28. Эх үрсийн баярыг тохиолдуулан байгууллагын ажилчдын тэргүүний 7 хүүхдийг урамшуулж, 35000 төгрөг зарцуулсан болно.
29. Байгууллагын нийт ажилчид, жижүүрүүдийн үүрэг хариуцлагаа өндөржүүлж, өмч хөрөнгийг гэмт халдлагад өртөх, галын аюул, ус алдах болон бусад гадны ямар нэгэн аюул гамшгаас урьдчилан сэргийлж, эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт, дэг журмыг сайжруулах талаар 9 заалт бүхий үүрэг даалгаврыг мэдэгдэх хуудсаар өгч биелэлтийг 01 сарын 15–ны дотор ажилчдаас авч ажилласнаар ажилчид өөрийн хариуцсан өрөө тасалгаа, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, галын аюул, ус алдахаас сэргийлэн ажил тараад явахдаа өрөөгөө цоожилж , лацдаж , өрөөний гэрлийг ажил тараад явахдаа унтрааж хэвшсэн ба байгууллагын захиргааны зөвшөөрөлгүй эд хогшил, техник хэрэгсэл гадагш гараагүй, жижүүрүүдийн хариуцлага дээшилсэн үр дүн гарч байна.
30. Аймгийн Засаг даргын 2010 оны 18 дугаар албан тоотоор ирүүлсэн Зудын байдалтай байгаа 5 сумын малчдад туслах уриалгыг хүлээн авч дэмжиж байгууллагын хамт олон 14 ажилчин 70000 төгрөгний хандив өгсөн болно.
31. Гэрээр ном олгогч Д.Алтанчимэг Улаанбаатар хотын ЭМШУИС –ын Анагаахын номын сангийн ажилтай танилцаж, CDIS/ISIS программыг хэрэгжүүлсэн туршлага судалж, дадлага хийж арга зүйн зөвлөгөө авсан болно.
32. Эрдэнэ, Сайхандулаан сумын номын сангийн ажилтай газар дээр очиж танилцан арга зүйн зөвлөгөө өгсөн.
33. “Номын сангийн өнөөгийн байдал, цаашдын зорилт” илтгэл бэлтгэж, аймгийн төвийн болон сумдын 20 номын санчдын уулзалт сургалтанд тавьж танилцуулан санал хүсэлтийг нь авч, 13 сумын соёлын төвийн захиралд “Сумын сангуудын цаашдын зорилт”-ыг албан тоотоор хүргүүлсэн”.
34. Хатанбулаг суманд болсон аймгийн номын санчдын уулзалт-сургалтанд 5 номын санч оролцож, зардалд нь шатахууны үнэ 139.0 мян. төгрөг зарцуулж, 12 сумын номын санч нарт арга зүйн зөвлөгөө өгч, туршлага солилцсон .
35. Номын санчдын уулзалт- сургалтыг сайн зохион байгуулсан Хатанбулаг сумын соёлын төвийн эрхлэгч Ц.Цэцэгийг Хүндэт өргөмжлөлөөр шагнаж урамшуулсан

36. Сумдын номын санчдын судалгааг шинэчлэн хийж, боловсон хүчин, номын фондын нэр төрөл, тоног төхөөрөмж, санхүүжилтын талаар мэдээлэл цуглуулсан.
37. Улаанбаатар хотоос МҮНС–гаас хуваарилсан Шилдэг ном -2009 хандиваар ирсэн 885.3 мян. төгрөгний 169 ш ном, /Нээлттэй нийгмийн хүрээлэнгээс 52 ш/ татан авчирч 13 сумын номын санд хуваарилан хүргүүлсэн .
38. ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсийн нэрэмжит сарын аяны хүрээнд Аймгийн Төв номын сангийн нээлттэй хаалганы өдрийг 10 сарын 11-ны өдөр спорт зааланд зохион байгуулж, байгууллагаа иргэд үйлчлүүлэгчдэд сурталчилж 100гаруй хүнийг хамарсан.
39. “Шинэ ном–танин мэдэхүйн гайхамшиг “шинэ номын үзэсгэлэнг гаргаж, 135 хүнд сурталчилсан. Үзэсгэлэнд Нийгэм эдийн засгийн ухаан, танин мэдэхүй, хэлний номууд, Монголын уран зохиол, хүүхдийн уран зохиол гэсэн төрөлжсөн 300 ширхэг ном зохиол тавигдсан болно..
40. Нийгмийн салбарын харъяа байгууллагуудын ажилтнуудын дунд зохион байгуулсан Гар бөмбөгийн тэмцээнд байгууллагын гар бөмбөгийн баг гарган бэлтгэж оролцуулсан.
41. “Авъяас–2010 “ нийгмийн салбарын ажилтнуудын урлагийн нэгдсэн тоглолтонд ажилтнаа амжилттай оролцуулсан.
42. Хүүхдийн танхим, Хатанбулаг, Иххэт, Эрдэнэ сумдын номын санд уншлагын ширээ, сандал, тавилга Улаанбаатар хот БСШУЯ –наас нэгдсэн журмаар татан авах ажлыг зохион байгуулж, ачаа тээшний зардлыг гарган, хөдөө орон нутгийн 3 сумын номын санд 24 уншлагын ширээ 48 сандалтай болгосон.
43. Иргэдийн хөгжил төвийн гадаа хаяг, дэлгэц, санхүүгийн төмөр сейф авах хөрөнгө мөнгөний асуудлыг шийдэж, шинээр гадаа хаяг, дэлгэц, сейфыг худалдан авч Улаанбаатар хотоос татан авчирсан.
44. Аймгийн Төв номын санд 2010 онд шинэ ном худалдан авах төсөв байхгүй байсныг БСШУЯ –наас шийвэрлэсэн 2500.000 төгрөгний төсвөөр 323 ширхэг шинэ ном хэвлэл худалдан авч уншлага үйлчилгээнд гаргасан.
45. Улаанбаатар хотод GOETHE INSTITYT дээр болсон “Монголын олон нийтийн болон сүм хийдийн номын сан, музейн сан хөмрөгийн хуучин ном судрыг сэргээн засварлах, хадгалах хамгаалах” сэдэвт төслийн хүрээнд зохион байгуулсан сургалтанд 2 номын санч хамруулсан.
46. Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 239 дүгээр тогтоолыг үндэслэн байгууллагын 11 ажилтанд сарын цалингийн 30 хувийн нэмэгдлийг 10 сарын 01-нээс эхлэн олгож, сарын цалингийн нэмэгдэлд 918000 төгрөг зарцуулж байна.
47. Ахмадын баярыг тохиолдуулан Байгууллагын 9 өндөр настан, ахмад ажилтнуудад 120000 төгрөгний буцалтгүй тусламж олгосон..
48. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2001 оны 180 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор Номын сангийн нэгдсэн сүлжээг бий болгоход зориулан ЮНЕСКО-гоос эрхлэн гаргасан CDIS/ISIS программыг номын сангийн үйл ажиллагаанд 2010 оны 05 сарын 01 –ний өдрөөс эхлэн нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг томилон бэлтгэл ажлыг хангаж, үндсэн фонд, гэрээр ном олгох тасгуудад программуудыг суулгаж, шинэ программыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө хийж баталгаажуулан DDC ангилалтай шинэ номуудад электрон католог бичих ажлыг эхлээд байна.

Хоёр. 2010 оны жилийн Тоон үзүүлэлтүүд

Номын санчийн нэр	Уншигч	Ирэгсэд	Ном олголт	Орлого	Сэргэн	Каталог, картын сан	Өгсөн Лавлагаа	Фондын баяжилт	Шинэ санаач-лага
Гансүрэн	450	4327	8005	250.0	150		33	142	3
Эрдэнэтуяа		2560	41	417.8	.62	263	57	9	3
Баттогтох	218	9489	4861	160.0	20	15	30	=	1
Алтанчимэг	386	1916	3327	212.0	150	1128	116	199	1
Г.Цэндсүрэн	=	=	852		500	412	56	263	1
Э.Цэндсүрэн	=	2300	=	384.2	8	=	20	=	
Батчимэг	97	1770	1456		=	=	3	=	2
Бүгд	1480	26388	22996	1603.0	1527	1968	392	613	15

Гурав.Уншлага үйлчилгээ, номын фонд, сурталчилгааны талаар

1. Уншлага үйлчилгээг хэвийн явуулж, 1480 уншигч шинээр карт нээлгэн 26388 ирцэд 22996 ном хэвлэл, лавлагаа–мэдээлэл, интернет цахим мэдээллээр үйлчилсэн байна.
2. Уншлагын танхимын үйлчилгээний хүрээг өргөтгөх, шинэлэг хэлбэрийг нэвтрүүлэх, дэг журмыг сайжруулах, уншигчдын бүртгэлийг шинэчлэх, төлбөрт үйлчилгээний орлогод тавих хяналтыг сайжруулах, уншигчдыг бүрэн үнэмлэхжүүлэх зорилгоор уншигчийн үнэмлэх шинээр хийж 1000 хувь хэвлүүлж, 04 сарын 01-нээс 06 сарын 01–ныг хүртэл “Номын сангийн уншигч болцгооё” аяныг зарлаж эхлээд байна. Энэ ажлыг санаачлан хийхэд номын санч Г.Баттогтох идэвхитэй оролцсоныг дурьдъя.
3. Уншигч олонд өөрийн нутгийн их соён гэгээрүүлэгч Д.Равжаа хутагтыг сурталчилж, таньж мэдүүлэхийн тулд түүний намтар уран бүтээлийг бяцхан номоор хийж, “Халхын ноён хутагт Лувсанданзанравжаа” нэртэй хутагтын буланг бий болгож , “Санал хүсэлт”-ийн хайрцагийг хийж байрлуулсан.
4. Иргэдийн хөгжил төвийн лавлагаа- мэдээллийн ажилд Улаанбаатар хотын Төв номын сангийн лавлагааны мэдээллийн тасагтай хамтран ажиллаж БНСУ-ын номын сангийн лавлагаа-мэдээллийн ажлыг туршлагыг судалж тэдний лавлагаа өгдөг туршлага, мөн цахим номын сангийн үйлчилгээг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангаад байна.
5. Хүүхдийн танин мэдэх, сонирхол, сэтгэн бодох чадварыг хөгжүүлж, хүмүүнлэг ёсны талаар, анхдагч, зөв ойлголттой, дүрслэн зурах, урлан бүтээх, дуулах, хөгжимдөх, бүжиглэх талаархи анхны төсөөлөл, чадвартай болоход нь дэмжлэг үзүүлэхэд зориулж хүүхдийн 549 нэр төрлийн зохиол бүтээлүүдээр ном зүйн жагсаалт, ЕБС –ийн сурагчдын уншдаг 166 нэр төрлийн эх зохиолоор санамж

өгөх ном зүйн бүртгэл зэргийг хийсэн. Энэ ажлыг ном зүйч Б.Эрдэнэтуяа санаачлан хийсэн байна.

6. Хүүхэд багачуудын сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор Хүүхдийн уншлагын танхимд тоглоомын булан шинээр нээн ажилуулж байна /Шагай, Даам, Эвлүүлдэг тоглоом, Шоотой тоглоом зэрэг/
7. Танхим тасгуудыг үйл ажиллагааг үйлчлүүлэгчдэд нээлттэй ил тод болгох зорилгоор мэдээллийн 4 самбар, 2010 оны хамгийн олон уншигдсан номын сурталчилгааны самбар, Тэргүүний уншигчдийн самбар, төрийн сүлд, төрийн дуулал, далбаа, номын үзэсгэлэнгийн хаяг 20ш, үсэг хаяг 70 ш, бусад хаяг самбарууд шинээр хийж ил хадсан
8. Цахим номын сан байгуулж, цахим номын сангийн фондонд байгаа 61 ширхэг DVD, CD, Аудио CD, Видео CD–үүдийг бүртгэж, шинээр бүртгэл нээн хөтөлж байна.
9. Төрийн мэдээлэл сэтгүүлд шинээр хэвлэгдсэн 13 хуульд картын сан бичиж, хүчингүй болсон 20 хуулийн жагсаалт хийж, 17 нэр төрлийн хуулийн он дараалал, үсэг дарааллын бүртгэл гаргасан.
10. Мэдээллийн самбарт Үндэсний уламжлалт баяр "Цагаан сарын бэлэгдэл, ёс заншил", "Бүсгүйчүүдэд зориулсан зөвлөмж", 2009 оны шилдэг 10 номын тухай 7 хуудас материалыг интернет, сэтгүүлээс авч уншигчдын хүртээл болгон сурталчилсан
11. Номын фондыг 4112.8 мян төгрөгний 613 ш шинэ номоор баяжуулж, бүгд 50061.7 мян. Төгрөгний 57350 ш номтой болов.
12. Иххэт суманд 02 сарын 26-28–ны өдрүүдэд болсон "Төгөлдөр соёл -2010" сэдэвт соёлын ажилтнуудын бүсийн сургалтанд 2 номын санч томилолтоор оролцуулж, 5 сумын номын санчдын дунд "Номын сангийн анхан шатны бүртгэл хөтлөлт" сургалт тэмцээн явуулж, 2 номын санч, 2 тэргүүний уншигч, 1 соёлын төвийн эрхлэгчийг байгууллагын захиргааны шагнал ном, цахим номын сан CD-р урамшуулсан болно.
13. Улаанбаатар хотод Гёте институтээс зохион байгуулсан "Номын чимэглэл, үзэсгэлэн сурталчилгаа" сэдэвт сургалтанд ном зүйч Б.Эрдэнэтуяа оролцсон.
14. Түгээмэл хэрэглэгддэг хуулиудыг интернэтээс татаж иргэдэд флаш болон цаасан хэлбэрээр гаргаж өгөх, хууль зүйн холбогдолтой сайтуудын болон иргэдэд өргөн хэрэглэгддэг сайтуудын жагсаалт хийж, өдөр бүр компьютеруудад вирусын эсрэг программын шинэчлэлийг татаж, тогтмол вирусыг нь уншуулж байна.
15. Уншигч олонд өөрийн нутгийн их соён гэгээрүүлэгч Д.Равжаа хутагтыг сурталчилж, таньж мэдүүлэхийн тулд түүний намтар уран бүтээлийг сурталчилан "Равжааг хэн сайн мэдэх вэ" сэдэвт АХА асуулт хариултын тэмцээнийг уншлагын танхимын номын санч Г.Баттогтох МСҮТөвийн оюутны зөвлөлтэй хамтран зохион байгуулж 35 оюутан оролцсоноос Д.Уранзаяа 1-р байр эзэлж , өргөмжлөл үнэ бүхий зүйл, 2-р байрыг Ширчин 3-р байрыг Сумъяасүрэн нар эзэлж үнэ бүхий зүйлээр шагнаж урамшууллаа.
16. Иргэдийн хөгжил төвийн номын санч Б.Эрдэнэтуяа Аймгийн Эрүүл мэндийн газар, Аймгийн Ахмадын хороотой хамтран Сайншанд сумын өндөр настан, ахмадуудын дунд " Эрүүл мэнд" сэдвээр сургалт явуулж, 30 гаруй ахмад оролцон тэдэнд гарын авлага сурталчилгааны материал тараан өгч, ярилцлага хийх, дуу дуулах, дасгал хийх хөгжөөнтэй хэлбэрээр зохион байгуулж, Хүүхдийн номын

санч Гансүрэн, заалны номын санч Баттогтох нар хамтран "Үлгэр сонсоё" цахим номын сан, аудио чанга уншлага явуулж 100 хүн хамарсан байна.

17. Интернет хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор Ном зүйч Эрдэнэтуяа Компьютерийн анхан шатны сургалтыг явуулж, 2-р цэцэрлэгийн ажилчдыг хамарсан байна.

18. Хүүхдийн танхимын номын санч А.Гансүрэн Аймгийн ЗДТГ–ын нийгмийн хөгжлийн бодлогын хэлтэстэй хамтран Америкийн хүүхдийн зохиолч Маргриат Руус, Хүүхдийн зохиолч Ж.Дашдондог нэртай уулзалт зохион байгуулж, асуулт хариулт, хүүхдийн урлагийн тоглолт, номын үзэсгэлэн гаргасан.

19. Хүүхдийн танхимаас алслагдсан номын санд ирж чаддагүй 11 жилийн 3 –р сургуулийн 2–4–р ангийн бүх бүлгүүдийн дунд нэг сарын хугацаатай нүүдлийн номын сан ажиллуулж , номын сангийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх талаар анхааран ажиллаж байна.

20. Гэрээр ном олгогч Д.Алтанчимэг Сайншанд сумын 4-р цэцэрлэгийн дунд бүлэгтэй хамтран 4 сарын 08-30-ны өдрүүдэд "Богцтой аялал" номын уншлага зохион байгуулан 25 хүүхдэд 20 номоор үйлчилсэн байна.

21. Интернет танхим, Гэрээр ном олгох тасаг, Хэвлэлийн фонд, уншлагын танхим байнга үйлчүүлдэг иргэдэд урамшуулал бий болгох журмыг нэвтрүүлж, 1 цаг үнэгүй үйлчлүүлэх интернетийн үйлчилгээ, 1 өдөр үнэгүй үйлчүүлэх үйлчилгээ , 2008- 2010 оны хуучин сонин хэвлэлийн 30ш дугаар авчирсан тохиолдолд 1 цаг интернэтэд үнэгүй суух, 2008-2010 оны 5ш дугаар авчирсан тохиолдолд мөн 1 цаг үнэгүй үйлчлүүлэх урамшуулал зэргийг нэвтрүүлснээр АУК –ын оюутан О.Пүрэвжав "Интернетийн 500 дахь хэрэглэгч- Азтан" болж , МСҮТ-ын оюутан Д.Уранзаяа, 11 жилийн 1-р сургуулийн 11г ангийн Н.Ганбаяр, 11 жилийн 2-р сургуулийн 11в ангийн Ч.Уртнасан нар урамшуулалт үйлчилгээнд хамрагдан АУК–ын оюутан Ж.Уянга "Интернетийн 1000 дахь хэрэглэгч- Азтан" болж, МСҮТ-ын оюутан Д.Уранзаяа, Г.Ган-Эрдэнэ нарыг Д.Нацагдорж тэмдэгтэн тэргүүний уншигчаар шалгаруулллаа .

22. Төрийн мэдээлэл сэтгүүлд шинээр хэвлэгдсэн 6 хуульд картын сан, Зууны мэдээ сониноос 9 картын сан бичиж, 61 картын санг катологт байрлуулж, "Эсээ хэрхэн бичих вэ?", "Математик, хими, Q –ийн талаар юу унших вэ?" сэдэвт санамж өгөх ном зүйн бүртгэл хийж, уншлагын танхим, гэрээр ном олгох тасагт ашиглаж байна.

23. ЕБС–ийн сурагчдын уншдаг Д.Гармаа "Халуун амьсгал", "Сургамжит өгүүллэгүүд", С.Эрдэнэ "Баян бүрд", Д.Пүрэвдорж "Хөх даалимбан тэрлэг", С.Буяннэмэх "Бүтэлгүй Гомбын маргааш" зэрэг 258 нүүр хуудас 10 эх зохиол номын санчид өөрсдөө компьютерт шивж 30 ширхэг бяцхан ном хийж уншлага үйлчилгээнд гарган уншигчдын хүртээл болгосон .

24. Мэдээллийн самбарт "Таны танин мэдэхүйн санд", "Бүсгүйчүүдэд зориулсан зөвлөмж", 2009 оны шилдэг 10 номын тухай 7 хуудас материалыг интернет, сэтгүүлээс авч уншигчдын хүртээл болгон сурталчилсан

25. "Хэн олон номтой вэ" уралдаан зарлан хувийн номын сангийн үзэсгэлэн гаргасан.

26. Танин мэдэхүй, Суут хүмүүсийн амьдралаас, Их,дээд сургуулиудад элсэгчдэд зэрэг сэдвүүдээр номын сэдэвчилсэн үзэсгэлэн гаргаж сурталчилсан байна.

27. "English club" байгуулан 7 хоног бүр хичээлж байна. Номын сангаас 3 ажилчин суралцаж байна.

28. Гэрээр ном олгох тасаг, Үндсэн фонд, Хүүхдийн фондын нөхөн бүрдүүлэх шаардлагатай номын нэрсийг шинэчлэн гаргасан.
29. ЕБС –ийн сурагчдын уншдаг "Малын хөлийн тоос", "Өвгөн шувуу", "Цахилж яваа гөрөөс", "Хангайн бор", "Шаргачин", "Хайрын өгүүллэгүүд" эх зохиолуудаар номын санчид өөрсдөө компьютерт шивж 11 ширхэг бяцхан ном хийж уншлага үйлчилгээнд гарган уншигчдын хүртээл бологосон .
30. Түгээмэл хэрэглэгддэг хуулиудыг интернэтээс татаж иргэдэд флаш болон цаасан хэлбэрээр гаргаж өгөх, хууль зүйн холбогдолтой сайтуудын болон иргэдэд өргөн хэрэглэгддэг сайтуудын жагсаалт хийж, компьютеруудад вирусын эсрэг программ, Yahoo messenger программуудыг шинэчлэн татаж, тогтмол вирусыг нь уншуулж байна.

Дөрөв. Шинээр санаачлан хийсэн бүтээлч ажил, тохижилт соёлжилтын талаар

1. Уншлагын танхимд Монголын Төрийн шагналт, Соёлын гавъяат зүтгэлтэн 30 зохиолчдын зургийг байрлуулж, "Ном унших нь тэнгэрт нисэж, далайд хөвөн, тэнгэрт нисэх мэтээ" гэсэн сургаал үгийг хайчилж, Номын сангийн танилцуулга хийж хананд байрлуулсан
2. Байгууллагын гадна саравчны хуурсан хэсгийг буцаан хадаж, гадна талын хаалгыг будаж өнгө үзэмжийг сайжруулсан болно.
3. Аймгийн ЗДТГ, Сайншанд сумаас зохион байгуулсан мод тарих, нийтийн цэвэрлэгээнд хамт олноороо оролцсон
4. Иргэдийн хөгжил төвийн талархалын хайрцаг шинээр хийж, лавлагааны архивын хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор сервантыг цоожтой болгосон.
5. Ном хэвлэлийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах, гэрэл, чийгшүүлэлт, стандартыг хангах зорилгоор 1:527 ширхэг ном хэвлэлийг сэргээн засварлаж, фондуудад түмпэнд ус хийж тавьж байна
6. Гадаа цагийн хуваарь, зарлалын самбар хийж хадсан
7. Цэвэр усны тоолуурыг шинэчлэн шинээр тавиулж баталгаажуулалт хийлгэсэн
8. Гэрээр ном олгох тасаг, Нягтлан бодогч хаягуудыг шинээр хийж, гэрээр ном олгох тасгийн өрөөний гэрлийг шинэчлэн сүүн гэрэл шинээр хийсэн.
9. Иргэн танд мэдээллийн самбар шинээр хийж , Иргэдийн хөгжил төв, уншлагын заал ханын цаг шинээр авсан
10. Номын фондын хадгалалт хамгаалалт, чийгшүүлэлтийг сайжруулан, ажилчид 88 ш варены шил цуглуулан фондуудад ус хийж тавьсан байна
11. Иргэдийн хөгжил төвийн гадаа хаягийг шинээр хийж хадаж, гэрэлтүүлгийг бэхэлсэн.
12. Дулааны худаг дотор цэвэр усны шугам хагарч ус дүүрснийг зөөж шавхсан, хүүхдийн номын фондын өрөөнөөс хий авч дулааныг хэвийн болгосон
13. Өрөөнүүдийн ажиллахгүй болсон унтраалгуудыг сольж, пускатель тавьсан, ОО–ын өрөөнүүдийн татуурга, хөвөгч эвдэрснийг 3 удаа, хаалганы цоож, нугасыг 3 удаа засч янзалсан.
14. Хоёр давхарын хана, шатыг будаж, шохойдож, хөлний тавиур шинээр хийж, хөлний алчуур 3 шинээр авч дэвссэн.

15. Гадаа үүдэнд 4 ширхэг цэцэгийн мандал тарьж, шалгаруулахад ном зүйч Эрдэнэтуяагийн цэцгийн мандал хамгийн сайхан ургасан цэцгийн мандалаар шалгарсан.

Ц.ДАМДИНСҮРЭНГИЙН НЭРЭМЖИТ ДОРНОД АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2010 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нэг. Соёлыг хөгжүүлэх бодлого стратегийг хэрэгжүүлэх

Зорилт: Номын сангийн уншлага үйлчилгээг цахимаар хүргэх

1. Хэрэгжилт: Уншигчдад цахимаар үйлчилгээ үзүүлэн монгол, орос номыг электрон хэлбэрээр хайж үзэх боломжтой болсон.

Lib4U програмын сервер компьютерийн ажиллагааг тогтмол хянаж байгаа. Программ ашиглагдаж эхлээд багагүй хугацаа өнгөрч хугацаа дуусаж байгаа тул программд хийгдэх үйлчилгээ ихэссэж байна. /сүлжээ тасрах, гацах хүндрэл байнга гарч байгаа тул сервер компьютертийг шинэчлэхэд 1,600,000төгрөг шаардагдаж байна./

Номын сангийн хуучин хувилбараас шинэ гарсан программыг номын санд нэвтрүүлэх шаардлагатай, нэн түрүүнд хэрэгтэй байна.

Номын сангийн барилгын өргөтгөлийн асуудлыг Дорнод аймгаас УИХ-д сонгогдсон гишүүдэд албан захидал өгсний дагуу УИХ-ын гишүүн Ц Шинэбаяр барилгын өргөтгөлийн зураг төсөвт 10 сая төгрөг их хурлын гишүүдийн багцаас өгч зураг төсвийг хийлгэсэн, номын фондын баяжилтанд Д.Одбаяр ном хүргүүлсэн. П.Алтангэрэл гишүүн цаашид хамтарч ажиллахаа илэрхийлсэн. Аймгийн засаг дарга, ИТХ-ын дарга, Төрийн сангийн хэлтэсийн дарга, БСГ-ийн дарга нарт барилгын өргөтгөл болон гадна талбайн тохижилтын хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгуулах талаар саналаа албан бичиг хүргүүлсэн.

Үр дүн: Монгол номыг электрон каталогоос хайх, тооллого хийх боломжтой болсон. Орос номыг программд оруулсан.

Нөөц: Номын санчид программд дадлагажсан. Шинэ гарсан хувилбарыг нэвтрүүлэх, сумдын номын сангуудад номын сангийн программыг нэвтрүүлэх

Хоёр. Соёлын ажилтны мэргэжил дээшлүүлэх , мэргэшүүлэх арга зүйг сайжруулах:

Зорилт: Орон нутгийн номын сангуудыг мэргэжил арга зүйгээр ханган ажиллах, үйл ажиллагааг тогтмолжуулахад туслах.

Хэрэгжилт: Орон нутгийн номын санчдын мэргэжил дээшүүлэх сургалтыг Боловсрол соёлын газартай хамтран 2010 оны 02 сарын 18-наас 20-ны өдрүүдэд зохион байгуулж нийтийн болон ЕБС-ийн 37 номын санчид хамрагдлаа.

Номын санчдын сургалтаар номын сангийн үйл ажиллагаанд баримтлах хууль эрх зүйн актууд, ном тодорхойлох, номын сангийн автоматжуулалт, интернэт зохион байгуулалт, тайлан төлөвлөгөө боловсруулах, архив, албан хэрэг хөтлөлт, стандарт, компьютер өргөн хэрэглээний программууд,номын сангийн анхан шатны бүртгэлүүд, номын сан ном зүйн ангиллын шинэчилсэн хувилбарууд, номын сангийн үйлчилгээний соёл, каталог зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хэрэгжүүлэх, зэрэг мэргэжлийн хичээл заагдсан.

Энэхүү сургалтаар номын санчдын тулгамдаад байгаа сэдвийг сонгон хийсэн нь талархалтайгаар хүлээн авч цаашид сургалтын арга барилыг шинэчлэн өөрчлөх талаар санал гаргалаа.

Сургалтын төгсгөлд орон нутгийн номын санг цаашид хөгжүүлэхэд яаж ажиллах тулгамдаж буй асуудлын талаар чөлөөт ярилцлага хийж, оролцсон номын санчдад сертификат гардууллаа. Үндэсний номын сангийн арга зүйч Г. Гүнжинлхам аймгийн төв номын сангийн үйл ажиллагаатай танилцаж хийж буй ажилд дүгнэлт өгч номын сан номзүйн ажлыг тогмолжуулах талаар арга зүйн зөвлөгөө өгсөн.

БСШУЯам, Монголын соёл урлагын хороо, Үндэсний номын сан, Хүүхдийн номын ордон хамтран зохион явуулсан номын “Яармаг-2010” үйл ажиллагаанд номын санч Д.Энхчимэг, Боловсролын зөвлөгөө мэдээллийн төвийн сургалтанд М. Ариунаа хамрагдаж, Номын сангийн эчнээ ангид номын санч Э Батцэцэг суралцаж байна. Удирдлагын академын нийгмийн удирдлагын чиглэлээр арга зүйч Н. Хандсүрэн суралцаж төгссөн. Бүх ажилчдад дунд “Бизнесээ хөгжүүлье амьдралаа сайжруулья” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.

Захирал Ж.Цагаан, арга зүйч Н.Хандсүрэн Хэрлэн сумын ЕБС-ын номын сангуудын үйл ажиллагаатай танилцаж ЕБС-ийн номын сангийн үлгэрчилсэн дүрмын хэрэгжилт, данс бүртгэлийг эхлүүлэх, ном ангилах, каталог зохион байгуулалтыг шинэчлэх талаар мэргэжлийн арга зүйн туслалцаа үзүүлсэн.

Үр дүн: Номын санчдын үйл ажиллагаа тотмолжуулах,

Нөөц: Номын санчдын мэргэжлийн түвшинд ахиц гарч ажилдаа дадлагажсан

Гурав. Соёлын үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулах талаар

Зорилт: Орон нутгийн ард иргэдэд ном хэвлэл, мэдээллээр үйлчлэх, уншигчдын тоог нэмэгдүүлэх, лавлагаа ном зүй, мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах.

Хэрэгжилт: Уншлага үйлчилгээнд ард иргэдийг өргөнөөр хамруулахын тулд уншлагын танхим, явуулын үйлчилгээ, анги хамт олноор уншигч болгох хөдөлгөөн

өрнүүлэх, номын сан хоорондын ном солилцоог өргөжүүлэх, зөөвөр, гэрээр хүргэх, лавлагаа ном зүй, мэдээлэл сурталчилгааны ажлуудыг удирдамж хөтөлбөрийн дагуу зохион явуулсан. Үүнд:

Уншлага үйлчилгээ:Тайлангийн хугацаанд 11 сарын байдлаар 2726 байнгын уншигч, / насанд хүрэгсэд 1300, гадаад уншигч 7, хүүхэд 1370/, 49300 ирцэд 97554 ном олгож номын сангийн үйл ажиллагааг сурталчлах, алслагдсан иргэдэд ном хэвлэл хүргэх явуулын үйлчилгээг 8 байгууллага, Хэрлэн сумын 1,2,3.4–р баг, Сэргэлэн суманд нийт 2786 хүнд 1890 номоор үйлчилгээ явуулж 21 хүнээс судалгаа авсан.

Бямба гаригийг хүүхдийн өдөр болгосонтой холбогдуулан Хэрлэн сумын цэцэрлэгүүдийн бэлтгэл бүлгүүдийн эцэг, эх, хүүхдүүдийн дунд “Номын сайн нөхөр болцгооё” уриан дор 1,12,8,6,10,14 дугээр цэцэрлэгүүдтэй хамтран зохион байгууллаа.

Бага ангийн сурагчдыг ном уншихад нөлөөлүүлэх зорилгоор “Ном бидний нөхөр” уншлага Хан-Уул цогцолбор сургуулийн 3[г], 4[а] ангийн эцэг эхийн зөвлөлтэй хамтран хичээлээс гадуур унших номоор “Элсэн цаг” тэмцээн зохион байгуулж, анги хамт олноор уншигч болгох 9 ангийг хамруулллаа.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настангуудад үнэ төлбөргүй карт нээж үйлчилгээ үзүүлж байна.

Ном солилцоо, зөөвөр: Ном солилцоог өргөжүүлэн 13 сумдын болон номын сангуудад 302 ном хүргэж, зөөврөөр 14 цэцэрлэгт 79 ном уншуулсан. Нийт зөөврөөр 381, Гэрээр 864 ном олгосон.

Боловсролын зөвлөгөө мэдээлэл: Англи хэлний тэтгэлэгт хөтөлбөрийн Access-2 элсэлтийн 10 хүүхэд амжилттай суралцаж төгссөн.

2010-2012 оны шинэ элсэлтийг зарлан сонгон шалгаруулан, хүүхдүүдийн тоог нэмэгдүүлэн 20 хүүхэд элсүүлэн авч 2011 оноос хичээллүүлэхээр болсон.

Боловсролын зөвлөгөө мэдээллийн төвийн үйл ажиллагааг сурталчилах олонд таниулах гадаадад тэтгэлгээр сурах сонирхолтой оюутан залууст ганцаарчилсан зөвлөгөө 89 хүнд, англи хэлний сургалтын ном гарын авлага, сургуулиудын танилцуулгыг 149 гадаад номыг чөлөөт сонголтонд гарган сурталчилсан. Шинээр зарлагдаж байгаа тэтгэлэгт, хөтөлбөрийн талаархи, танилцуулга материалыг тарааж, мэйл хаягаар явуулж сурталчиллаа.

Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн тэтгэлэгт хөтөлбөрүүд, гадаадад боловсрол эзэмших, сурах TOEFL-ийн шалгалтанд бэлтгэх, сургалтын тэтгэлэгт хөтөлбөр, гадаад улсуудад суралцах хөтөлбөрийн талаар орон нутгийн оюутан залуучууд, багш, сурагчид, иргэдэд лекц хийж, Дорнод аймгийн төвийн сургуульд багшилж байгаа Энхтайвны корпусын сайн дурын багш нартай хамтарч ажиллан англи хэлний ярианы клубыг тогтмол баасан гариг бүр хичээллүүлснээр хэлний ярих чадвар дээшилж хүүхдүүд өргөн хамрагдах болсон. Ярианы клубыг 45 удаа хичээллүүлсэн.

Нээлттэй хаалганы өдрөөр орон нутгийн иргэд оюутан залуучуудад зарлагдаж байгаа тэтгэлэгт хөтөлбөрийн талаар сурталчилж, төвийнхөө үйл ажиллагааг

танилцуулан ажилласнаар иргэд энэ төвийн талаар мэдлэгтэй болж ирц үйлчлүүлэх уншигчдын тоо нэмэгдэж 259 хүнд үйлчилсэн.

Лавлагаа ном зүй: Уншигчдын асуусан мэдээллийг амаар болон бичгээр электрон каталогоос ном хайх лавлагааг 678 хүнд өгч, хуулийн болон гарын авлагаас 280, номын санчдад гарын авлага, хэрэгцээт мэдээллийг 13, Дорнод аймгийн хэвлэлийн хуудаснаас үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн сэдвээр картын сан хийсэн.

Мэдээлэл сурталчилгаа: Хүүхэд багачуудын уран унших авьяасыг нээн илрүүлэх, хөхүүлэн дэмжих, тэдэнд утга зохиолыг сурталчилах, үгийн урлагийн гайхамшигийг мэдрүүлэх зорилгоор “Хүрэл тулга-2010”, Уран уншлагын “Уран жиргээ-2009” наадмыг насны онцлогоор зохион байгуулсан.

Дорнод нутагтаа билэг авъяасаа зориулан, үзгийн хурцаар цаг хугацааг урлаж явсан сэтгүүлч, яруу найрагч Ишийн Батсүх агсны “Сэтгэлд уянгалах яруухан хөгжим шиг” номын хуримыг гэр бүл үр хүүхдүүдийн хамт зохион байгууллаа. Үйл ажиллагаанд УИХ-ын гишүүн П.Алтангэрэл, ИТХ-ын дарга Н. Хүрэлбаатар, Засаг дарга Ц.Жанлав болон И.Батсүх агсантай хамт ажиллаж байсан хүмүүс, албан байгууллага, аж ахуй нэгжүүдийн болон иргэдийн төлөөлөл оролцож дурсамж дуртгал зориулсан шүлгээ уншиж, энэхүү номыг хэвлүүлэхэд Аймгийн Засаг дарга Ц.Жанлав санхүүгийн дэмжлэг үзүүлсэнд талархан Соёл урлаг утга зохиолыг дэмжих “Соёлын ертөнц“ төвийн шагналаар шагнасан.

Батсүх агсны гэр бүл хүүхдүүд энэ номын үргэлжлэлийг гаргаж утга төгс яруу шүлгийнхээ охь дээдийг өргөн барихаар болсон.

Аймгийн утга зохиолын нэгдлийн гишүүн, Яруу найрагч Жамбалгаравын “Сүүдрийн од “номын цэнгүүн, зохион байгууллаа.



Монгол улсын Ерөхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлагийн дагуу Үндэсний бичиг үсгийн баярыг зохион байгууллаа. ”Босоо монгол бичиг минү” уран бичлэгийн уралдаанд ирүүлсэн материалаар үзэсгэлэн, номын үзэсгэлэн худалдаа-2010, Хөгжим дууны болон монгол бичгийн номын үзэсгэлэн, аймгийн музейгээс эртний хөгжмийн болон бичгийн хэрэгслээр үзэсгэлэн гаргаж ХДТ-ын симфони-оркестр заавал сонсох хөгжмийг хэсэгчилэн тоглож, данраг данжаалан хийдийн лам нараар судар номыг уншуулан, ном баринтаглах үйл ажиллагаа болсон нь уншигчид сэтгэл өндөр сайхан ажил болсон.

Жил бүр уламжлал болгон тэмдэглэдэг “Номын яармаг-2010” аяныг 1 сарын хугацаанд уралдаан тэмцээн зохион байгуулан 11 сарын 13 нд шалгарсан бүтээл болон илгтэлийг шалгаруулан шагнаж урамшууллаа. Үүнд: Д. Батбаярын “Цахилж яваа гөрөөс” хайчилбарын уралдаанд 1-р байранд 8-р сургуулийн 9б ангийн сурагч Ч. Ганбаяр , 2-р байранд 8-р сургуулийн Анужин, тусгай байранд 1-р сургуулийн

Мөнхдэлгэр, Э.Тэлмүүн, Д.Нямаагийн “Талын шувуудын өндгөнд сүүдрээ бүү хүргээрэй” гар зургийн уралдаанд 1–р байр 8-р сургуулийн 8а ангийн сурагч Ч. Ганбаяр, 2-р байр 8-р сургуулийн 7г ангийн сурагч Ц. Анужин, тусгай байр 11 сургуулийн 11а ангийн сурагч С. Мөнхдэлгэр, 1 сургууль 9в Э. Тэлмүүн, “ Эртний уран зохиолын уламжлал шинэчлэл” сэдэвт оюутны эрдэм шинжилгээний бага хуралд Дорнод дээд сургуулийн 4-р курсын оюутнууд оролцсоноос Оюунтуяа шилдэг илтгэгчээр, уран илтгэгчээр Сольчулуун, сонирхолтой илтгэл Оюунтунгалаг, тусгай байр Даваажаргал, Гантуяа нар шалгарлаа. Уралдаан тэмцээнд хүүхдүүдээ идэвхитэй оролцуулсан 8-р сургуулийн Намсрай багшийг шагнаж урамшуулсан.

5-р сургуулийн 3а ангийн хамт олон Шинэ суваг ТВ-тэй хамтран Хичээлээс гадуурх унших зохиолоор уран уншлага Л.Бадарч Шүүмжлэгдсэн баавгай, Д.Нацагдоржийн “Хэнз хурга” Д.Содномдоржийн “Норовын намтар” дүрийн тоглолт зохион байгуулсан.

Уншлагын нэг өдөр арга хэмжээг номын сангийн гаднах талбайд зохион байгуулан, 45 номоор үзэсгэлэн гарган уншсан номноос сэдэвлэн зургийн уралдаан зарлан 20 хүүхэд оролцсоноос 1 сургуулийн $5^{б}$ ангийн сурагч Б.Ганбаяр “Өнчин цагаан ботго” номыг зурж 1–р байранд, 1-р сургуулийн $5^{б}$ ангийн сурагч Г.Алтангэрэл Slam dank номноос сэдэвлэн зурж дэд байранд шалгарсан.

8-р сургуулийн Наранцацрал багштай 5а ангийн сурагчдын дунд “Элсэн цаг “танин мэдэхүйн тэмцээн явуулсан. 1-р байр Г.Өсөхбаяр ахлагчтай “Дэлбээ “-баг тэргүүн байр эзэлж Д.Орхон ахлагчтай “ирээдүй “ баг дэд байранд шалгарсан.

Хүүхдийн хичээлээс гадуур хүмүүжлийн ажлын үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор “Соёл хүмүүжлийн нээлттэй өдөрлөг”-өөр БСШУ Сайдын 2008 оны 169 дугаар тушаалаар батлагдсан “Хүүхдийн уран сайхан, гоо зүйн мэдлэг олгоход баримтлах уран бүтээл”-ийг танилцуулан, үзэсгэлэн гаргасан.

Вэб сайтад шинэ номын мэдээлэлд өөрийн номын санд байгаагаас гадна шинээр хэвлэгдсэн номын тухай, номын сангаас зохион байгуулсан ажлын мэдээлэл, соёл урлагийн талаар хэрэгжиж буй хөтөлбөр болон шинэ мэдээллээр тогтмол баяжуулж байна.

Цахим номын бааз үүсгэн эхэлж 100 гаруй ном серверт хадгалагдаад байна. Электрон хайлтат зориулагдсан компьютер бэлтгэж байрлуулсан. Вэб сайтад и-мэйл сервэр байрлуулсан 5 мэйлийн эрхтэй / user@dornod-library.mn/

Шинэ суваг телевизээр үйл ажиллагаа болон шинэ номын мэдээллийг орон нутгийн телевиз болон өөрийн вэб сайтаар сурталчиллаа.

Зохиолчдын уран бүтээлийг болон шинэ ном хэвлэлийг сурталчлах номын үзэсгэлэнг 23 удаа 634 номоор гаргасан.

Үр дүн:

- Уншигчид шинэ ном хэвлэл, мэдээлэлтэй танилцаж цахим үйлчилгээг хүргэсэн
- Хүүхдийг багаас нь номтой нөхөрлүүлэн, эцэг эхийн оролцоог нэмэгдүүлсэн
- Мэдээлэл сурталчилгааны ажилд уншигчид идэвхитэй оролцох болсон

Дөрөв. Үндэсний төсөл хөтөлбөр, Засаг даргын захирамж хөтөлбөр хэрэгжүүлэх

Зорилт: Үндэсний хөтөлбөрүүдийг сурталчлах

Хэрэгжилт: Соёл урлагийн салбарт хэрэгжиж байгаа үндэсний хөтөлбөрүүдийг иргэдэд хүргэх, монгол хөөмийн урлаг сурталчлах хөтөлбөр, гарал үүсэл, угийн бичиг хөтлөх тухай танхимуудаар мэдээлэл хийж, өөрийн сайтад тавьсан. Угийн бичгийн тухай цагдаагийн газар, ШТТС-ийн оюутнууд багш нарт мэдээлэл хийсэн.

Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон эдийн засгийн хүндрэлийн үед баримтлаж ажиллах 9 зарчмын дагуу ажлын төлөвлөгөө гарган ажилласан.

Засгийн газрын 2009 оны 03 тоот , АЗД-ын 2009 оны 04 тоот албан даалгавар, Засаг даргын санаачлагаар гаргасан 9 зарчмыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг гарган хүн бүр мөрдлөгө болгон ажилласны үр дүнд ажлын цагийн ашиглалт, ажлын ачааллыг тэнцвэржүүлэн ажил хөдөлмөрийн үр дүнг хүн бүрээр бодитойгоор үнэлэснээр байгууллагын өмнөх хүлээх хариуцлагыг дээшлүүлэн ажлын цаг ашиглалтыг сайжруулан ёс зүйг эрхэмлэн үйлчилгээний соёлыг нэвтрүүлэн хамтын хүчийг нэгтгэн ажиллалаа.

Үр дүн: Хөтөлбөрүүдийн мэдээлэл уншигчдад хүрсэн.

Тав. Соёлын салбарын статистик мэдээний үнэн зөв байдал:

Номын сангийн жил бүрийн тайлан судалгааг төвлөрсөн СУ-3, СУ-5, төвлөрсөн бус СУ-10, СУ-14 маягтаар гаргаж хүргүүлсэн.

Зургаа. Соёл урлагийн байгууллагуудын тоног төхөөрөмж, номын хангалт

Зорилт: Уншигчдын хэрэгцээт шинэ ном хэвлэлээр сан хөмрөгөө баяжуулж нөхөн бүрдүүлсэн.

Хэрэгжилт: “Шилдэг ном-2009” шалгарсан 201 төрлийн 1997500 төгрөгийн номыг 13 сумдын номын сангуудад хүргүүлсэн. Хандив тусламжаар 1224671 төгрөгийн 315 ном, “Иргэн бүр нэг ном” аяны хүрээнд 900 гаруй ном цугларснаас төв номын сангийн фондод 286 ном, бусдийг сумдын номын санд, Соёл урлагийн хорооноос ном худалдан авах зардалд 2533000 төгрөгөөр 354 номоор фондоо баяжуулан тайлангийн хугацаанд аймгийн төв номын сан 71041 номтой болсон. Фондын эргэлт 169.3 %-тай,

Урагдаж гэмтсэн 1737 ш номыг сэлбэн зассан.

Америкийн элчин сайдын яам, Боловсролын зөвлөгөө мэдээллийн төвийн санхүүжилт, тэтгэлэгээр компьютер, принтер, БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар Баянтүмэн, Булган, Хөлөнбуйр, Чойбалсан, Матад сумдын номын санд тус бүр 5 ширээ 10 сандал өгсөн.

Үр дүн: Ном авах зардал шийдэж өгснөөр уншигчдын эрэлт хэрэгцээг шинэ номоор , хандивын аянаар хэрэгцээт номоор хангагдсан.

Санхүүжилт 2.533.000 ₮, Техник хэрэгсэл англи хэлний ном 2337500 төрлийн

Долоо: Хяналт шалгалт үнэлгээ бодит болгох , иргэдийн санал хүсэлтийг барагдуулах

Зорилт: Төрөөс баримтлах соёлын бодлого, Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийх, илэрсэн зөрчлийг арилгуулах , соёлын байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах, зөвлөгөө өгөх.

Хэрэгжилт: Соёл урлагийн хорооны орлогч дарга Б.Очирбаатараар ахлуулсан гадаад харилцааны мэргэжилтэн Д. Мэндсайхан мэргэжлийн зөвлөлийн гишүүн хөгжмийн зохиолч СГЗ Хаянхярваа, бужиг дэглээч С.Сүхбаатар нарын бүрэлдхүүн аймгийн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаатай танилцаж үнэлэлт дүгнэлт өгч ажилласан. Энэ үнэлэлтээр тус номын сан хангалттай сайн дүгнэгдсэн.

Төсвийн зарцууллалтын гүйцэтгэлийн аудитын шалгалтанд орж шалгалтаар илэрсэн зөрчлийг барагдуулсан.

Үр дүн . Сайн үнэлгээ авсан

Найм: Бусад ажлын талаар:

Архив албан хэрэг хөтлөлтийн байгууллагын дэргэдэх баримт бичиг нягтлан шалгах комиссын үйл ажиллагааг тогтмолжуулан байнга, түр устгах бичгийн түүвэр жагсаалт, боловсон хүчний хувийн хэргийн бүртгэл, байгууллагын үлгэрчилсэн жагсаалтыг хэлэлцэн баталж аймгийн архивын дэргэдэх баримт бичиг нягтлан шалгах комиссын хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулж, архивын баримтыг эмхлэн цэгцлэж техник боловсруулалтыг хийж, номын санчдад албан хэрэг хөтлөлтийн талаар сургалт хийсэн. Мөн соёлын байгууллагуудын архив бичиг хэргийн ажилтангуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Ажилчдаас ирсэн өргөдөл гомдлыг хүлээн авч бүртгэн шийдвэрлэн ажиллалаа. Няравын тайлан тооцоог тухай цаг бүрт нь гаргаж, тооллого тооцоо хийн ажилласан. Байгууллага хоорондын тооцоог тогтмол хийж , гэрэл , дулаан, усыг ариг гамтай хэрэглэж хэвшүүлсэн.

Байгууллагын эд хөрөнгө алдаж үрэгдүүлэхгүй хэвийн ажиллагаанд харуул хамгаалалтыг сайжруулах 4 жижүүрт сургалтыг хийлгүүлж, мэдээллийн цагийн тогмолжуулан үр дүнтэй зохион байгуулж байна.

Төлбөрт үйлчилгээний орлого 11 сарын 1-ний байдлаар 934000

Ажилчдын дунд 7 хоног бүрийн Бямба гаргийг “Эрүүл мэндийн цаг” спортын секцийг ҮЭ-ийн тэргүүлэгчид хариуцан явуулж, хийн дасгалд ажилчдаа хамруулсан. Жижүүр Чадраабал хийн дасгалыг хамгийн сайн хийж байгааг тэмдэглэхэд таатай байна.

Соёлын байгууллагын ҮЭ-ийн хорооноос зохион байгуулсан гар, сагсан бөмбөг, буухай тэмцээнд амжилттай оролцож тэргүүн байр эзэлсэн. Соёлын байгууллагуудын ҮЭ-ийн хороотой хамтран номын санч Л. Цагааны хөдөлмөр алдрыг тэмдэглэсэн.

Иргэн бүр нэг мод, байгууллага бүр 5 мод тарих уриан дор байгууллагын гаднах талбайд 5 мод тарьж ургуулсан. Байгууллагынхаа хашааг эргэн тойрон шавардаж, шохойдож сэргээн засварлалаа.

Ажилчдын хөдөлмөрийг үнэлж арга зүйч Н. Хандсүрэн, хүний нөөцийн ажилтан М. Ариунаа нарыг засаг даргын жуух бичиг, номын санч Э.Батцэцэгийг Хэрлэн сумын Жуух бичгээр шагнагдсан.

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах талаар төлөвлөгөө гарган ажиллаж бохирын худгийг хөлдөлтөөс сэргийлэх талаар арга хэмжээ авч ажиллаа.

Дүгнэлт. 2009 онд байгууллагын өмнө тавигдсан зорилтуулаа бүрэн хэрэгжүүлж ажилласан бөгөөд хүүхдийг номтой нөхөрлүүлэх ажилд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэхэд нилээд ахиц гарсан.

Фондын 71 %-ийг автомажуулалтын программд орууласнаар монгол,орос номыг электрон каталогоор хайх, электрон ном унших, уншлага үйлчилгээг цахимаар хөтлөх боломжоор хангагдаж эхэлсэн.

Бие даасан сайттай болсноор орон зай харгалзахгүйгээр интернэтээр тус номын сангийн үйл ажиллагаатай танилцах шинэ ном болон зарим мэдээллийг унших боломжтой болж уншлага үйлчилгээндээ мэдээлэл холбооны технологыг ашиглаж эхэлсэн гэж үзэж байна.

Номын сангийн үйлчилгээний хүрээ номын сангийн орчны стандартын үйлчилгээний жишгийг биелүүлсэн боловч урьд оноос бага байгаа нь N1H1 ханиадын гарч уншлага үйлчилгээ хаагдсан, мөн Малын гоц халдварт шүлхий өвчин гарч хорио цээр тогтоосон холбоотой хөдөө сумдаар нүүдлийн явуулын үйлчилгээгээр үйлчилж чадаагүй болно.

Санал.

1.Номын сангийн барилгын өргөтгөлийн асуудлыг улсын хөрөнгөөр шийдвэрлэж өгөх.

2. Номын сангийн автомажуулалтын Lib4U net Version 1.8 программын шинээр нэмэгдсэн хувилбарууд болон вэб сайтын ашиглалтыг сайжруулах, шинэлэг үйлчигээг нэмэгдүүлэхэд өндөр хүчин чадалтай сервер, 128 –аас дээш хурдтай интернэтийн суваг мэдээллийн хэрэгцээгээ дагаад шаардагдаж байна.

3. Аймаг орон нутгийн номын сангуудын үйл ажиллагааг үнэлэн дүгнэж сайн ажиллаж байгааг урамшуулах,

4. Орон нутгийн номын санчдыг гадаад дотоодын номын сангуудын арга барилтай танилцуулах, туршлага судлуулах, гадаад харилцааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх,

5. Номын санчдыг мэргэжил дээшлүүлэх, нийгмийн асуудлыг сайжруулахад анхаарах

С.БУЯННЭМЭХИЙН НЭРЭМЖИТ ДУНДГОВЬ АЙМГИЙНТӨВ НОМЫН САНГИЙН 2010 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ХУУЛЬ, ТОГТООМЖ ШИЙДВЭРҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР

Төсвийн байгууллагын Удирдлага санхүүжилтын хуулийн дагуу 2010 онд хийх ажил, нийлүүлэх бүтээгдэхүүний Үр дүнгийн гэрээг төсвийн Ерөнхий менежертэй хийлээ. Менежерээс албан хаагчидтай байгуулах үр дүнгийн гэрээг хүн нэг бүртэй хийж, хагас жил, жилээр дүгнэж ажлын амжилтаар урамшуулал, нэмэгдэл зэргийг ажиллагсдад олгож ирлээ. Сангийн сайд, БСШУЯ-ны сайдын хамтарсан 2006 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 357/406 дугаар тушаалаар батлагдсан “Ном, хэвлэл дахин үнэлэх журам”-ын дагуу номын фондын 74 хувь буюу 40000 ширхэг номыг дахин үнэллээ. БСШУхааны сайдын 2005 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 441 дүгээр тушаалын “Номын сангийн данс, маягт шинэчлэн батлах тухай” журмыг үндэслэн 2006 оны 1 дүгээр сараас эхлэн дараах байдлаар:

- Номын нэг бүрчилсэн бүртгэл: код- 00791
- Номын сангийн фондын нэгдсэн бүртгэл: код – 000425
- Номын санчийн өдөр тутмын ажлын бүртгэлийг шинэчлэн хөтөлж байна.

БСШУ-ны сайдын 2007 оны 11 сарын 8-ны өдрийн 415 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт “Алдагдсан буюу гэмтээгдсэн ном, хэвлэлийг дахин төлүүлэх журам”-ын дагуу тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн урагдаж гэмтэж уншлагын шаардлага хангахгүй байгаа номыг актанд бүртгэж журмын дагуу удирдах дээд байгууллагын /МҮНСан/ зөвшөөрлийг авч ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар оруулах бэлтгэл ажлуудыг хийж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 190 дугаар тогтоол, Засаг даргын 2007 оны 228 дугаар захирамжийн дагуу 2010 оны 10 сарын 20-ны өдөр “Нээлттэй хаалга” мэдээллийн өдөрлөгөөр байгууллагаа сурталчлах, судалгаа явуулах, номын 1 сарын аяны нээлтийг хийх, шинэ номын үзэсгэлэн гаргах, “С.Буяннэмэх тэмдэгтэн”-ний шагнал гардуулах, зэрэг арга хэмжээнүүдийг явуулж иргэдээс өндөр үнэлэлт авлаа. 720 уншигчид үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлж санал солилцлоо. Мөн үндэсний бичиг үсгийн баяр “Бичиг соёлын хишиг өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүллээ.

Монголын Үндэсний номын сангаас зохион байгуулсан номын сангийн удирдлагуудын сургалтанд оролцож, БСГ-тай хамтарч сумдын соёлын төвийн эрхлэгч нарт маркетинг, менежментийн сургалтыг зохион явууллаа.

Сумдын номын санг арга зүй, бусад мэдээллээр хангаж байх үүргээ биелүүлж дараах арга хэмжээг зохион байгуулсан. Сумдын номын хөмрөгийн баяжилтыг чанаржуулах зорилгоор 2009 оны шилдэг ном, “Нээлттэй нийгэм форум”-ын улс төр танин мэдэхүйн номуудыг 14 сумдын номын санд хуваарилан хүргүүллээ.

Байгууллагаас чөлөөнд гарсан өндөр настангуудыг хүлээн авч, номын сангийн “Гурван үеийн эрхлэгч” нарын уулзалтыг зохион байгууллаа.

“Төрийн албан хаагчийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх жил”-д тусгай төлөвлөгөө гарган түүний хэрэгжилтэнд хяналт тавих Ёс зүйн зөвлөлийг байгууллаа. Мөн тусгай самбар булан ажиллуулж ёс зүйн зөрчилгүй хамт олон болох хөдөлгөөн өрнүүлж байна.

Долоо хоногийн Даваа гарагийн 17-18 цагт хууль эрх зүйн болон бусад мэдээллийг холбогдох мэргэжилтнүүдийг урьж хийлгэж заншсан.

ХОЁР. МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГАА, СОЁЛ ОЛОН ТҮМНИЙ АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТАЛААР

- Дундговь аймгийн соёл урлагийг сурталчлах 3 хоногийн арга хэмжээнд идэвх санаачилгатай оролцож, аймгаас төрж гарсан 80 шахам зохиолч, яруу найрагч, зохиолчдын номын үзэсгэлэн, “Эргэх холбоо” үе үеийн зохиолчдын уулзалт, өдөрлөгийг зохион байгууллаа.
- Насанд хүрэгчдийн уншлагын танхим 2010 оны 1-р сараас эхлэн цахим үйлчилгээ явуулж байна.
- Сургалтанд зориулж проектор, камер худалдаж авлаа
- Фондын номын 71 хувийг электрон каталогт оруулсан
- 2010 оны 5-р сард сумын номын санч, ЕБС-ийн номын санч нарт мэргэжлийн анхан дунд шатны мэдлэг олгох, онолын болон дадлагын 2 хоногийн сургалт хийлээ
- Хулд, Эрдэнэдалай, Дэрэн, Луус сумын номын сан, ЕБС-ийн 3, МГСС-ийн номын санч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө

- 5 сумын /Цагаандэлгэр, Дэлгэрхангай, Гурвансайхан, Өндөршил, Луус/ номын санг уншигчийн ширээ сандлаар хангуулахаар БСШУЯаманд санал хүргүүллээ.
- Хулд сумын нийтийн номын санд орчин үеийн дизайн бүхий номын тавиур 1ш-ийг хандивын журмаар өгүүллээ.
- Эмэгтэй зохиолч яруу найрагчдын уран бүтээлийг сурталчилж “Эмэгтэй зохиолчид”, ”Ээжийн бүүвэйтэй хорвоо”номын сэдэвчилсэн үзэсгэлэнгүүдийг гаргалаа.
- “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг аймгийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүллээ. Энэ үеэр эрдэм шинжилгээ, хэл судлалын танхим нээж, төвд номын фондын эх суурийг тавилаа.
- Шинэ номын болон сэдэвчилсэн үзэсгэлэнг 34 удаа 921 номоор, Улаанбаатар хотод аймгийн зохиолчдын 80 шахам номоор үзэсгэлэн тус тус гаргалаа.
- “Жижиг бизнесээр баяжих аргууд”, “Алсын хараа”, “Өөртөө туслах ухаан” зэрэг 5 номоор уншигчийн бага хурлуудыг зохион явууллаа.
- “Хүүхдийн төлөө бүтээн байгуулалтын жил”-ийн ажлын хүрээнд номын сангийн дэргэд “Номун далай” клуб байгуулан улсын чанартай төсөл, уралдаан тэмцээнд хамрууллаа.
- ЕБС, МСҮТ-ийн номын сан, цэцэрлэгүүдтэй хамтын ажиллагааны гэрээний үндсэн дээр шинэ мэдээлэл солилцох, зөөврийн номын сан ажиллуулах, уншигчийн бага хурал, төрөл бүрийн танин мэдэхүйн тэмцээн уралдааныг хамтран явууллаа.
- Эрдэм шинжилгээ, хэл судлалын танхимыг байгуулж, тохижууллаа. Аймгийн 80 гаруй эрдэмтдийн жагсаалтыг гаргаж холбоо тогтоон тусгай фонд байгуулах ажлыг зохион байгуулж байна
- “Дундговь ном хэвлэлийн хуудаснаа” ном зүйн бүртгэлийг хэвлүүлэхэд бэлэн болгосон ба аймаг байгуулагдсаны 70 жилийн ойн өмнө хэвлүүлэн гаргахаар 2011 оны аймгийн эдийн засаг, нийгмийн үндсэн чиглэлд оруулсан
- Яруу найрагч П.Нямлхагвын “Алтан хагсуурга” номын хуримыг хийж, төвд номын фондын нээлтийг хийлээ.
- Ардын уран зохиолч С.Дашдооровын нэрэмжит “Дэлгэрхангай уулан дээрээс Дэлхийн юм бүхэн харагдана” 1 сарын номын аяныг зохион байгуулж хүүхдийн насны онцлогуудад тохирсон уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулан шагнаж урамшууллаа.

ГУРАВ. УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭ ТӨЛӨВЛӨГӨӨТ АЖЛЫН ТАЛААР

Д/д	Үзүүлэлтүүд	Гүйцэтгэл
1	Уншигч	2964
2	Ирэгсэд	18340
3	Ном олголт	42401
4	Орлого	725000

Үйлчилгээний танхимууд каталогийн хаяг, ялгагчуудыг шинэчлэн байрлууллаа. Номын фондын баяжилтыг чанаржуулах зорилгоор уншигчдаас санал асуулгын хуудсаар захиалга авч байна.

Орон нутгийн “Хадаг”, “Говийн амьдрал” сонин, “Цоглог” ТВ-тэй хамтран ажиллах гэрээгээ шинэчилж, номын сангийн үйл ажиллагааг сурталчлан, шинэ номын тойм хийж байгаа.

Үйлчилгээний 4 номын санч, 3 тасагт 1094 ширхэг ном үндсэн фондоос захиалгаар үйлчилсэн байна.

21304 уншигчид 42401 ном хэвлэлийн бүтээгдэхүүн олгож үйлчилсэн нь урд оноос 10 хувиар нэмэгдсэн байна

2010 онд улсын төсвөөр 208 нэрийн 263ш 2345200 төгрөгийн ном, хандивийн 10 нэрийн 21ш 24200 төгрөг, бэлгийн 16 нэрийн 29ш 113420 төгрөг. нийт 234 нэрийн 313 ш 2482820 төгрөгийн номоор фондын баяжилт хийлээ. 14 нэрийн 570250 төгрөгийн тогтмол хэвлэл захиалан уншигчдад үйлчлэв. Үүнээс 2 нэр төрлийн хэвлэл нь хүүхдэд зориулсан тогтмол хэвлэл байна. Хөмрөгийн 5% буюу 2715 номд сэлбэн засалт хийж уншигчдад үйлчиллээ.

Шинэ номын мэдээллийг орон нутгийн телевиз, байгууллагуудын мэдээллийн самбар, зөөврийн номын үзэсгэлэн хэлбэрээр сурталчиллаа.

ДӨРӨВ. ДОТООД АЖЛЫН ТАЛААР

- 2010 онд хийх жил, улирлын ажлын төлөвлөгөөгөө гарган аймгийн БСГазрын даргаар баталгаажуулж хэрэгжүүлж ирлээ.
- Үйлчилгээний тасгууд болон номын үндсэн фонд хоорондоо дотоод сүлжээгээр холбогдох, электрон каталогт номуудыг оруулах ажлууд хийгдэж байна. Нийт номын 72%-ыг электрон каталогт оруулсан. Насанд хүрэгчдийн уншлагын танхимыг бүрэн цахим буюу виртуаль болгон уншигч, хэрэглэгчдэд хүрч үйлчилгээгээ явуулж байна.
- БСШУЯам, Соёл Урлагийн Хороо, МҮНС-аас зохион байгуулагдсан бүх сургалтанд идэвхтэй хамрагдаж 6 мэдээллийн ажилтанг оролцуулсан
- Хүүхдийн уншлагын танхимын дэргэдэх “Номун далай” баг “Номын анд” төсөл хэрэгжүүлэн улсын хэмжээнд тусгай байр эзэлсэн амжилт үзүүллээ. Мөн тус төслийн хүрээнд 3 хоногийн сургалтанд хүүхдийн номын санчаа хамрууллаа
- Хас банк, ХААН банкны мэргэжилтнүүдийг урьж шаардлагатай мэдээллийг ажиллагсдад өгүүллээ.
- Ажиллагсад үйл ажиллагаандаа мөрдлөг болговол зохих хуулиудын сорилго боловсруулж өөрсдийн хуулийн мэдлэгийг шалгах, дээшлүүлэх арга хэмжээ явагдаж байна
- Мэдээллийн ажилтан Ч.Түмэннаст СУИС-ийн харъяа Соёлын сургуулийн магистрантурт суралцаж байна
- Хүүхдийн тасгийг тохижуулах төсөл боловсруулан “Дэлхийн зөн” ОУБ, МҮНСан, БХБЗТЯ-д хандсан. Мөн 2011 онд аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгуулсан.
- Байгууллагын тохижилтийг батлагдсан төсөвт багтаан чанартай хийлээ. Үүдний танхимын тохижилтийг сайжруулж ваакуум хана, хаалгатай болсон.

ТАВ. САНХҮҮГИЙН ТАЛААР

2010 онд ном хэвлэл худалдан авах зардлыг хэт багасгаснаар манай байгууллагын үндсэн үйл ажиллагаа алдагдахад хүрлээ.

“Дундговь ном хэвлэлийн хуудаснаа” ном зүйн бүртгэлийг хийсэн нь орон нутгийн номын сангуудын хувьд анхдагч байгаа ч хэвлүүлэх санхүүгийн боломжгүйгээс хэвлэлтэнд өгч чадсангүй.

Дотоод томилолтын зардал хүртэлцэхгүй, шуудан холбооны зардалд интернетийн зардлыг тусгаагүй, соёл олон түмний ажлыг явуулах төсөв огт байдаггүй зэрэг санхүүгийн бэрхшээлтэй байна.

Соёл урлагийн Хорооноос аймгийн төв номын сангуудад 2533000 төгрөгийн ном хэвлэл худалдан авах санхүүжилтийг хийсэн нь ажиллагсдын болон иргэд уншигчдын талархалыг ихэд хүлээж, уншигчийн тоо нэмэгдэн төлөвлөгөөт ажил биелэгдэх нөхцөл бүрдсэн юм. Харин “Дундговь ном хэвлэлийн хуудаснаа” номзүйн 3-н боть номыг 2011 оны аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгуулж, аймаг байгуулагдсаны 70 жилийн ойг угтан хэвлүүлж гаргахаар боллоо.

ЗУРГАА. ДҮГНЭЛТ

2010 оны эхний хагас жилд хийсэн ажил, арга хэмжээндээ дүгнэлт хийж үзэхэд Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Менежерээс ажиллагсадтай хийсэн үр дүнгийн гэрээг хагас жилээр дүгнэж ажлын үр дүнгээр цалинд өөрчлөлт оруулан ажлын амжилт, ур чадвараар нь нэмэгдэл урамшил олгосон нь ажил эрчимтэй явах, шинээр төрөл бүрийн ажил, арга хэмжээ зохион байгуулагдах, ажлын өрсөлдөөн бий болох зэрэг ажлын ахиц, өөрчлөлт гарч байгаа нь харагдаж байна. Нөгөө талаар БСШУЯ-аас номын санчдын ур чадварыг дүгнэх шалгуур журам боловсруулж, мэргэжлийн зэрэглэл тогтоож өгөх нь зүйтэй байна. / Энэ тухай мөн урд онуудад ч санал болгож байсан/

2008-2010 онуудад их, бага урсгал засварууд хийгдсэнээр уншигчдын үйлчлүүлэх тав тохитой орчин бүрдэж ирэгсдийн тоо, байнгын уншигчдын тоо өмнөх онуудтай харьцуулахад өссөөр байна.

Санхүү төсвийн хүндрэл их байгаа ч дотоод хүчин чадлаа дайчлан ажиллаж, орон нутгийн мэдээллийн төв, цаашилбал сургалтын төв болох, үйлчилгээндээ орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж ажиллах боломж байна гэж дүгнэж байна.

Б.ЯВУУХУЛАНГИЙН НЭРЭМЖИТ ЗАВХАН АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2010 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- Б.Явуухулангийн нэрэмжит Төв номын сан нь 1946 онд байгуулагдсан.
- Монгол улсын Засгийн газрын 1999 оны 109-р тогтоолоор төрийн соёрхолт, соёлын гавъяат зүтгэлтэн Б.Явуухулангийн нэрэмжит болж нутгийн зөвлөлийн хөрөнгөөр 3,2 сая төгрөгөөр түүний хөшөөг босгосон.
- Нийтийн ушлагын танхим, хүүхдийн уншлагын танхим, гэрээг ном олгох тасгуудаар уншлага үйлчилгээ явуулдаг.
- Орон тоо хүний нөөц: Нийт 10 орон тоотой, Дээд боловсролтой- 8, тусгай дунд -1, бүрэн дунд боловсролтой-1, СТА-3, Санхүү банкны тэргүүн-1

1. **2010 оны үйл ажиллагааны зорилтын хэрэгжилт, үр дүн**

Иргэд олон нийтийг өргөн хүрээтэй иж бүрэн мэдээллээр найдвартай шуурхай хангах, мэдээллийн технологийн хүчин чадлыг олны хүртээл болгох, иргэдийн оюун санааг хөгжүүлэх, соёл, мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, нэмэгдүүлэхэд тэдний өөрсдийн оролцоо, хүчин зүйлийг дайчлах, үүнд чиглэсэн орчинг бий болгоход үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа.

Үйлчилгээний хүрээ, хүртээмжийг өргөжүүлэх хүрээнд

Уншлага үйлчилгээний үндсэн зорилтууд бүрэн хангагдаж, үйлчилгээний шинэлэг дэвшилтэт арга хэлбэрүүд амжилттай хэрэгжиж байна.

А/Номын сангийн үндсэн үйл ажиллагаа

- 5521 уншигчидад карт нээж 30325 ирэгсдэд 92792 ном олгож үйлчиллээ.
- Дэлхийн Зөн Монгол ОУБайгууллагийн Завханхангай ОНХХ-тэй хамтран "Ном бол Ертөнцийг харах цонх мөн" сэдэвт хоёр сарын ном уншлагын аянг Улиастай сумын ЕБС-н сурагчдын дунд зохион байгуулж дүгнэлээ.
  1-р байр Дэвшил сургууль 250$
  2-р байр Жавхлант цогцолбор сургууль 150$
  3-р байр Чандмань эрдэнэ цогцолбор сургууль 100$ эдгээрийг Дэлхийн Зөн Монгол ОУБ-н Завханхайнгай ОНХХ-с ивээн тэтгэв.
  Мөн тэргүүний анги хамт олон шалгаруулав.Үүнд:
  1-р байр 3-р сургуулийн 7б анги /ангийн номын санд 100,000 төгрөгийн ном Хас банк ивээн тэтгэв/
  2-р байранд ЧЭЦС-н 4в анги /ангийн номын санд 80,000 төгрөгийн ном Хадгаламж банк ивээн тэтгэв/
  3-р байранд ЖЦС-н 9а анги /ангийн номын санд 50,000 төгрөгийн ном Номын сан ивээн тэтгэв/
  Сургууль тус бүрээс бага дунд ахлах гэсэн насны ангилалаар тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгээр 15 уншигчийг шагналаа.
- Албан байгууллага, сургууль, сум, нийгмийн эмзэг бүлэгт үйлчилгээг хүргэх зорилгоор зөөврийн номын сан ажиллуулж 1360 уншигч 2358 ирэгсэдэд 22469 ном олголоо.
- Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн 23
- Номын тойм 13, чанга уншлага 22, лекц яриа 9 удаа
- ЭШБХ болон УБХ тус бүр нэг нэг удаа зохион байгууллаа.
- Дүрийн тоглолт 4 удаа.
- Яруу найргийн тэмцээн 2 удаа.

Б/ Дэвшилтэт шинэ үйлчилгээ

- Лавлагаа ном зүйн ажлыг орчин үеийн техниктэй хослуулан зохион байгуулснаар аливаа мэдээллийг олон эх сурвалжаас авах,хэрэгцээт мэдээллийг шууд хэвлэн өгөх, уншигчид өөрсдөө хэрэгцээт мэдээллээ файл хэлбэрээр авах зэрэг үйлчилгээний шинэлэг хэлбэр амжилттай хэрэгжиж байна. Шинжлэх ухаан техник хөгжижи байгаа өнөө үед номын сангийн үйлчилгээг автоматжуулах зорилгоор LIB4U программыг авч үндсэн фондын номын 54% болон ойрын фондын номыг 100% хувь электрон каталогид оруулж уншлага үйлчилгээнд гаргаад байна.Олон улсын ангилал DDC-г англи хэл дээрх номондоо хэрэгжүүлж техник арга ажиллагаа хийсэн. Уншигчидад үйлчилгээг өргөтгөх зорилгоор чөлөөт сонголтын үйлчилгээг нэвтрүүлээд байна.

Фондын баяжилт бүтэц зохион байгууллтыг сайжруулах, лавлагаа мэдээллийн санг өргөжүүлэх хүрээнд:

- ❖ Номын сангийн номын фондыг 194 нэрийн 492 ширхэг 2545850 төгрөгийн номыг төсвөөр, 56 нэрийн 127 ширхэг 539560 төгрөгийн номыг албан байгууллаг ард иргэдийн хандиваар тус тус фондоо баяжуулж техник арга ажиллагаа хийж уншлага үйлчилгээнд гаргалаа.
- ❖ Байгаль экологи, Эрүүл аж төрөх ёс, Жижиг дунд үйлдвэрлэл, Л.Ванганы намтар ном зүй, Завхан аймаг хэвлэлийн хуудсанд, Төр засгийн шийдвэр зэрэг картын сангуудыг баяжуулах болоншинээр хийж Каталогийн ялгачыг шинэчлэн, 1626 ширхэг элэгдэж хуучирсан каталогийг шинэчлэн каталогийн хаяг болон каталогийн зөв ашиглалтын талаар зөвлөмж гаргалаа.
- ❖ Дэвшил сургууль болон 11 жилийн 3-р сургууль, МСҮТ-д нийт 5 удаа хэрэгцээт болон шинээр ирсэн номын жагсаалтыг гаргаж уншигчдад хүргүүллээ.
- ❖ Ном бол ертөнцийн харах цонх мөн сэдэвт аяны хүрээнд номтой зөв боловсон харицах талаар яриа таниулга 3 хийж, ном сэлбэн засах хөдөлгөөн өрнүүлж ЕБС-иуд хувиарын дагуу ээлжээр урагдаж гэмтсэн 326 номыг сэлбэн заслаа.
- ❖ Мэдээллийн 3 самбараар уншигч олон нийтэд шинэ номын мэдээ, хууль эрх зүйн мэдээллийг хүргэлээ.
- ❖ Ном зүйн ажлыг компьютертэй хослуулан ном зүйн лавлагааны чиглэлээр төрөл бүрийн мэдээллийн сан байгуулан иргэдэд үйлчлэх мэдээлийн үйлчилгээний чанарыг сайжруулж 1029 хүнд лавлагаа өгч үйчиллээ.

Үйлчилгээний орчинг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ

- ❖ Үйлчилгээний таатай орчин хөнгөн шуурхай байдлыг хангах мэдээлийн орчин үеийн олон талт үйл ажиллагааг явуулах нөхцлийг бүрдүүлэх байгууллгын дотоод тохижилт техник хэрэгслийн хангамж гэсэн үндсэн 2 чиглэлээр жил бүр тодорхой ажлуудыг төлөвлөж , төсвийн болон өөрсдийн нөөц боломцоог нэмэгдүүлэх замаар шийдвэрлэж байна. Байгууллгын сантехникийн гадна шугам сүлжээний тодорхой хэсгийн шинэчлэх, цэвэр усны шугам оруулах ажлыг хийх, байгууллагад урсгал засварыг нийт 820000 төгрөгөөр хийлээ. Мөн өөрийн орлогоос скайнер, канон, принтертэй хэвлэгч 350,0 мянган төгрөгөөр авлаа.
- ❖ Номын сангийн үйл ажиллагааг автомажуулах зорилгоор 8 компьютер дотоод сүлжээнд холбогдож LIB4U програмын туламжтайгаар ном хэвлэлийг оруулж байна. уншлагын танхимд уншигчдад зориулсан компьютерийг байрлуулж интернэт болон төрөл бүрийн CD–ний тусламжтайгаар мэдээ мэдээллийг өгч байна.

Ном сурталчлах ажлын хүрээнд

Аймгийн Ерөнхий боловсролын 1-5 ангийн сурагчдын дунд “Миний эх орон бидний ирээдүй” сэдэвт гар зургийн уралдааныг 2 үе шаттай зохион байгуулж 2-р шатанд 25 бүтээл шалгаруулснаас үзэсгэлэн гарган нийтэд сурталчлаж 1,2,3 байр эзлүүлж шагнаж урамшууллаа.

1-р байр 11 жилийн 4-р сургууль
2-р байр Дэвшил сургууль
3-р байр ЖЦСургууль

ЕБС-ийн Ердийн болон шилжилтийн 7-р ангийн сурагчдын дунд Дэлхийн байгаль хамгаалах өдрийг тохиолдуулан “Цэвэр ус эрүүл амьдрал сэдэвт” зохион бичлэгийн уралдааныг 2 үе шаттай зохион байгуулж 15 зохион бичлэгийг шалгаруулж 1,2,3 байр эзлүүлж шагнаж урамшуулав.

1-р байр Дэвшил сургууль
2-р байр ЖЦСургууль
3-р байр ЧЭЦ сургууль

ЕБС-ийн 8-р ангийн сурагчдын дунд Үндэсний бичиг соёлын хишиг өдрийг тохиолдуулан “Монгол бичгээр хэн зөв цэвэр сайхан бичих вэ?” уралдааныг 2 үе шаттай зохион байгууллж 2 шатанд 15 хүүхэд шалгаруулж урамшуулав.

1-р байр 11 жилийн 3-р сургууль
2-р байр Дэвшил сургууль
3-р байр ЖЦСургууль

ЕБС ахлах ангийн сурагчдын дунд “Ухаан далай номоос эхтэй” Дэвжээ тэмцээнийг зохион байгууллаа.

1-р байр Жавхлант цогцолбор сургууль
2-р байр Чандмань Эрдэнэ цогцолбор сургууль тус тус байр эзэлж ХААН банк ивээн тэтгэлээ.

Аймгийн ХЖТеатртай хамтран ЕБС-уудын дунд Ванганы 90 насны ойг тохиолдуулан “Ванган уран бүтээлийг хэн сайн мэдэх вэ?” сэдэвт дүрийн тоглолтыг 2 үе шаттай зохион байгууллаа. 1-р шатыг сургууль дээрээ, 2-р шатыг ХЖТеатрт шалгарууллаа.

1-р байр ЧЭЦСургуулийн
2-р байр Дэвшил сургуулийн
3-р байр ЖЦСургуулийн
Тусгай байр 11-н жилийн 3 сургууль тус тус шалгарлаа.

Соёл олон түмний ажлын хүрээнд:

- Дорнын нэрт яруу найрагч Б.Явуухулангийн мэндэлсэн өдөрт зориулан ЧЭЦСургуулийн ахлах анги болон 11 жилийн 3-р сургуулийн ахлах ангиудын дунд Явуугийн уран бүтээлийг хэн сайн мэдэх вэ? Сэдэвт номын маргаан зохион байгууллаа.
- Л.Ванганы мэндэлсэний 90 насны ойн хүрээнд Л.Ванганы уран бүтээлийг хэн сайн мэдэх вэ? Сэдвийн дор ЕБС-н сургуулиудын дунд хоёр сарын аянг зохион байгууллаа.
- Цэцэрлэгийн ахлах ангийн сурагчдыг номын сантай танилцуулах, номын сангийн анд болох талаар аймгийн 5-р цэцэрлэгийн ахлах ангийн сурагчдыг номын сантай танилцуулж, чанга уншлага хийж өглөө.
- Ард иргэд болон уншигч хүүхэд багачуудын дунд ном сурталчилах ажлыг сургууль, албан байгууллагатай хамтран өв уламжлал, зан заншлын сэдвээр 5 удаа, эрх зүйн боловсролын чиглэлээр 3, эрүүл мэндийн чиглэлээр 5, тэмдэглэлт ой, баяр ёслолуудыг тохиолдуулан 8, ЭШБХурал, УБХурал нийт 2 удаа зохион байгуулан давхардсан тоогоор 2154 хүн хамруулллаа.
- ЖЦС-н Хулан багштай 7-р ангийн сурагчдийн дунд Танин мэдэхүйн чиглэлээр Алтан хонх тэмцээнийг зохион байгууллаа.
- 11 жилийн 3-р сургуулийн 7б ангийн сурагчид бага ангийн сурагчидад “Хүнсний зах дээр” сэдэвт дүрийн тоглолтыг зохион байгууллаа.
- ЖЦС-н 4в ангийн хамт олон анги нийтээрээ номын сангийн уншигчидад зориулан “Номын тухай бидний ойлголт” сэдвийн дор өөрсдийн зохиосон оньсого, зүйр цэцэн үг, сургааль үг, шүлгийг уншиж сонирхуулан уг бүтээлээрээ үзэсгэлэн гаргалаа.
- Завхан аймгийн Эдийн зэсгийн салбар сургуулийн Аялал жуулчлалын анги, Отгонтэнгэрийн тусгай хамгаалалттай газар, Дэвшил сургуулийн 7-р

ангийн сурагчдын дунд “Дэлхийн иргэншлийн түүх”, МУИС-н салбар сургуулийн оюутнууд Шүүхийн ажилчдын дунд “Хүний эрхийн тухай, эрхээ хэрхэн хамгаалах вэ?”, ЖЦСургууль болон 11 жилийн 3-р сургуулийн 7-р ангийн сурагчдын дунд “Ёс заншил ба танин мэдэхүйн чиглэлээр”, ЖЦС-н сурагчдын дунд Дэлхийн байгаль байгаль хамгаалах өдрийг тохиолдуулан экологийн бохирдолттой холбоотой сэдвүүдээр тус тус танин мэдэхүйн АХА тэмцээнүүдийг амжилттай зохион байгууллаа.

- ❖ ЧЭЦС-н номын сантай хамтран Шинжлэх ухаан танин мэдэхүйн сэдвээр Эрдэм шинжилгээний бага хурал зохион байгууллаа.
- ❖ ЧЭЦС-н 4в ангийн сурагчдын дунд Шидэт бөгж дүрийн тоглолт зохион байгууллаа.
- ❖ Номын сангийн уншигч хүүхдүүдэд дэлхий даяар тархаад байгаа Томуугийн А/Н1N1/ вирусийн халдварийн үед гэрийн нөхцөлд хийх асаргаа сувилгааны талаар Медикал өрхийн эмнэлгийн эмч Цэрэндүг лекц яриа зохин байгууллаа.
- ❖ ХБК-н сурагчдын дунд “Уянгын тойрог”, Б.Явуухулангийн амьдрал уран бүтээлийн хэн сайн мэдэх вэ?” сэдэвт яруу найргын тэмцээнийг амжилттай зохион байгууллаа.
- ❖ ЖЦС-тай хамтан сурагчдын дунд С.Эрдэнэ “Малын хөлийн тоос”, Д.Нацагдорж “Цагаан сар ба хар нулимс” сэдэвт дүрийн тоглолтыг аймгийн төв номын сан дээр зохион байгуулж уншигч хүүхдүүйн хүртээл болголоо.
- ❖ МУИС-н салбар сургуулийн эрдмийн сарын хүрээнд эдийн засгийн болон шинэ ном сурталчилах ажлыг зохион байгууллаа.

Үйлчилгээний орчинг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ

Үйлчилгээний таатай орчин, хөнгөн шуурхай байдлыг хангах, мэдээллийн орчин үеийн олон талт үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх, байгууллагын дотоод тохижилт, техник хэрэгслэлийн хангамж гэсэн 2 үндсэн чиглэлээр жил бүр тодорхой ажлуудыг төлөвлөн өөрсдийн болон бусад байгууллагаас дэмжлэг авахын зэрэгцээ өөрсдийн нөөц бололцоог нэмэгдүүлэх замаар шийдвэрлэж ирлээ.

Ном зүйн ажлыг компьютертэй хослуулан ном зүйн лавлагааны чиглэлээр төрөл бүрийн мэдээллийн сан байгуулан иргэдэд үзүүлэх мэдээллийн үйлчилгээний чанар, хөнгөн шуурхай байдлыг сайжрууллаа.

Хамтын ажиллагааны талаар:

Мэдээллийн үйлчилгээний хүрээг өргөжүүлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад бусад сургууль олон нийтийн байгууллагатай хамтрах, тэдний дэмжлэгийг авахад анхаарч соёл мэдээллийн үйлчилгээний ажлын үр өгөөж дээшилж манай байгууллагын нэр хүнд өсөж байна.

Хүний нөөцийн талаар:

Мэргэжлийн боловсон хүчиний мэргэжил боловсролыг дээшлүүлэх чиглэлээр номын сангийн нийт ажилтан албан хаагчдыг 2 баг болгон хувааж номын сангийн мэргэжлийн хичээлийг хуваарь гарган нөгөө багтаа зааж хэвшүүллээ. Мөн аймгийн хэмжээний сумын номын санчдыг МҮНСан дээр, сургуулийн номын санчдыг ХНОрдон дээр мэргэжил дээшлүүлэх ажлыг амжилттай зохион байгууллаа.

Санхүү эдийн засгийн нөөцийг сайжруулах хүрээнд:

Аймгийн төв номын сан 2010 онд 60,310,000 төгрөгийн төсөвтэй ажиллан зардлыг зүйл бүрээр нь зохих журмын дагуу зарцуулан өр авлаггүй ажиллаж, өөрийн орлогын 1,000,000 төгрөгийн төлөвлөгөөг 1,872,500 төгрөгөөр буюу 187%-р

давуулан биелүүлж, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг ханган амжилттай ажиллалаа.

Хоёр. Соёл урлагын салбарын бодлогын хэрэгжилт

- Уншлага үйлчилгээний зэрэгцээ компьютер техникийн хүчин чадалд тулгуурлан мэдээллийн олон талт үйлчилгээг иж бүрэн үзүүлэн ажиллаж байна.
- Боловсон хүчний хувьд Соёлын дээд сургуулийн номын сангийн анги төгссөн мэргэжлийн шинэ боловсон хүчнийг түшиглэн эдийн засаг, англи хэлний мэргэжилтэй хүмүүсийг номын сан мэдээллийн ажилд мэргэшүүлэх замаар мэдээллийн шинэ нөхцөл, орчинд ажиллах өндөр боловсрол, мэдлэгтэй мэргэжилтэн бэлтгэх ажлыг зохион байгуулж байна.
- Фондын баяжилтанд зориулсан төсөв хөрөнгийн жил бүр батлуулан жилд 2,5 сая төгрөгийн ном хэвлэл авч фондоо баяжуулж байна.
- Материаллаг нөхцөл, техник хэрэгслийн хангамжийг сайжруулах талаар жил бүр тодорхой ажлууд төлөвлөн хэрэгжүүлж үйлчилгээний тав тухтай орчинг бүрдүүллээ.

Гурав. Соёл урлагийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагаа

А/Төрөөс баримтлах соёлын бодлогын үндсэн чиглэлийн хүрээнд

- Үндэсний соёлоо эрхэмлэн дээдлэх, эрүүл аж төрөх чиглэлээр ардын ёс заншил, аман зохиол, үндэсний дуу хөгжмийг сурталчилсан уралдаан тэмцээн, өдөрлөг зохион байгуулах, номын үзэсгэлэн гаргах ажлыг 23 удаа зохион байгууллаа.
- Байгууллагын үйл ажиллагааг хэвийн хэмжээнд явуулах зардлын төсвийг зохиож холбогдох байгууллагад хүргүүлж батлуулан зохих журмын дагуу зарцууллаа.
- Хүн амын соёлын хэрэгцээг хангахад хэвлэл мэдэллийн байгууллагуудтай нөөц бололцоогоо хамтран ашиглах талаар тогтсон арга хэлбэрийн ажлуудыг хамтарч зохион байгуулж байна.

Монгол улсын соёлын тухай хуулийн хэрэгжилт:

А/ Монгол улсын засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан номын сангийн талаарх зорилтын биелэлт

Д/д	Заалт	Биелэлт
3.1	Соёл урлагын байгууллагын бүтэц зохион байгуулалтыг төгөлдөржүүлэх удирдлагыг сайжруулах	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилтуудыг боловсруулан аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт номын санг мэдээллийн төв болгон хөгжүүлэх, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, боловсон хүчний мэдлэг боловсролыг дээшлүүлэх, техник хэрэгслэлийн хангамж, материаллаг нөхцлийг сайжруулах чиглэлээр тодорхой асуудлууд тусгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж өнөөгийн нөхцөлд нийцсэн үйлчилгээний шинэ загвар бүхий мэдээллийн төв болж үйлчилгээний чанар хүртээмж өргөжиж

		хөтөлбөрүүдийн зорилт хэрэгжиж байна.
3.2	Соёл урлагын байгуулагын хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх, давтан сургах тогтолцоо бүрдүүлнэ	Боловсон хүчний мэргэжлийг дээшлүүлэх ажлын чиглэл гарган төвийн болон орон нутгийн хэмжээний сургалтанд нийт номын санчдыг бүрэн хамруулснаас гадна бакалаврын зайны сургалтанд төв номын сангийн 2 номын санчийг сургаж, аймгийн нийт сум болон сургуулийн номын санчдыг Улаанбаатар хотод 5 хоногийн сургалтанд хамруулдаа. Мөн Тэлмэн, Идэр, Шилүүстэй, Отгон сумдын сум болон сургуулийн номын санчдыг өөрийн номын сан дээр сургаж арга зүйн зөвлөгөө өглөө.
3.3	Сумдын номын сангуудын үйл ажиллагааг сэргээж хөдөөгийн хүн амд хүргэх мэдээллийн үйлчилгээний хүрээ хүртээмжийг өргөтгөнө	Тус аймагт нийтийн 24, ЕБС-н 31, дээд сургууль МСҮТ-н 3 бүгд 58 номын сан үйл ажиллагаагаа явуулж байна. 2010 онд хөдөөгийн хүн амд шинэ ном хүргэх ажлыг амжилттай зохион байгуулан 24 сумын номын сангуудад 2009 оны шилдэг ном болох 15 нэр төрлийн 330ш 1786,4 мянган төгрөгийн номыг тараалаа. БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар Отгон, Их-Уул, Ургамал, Нөмрөг, Сонгино зэрэг 5 сумдад нийт 2,337,500 төгрөгийн уншигчийн ширээ сандал хүлээлгэн өглөө.

Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн I хэсэг	
Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд соёлын талаар дэвшүүлсэн зорилтын биелэлтийг дүгнэж түүний хөгжлийн хэтийн төлөвийг тодорхойлж хяналт тавина.	Жил бүр аймгийн ИТХ-аар төсөв батлуулан төсвийг зохих журмын дагуу зарцуулан холбогдох байгууллагуудад тайлан гарган ажиллаж байна.
Соёлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн II заалт	
Соёлын зориулалтаар ашиглаж байгаа төрийн өмчийн барилга байгууламж, эзэмшил газрыг өөр зориулалтаар ашиглах бөгөөд бусдад түрээслүүлэх эзэмшүүлэх асуудлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ	Номын сангийн барилга 1968 онд ашиглалтанд орсон 2 давхар 10 өрөө бүхий барилгыг уншлага мэдээллийн үйлчилгээнд бүрэн ашиглаж байгаа бөгөөд үндсэн чиг үүргээс өөр зориулалтаар ажил үйлчилгээ явагдаагүй болно.
17 дугаар зүйл. Соёлын байгууллагын нийтлэг үүрэг	
1. Соёлын үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд мэргэжил ур чадвар үйлчилгээний өндөр түвшинд явуулах	Монгол улсын засгийн газар орон нутгийн төр захиргааны байгууллагаас хүн амын соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх талаар бодлого чиглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллагын бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгож номын санг

	мэдээллийн төв болгон өргөжүүлж материаллаг бааз техник хэрэгслэлийн хангамжийг сайжруулан интернэтэд холбогдон уншлага үйлчилгээ мэдээллийн ажлыг хослуулан үйлчилгээний дэвшилтэт хэлбэрүүдийг нэвтрүүлэн ажиллаж байна.

Дөрөв. Үндэсний бусад хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан ажил

Үндэсний соёлоо эрхэмлэн дээдлэх, түүнийг залуу үедээ уламжлуулах чиглэлээр ардын ёс заншил, аман зохиол, үндэсний дуу хөгжим, спортыг сурталчилах уралдаан тэмцээн, өдөрлөг зохион байгуулах, номын үзэсгэлэн гаргах ажлыг тогтмол явуулдаг.

Үндэсний бичиг үсгийн баярыг жил бүр 5 сард тэмдэглэж, ховор хуучин номын үзэсгэлэн гаргаж номын тойм хийх, номын худалдаа зохион байгуулахын зэрэгцээ “Монгол бичгээр хэн зөв сайхан бичих вэ?” тэмцээнийг зохион байгууллаа.

Мөн угийн бичиг хөтлөх талаар хүүхэд залуучуудын дунд лекц яриа явуулж үзэсгэлэн гаргах, гарын авлага, самбар гаргах зэргээр сурталчилж байна.

Тав. Бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээний биелэлт

- Мэргэжлийн боловсон хүчний манлайлал, ур чадвар, мэдлэг, ажлын идэвх санаачлагыг дээшлүүлэх чиглэлээр 2010 онд боловсон хүчний мэдлэг чадварыг дээшлүүлэх тодорхой ажлууд төлөвлөн хэрэгжүүллээ.
- Байгууллагын дотоод хяналтын системийг сайжруулах ажлын хүрээнд ажилтнуудын албан тушаалын зааврын хэрэгжилт төлөвлөгөөт зорилтын биелэлт, дээд байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг шалгаж түүний дагуу хяналтыг тогтмол хийж байгууллагын шуурхай зөвлөлгөөнөөр сонсгол мэдээлэл болон ажлын дэг журам хариуцлагын асуудлыг хэлэлцэн ярилцаж, ажлын ололт дутагдалдтухай бүр дүгнэлт хийж дотоод мэдээ судлагааг чанаржуулан ажлын үр дүнгээр нэмэгдэл цалин олгох, мэргэжил боловсролоо дээшлүүлэх талаар онцгой идэвхитэй ажиллаж байгаа мэргэжлийн боловсон хүчнүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүллээ.
- Байгууллагын ажилтнуудтай бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулан улирал тутам дүгнэж, үйлчилгээний чанар үр өгөөжийг сайжруулж өргөжүүлэхэд анхаарч ажиллалаа.

Зургаа. Статистикийн мэдээ гаргах, байгууллагын үйл ажиллагааны явц үр дүнд хяналт шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, тайлагнах чиглэлээр авсан арга хэмжээ

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой дотоод мэдээ судлагааны загваруудыг танхимуудаас ирсэн мэдээнүүдийг нэгтгэх дүгнэхэд хялбар болгоход чиглэсэн нэгдсэн загварыг гаргаж хүн бүрт мэдээлэл судлагааны нэг загварын хавтастай болгон бүртгэлийн үнэн зөв хөтлөлтөнд тогтмол хяналт тавьж гарсан зөрчил дутагдлуудыг байгууллагын шуурхай дээр мэдээлж, сануулж, зөвлөж ажилласнаар мэдээ судлагааны үнэн зөв байдал сайжирч цаг хугацаанд нь аймгийн ЗДТГ-ын статистикийн болон бусад холбогдох хэлтэс тасгуудад хүргүүллээ.

- ✓ Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт түүн дотроо уншигч, ирэгсэд, орлогын төлөвлөгөөг сар улирал жилээр мэдээлэл авч шуурхай

зөвлөгөөн дээр зохих үүрэг даалгаваруудыг өгч ажилласнаар бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээгээ үзүүлэлт бүрээр нь хүрэх түвшинд нь хүргэлээ.

- ✓ Байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгчдээс өгөх үнэлгээг авах чиглэлээр санал асуулга явуулж үйл ажиллагаандаа дүгнэлт хийж байгууллагын тохижилт, уншлага үйлчилгээний хөнгөн шуурхай байдлыг хангах, хэрэгцээт ном мэдээллээр үйлчлэх арга хэмжээг тухай бүрд нь авч ирлээ.
- ✓ Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтыг хангахад номын санчдаас гүйцэтгэж буй үүрэг чиглэлээр нь мэдээлэл, сонсголыг графикаар авч хэлэлцүүлж нийт ажилчдын хурлыг хийж 2010 оны зорилтын хэрэгжилт, цаашдын чиглэлээ тодорхойлон ажиллалаа.

ОРХОН АЙМГИЙН НОМЫН ТӨВИЙН 2010 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Орхон аймгийн номын төв нь 2010 онд уншлага үйлчилгээг нэмэгдүүлэх, номын санчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, цахим номын фондыг болон уншлага үйлчилгээний цэгийг нэмэгдүүлэх зорилтыг тавьж ажиллалаа.

Номын төв нь уншлага үйлчилгээ, мэдээлэл сурталчилгаа, чөлөөт цагийн чиглэлээр Нийтийн танхим, Хүүхдийн танхим, Гэр бүлийн танхим, Гэрээр ном олголтын танхим, Лавлагаа-мэдээллийн танхим, виртуаль-гадаад хэлний танхим, интернет-номын худалдаа, салбар номын сан гэсэн 8 танхимаар нэг зэрэг 180 гаруй хүнд үйлчилгээ үзүүлэх тохилог орчин бүрдүүлэн мэдээллийн үйлчилгээ үзүүлж байна.

Нэг. Уншлага үйлчилгээ

Аймгийн номын төв нь 6800 уншигчдад буюу давхардсан тоогоор 62006 ирэгсдэд 131831 ном олгосон байна. Уншлагын танхимаар нь задалвал:

№	Уншлагын танхимууд	Уншигч	ирэгсэд	олголт
1	Нийтийн уншлагын танхим	2040	18080	28111
2	Хүүхдийн уншлагын танхим	3800	27334	74650
3	Виртуаль-Гадаад хэлний уншлагын танхим	410	3800	4500
4	Гэр бүлийн уншлагын танхим	250	11280	23000
5	Салбар номын сан	300	1512	1570
	Нийт	**6800**	**62006**	**131831**

Сүүлийн 3 жилтэй харьцуулвал:



Уншлага үйлчилгээний цэгийг нэмэгдүүлэх, иргэдэд хүрч үйлчлэх зорилт тавьж ажилласны үр дүнд "Гэр хорооллыг олон нийтийн оролцоотой хөгжүүлэх" төслөөс Дэнж багт салбар номын сан байгуулан ажиллах дэмжлэг авч 2011 оны 1-р сараас нээн ажилуулах гэж байна.

Хоёр. Номын фондын баяжилт, бүтэц зохион байгуулалт

Номын төвийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, уншигч үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан ном хэвлэлийг татан авч, тэдний санал хүсэлт, захиалганд тулгуурлан фондын номын баяжилт хийж, номын сангийн стандарт шаардлагын дагуу номыг бүртгэж, номын бүрэн бүтэн байдлыг хангаж хянаж ажиллахад оршино.

2010 оны 9 сард улсын төсвөөс 2533000 төгрөг өгснөөр 2009, 2010 онд шинээр гарсан зарим нэгэн номоор фондоо баяжуулж уншигчиддаа өргөн барьсан. Гэвч номын үнэ ихээр өсөж байгаа өнөө үед уншигчийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан номыг олон нэрийн нэг ширхэгтэй ном авснаар номын сангийн фондонд хадгалах, урагдаж алга болсон номыг нөхөн сэргээж гаргах зэрэг номын сангийн фондын үйл ажиллагааны горим ихээр алдагдаж байна.

2010 онд өөрсдийн нөөц бололцоо, уншигчдын тогтмол хэвлэлийн судалгаанд тулгуурлан жилд 2 удаа 15 нэрийн 397200 төгрөгний хэвлэл захиалгыг хийж уншигчдад үйлчилж байгаа хэдий ч хүүхдийн хэвлэл огт гаргахгүй болсон эсвэл шаардлага хагасан хүүхдийн унших сонирхолтой сэдэвтэй сонин гарахгүй байгаа нь харамсалтай байна.

2010 оны фонд бүрдүүлэлт:

№	Ямар журмаар ирсэн	нэр	ширхэг	Төгрөг
1	Бэлгийн журмаар	18	20	104300
2	Хандиваар	18	33	158800
3	Худалдаж авсан	248	343	2520285
	Нийт дүн	284	396	2783385

Дээрх 284 нэрийн 396 номонд техник ажиллагаа хийж электрон катологит бүртгэн авч уншлагын танхимуудад хувиарлалт үйлчилгээнд гаргасан байна.

Гурав. Лавлагаа, номзүй

Боловсрол, соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтыг биелүүлэх хотын хүн амын өдөр тутмын өсөн нэмэгдэж байгаа мэдээллийн хэрэгцээг бүрэн дүүрэн хангах тэдэнд мэдээлэл өгөх бүрэн хэмжээний лавалгаа номзүйн аппараттай болж орон нутгийн хүн амыг үйлчилгээндээ бүрэн хамруулахад байгууллага иргэдэд лавалгаа мэдээллээр үйлчлэх зорилттой үйл ажиллагаа явуулж ирсэн.

- Лавлагаа номзүйн өрөөг шинээр байгуулж засвар үйлчилгээ хийж тохижуулсан.
- Номзүйн фондын 485 номын котологийг шинэчилсэн.
- Төрөл анги, үсэг дараалын ангийн каталогийг шинээр хэвлэж гаргасан.
- Орхон аймгийн 35 жилийн ойд зориулан орон нутгийн номзүйг хийж байна. Үүнд:

  -111 байгууллага, аж ахуй нэгжид бүтээлийн жагсаалт хүргүүлэх албан тоот хүргүүлсэн.

  - Нийт 81 нэрийн 209 багц сонинг шүүж ярилцлага, нийтлэл, түүх сөхвөл, үндсэн чиглэл, сурвалжлага, тэмдэглэл, хөтөлбөр, хөрөг, шүүмжлэл, илтгэл, дурсамж, тодруулга, яруу найраг , мэдээ мэдээлэл, эрдэм шинжилгээний бүтээл гэсэн 18 бүлэг болгон хуваасан ангилсан.

- Шинэ номын нээлт 2 удаа хийсэн. /Зохиолч Д.Энхтуяа “Дэлбээлж амжаагүй цэцэг” , Д.Пүрвээ “Үлэмжийн цагаан бороо” /

Дөрөв. Номын сангийн үйлчилгээ, автоматжуулалт

Мэдээллийн эрин зуун дахь технологийн шинэчлэлт нь уламжлалт номын сангийн үйл ажиллагааны орчинг өөрчлөн шинэчилж, нэг талаас сан хөмрөгийг хэрэглэгчдэд хүртээмжтэй болгохын хамт нөгөө талаас технологийн дэвшил ашиглан хялбар, хурдан шуурхай үйлчлэх боломжийг номын санд нээж байгаа билээ.

Аймгийн номын төв нь Бүх номоо электрон катологит оруулан үйлчилж байна. Мөн хайлтын 2 компьтерийг коридорт байрлуулж уншигчдынхаа хэрэгцээг хангаж байна. 2010 оны 1-сарын 1-нээс пластик уншигчийн үнэмлэх хэвлэж өгч эхэлсэн.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 3180000 төгрөгөөр номын сангийн LIB4U программын шинэчлэгдсэн хувилбарыг авч суулгуулсан. Мөн БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 3,6 сая төгрөгийн техник хэрэгсэл ирсэн.

Номын төв нь http //www.orkhon-library.mn вэйб сайттай болсон.

Тав. Соёл олон түмний ажил

СОТА нь хүүхэд багачууд уншигчдыг номонд дуртай болгох, ном хэвлэл, мэдээллийн нөлөөг дээшлүүлэх, олсон мэдлэгээ бататгах, нийгэм олон нийтийн ажилд оролцох идэвхи санаачлагатай болгох, өөртөө итгэлтэй нээлттэй болгох ач холбогдолтой. Номын төвөөс 2010 онд 80 удаа соёл олон түмний ажил явуулж 4464 хүнийг хамруулсан байна.

Агуулгаар нь авч үзвэл:

- Зан заншил

- Байгаль экологи
- Эрүүл мэнд
- Танин мэдэхүй
- Уран зохиол
- Бусад

СОТА явуулсан төрлөөр нь авч үзвэл:

- Эссэ зохион бичлэг -4 удаа
- Гар зургийн уралдаан -11 удаа
- Асуулт хариулт /АХА/- 22 удаа
- Зохиолч уулзалт ярилцлага-2
- Уншигчийн бага хурал – 2 удаа
- Мэтгэлцээн – 5 удаа
- Номын баяр -23 удаа
- Бусад – 11

Дээрх соёл олон түмний ажилд нийт 1541450 төгрөгийн зардал гарснаас хандиваар 778600 төгрөг, байгууллагаас 762850 төгрөг зарцуулсан байна.

- Хөгжлийн бэршээлтэй 46 хүнд 64 номоор үйлчилсэн байна.
- Зөөврөөр албан байгууллага, сургууль цэцэрлэгт давхардсан тоогоор 109 байгууллагад 1011 нэрийн 2161 ширхэг номоор 2862 хүнд үйлчилсэн.
- Номын төвөөс 2010 онд номын тойм 107 удаа, Чанга уншлагыг 42 удаа, үлгэрийн цагийг 23 удаа явуулж 4502 хүүхдийг хамаруулсан байна.
- Номын төвийн үйл ажиллагааны талаар FM -16 удаа, ТВ-43 удаа , сонин-9 удаа, бусад- 6 буюу нийт 74 удаа орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагаар мэдээ мэдээлэл өгсөн байна. Мөн номын төв нь 74 удаа 2752 номоор үзэсгэлэн гаргасан. /СОТА-ийн мэдээг хавсралтаас үзнэ үү/

Зургаа. Тохижилт үйлчилгээ

- Хувцасны өлгүүрийг үүдний өрөө рүү нүүлгэж лавлагаа номзүйн өрөөг засвар хийж тохижуулсан.
- Шатны хажуу талд вакум шилэн хорго хийж байрлуулсан.
- 1 давхарын коридорт “Монголын нууц товчоо”, “Морин хуур”, “Нум сум”–ыг вакум шилэн хорго хийж залсан.
- 2010 оныг аймгийн ИТХ-аас “Цэвэр орчин бүрдүүлэх жил” болгон зарласантай холбогдуулан байгууллагын гадаад үзэмжинд нилээн анхаарч ажиллаж байна. Байгууллагынхаа ар талд 70 м^2 хайлсыг 836000 төгрөгөөр хийлгэн будаж 49600 төгрөгийн согоо үр цацан зүлэгжүүлж хүн бүр нэг мод тарьж суулгасан.
    - Гадна зүлэг талбайг услах зорилгоор 50 метр 50000 төгрөгөөр шаланк авч усалгаа хийж байгаа.
    - “Цэвэр орчин бүрдүүлэх жил”-ийн ажлын хүрээнд зохион байгуулсан аж ахуйн нэгж байгууллагуудын мод тарихад 20м^2 газарт 160 ширхэг шар хуайсийг 160000 суулгаж тарьсан.
    - Бүх нийтийн их цэвэрлэгээнд 4 удаа гарч байгууллагынхаа орчин тойронг цэвэрлэсэн.

Долоо. Хүний нөөц, шагнал урамшуулал

- 2010 оны 5 сард УБ хотын Соёлын дээд сургуулийг 6 хүн номын санч-мэдээллийн ажилтанаар бакалавр зэргээр төгссөн. Мөн УУА-ны дарга

Н.Отгонцагаан СУИС-ийн Соёлын сургуулийн номын сангийн удирдлагын магистрт сурч байна.

- Мэдээллийн ажилтанг сонгон шалгаруулалт зарлан шалгалт авч ажиллуулж байна.
- Яамны, орон нутгийн тамгын газрын болон бусад газрын шагналаар байгууллагын ажилчдын ажилласан жил, үр бүтээлтэй ажиллаж байгаа зэргийг харгалзан 2010 оны соёл урлагийн ажилтны өдрөөр Соёлын тэргүүний ажилтнаар номын санч Ш.Гарамханд, БСШУЯ-ны жуух бичгээр үйлчлэгч Ц.Оюунчимэг, засаг даргын жуухаар номын санч Д.Отгонцэцэг, аймгийн ИТХ-ын шагналаар үйлчлэгч П.Даарийжав, Баян-Өндөр сумын ИТХ-ын шагналаар номын санч Д.Мөнгөнцэцэг, Хүүхдийн төлөө хэлтсийн алтан медалиар номын санч С.Доржбат тус тус шагнагдсан байна.
- Засгийн газрын 2010 оны 239 дүгээр тогтоолыг үндэслэн ажиллагсдын цалинг 10-р сарын 01-нээс 30 хувиар, Засгийн газрын 90 дүгээр тогтоолыг үндэслэн мэргэжлийн номын санчдын цалинг 08 сарын 01-нээс 8 хувиар тус тус нэмэн олгож байгууллагын захиргааны зүгээс ажилчдын нийгмийн тал дээр анхаарч ажиллалаа.
- Улирал хагас жилийн ажлын явцыг дүгнэн давхардсан тоогоор 22 хүнд ..... сая төгрөгийн үр дүнгийн нэмэгдэл, дотоод журмын дагуу 3 хүнд 200,0 төгрөгний буцалтгүй тусламж тус тус олгосон байна.

Найм. Бичиг хэрэг, архив

- Албан бичиг тоот гаднаас 51 авч, хариутай бичиг хугацаанд нь шийдвэрлэж 61 албан тоот гадагш нь явуулж, байгууллагын даргын тушаал 33 гаргаж хэрэгжилтийг хангуулан ажиллаа.
- Иргэдээс 13 өргөдөл, санал хүсэлт бичгээр авч асуудлыг хугацаанд нь шийдвэрлэсэн.
- Байгууллагын зорилт, чиг үүрэг, ирээдүйн дүр төрхийг тодорхойлон харуулсан түүхчилсэн лавлагааг шинээр бичиж, баримтын тооллогын хуудас, байнга болон түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүрдлийг тус бүр бүрдүүлж аймгийн архивын газарт шинээр хавтас нээн бүрдүүлж өгсөн.
- Архивын нөхөн бүрдүүлэлтийн эх үүсвэр болох байгууллага түүний зохион байгуулалтын нэгж, бие даасан хөмрөг үүсгэдэггүй, удирдах дээд шатны байгууллагад баримтаа шилжүүлдэг харьяа газруудын архивын үйл ажиллагааг автоматжуулах , хөмрөг, данс, хадгаламжийн нэгж, баримтын түвшин, мэдээллийг бүртгэж архивын мэдээллийн сан үүсгэх зорилго бүхий архивын програмыг 200,0 төгрөгөөр авч суурилуулсан.
- Аймгийн архивын газраас зохион байгуулсан архивын талаарх сургалтанд нарийн бичигээ 3 удаа хамруулсан.

Ес .Бусад

- ЕБС болон соёлын төвүүдийн номын санд БСШУЯ-наас ирсэн хандивын номуудыг бүртгэж авсан байдал, номын сангийн анхан шатны бүртгэлүүдийн хөтлөлт дээр хяналт шалгалт хийсэн.
- Соёлын хүрээлэнгийн доктор проффесор Ж.Цэзэн болон МҮНС-ийн ахлах арга зүйч Б.Энхжаргал нарын авчиран “номзүйн” чиглэлээр сургалт авсан.

- Баян-Өндөр сумын ИТХ-аас гаргасан уриалгын дагуу зуданд нэрвэгдсэн малчдад ажилчдаас 47000 төгрөг, аймгийн бүтээн байгуулалт буюу цэнгэлдэх хүрээлэнгийн ажилд ажилчдаас 110000 төгрөгийн хандив тус тус өгсөн.
- Аймгийн музейн өдөрт зориулсан АХА тэмцээнд 2-р байр эзэлсэн.
- Аймгаас зохион байгуулсан цасны баяраар спортын уралдаан тэмцээнд 18 байгууллага оролцсоноос 6-р байранд шалгарсан.
- Аймгийн ҮЭ-ийн холбооноос зохион байгуулсан гар бөмбөгийн тэмцээнд идэвхтэй оролцсон.
- Аймгийн Засаг даргын нэрэмжит гар бөмбөгийн тэмцээнд эмэгтэй баг тусгай байр эзэлсэн.

Номын баяр сарын аян

Номын төвийн дэнж дэхь салбарын нээлт

Хэн хуулиа сайн мэдэх вэ? СОТА /МСҮТ оюутанууд/

Нээлттэй хаалганы өдөр /Хивсний үйлдвэр/

Цэцэрлэгтэй хамтран явуулсан АХА тэмцээн

Үзэсгэлэн худалдаа

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2010 ОНЫ ТАЙЛАН

Аймгийн төв номын сан нь 2010 онд Аймгийн Засаг даргатай бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээг байгуулан уншигчдад ном хэвлэлээр үйлчлэн тэдний боловсрол мэдлэгийг дээшлүүлж орчин үеийн мэдээллээр шуурхай хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа. 2010 онд Захирал 1, Номын санч мэдээллийн ажилтан 4,фондч 1, катологич номзүйч 1, үйлчлэгч нярав 1 гэсэн 8 орон тоотойгоор 42066 сая төгрөгний төсөвтэйгээр, Боловсрол танхим, Хүүхдийн уншлагын танхим, Гэрээр ном олгох танхим, Гадаад мэдээллийн танхимуудаар дамжуулан уншлага үйлчилгээ явуулж ажиллалаа.

Аймгийн төв номын сан нь байгууллагын хэмжээнд мөрдөгдөх хууль эрх дотоод журмын дагуу үйл ажиллагаагаа явуулж ирлээ.

- Аймгийн төв номын сангийн үлгэрчилсэн дүрмийг мөрдөн ажиллаж байна.
- Аймгийн төв номын сангийн дотоод журманд нэмэлт өөрчлөлт оруулж мөрдлөгө болголоо.
- Аймгийн төв номын сангийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулсан.
- Ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээг байгуулан ажиллаж байна.
- Боловсрол танхим, Хүүхдийн уншлагын танхим, Гэрээр ном олгох танхимын үйл ажиллагааг сайжруулж уншигчийн картны үнийг шинэчлэн тогтоолоо.
- Ирсэн явуулсан баримт бичгийг цаг тухайд нь бүртгэж, холбогдох албан тушаалтанд өгч, албан бичгийн хариу өглөө.
- Байгууллагын архивын бичиг баримтыг эмхлэн цэгцэлж, хадгаламжийн нэгж болгон хадгалж байна.

- "Алдагдсан буюу гэмтээгдсэн номыг төлүүлэх журам", буюу "Аймаг нийслэлийн номын сангийн үлгэрчилсэн дүрэм"-ийг уншигчдад танилцуулан ажиллаж байна.

<u>Номын санчдын мэргэжлийг дээшлүүлэх талаар</u>

Аймгийн төв номын сан нь номын санчдынхаа мэргэжил боловролыг дээшлүүлэх талаар нэлээд анхаарч ажиллалаа.

Өөрийн аймгийн Баянгол сумын номын сангийн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах сургалтанд бүрэн хамрагдсан. "Номын сан мэдээллийн төв" сургалтыг Аймгийн Боловсрол соёлын газрын мэргэжилтэн Л.Пүрэвлхам

санаачлан Улаанбаатар хотын Үндэсний номын санд зохион байгуулж 40 цагийн сургалтанд хамрагдлаа. Сургалтанд "номын сангийн анхан шатны бүртгэл", "каталоги зохион байгуулалт", "интернет ба компьютер", "программ хангамж" "Номын сангийн ангилал", "Номын сангийн үйл ажиллагааны стандарт" гэх мэт сэдвүүдээр хичээл орлоо.

Хүүхдийн номын ордон, Үндэсний номын сангийн үйл ажиллагаатай танилцан, мэргэжил арга зүйн заавар зөвлөгөө авч, номын санч мэдээллийн ажилтнуудад шинээр гарсан хууль дүрэм болоод зөвлөмжийг танилцууллаа.

Мөн ШУТИС -ийн салбар Өвөрхангай аймаг дахь Технологийн Сургууль болон орон нутагт үйл ажиллагаа явуулагч программ хангамжийн компани ДевСофт ХХК-ний хамтран боловсруулсан орон нутагт мэдээллийн технологийг хөгжүүлэх зорилго бүхий "Нээлттэй аймаг" хөтөлбөр, тус хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих "Бүс нутгийн мэдээллийн төв" төслийн танилцуулга сургалтанд номзүйч Б.Жаргал хамрагдлаа.

Соёл урлагийн хороо, Үндэсний номын сангаас зохион байгуулсан "Номын яармаг" арга хэмжээний хүрээнд зохиогдсон сургалт сурталчилгааны арга хэмжээнд фондоч О.Долгормаа оролцлоо.

Сумдын номын санчидтай байнгын харилцаатай байж Хужирт, Өлзийт, Зүйл сумдын номын санчдад каталоги зохион байгуулах талаар гарын авлага бэлтгэж хүргүүллээ. Мөн Гучин-Ус, Төгрөг, Баруунбаян-Улаан сумдын номын санчдад арга зүйн зөвлөгөөг өгч ажиллалаа.

Уншлага үйлчилгээний талаар

Номын сан нь уншигчдын эрэлт хэрэгцээг хангах.номын фондын эргэлтийг хурдасгах,мэдээллийг түргэн шуурхай хүргэх зорилгоор Боловсрол танхим, Гэрээр ном олгох танхим, Хүүхдийн уншлагын танхим, зөөврийн үйлчилгээний хэлбэрүүдээр 667 уншигч 8546 ирэгсэд, 28100 ном олгож уншигчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэн үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна. Фондын эргэлт 55 %-тай байна. Боловсрол танхим нь уншигч хэрэглэгчдэд үйлчилгээг шуурхай болгохын тулд ойрын фондын номыг уншигчдын эрэлт хэрэгцээт номоор хангах талаар судалгаа хийж, судалгааны дагуу ойрын фондоо баяжуулж байна.

Аймгийн төв номын сан нь хандив буюу бэлгийн журмаар 2597600 төгрөгний 406 ш ном хэвлэлээр фондоо баяжуулж уншигчдад үйлчилгээ үзүүлж байна.

Үндсэн фондноос Боловсрол танхимын ойрын фондонд 147ш, захиалгаар 72 ш ном, Гэрээр ном олгох танхимын ойрын фондонд 46ш ном, захиалгаар 88

ш ном, Ирээдүй танхимын ойрын фондонд 93 ш ном олгож үйлчилгээ явуулсан байна.

Бичиг үсгийн Үндэсний өдрийг тохиолдуулан "Хүн бүр номтой нөхөрлөе " 10 хоногийн аяны хүрээнд "Цэвэр сайхан бичигтний уралдаан", "Алдаагүй зөв бичигтний уралдаан", "Үндэсний монгол бичгээ дээдлэе" номын үзэсгэлэн , "Өвөрхангайг хэн сайн мэдэх вэ?" танин мэдэхүйн “АХА” тэмцээн, Хувийн номын сан шалгаруулах, Тэргүүний уншигч хамт олон шалгаруулах , 1-7 —р ангийнхны дунд " Номын сан -миний гэр" сэдэвт зохион бичлэгийн уралдааныг зохион байгууллаа. Мөн хүүхдийн уншлагын "Ирээдүй" танхимаас "Номын анд" гэсэн 3 сарын аяныг зохион явуулж "Тэргүүний уншигч анги хамт олон" , "Бүтээлч уншигч", "Идэвхтэй уншигч"-ийг тус тус шалгаруууллаа. Уншигчдын шинэ жилийг зохион байгуулж Д.Нацагдорж тэмдэгтний болзол хангасан тэргүүний уншигчдад шагнал гардуулах “Номын анд" аяны хүрээнд шалгарсан тэргүүний анги хамт олон болон шилдэг уншигч сурагчдад шагнал гардуулах үйл ажиллагаа явагдлаа. Уг арга хэмжээ нь олныг хамарсан шинэлэг соёл олон түмний ажил болсон бөгөөд Хүүхдийн уншлагын номын санч С.Энхтогтох, Боловсрол танхимын номын санч А.Цэрэндэгд, Гэрээр олгох танхимын номын санч Ч.Хоролгүр нар санаачлан идэвхтэй зохион байгуулсан байна.

Шинэ ба сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 11 удаа гаргаж 628ш номыг уншигчдад сурталчилсан байна. Татгалзлын дэвтэр хөтлөлтийн дагуу уншигчдын эрэлт ихтэй доорхи номуудаар фонд баяжилт хийлээ. Тухайлбал;

1.Багабанди гуайн " Титэм үг" 2.
Оюунгэрэлийн " Ногоон нүдэн лам" 3."
Чонон сүлд" 4."Охьүгс"

5."Цэцэн мэргэний толь" 6."
Оюун ухааны фитнесүүд"
7."Ижиидээ захидал бичээрэй"

8. Шүүдэрцэцэгийн "Сэтгэлийн анир , Сувдан дараулга ,Туужууд" Э."Хөх судар" гэх мэт номнуудаар уншигчдын эрэлт хэрэгцээг хангалаа.

Цаашид зөвхөн шинэ ном төдийхөн биш фондонд байгаа олны хүртээл болсон хуучны романуудыг сурталчлан үзэсгэлэнд гаргах нь уншигчдыг татах давуу талтай.

Боловсрол танхимаас "Танил ертөнц" сонинд Өвөрхангай аймгийн төрийн шагналт зохиолчдын намтар уран бүтээлээс нь цуврал гаргаж сурталчилж байгаа нь мэдээллийг хүргэх зөв аргыг сонгож авсан нь харагдаж байна.

Хүүхдүүдээр уншсан номын үйл явдлыг дүрслэн зурах сэтгэж наах, цаасаар урлах зэрэг уралдааныг явуулж уншигч хүүхдүүдийн "Уран сэтгэмж" бүтээлүүдийг танхимд байрлуулсан байна.

Шинээр ирсэн 406ш номонд техник ажиллагаа хийж, номын нэг бүрчилсэн бүртгэл дансанд авч, номзүйн бичилтийг хийж катологжуууллаа.

Мэдээлэл танин мэдэхүйн самбарт 38 сэдвээр мэдээлэл бичиж олны хүртээл болголоо. Иргэдэд шинэ номын болон бусад холбогдох мэдээллийг лавлагаа ном зүйн хэлбэрээр өгч ажиллаа. 125 хүнд мэдээлэл ном зүйн үйлчилгээ үзүүллээ.

Гэрээр ном олгох танхим ба Ирээдүй танхим нь номын тооллогыг 2 удаа хийж, номын дутагдалгүй ажиллаж байна.

Ажилчдын хоолны мөнгө 1920000 төгрөг, өвлийн түлш авахад нь зориулж 440000 төгрөгний буцалтгүй тусламж үзүүлсэн байна.

Байгууллагын гаднах цэцэрлэгт талбайд хайлаас, улиас зэрэг 25 ширхэг мод тарьж уншигч үйлчлүүлэгчдэд таатай орчин бүрдүүллээ.

Үндсэн фонд болон танхимуудын ариутгалыг мэргэжлийн байгууллагуудаар 2 удаа хийлгэж цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийлгэж байна. Мөн урагдаж гэмтсэн болон уншигчийн буруугаас ашиглах боломжгүй болсон 1354 номонд сэлбэн засалт хийж үйлчилгээнд гаргалаа.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2010 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Тус номын сан нь нийт 10924 иргэсэд, байнгын 11056 уншигчдад 33635 номоор номын сангын үйлчилгээг үзүүлсэн байна. Мөн 2526000 төгрөгний 371 ширхэг шинэ ном худалдан авч фондын баяжилт хийгдлээ. Интернэтийн болон компьютерийн төлбөртэй болон төлбөргүй сургалтанд нийт 34 хүнийг хамруулжээ. 2010 онд нийт 1400000 төгрөгний орлоготой ажиллалаа .

Хүүхдийн уншлагын танхим

1. ХУТ-ын төлөвлөгөөт ажлын талаар

Уншигч 500

Ном олголт 11440

Ирэгсэд 5396

2. Уншлага үйлчилгээ мэдээлэл

2010 онд уншигч үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор бага ангийн сурагчдад ангиудад урилгат үйлчилгээг илүүтэй явууллаа.Нийт 5 ангид урилга өгч 200 гаруй хүүхэд хамрагдлаа.

- Нэгдсэн цэцэрлэгүүдээс 11,24,2-р цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн хүүхдүүдийг номын сантай танилцуулж ХУТ-аар үйлчиллээ.

- Шинэ номын мэдээ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг нийт 6 удаа гаргасан байна.

4-р сургуульд зөөврийн номын санг 1 удаа 25 номоор ажиллуулав.

1. Нийт 56 номоор
2. Англи номын үзэсгэлэн 15 номоор
3. Үлгэрийн баатрууд үзэсгэлэн 56 номоор
4. “Сургуульд ормогцоо үзээрэй” сэдэвт танин мэдэхүйн холбогдолтой цуврал 8 номоор сэдэвчилсэн үзэсгэлэн
5. “Чингис хаан” цувралаар түүхийн сэдэвт үзэсгэлэнг 20 номоор “Орос ардын үлгэрүүд” сэдвийн дор хуучин номуудаар үзэсгэлэн 25 номоор тус тус гаргалаа

3. СОТА-ын талаар

3-р сургуулийн 3г ангид уншлагын семинар зохион байгуулж явууллаа. Нийт 16 хүүхэд хамрагдсан. “Бидний ирээдүй хүүхэд” сэдэвт Хүүхдийн байгууллагын цомын аялалд Номын сангийн ажилчдын хүүхдүүдийн дунд Ардын уламжлалт тоглоом наадгай, оньсого таавар хосолсон уралдаан тэмцээнийг Номын санч Алтанцэцэг, мэдээллийн ажилтан Одончимэг нартай хамтран зохион байгуулав.

Улсын хэмжээнд 3 сарын хугацаатай зарлагдсан “Номын анд” уралдаанд бага ангийн сурагчдыг хамруулж ажилласнаас 2-р сургуулийн 2б ангийн Гантулга бага ангийн сурагчдын ангилалд 2-р байранд орж өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдсан.

Нийтийн уншлагын танхим

1. **Уншлага үйлчилгээ , ном олголт**

Уншлагын танхимаас 270 уншигчдад карт нээж 3040 ирэгсэдэд 15470 ном олгож үйлчиллээ. Уншигчдын эрэлт хэрэгцээг хангах, номын фондын эргэлтийг хурдасгах, мэдээллийг түргэн шуурхай хүргэх зорилгоор орос, англи, монгол сонин сэтгүүлээр фондоо баяжуулан номын сан, мэдээллийн төв чиглэлээр ажиллаж байна.

2. **Ном хэвлэл сурталчилах**

Анги хамт олны дунд хамтын уншлага зохион явуулж 203 хүнд сурталчлав. Шинэ номын үзэсгэлэнг 4 удаа 120 ширхэг номоор , сэдэвчилсэн үзэсгэлэнг Боловсрол-2010 41 ширхэг номоор, Төрийн шагналт соёлын гавъяат зүтгэлтэн Б.Явуухулангын уран бүтээл 40 ширхэг номоор , Ногоочдод зориулан Хүнсний ногоо үзэсгэлэнг 41 ширхэг номоор, Номын аяны хүрээнд заавал унших номуудаар үзэсгэлэн гаргаж сурталчилав.

3. **СОТАжлын талаар**

Үндэсний бичиг соёлын хишиг өдөрт зориулан МУ-ын шилдэг номнуудаар үзэсгэлэн гаргаж 51 ширхэг ном сурталчиллаа. Номын анд аяны хүрээнд А.Гайдарын “Чук Гек 2 “ зохиолоор сурагчдын дунд уншлагын танхимдаа дүрийн тоглолт хийж 63 хүн оролцов.

Мөн аяны хугацаанд “4Н” багийн гишүүд “3 тоорой” үлгэрээр хүүхэлдэйн тоглолт хийж сурагчдад сурталчилав. Энэ арга хэмжээнд орлоцсон бага хамт олонд тусалж оролцуулав.

Говь фестиваль арга хэмжээний үеэр танхимдаа үзэсгэлэн гаргаж хуучин бар бичмэл, ховор номуудаар үзэсгэлэн гаргаж сурталчилсан.
Орон нутгийн иргэдийн хурлын материалаар номын үзэсгэлэн гаргаж хууль эрх зүйн мэдээллийг уншигчдад өгөх, интернэт мэдээллийг хүргэх зорилготой ажиллаж ирлээ.

4. Лавлагаа ном зүй

Лавлагааны баяжилтаа сайжруулж орос, англи монгол номоор фондоо баяжуулж дэлхийн хэмжээний толь бичиг, МУ-ын 108 боть , шинжлэх ухааны салбаруудын номууд, улс төрийн мэдээллээр тус тус номзүйн бүртгэл гаргав.

МУ-ын УЗ-ын товчоо 9 боть ном, Р.Ганбатын 8 боть номонд тус тус санамж өгөх ном зүйг хийж уншлага үйлчилгээнд гаргав.

Гэрээр ном олгох тасаг

№	Үзүүлэлт	Нийт тоо
1	Байнгын уншигч	108
2	Ирэгсэд	2488
3	Ном олголт	6290

- Фондоос шинэ ном хүлээн авч, шинэ номын үзэсгэлэнг тухай бүрд нь гаргаж уншигчдад танилцууллаа. Номын үзэсгэлэнд 11 удаа нийт 263 ширхэг номоор үзэсгэлэн гаргав
- Урагдаж гэмтсэн номуудыг тухай бүрд нь сэлбэн засалт хийж ажиллалаа.Нийт 248 ш номыг сэлбэн засав
- Өрөөндөө мэдээллийн самбар гаргаж үйлчилгээний үнийн тариф, тухайн хугацаанд үйлчлүүлсэн уншигчдын судалгаа, шинэ номын жагсаалт, шинэ номын зурагт сурталчилгаа, уншигчийн эрх үүрэг, номыг дээдлэх ёс, алдагдсан буюу гэмтээгдсэн ном хэвлэлийг төлүүлэх журам, уншигчдад санамж , Д.Нацагдорж тэмдгийн болзол зэргийг бичиж мэдээлэв.
- Шинэ номын болон ГНОТ-ын танилцуулга хийж албан байгууллагуудын мэдээллийн самбарт тавьж олон нийтэд танилцууллаа.

Зохион явуулсан соёл олон нийтийн ажил

1. Нүүдлийн номын сан

Өмнөговь аймгийн төв номын сангийн захиргаа ГНОТ, 24-р цэцэрлэгийн захиргаатай хамтран Зөөврийн номын сан ажиллуулах гэрээ байгуулан тус гэрээний дагуу Зөөврийн номын санг цэцэрлэгийн эмч Ш.Мөнхзул ажиллууллаа. 15 хоногт 1 удаа номын сангаас шинэ номуудыг хүлээн авч уншиж ашигласан номын тайлан тооцоог тогтмол хийж хүлээлцэв. Нийт 11 удаагийн номын сангийн үйлчилгээгээр 205 ширхэг ном хүлээн авч 18 уншигчийг шинээр бүртгэн 365 ширхэг ном олгож үйлчиллээ. Багш ажилчид уншсан номын тэмдэглэл хөтөлж сурган хүмүүжүүлэх холбогдолтой сэдвүүдийг сонгон ярилцлага хийж цэцэрлэгийн насны хүүхдүүдийн цээжлэх дуу шүлэг зэргийг гарын авлага, сургалтын материал хийхэд ашиглав.

2. **2010/5/26 Монгол зан үйл аман зохиолын хэлхээ “ сэдэвтэй тэмцээн**

“Хүүхдэд ээлтэй орчин” ажлын хүрээнд байгууллага дээрээ 5р ангиас доош насныхан дунд “Монгол зан үйл аман зохиолын хэлхээ “ сэдэвтэй тэмцээн зохион явуулж морь уралдуулангаа, монгол ардын оньсого, зүйр цэцэн үг, түргэн хэллэг хэлж наадлаа. 2-р ангийн сурагч Мягмар тэргүүн байр эзэлж дурсгалын зүйл үнэ бүхий зүйлээр шагнууллаа.

3. **Номын анд уралдаанд оролцов.**

Сурагчдын зуны амралтыг тохиолдуулан АНУ –ын Хүүхдийн байгууллагын монгол дахь төлөөлөгчийн газар, Хүүхдийн номын ордоноос зохион явуулсан “ 4 –Н “уралдаанд ахлах ангийн сурагчдын” 4-н “ багийг бүрдүүлж удирдан амжилттай оролцож улсын хэмжээнд багаараа 1-р байр эзлэн алтан медаль, цом, өргөмжлөл бусад зүйлээр шагнууллаа. Тус уралдаанд оролцогчид багаараа хамтран олон сонирхолтой ажлуудыг зохион байгууллаа. Үүнд: 2010 оны 6 сарын 20 ноос - 8сарын 15

1. Сургуулийн бага ангийн сурагчдыг номтой нөхөрлүүлэх, тэднийг номонд дуртай болгох, гадаадын хүүхдийн сонгодог уран зохиолтой танилцуулах зорилгоор “ Гурван тоорой” зохиолоор хүүхэлдэйн тоглолт хийж бага ангийн сурагчдад үзүүллээ.
2. Мөн 1-5 сурагчдад “ Долоон бор оготно”,” Өнчин цагаан ботго”,” Болдоггүй бор өвгөн”, ”Эвтэй дөрвөн амьтан”, ”Шаазгайн үлгэр”, ”Тэмээ үнсэн дээр хөрвөөх болсны учир” Гадаадын хүүхдийн уран зохиолын шилдэг бүтээл болох “Улаан малгайт”, “Гуталт Муур”, ”Алтан загасны үлгэр”, ”Бөгтрөгтэй морьхон”, ”Алтан түлхүүр буюу Буратиногийн адал явдал” зохиолуудар чанга уншлага 3 удаа хийж өгөв. Нийт 62 сурагч хамрагдлаа .
3. Аркадий Гайдарын зохиол Чук Гек хоёр зохиолоор жүжигчилсэн тоглолт хийж 1--5 ангийн нийт 21 сурагчдад сонирхууллаа.
4. “НОМ” сэдэвт илтгэлийн аймгийн төв номын сангийн уншлагын танхимд сурагчдад хийлээ. Мөн уншсан номын талаарх сэтгэгдэлээр хүүхэд бүр эссэ бичив.
5. Эзэн чингис хааны хөрөг зээгт наамалыг сурагч Нандинцэцэг урлан бүтээв.
6. Габирэль Гарсиа Маркесийн “Зуун жилийн ганцаарал” зохиолыг уншиж зохиолын гол баатруудын ургийн бичиг гаргав.
7. Гадаадын болон монголын шилдэг зохиолчдын төлөөлөгчидтэй танилцан, намтар уран бүтээлээр бүтээлийн сан хийлээ.
8. “Жонон гуйлгачин хоёр“ зохиолоор хөдөлгөөнт зурган бүтээл хийж сурагчидад танилцуулав.
9. Л.Түдэвийн “Хорвоотой танилцсан түүх “ туужаар бүтээлийн сан гаргав.
10. “Амьддаа бие биеэ хайрла” үсгэн хайчилбар цуглуулан зурагт бяцхан ном хийлээ.
11. Монголын нууц товчоо болон Ч. Лодойдамбын “Шаргачин “ өгүүллэгээр тус тус уншин танилцаж зурагт бүтээлийн сан хийв.
12. Л.Түдэвийн “Эрхий дарам зай” өгүүллэгээр жижиг бяцхан ном хийсэн
13. “Шадар гурван цэрэг” зохиолоор Хүүхэд танин мэдэхүйн сэдэвт “ Та битгий уурлаарай “ бүтээв
14. Тусгаар тогтнол “ Есөн эрдэнийн орон, Миний нутаг шүлгүүдийг уран уншиж CD- нд бичүүлэв.

Номын анд уралдаанд оролцогч 4-Н багийн үйл ажиллагааны хэсгээс

Багийн хамт олон номын санчтайгаа Гурван тоорой зохиолоор үлгэрчилсэн хүүхэлдэйн тоглолт

4-Н Багийн гишүүдийн үйл ажиллагааны хэсгээс

4. Номын сангийн мэдээлэл сурталчилгааны өдөрлөг

Номын сангийн мэдээлэл сурталчилгааны өдөрлөгийг 2010-9-23 наас 29 хооронд аймгийн төвийн ЕБСургуулиуд дээр очиж зохион байгууллаа.

9/23 нд Даланзадгад сумын 11 жилийн 4-р сургууль дээр Хөгжил мэдээллийн төвийн ажилтан Одончимэгтэй хамтран номын сан сурталчлах өдөрлөг зохиов.

- Үүнд: Номын сангийн үйл ажиллагааны танилцуулга
- Номын үзэсгэлэн сурталчилгаа
- 1-5 ангийн сурагчдын дунд "Хэн таах вэ?" тэмцээн
- Бага ангийн сурагчдад тойм яриа, чанга уншлага хийж үлгэр ярьж өгөв
- Гадаадад тэтгэлэгт хөтөлбөрөөр суралцах боломж лекц
- Номын сангаас зохион байгуулсан "Номын анд" уралдаанд оролцогч сурагчдын хийсэн бүтээл шагналаар үзэсгэлэн гаргаж тус тус сурталчиллаа.

Бага ангийн сурагчдыг номтой нөхөрлүүлэх ардын аман зохиолоос сурталчлан таниулах зорилгоор 3в ангид "Монгол ардын аман зохиолын сэдэв"-р тэмцээн явуулахад 3в анги Золбаяр тэргүүлж дурсамжийн зүйлээр урамшуулав. Мөн тойм яриа, 1 жүжигчилсэн чанга уншлага хийж өгөв.

\9/25 Даланзадгад сумын 1 болон 7 багийн өдөрлөгт оролцож шинэ номын үзэсгэлэн гарган номын сангийн танилцуулга сурталчилгаа хийж үйлчиллээ.

Багийн өдөрлөгт очиж мэдээлэл сурталчилгаа хийв.

9/23 4-р сургуулийн зааланд Номын сангийн мэдээлэл сурталчилгааны өдөрлөг

9/27 3-р сургуулийн Хүүхэд хөгжлийн төвд номын сангийн мэдээлэл сурталчилгааны өдөрлөг

9/28 2-р сургуулийн номын санд номын сангийн мэдээлэл сурталчилгааны өдөрлөг

9/29 1-р сургуулийн номын санд номын сангийн мэдээлэл сурталчилгааны өдөрлөг тус тус зохион явууллаа.

Багш сурагчид номын үзэсгэлэн сонирхож байгаа нь :

Бага ангийн сурагчдад үлгэр ярьж өгч байгаа нь:

5.Сэдэвчилсэн болон шинэ номын үзэсгэлэн

1.1/12 Төрийн соёрхолт зохиолч Лодонгийн Түдэвийн зохиол бүтээлийн үзэсгэлэн - 32 номоор гаргав.

2.2/4 Хүүхдийн уран зохиолын номын үзэсгэлэнг - 24 ширхэг номоор гаргав.

3.3/12 ”Амжилтанд хүрэхийн нууцаас “сэдэвчилсэн үзэсгэлэн -30 ш номоор

4.4/16 “Эрүүл амьдарч урт удаан наслахын нууцуудаас“ сэдэвчилсэн үзэсгэлэн- 28 ш номоор

5.5/5 “Монгол романууд “ 24 ш номоор

6.6/25 Номын анд уралдаанд оролцогчдод зориулан заавал унших эх зохиолуудаар үзэсгэлэн -32 ширхэг номоор

7.9/8-9 Говь фестивалийг тохиолдуулан "Өмнөговь аймгийн зохиолчдын зохиол бүтээлээс" сэдэвт - 32 ширхэг номоор үзэсгэлэн гаргав.

8. 9/15 Бага ангийн сурагчдад зориулсан номын үзэсгэлэн 22 ш номоор

10/10 Гадаадын зохиолчдын адал явдалт 24 романуудаар

11/8 Шелдон, Агата Кристагийн 15 номоор тус тус 11 үзэсгэлэн гаргаж сурталчиллаа.

Хөгжлийн Мэдээлэл –Сургалтын төв

Интернэт, компьютер болон Мэдээллийн үйлчилгээ

2010 онд нийт 721 хүнд 463900 төгрөгийн компьютер болон интернэтийн үйлчилгээ үзүүлж 250 орчим иргэд, үйлчлүүлэгчдэд мэдээлэл лавлагаа өгч ажиллаа.

Номын сангийн уншлага үйлчилгээ

Уншигч -38

Ирэгсэд -132

Ном олголт -159

Иргэний нийгмийн өдрийг угтаж иргэний нийгмийнхэнд зориулсан 31 ном гарын авлагаар сэдэвчилсэн үзэсгэлэнг гаргаж үйлчиллээ.

Сургалт

Тайлангийн хугацаанд нийт интернэтийн болон компьютерийн төлбөртэй болон төлбөргүй сургалтанд нийт 34 хүнийг хамрууллаа. Төлбөрт сургалтын орлого 280000төгрөг.

Иргэний нийгмийн байгууллагынхныг чадавхижуулах зорилгоор интернэтийн сургалтыг үнэ төлбөргүй зохион байгууллаа.

Аймгийн Ус цаг уур орчны албаны ажилчдад Интернэтийн анхан шатны сургалт зохион байгууллаа. Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоотой хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд компьютерийн анхан шатны 14 хоногийн сургалтыг үнэ төлбөргүй зохион байгуулж хөгжлийн бэрхшээлтэй 5 иргэнийг хамрууллаа.

Мөн дотоод ажилчид болон гадны хүмүүст төлбөртэй 14 хоногийн компьютерийн сургалт зохион байгууллаа.



Мэдээлэл сурталчилгаа

1. **"Номын анд" улсын уралдаанд баг идэвхжүүлж оролцуулав**
   Номын анд улсын уралдаанд багийн төрөлд 1,2-р сургуулийн ахлах ангийн сурагчдыг идэвжүүлэн баг болгон оролцуулж уншигч олон түмэнд хандсан арга хэмжээнүүдийг зохион байгуулж амжилттай оролцсон.
2. **Говь фестиваль арга хэмжээний үеэр номын үзэсгэлэн гаргаж олон нийтэд үйлчлэв.**
   Хөгжлийн мэдээллийн төвд ирсэн шинэ ном, англи хэлний ном хэвлэлээр шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн
3. **Тэтгэлэгт хөтөлбөрийн мэдээлэл**

   Хөгжлийн Мэдээлэл сургалтын төвийн Боловсролын Зөвлөгөө Мэдээллийн төвтэй хамтрах ажлын хүрээнд 9 сараас хойш 3 тэтгэлэгт хөтөлбөрийн мэдээллийг олон нийтэд мэдээллийн самбараар болон мэйлийн лист ашиглан хүргэж ажиллалаа.

4. ***Аймгийн төвийн 4 сургуулиар мэдээллийн өдөрлөг зохион байгуулав***
   9-р сарын 23-27 ний өдрүүдэд төвийн 4 сургуулиар номын сангийн үйлчилгээ ном хэвлэлийг сурталчилсан өдөрлөгийг зохион байгуулж газар дээр нь ном олгох, карт нээх, мэдээлэл зөвлөгөө өгөх, хүүхдүүдийг идэвхжүүлэх авхаалж сорих тэмцээн зохион байгуулж ажиллаа.
   Мөн энэ үеэр Номын анд улсын уралдаанд Тэргүүн байр эзэлсэн багийн хүүхдүүдийн бүтээлийн үзэсгэлэнг давхар гарган хүүхэд багачуудад ном унших ач холбогдолыг таниулж ажилалаа

4-р сургууль

9-р сарын 23-ны өдөр номын сангийн өдөрлөг арга хэмжээг зохион байгуулан сурагчдад номын сангийн үйлчилгээний журам, үйл ажиллагааны мэдээг танилцуулан бага ангиудад Хэн таах вэ? Хэн унших вэ? тэмцээн зохион байгуулж шагнаж урамшуулав.

3-р сургууль

9-р сарын 27-ны өдөр өдөрлөг арга хэмжээг зохион байгууллаа.

2-р сургууль

9-р сарын 28-ны өдөр өдөрлөг арга хэмжээг зохион байгууллаа.

1-р сургууль 9-р сарын 29-ны өдөр өдөрлөг арга хэмжээг зохион байгууллаа.



Багийн иргэдийн хурал дээр номын үзэсгэлэн гаргаж номын сангийн үйл ажиллагаа, үйлчилгээний талаар мэдээлэл хийв.

9-р сарын 25 ны өдөр 1,7–р багийн иргэдийн хурал дээр номын сангийн үйлчилгээ, сүүлийн үед хийгдэж байгаа иргэдэд хандсан үйл ажиллагааны тухай мэдээлэл хийж номын сангийн Хөгжлийн мэдээлэл сургалтын төв болон гэрээр ном олгох танхимын сүүлийн үед ирсэн шинэ номын үзэсгэлэн гаргав

Дэлхийн банк, Нээлттэй нийгэм форум, БЗМТөвтэй хамтрах ажлын хүрээнд

Дэлхийн банктай хамтрах ажлын хүрээнд:

Өмнөговь Аймгийн Хөгжлийн сургалт-мэдээллийн төвөөс “1-р сарын 31 Иргэний нийгмийн өдөр”-ийг угтаж иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг болох дараах сургалт үйл ажиллагааг зохион байгууллаа.

1. Дэлхийн банкны хөгжлийн мэдээлэл, Онлайн мэдээлэл ашиглах арга барил эзэмшүүлэх сургалт

Энэхүү сургалтаар төвийн болон Дэлхийн банкны үйл ажиллагаа, вэб хуудсыг танилцуулж, интернэт ашиглан хөгжлийн мэдээлэл хэрхэн олж авах талаар заалаа. Сургалтанд 10 иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл хамрагдлаа.

Сургалтуудын үеэр Иргэний нийгмийнхэнд зориулсан ном гарын авлагаар үзэсгэлэн гаргалаа.

Мониторинг хийх аргачлалын сургалт

Энэхүү сургалтыг НДЭХөдөлгөөний Өмнөговь аймаг дахь салбар зөвлөлийн тэргүүн, ИНБайгууллагын сүлжээний зохицуулагч С.Энэбишийг урьж заалгалаа. Сургалтаар мониторинг хийх аргачлалыг Энэбиш өөрийн хэрэгжүүлсэн мониторингын ажлууд дээрээ жишээ тайлбар гарган сонирхолтой хэлбэрээр зохион байгууллаа. Сургалтанд 11 хүн хамрагдлаа.

4-р сарын 13-18-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохиогдсон Дэлхийн банкны Мэдээллийн төвүүдийн ээлжит уулзалт семинарт дарга Б.Батсаруулын хамт

оролцож төвийнхөө өнгөрсөн хугацаанд хийсэн ажлыг танилцуулж цаашид ажиллах төлөвлөгөөний талаар мэдээлэл хийлээ.

Энэ үеэр тус мэдээллийн төвд нэн шаардлагатай, уншигчдын эрэлт хэрэгцээ бүхий шинэ номын жагсаалт гарган Дэлхийн банкинд өгч 6-р сарын эхээр шилдэг борлуулалт бүхий 30 номыг хүлээн авч Сан хөмрөгийн номын санч Ч.Түвшинжаргалд ажиллагаа хийлгэхээр хүлээлгэн өглөө.

Нээлттэй Нийгэм форумтай хамтрах ажлын хүрээнд:

1-р сард. Нидерландын Вант Улсын Засгийн Газрын Итгэлийн Сангийн дэмжлэгээр Монгол орны байгаль орчны засаглалыг бэхжүүлэх, хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн менежментийг сайжруулах зорилгоор Дэлхийн Банк болон Монгол улсын Байгаль Орчны Яам хамтран “Байгаль Орчны Шинэчлэл–2” төслийн хүрээнд зааглагдсан жижиг төслийн материалыг 42 иргэн, албан байгууллага, сумдад түгээв. Мөн энэхүү жижиг төслийн тэтгэлгийн талаар мэдээлэллийг сонирхогч иргэдэд Аймгийн БОАЖ-ын албатай хамтран өгөв.

БЗМТөвтэй хамтрах ажлын хүрээнд:

Тус төвөөс зарлагдсан сургалтын тэтгэлэгт хөтөлбөрүүдийг сонирхогч иргэдэд сурталчилж ажиллаа.

- Мөн уг БЗМтөвийн санхүүжилтээр өөрийн төвийн 5 компьютерт Bitdefender 2010 вирусны эсрэг программ худалдан авч суулган төвийн компьютеруудын хэвийн ажиллах боломжийг бүрдүүллээ.

4-р сард USAP тэтгэлэгт хөтөлбөрийг орон нутагт зарлаж олон нийтэд танилцуулсан бай энэхүү ажлын хүрээнд БЗМТөвийн зохицуулагч, багш 2 ажилтан ирж аймгийн төвийн 4 арван нэгэн жилийн сургуулийн 10,11-р ангийн сурагчид, МСҮТөвийн сурагчдад

- Америкийн боловсролын систем болон тэтгэлэгт хөтөлбөрүүдийн талаар мэдээлэл өгч лекц зохион байгууллаа.
- 2010 оны 5-р сарын 5-ны өдөр АНУ-ын элчин сайд ноён Жонатан Эдлтонг бусад төлөөлөгчдийн хамт хүлээн авч төвөө танилцуулан олон нийтэд хандсан лекцийн үйл ажиллагааг зохион байгууллаа.



- БЗМТөвийн дэмжлэгтэйгээр хүүхэд залуучуудын англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх зорилгоо англи хэлтэй /subtitle-тай үзэх боломж бүхий/ 15ширхэг DVD кино хүлээн аваад байна.
- USAP тэтгэлэгт хөтөлбөрийн 1-р шатанд манай аймгийн 2-р сургуулийн 10-р ангийн Б.Отгонтуяа, М.Алтанцэцэг нар шалгарч 2-р шатны Mock TOEFL шалтгалтыг төв дээрээ анх удаа зохион байгууллаа. Уг сурагчид 2-р шатанд тэнцээгүй хэдий ч нилээд боломжийн оноо авч цаашид TOEFL шалгалт албан ёсоор өгөх боломжтой юм байна гэдгийг ойлгож авсан сайхан ажил боллоо. USAP тэтгэлэгт хөтөлбөрт 1-р шатанд амжилттай оролцсон 2 сурагчдаа АНУ-ын боловсролын төвийн гарын бэлгээр шагналаа.
-

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2010 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Засгийн газрын болон Аймгийн Засаг даргын “2008-2012” оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх Засаг даргатай 2010 онд байгууллагын үр дүнгийн гэрээнд тусгагдсан Номын сангийн үйлчилгээг өргөжүүлэх, мэдээ мэдээллийг цахим хэлбэрээр хүргэх, номын сангийн ном хэвлэлийг сурталчлах, номын фондыг баяжуулах ажлыг оны эхнээс тусгай төлөвлөгөө гарган хамт олны хурлаар хэлэлцэж мөрдөж ажиллалаа.

Уншлага үйлчилгээ:

Уншлага үйлчилгээний үндсэн зорилтууд бүрэн хангагдан үйлчилгээний таатай орчин бүрдэн ажиллалаа. 2800 хүнд карт нээж, 23600 хүнд 35300 ном хэвлэлээр үйлчиллээ. Өөрийн байрнаас гадна ЕБС-иуд болон Техникийн Их сургууль, албан байгууллага дээр зөөврөөр ном хэвлэлээр үйлчлэх ажлыг 10 удаа зохион байгуулж 350 номоор 800 хүнийг хамарлаа. Хөгжлийн бэрхшээлтэй 12 хүнд 57 удаа гэрээр болон танхимаар 125 ном хэвлэлээр үйлчиллээ. Хүүхдийн амралтын үеэр орон сууцны хүүхэд, багачууд, оршин суугчдад 4 удаа 100 гаруй хүнд уншлага үйлчилгээ зохион байгууллаа.

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт	Үнэлгээ	
					Хувь	Оноо
0		2	3	4	5	6
1.	**Уншигчийн ирц**	25555	23600	845	103.3%	100
2.	**Ном олголт**	34883	35300	417	101.2 %	100
3.	**Номын фондын баяжилт**	41206	42021	815	103.2	100
4.	**Төлбөрт үйлчилгээний орлого**	300.0	1.100.0	800	303.6 %	100

Аймгийн Нийтийн номын сан нь Хүүхдийн зуны амралтыг үр бүтээлтэй өнгөрүүлэхэд чиглүүлсэн Америкийн 4-Н нь байгууллагын Монгол дахь салбараас явуулж байгаа “Номын анд” уралдаанд байгууллага хамт олноороо сайн зохион байгуулан оролцсоны дунд Хүүхдийн уншлагын танхимаас багаар болон ганцаарчилсанаар 15 хүүхэд оролцож нийт 3 хүүхэд шагнал байранд орлоо.

Үүнд:

10-н жилийн дунд сургуулийн 9 д ангийн сурагч Нарандэлгэр 1-р байр. “Алтан медаль”, мөнгөн шагнал.

Тэмүүлэл цогцолбор сургуулийн 2 г ангийн сурагч Г.Сумъяагарав 1-р байр “Алтан медаль”, өргөмжлөл, мөнгөн шагнал,

Д.Сүхбаатарын нэрэмжит 10 жилийн дунд сургуулийн 9ё ангийн сурагч Б.Эрдэнэжаргал 3-р байр, мөнгөн шагнал, өргөмжлөл,

Хүүхдийн уншлагын номын санч Б.Сумъяа өргөмжлөл, мөнгөн шагналаар тус тус шагнагдсан.

Соёл олон түмний ажил:

Хүүхэд залуучуудын дунд зохиох соёл олон түмний ажлыг албан байгууллага, ЕБС-иуд, багийн иргэдийн дунд зохион байгуулан байгууллагын хаяг, мэдээлэл сурталчилгаа, үйлчилгээний тухай гарын авлага тараан зөөврийн номын сан ажиллуулсан. Мөн Сүхбаатар нутгаас төрсөн эрдэмтэн, зохиолч уран бүтээлчдийн номын дээжис, "Үндэсний хувцсаараа гоёцгооё", Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулсан үзэсгэлэн, Их дээд сургуульд элсэгчдэд, ЕБСургууль төгсөгчдөд гэх мэт нийт 25 удаа 1742 номоор үзэсгэлэн гаргахад 16035 хүн хамрагдсан.

Мөн бид "Жанжин Сүхбаатарын удмынхан" уулзалт, ярилцлагыг Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газар, Парчиндүг төвийн тэргүүн Цамбанүрдэвтэй хамтран зохион байгуулахад 1-р 10-н жилийн дунд сургуулийн 5-6-р ангийн сурагчид оролцов.

Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэний болзол шалгаруулах уралдаанд нийт бага, дунд, ахлах ангийн 41 сурагчид оролцсоноос "Тэмүүлэл" цогцолбор сургуулийн 9-р ангийн сурагч Б.Дулмаа, Сүхбаатарын нэрэмжит 10 жилийн дунд сургуулийн 10-р ангийн сурагч Б.Нарандэлгэр, Тэмүүлэл цогцолбор сургуулийн 5-р ангийн сурагч Ч.Хулан, Б.Минж, Г.Азням нар шалгарлаа.

Д.Нацагдоржийн зохиолоор ном зүйн бүртгэл гаргахаас гадна 2007-2009 оны "Д.Нацагдорж тэмдэгтэний болзол хангасан сурагчдын бүтээлийн үзэсгэлэн гаргаж, 100 гаруй сурагчид үзэж сонирхлоо.

-Их зохиолч Д.Нацагдоржийн "Хуучин хүү" өгүүллэгээр "Тэмүүлэл" цогцолбор сургуулийн Сэлэнгэ багштай 4г ангийн сурагчид дүрийн тоглолт гаргаж нийт 50 гаруй сурагч үзэж сонирхов.

-Номын сэдэвчилсэн үзэсгэлэнг Уншлагын танхим, Гэрээр ном олгох, Хүүхдийн танхимаас тогтол гаргаж ирсэн. Номын үзэсгэлэнг:

- ✓ Ховор үнэт номын үзэсгэлэн
- ✓ Их жанжин Д.Сүхбаатар-номын ертөнцөд
- ✓ Сар шинийн баяр-Цагаан сар
- ✓ Олон улсын эмэгтэйчүүдийн баяр
- ✓ Монголын зэвсэгт хүчин
- ✓ Дэлхийн яруу найргийн өдөрт
- ✓ Монгол хүн сансарт
- ✓ Дэлхийн эрүүл мэндийн өдөрт
- ✓ Сувилахуйн ухаан-Сувилагчдын өдөрт
- ✓ Америкийн хүүхдийн уранзохиол
- ✓ Олон улсын хүүхдийн баярт
- ✓ Их дээд сургуульд элсэгчдэд
- ✓ Ногоон гаригаа хамгаалъя
- ✓ Бичил зээл
- ✓ Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт зохиолчдын бүтээлүүд
- ✓ Англи хэл сурцгаая
- ✓ Үндэсний бичиг үсгийн баярт
- ✓ Америк орноор
- ✓ Д.Нацагдоржийн уран бүтээл тухай нийтдээ 2530 номоор үзэсгэлэн гаргаж нийт 5 удаа номзүйн мэдээлэл, шинэ номын тойм 1 удаа гарсан.

Их танхимд Болор цом, Соёл урлаг 2008-2012 он, Соёл урлагийн байгууллагуудын хууль эрх зүйн булан, бусад хууль тогтоомжуудыг нийт иргэдэд тогтмол сурталчилж байна. 1360 хүн хамрагдсан. Хүүхдийн бага танхимд "Номын ертөнцөөр аялцгаая" сурталчилгааны зурагт булан хийж, танин мэдэхүйн "Оюуны хөтөч", хүүхдийн зохиолч Г.Ловорын амьдрал уран бүтээлээр Сониучхан, "Шинэ нийгмийн-Шинэ хүүхэд, Өсвөр үе -Эрүүл мэнд зэрэг сурталчилгааны самбаруудыг тогтмол гаргаж хэвшсэн.

"Монгол бичиг үндэсний хөтөлбөр 2"-ийн хүрээнд номын фондонд байгаа хуучин үнэт ховор номуудыг сурвалжлан олж уншлагын танхимд нэрсийн жагсаалт гарган иргэдэд сурталчлахаас гадна хөдөө сумдын номын сангуудад "Монгол бичиг үндэсний хөтөлбөр" –2 материалыг хувилан тараасан.

Уйгаржин монгол бичгийн уран бичлэгийн таталбарын уралдаанд түрүүлсэн бичмэл үгсийг жаазлан уншлагын танхимд байрлуулан сурталчилж байна.

2010 оны 1 сараас эхлэн ажилчдын ажлын төлөвлөгөөг жил, улирал, сараар батлан хяналт тавьж ажиллаж хэвшлээ. Ажилчдын ажил үйлчилгээний чанарт анхаарал тавьж санал хүсэлтийн хайрцаг уншигчдын дунд аялуулж байна. Соёл үйлчилгээний цэгийг уншигчдын эрэлт хэрэгцээг ханган таатай орчинг бүрдүүлэхэд зориулан тогтмол ажиллуулж байна.

Номын санг автоматжуулах ажлын хүрээнд:

- Аймгийн засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээнд тусгагдсан номын сангийн үйл ажиллагааг автоматжуулах, номын санд орчин үеийн үйлчилгээ нэвтрүүлэх зорилгоор "Lib-4U" программыг авч дотоод сүлжээнд холбогдон фондын 4000 номыг программд орууллаа. Улаанбаатар хотын номын сангуудын цахим үйлчилгээ программ хариуцсан "Волвейс" компанийн инженер М.Гантулга гэрээний дагуу ирж программын сургалтыг аймаг, сум, сургуулийн номын санчдын хэмжээнд зохион байгуулж сум, сургуулийн нийт 33 номын санч хамрагдаж цахим каталогт ном оруулах дадлага ажил хийж мэдлэг боловсролоо дээшлүүлж, арга зүйн зөвлөгөө авч, сертификат олголоо. Энэ арга хэмжээнд Боловсрол Соёлын газрын дарга Сэнгэдорж, Нийгмийн бодлогын дарга Б.Буянтогтох оролцов.

Цахим сургалт-2010 сургалтын үеэр сумдын болон сургуулийн номын санчдын дунд мэргэжлийн сэдвээр АХА тэмцээн зохион явуулахад Асгат сумын сургуулийн номын санч шалгарч мөн сургалтын дараа цэнгүүн зохион байгуулан мэргэжил нэгт номын санчид бие биетэйгээ танилцаж ажлын арга туршлага, санаа бодлоо хуваалцаж, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд үр дүн үзүүлсэн чухал ажил боллоо. Нийт 40 гаруй соёлын ажилчид оролцлоо.

-Бүртгэл мэдээллийн албанаас интернэтээс болон төрөл бүрийн CD-ний тусламжтайгаар уншигчдад электрон хэлбэрээр мэдээ мэдээлэл авах орчин бүрдүүлэн ажиллаж байна.

Ном зүйн мэдээллийн ажлын хүрээнд:

Сүхбаатар нутгийн эрдэмтэн зохиолч, яруу найрагчид-ын уран бүтээлээр ном зүй, "Болор цомын жил жилийн тэргүүн байрын шагналтнууд, Эргэн дурсахуй - Монгол Улсын Төрийн шагналт яруу найрагч О. Дашбалбар, Их зохиолч Д.Нацагдорж гэх мэт сэдвээр ном зүйн үзэсгэлэн гаргаж сурталчлахад нийтдээ 3000-4000 гаруй хүн хамрагдлаа.

-Сүхбаатар аймгийн вэб сайтад гэрээ хийн өөрийн байгууллагын үйл ажиллагааны талаар улирал тутамд сурталчилдаг боллоо. Д.Нацагдоржийн түүвэр, зохиолын эмхэтгэл, Тунгалаг Тамир, Заан Залуудай роман, Шилмэл өгүүллэгүүд, Монголын өгүүллэгийн цоморлиг, Монголын шилдэг яруу найраг, Сүмтэй будрын чулуу, Монголын шилдэг өгүүллэг, Монголын нууц товчоо, Цахилж яваа гөрөөс, Хүүхдийн зохиолуудаар мэдээлэл лавлагаа өгч 250-300 гаруй уншигч хамрагдлаа.

-Төсөв болон хандиваар ирсэн номонд “Шинэ номын тойм мэдээ”- г тогтмол гаргаж ажилчин албан хаагчид уншигчид, иргэдийн цаг хугацааг хэмнэх зорилгоор мэдээлэл хүргэж хэвшлээ.

Номын сангийн фонд:

Монгол Улсын болон дэлхийн эрдэмтэн мэргэдийн бүтээсэн соёлын үнэт өв болох ном судрыг хадгалан хамгаалах хойч үедээ өвлүүлэн үлдээх олон нийтэд дэлгэрүүлэн сурталчлах, олон талт ажлыг зохион байгуулан фондын хадгалалт хамгаалалтыг сайжруулан ажиллаж байна. Фондын бүрдүүлэлтийг хийхдээ уншигчдын санал хүсэлтийг харгалзан фондын эргэлтийн судалгаан дээр тулгуурлан тухайн үеийн болон нөхөн бүрдүүлэлтийг хийж байна.

2010 оны фондын баяжилт

д/д	**Нэр**	**Төрөл**	**Тоо ширхэг**	**Үнэ**
1.	Төсвөөр	140	386	2.598.0 мян
2.	Хандиваар	87	344	1.597041 мян.
3.	Тогтмол хэвлэл	52	52	481350 мян
	Дүн			4.676.3 мян

Фондын хадгалалт хамгаалалтыг сайжруулахад анхаарч тавиурт байгаа номуудыг 0.5 хувийн формалины уусмалаар арчиж, тоос шороо, нарны гэрлээс хамгаалж хар хөшиг 15 тавиурт хийсэн. Шавьж устгалтын хорыг зохих журмын дагуу хийв. Уншигчийн захиалгын дагуу фондноос 1170 ном гаргаж үйлчилсэн. Фондны чийгшилтийг хэвийн байлгах үүднээс 10 литрийн хэмжээтэй 5 саванд ус хийж 14 хоног тутам сольж хэвшлээ.

Түүх соёлын хосгүй үнэт зүйлсийг хадгалах хамгаалах үүднээс 1500-гаад номыг сэлбэн засаж, хосгүй үнэт 40 номыг стандартын дагуу бүртгэж зурагжуулан Аймгийн бүртгэл мэдээллийн санд оруулав.

Сүхбаатар аймгийн түүх, соёлын холбогдолтой 300 гаруй номыг фондноос түүвэрлэн авч иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулсан нь уншигчдын талархлыг хүлээж байна.

Номын санчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх талаар:

-Аймгийн нийтийн номын сан сумдын болон сургуулийн номын санчдад мэргэжил арга зүйн зүйн туслалцаа үзүүлж 2010 онд өөрийн номын сан дээр 2 удаа номын сангийн сургалтанд хамруулаа.

Аймгийн Нийтийн номын сангийн номын санчид "Цахим сургалт-2010" номын сангийн цогц Lib-4U программ - ын сургалтанд сууснаар өөрийн номын сангийн ойрын фондын номноос эхлэн электрон каталогт оруулж эхлээд байна. Үндэсний бичиг үсгийн баяр 5-р сард, Номын яармаг үзэсгэлэн худалдаа 11- р сарын 7-9 ны хооронд Номын сангийн захирал оролцож , "Номын сангийн өнөө ба ирээдүй" сургалтанд 2 удаа оролцож, Бүртгэл мэдээллийн ажилтан 2008-2010 онд Соёлын дээд сургуулийн интернэтэд суурилсан зайны сургалтын "Номын сан судлал-мэдээлэл"-ийн ажилтны ангид суралцан 2010 оны 5-6 сард бакалавр зэрэгтэй "В" үнэлгээтэй төгссөн.

- Бүртгэл мэдээллийн ажилтан М. Нарангэрэл Хүүхдийн номын ордон дээр ном сэлбэн засалтын 3 хоногийн сургалтанд суусан.

- 2010 оны 1 сард Боловсрол соёлын газар, Угсаатны зүйн музей, Сүхбаатар сумын соёлын төв, номын сантай хамтарч ,"**Соёл урлаг-2010**" сургалтыг зохион байгуулахад нийт 40-50 хүн оролцсон

Аймгийн Нийтийн номын сан дээр номын сангийн үйл ажиллагаатай танилцуулах үзүүлэх сургууль зохион байгуулж бүх сум сургуулийн номын санчдад мэргэжлийн чиглэлээр арга зүйн зөвлөгөө үзүүллээ.

Номын сангийн орчныг сайжруулах үйлчилгээ:

Байгууллагын гадна дотно талыг өнгө үзэмжийг сайжруулж өдөр бүр хлорамины уусмалаар чийгтэй цэвэрлэгээ хийж гадна орчноо цэвэрлэн ажиллалаа. Мөн сар бүрийн 20-нд их цэвэрлэгээг чанартай хийж байна. Уншигчдын санал хүсэлтийн дагуу Нийтийн уншлагын танхим, Гэрээр ном олгох тасаг, Бүртгэл мэдээллийн албанд сантехникийн засвар оруулж дулааны секцийг шинээр нэмж тавих, мөн коридорт дулааны шугамыг гүйлгэж тав тухтай тохилог орчинг бүрдүүллээ. Үүнд 1.500.0 мянган төгрөг зарцуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн зарлигаар жил бүрийн 5-10 дугаар сарын 2 дахь долоо хоногийн бямба гаригийг бүх нийтээрээ мод тарих Үндэсний өдөр болгон зарласан билээ. Үүний дагуу Аймгийн Засаг даргын Тамгын газрын БОАЖГ-аас 5-р сарын 9-нөөс 10-р сарын 1-нийг хүртэл "Төрөлх хотоо ногооруулъя" аяныг зохион байгуулж байна. Энэ аянд манай хамт олон эзэмшил газрынхаа талбайг цэвэрлэн хөрсийг сийрэгжүүлэн 196 м к2 талбайд 10 ширхэг хайлаас мод, 4-5 цэцгийн мандал ургууллаа. Уншлагын заалнуудад 10-15 цэцэг тарьж цэцгийн тавиур шинээр 2 ширхэгийг хийлгэж тохижууллаа.

Хүүхдийн уншлагын бага заалыг "Номын ертөнцөөр аялцгаая" сэдэвт сурталчилгаа мэдээллийн танхим болгон тохижуулж үйлчилгээг өргөжүүлэн ажиллаж байна. Үүнд: Сүхбаатар аймгийн хүүхдийн зохиолч Г.Ловорын уран бүтээлээс "Сониучхан" самбар, номын ашиг тус, үнэт ховор номын дурсгал, Д.Нацагдорж тэмдэгтэний болзол, танин мэдэхүйн сонирхолтой сэдвүүдээр "Оюуны хөтөч" мэдээллийн самбар, Шинэ нийгмийн -Шинэ хүүхэд, Өсвөр үе - Эрүүл мэндэд эмийн хэрэглээ - ний тухай гэх мэт сонирхолтой сэдвүүдээр мэдээ мэдээллийг улирал тутамд шинэчлэн сурталчилж байна.

Аймгийн Нийтийн номын сангийн эдийн засаг , нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт:

Иргэд олон нийтийг өргөн хүрээтэй иж бүрэн мэдээлэлээр найдвартай шуурхай хангах, мэдээлэл технологийн хүчин чадлыг олны хүртээл болгох.

Иргэдийн оюун санааг хөгжүүлэх мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэхэд тэдний өөрсдийн оролцоо, хүчин зүйлийг дайчлах, үүнд чиглэсэн орчинг бий болгоход үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллалаа. Уншлагын үйлчилгээний үндсэн зорилтууд бүрэн хангагдсан үйлчилгээний шинэлэг дэвшилтэт арга хэлбэрүүд амжилттай хэрэгжиж байна.

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт	Үнэлгээ	
					Хувь	Оноо
0		2	3	4	5	6
1.	Уншигчийн ирц	25555	26400	845	103.3%	100
2.	Ном олголт	34883	35300	417	101.2 %	100
3.	Номын фондын баяжилт	41206	42021	815	103.2	100
4.	Төлбөрт үйлчилгээний орлого	300.0	1.100.0	800	303.6 %	100

Сумдын номын сангийн фондын баяжилтыг 192 нэр төрлийн 350 ширхэг 2.200.0 мянган төгрөгийн шинэ номоор баяжилт хийсэн. Сумдын номын сангийн үйлчилгээний хүрээг өргөжүүлэхийн тулд номын сангийн тоног төхөөрөмжийн судалгааг авч Мөнххаан, Уулбаян, Түвшинширээ, Халзан, Онгон сумдад 2.500.0 мянган төгрөгийн уншигчийн ширээ сандлыг БСШУЯ-ны хандиваар Улаанбаатараас татан авчирч хуваариллаа. Мөн Уулбаян, Мөнххаан, Дарьганга сумын номын санчдыг мэргэжил дээшлүүлэха 21 хоногийн сургалтанд хамруулж аймгийн төв дээр нэгдсэн сургалтыг 2 удаа зохион байгуулж арга зүйн зөвлөгөө өглөө.

Мэдээ тайлан хугацаандаа ирүүлэлт

1. Байгууллагын ажилчдын гэрээний биелэлт болон жилийн ажлын төлөвлөгөөний биелэлтийг хагас бүтэн жилээр шалган ур чадвар, урамшуулалтанд өөрчлөлт оруулж жилийн эцсээр нийт ажилчдаар тайлан хамгаалуулж ажлыг дүгнэж хэвшлээ. Мөн жил улирлаар Соёл урлагийн газар, Үндэсний номын сан, Аймгийн Статистикийн газар, СУ-3, СУ-15, СУ-10 мэдээнүүдийг гаргадаг.
2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын статистикийн хэлтэс, хяналт шинжилгээ үнэлгээний газраас сар улирлаар мэдээ тайлан гаргах журмыг хэрэгжүүлж Нийгмийн бодлого хөгжлийн хэлтэст сар бүр, Статистикийн хэлтэст сар, улирлаар тогтмол гаргаж хэвшсэн.

3. Аймгийн Аудитын газар, Нийгмийн даатгалын хэлтэсээс Нийтийн номын сангийн 2008-2009 оны Санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийж эерэг үнэлгээ авсан ба хойшид хийх ажлын үнэтэй санал зөвлөгөө өгсний дагуу холбогдох хууль тогтоомжуудыг судалж ажилдаа хэрэгжүүлж байна.
4. Цаг үеийн ажлаар Аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол соёлын газар, БСШУЯ, Үндэсний номын санд шаардагдсан мэдээ судалгаануудыг цаг хугацаанд гаргаж өгч хэвшсэн.

Байгууллагын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдал

Аймгийн Иргэдийн хурлаас 2010 оныг Хэрэглэгчийн эрхийг дээдлэх жил болгосонтой холбогдуулж уншлагын танхимуудыг “Хэрэглэгч та хаан” уриан доор уншигчийн өдөр тутмын хэрэгцээт номуудаар чөлөөт сонголтын хэлбэрээр номын үзэсгэлэнг 25 удаа гаргаж үйлчилгээг өргөжүүлж байна.

Номын сангийн үйл ажиллагааг иргэдэд нээлттэй болгох үүднээс санал хүсэлтийн дэвтрийг оны эхнээс уншигчдын дунд аялуулж хагас бүтэн жилээр дүгнэж үзэхэд нийт 56 санал ирсэнийг судалж үзэхэд уншлагын танхимуудын халаалт муу, номын санд хэвлэл захиалах сүүлийн үед ирсэн шинэ номуудаар фондоо баяжуулах, мэдээлэл хайлтын танхим байгуулж, интернэтийн үйлчилгээг оюутнуудад хямд өргөн хүрээгээр үйлчлэхийг санал болгосон байлаа. Эдгээр саналыг багцлан авч үзэж энэ онд доорх саналуудыг шийдвэрлэв.

Уншигчдаас санал авахад ЕБС-иудын сурагчид, ТИС-ийн оюутнуудаас үйлдвэрлэлийн технологи, эдийн засаг, банк санхүү, албан байгууллагын ёс зүйн талаар, ядуурлын судалгаа, сурах бичгүүд, төрийн албаны шалгалтанд бэлтгэх гарын авлага, лавлагааны сурах бичгүүдийг нэмэгдүүлэх шаардлагатай байсныг харгалзан үзэж 130 нэр төрлийн 386 номыг “Шилдэг ном-2010” үзэсгэлэн худалдаанаас авч уншлагын танхимуудад гаргалаа. Нийт 2.533.0 мянга мөн 52 нэр төрлийн 481.350 төгрөгийн тогтмол хэвлэлийг захиалан Гэрээр ном олгох танхимд гаргаж үйлчилгээг өргөжүүлэн ажиллаж байна.

Мөн Сүхбаатар аймгийн ард иргэд, хүүхэд багачуудад өв уламжлалаа дээдлэх, хайрлан хамгаалах, сурталчлах зорилгоор “Сүхбаатар аймгийн Түүх соёлын дээж” нээлттэй үзэсгэлэнг 300 гаруй номтойгоор Их танхимд байрлуулсан нь уншигчдын талархлыг хүлээж байна. Албан байгууллагуудтай хамтран ажиллаж Байгаль орчин аялал жуулчлалын газар, Баруун-Урт сумын Иргэдийн Хурал, Нийгмийн даатгалын хэлтэс, Аймгийн Засаг даргын Тамгын газар, Төрийн захиргаа хууль зүйн хэлтэс, Цэргийн хэлтэс, Нээлттэй нийгэм форум зэрэг газруудын үйл ажилагааг олон түмэнд сурталчлахын тулд мэргэжлийн номнуудыг авч үзэсгэлэн гаргаж үйлчилгээгээ өргөжүүлж байна.

Хүүхдийн уншлагын танхимд хүүхдийн эрхийг хамгаалах “Хууль эрх зүйн булан” - г тогтмол ажиллуулж байна.

Сүхбаатар аймгийн вэб сайтад өөрийн байгууллагын түүхэн товчоон 2010 онд хийсэн бүтээлч ажлууд шинэ номын мэдээлэл зэргийг өгч сурталчилгаа тогтмол явуулж байна.

Орон нутгийн телевизүүдээр байгууллагын сурталчилгааг улирал тутам явуулж, Шинэ Сүхбаатар сонинд тусгай нүүр бэлтгэн өгч байгууллагаа сурталчилж байна.

Цаашид хийх ажлын талаар:

-Номын санд цахим үйлчилгээг өргөжүүлэхэд анхаарч “Мэдээллийн нээлттэй төв” болгох зорилт тавин ажиллах болно. Үүнд: компьютер техник хэрэгслийг сайжруулж мэдээлэл хайлт, цахим үйлчилгээний танхим байгуулахад Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсаны дагуу шийдвэрлүүлэх.

-Аймгийн Нийтийн номын сангийн номын санчдыг цаашид компьютер, интернэтийн дунд шатны сургалтанд хамруулах.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2010 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сан нь хүн төрөлхтний оюуны үнэт өв болсон ном, хэвлэлийг хадгалж хамгаалах, хойч үедээ өвлүүлэн үлдээх, номын сангийн үйлчилгээг орчин үеийн дэвшилтэт арга хэлбэрээр баяжуулж, уншигчдад мэдээллийг түргэн шуурхай хүргэх зорилт тавин ажиллаж байна.

Нэг. Хууль, дүрэм, тогтоол, шийдвэрүүдийн хэрэгжилт, үр дүн:

а. Соёлын хууль, Соёлын өвийн хууль, Хөдөлмөрийн хуулийн хэрэгжилт

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сан нь Соёлын хуулийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлсэн гэрчилгээтэй, албан ёсоор үйл ажиллагаа явуулж байгаа зориулалтын барилга, тоног төхөөрөмжтэй байгууллага юм.

Номын сангийн дотоод журмыг хууль тогтоомжийн дагуу өөрийн байгууллагын онцлогт нийцүүлэн боловсруулж мөрдөн ажиллаж байна.

Хүн амд үзүүлэх соёлын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан өргөжүүлж, фондын хадгалалт хамгаалалтыг сайжруулж, ном хэвлэлийг олон нийтэд дэлгэрүүлэн сурталчлах талаар олон талт ажлуудыг зохион байгуулж, мэдээлийн баазаа өргөжүүлэн хөгжүүлж байна.

Жил болгон өөрийн байгууллагын нөөц бололцоог ашиглан номын санч нарын сургалт- семинар зохион байгуулахын зэрэгцээ, төв, орон нутагт зохион байгуулагдаж байгаа төрөл бүрийн сургалт-семинарт номын санч нараа оролцуулж байгаа нь номын санч нарын мэргэжил мэдлэг, ажлын ур чадварыг дээшлүүлэхэд их ач холбогдолтой юм.

Ажилтан албан хаагчдын нийгмийн байдалд анхаарч, ур чадварын нэмэгдэл, шагнал, урамшил олгох ажлыг зохион байгуулж байна.

б. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Засгийн газрын мөрийн хөтөлбөрт заагдсаны дагуу үндэсний уламжлалт болон орчин үеийн соёлыг хөхүүлэн дэмжиж, хөгжүүлэх ажлын хүрээнд доорх ажлуудыг хийлээ.

- Үндэсний өв уламжлал, зан заншил, түүх соёлоо түгээн дэлгэрүүлэх, хойч үедээ өвлүүлэн үлдээх ажлын хүрээнд “Бичиг соёлын хишиг өдөр”-ийг тохиолдуулан монголын үндэсний уйгаржин монгол бичгээр “Хэн зөв, сайхан бичих вэ” уралдааныг ЕБС-ийн 4-р сургуулийн 5а, 5б ангийн сурагчдын дунд зохион явууллаа. Уг арга хэмжээний үеэр номын сангийн үйл ажиллагаа, номын фондыг сурагчдад танилцуулан хүүхдийн болон шинэ номын үзэсгэлэн, монголын өв соёл, зан заншилын номын үзэсгэлэн, уйгаржин

монгол бичгээр хэвлэгдсэн номын үзэсгэлэн, ховор номын үзэсгэлэн тус тус гаргалаа.

- Монголын уламжлалт тоглоом, ёс заншлаар “Монгол ёс заншил”, ”Монголын уламжлалт баяр цагаан сар- сэдэвт номын үзэсгэлэн, Сэлэнгэ аймгийн Нэгдсэн музейгээс зохион байгуулсан “Монголын төр, нийгмийн зүтгэлтнүүд- Сэлэнгэчүүд” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын арга хэмжээнд оролцож түүхийн сэдэвт номын үзэсгэлэн тус тус гаргалаа.
- Сэлэнгэ аймгийнхаа түүх соёлыг хойч үедээ уламжлуулан үлдээх, ахмад үеэ хайрлан хүндлэх үзлийг дэмжих зорилгоор “Сэлэнгэ сайхан нутаг” байнгын булан гаргалаа.

в. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

2010 онд Аймгийн Засаг даргатай хийсэн үр дүнгийн гэрээнд тусгагдсан бүтээгдэхүүнүүдийг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэлээ.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйлажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.3.4-д заагдсаны дагуу сум, сургуулийн номын санч нарт мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгч, сургалт семинарыг зохион байгуулж ажиллаж байна. Үүнд: Алтан булаг сумын сургуулийн номын сан, Алтанбулаг сумын Соёлын төвийн номын сан, Сүхбаатар сумын ЕБС-ийн 1,2,3,4,5,6-р сургуулийн номын сангуудын үйл ажиллагаатай танилцан арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

Аймгийн номын санд Сүхбаатар сумын ЕБС-ийн номын санчидтай ярилцлага зохион байгуулж дараа нь хөтөлбөрийн дагуу ЕБС-ийн 1,2,3-р сургууль, МСҮТ-ийн номын сангийн үйл ажиллагаатай танилцан туршлага судлах ажлыг зохион байгуулав.

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сан нь Улаанбаатар хотын Хүүхдийн номын ордонтой хамтран 3 хоногийн семинарыг 2010 оны 05 дугаар сарын 03-наас 05-ны өдрүүдэд Улаанбаатар хотод Хүүхдийн номын ордонд зохион байгуулан 22 сумын ЕБС-ийн номын санчдыг хамрууллаа.

Аймгийн нийтийн номын сангийн захирал С.Шинэчимэг, арга зүйч Ч.Үзмээ, ном зүйч А.Оюунсүрэн нар төв орон нутагт зохион байгуулагдсан сургалт семинаруудад оролцож, номын санч Б.Цолмонбаатар Соёлын дээд сургуулийг номын санч мэргэжлээр төгслөө.

Мөн номын сангийн фондын баяжилтанд анхааран ажиллаж, фонд бүрдүүлэлтийг хийхдээ, өөрийн номын сангийн онцлог, нутаг дэвсгэр хүн амын хамрах хүрээ, нийгмийн байдал, иргэдийн мэдээллийн эрэлт, хэрэгцээ , сонирхол, цаг үеийн шаардлагыг харгалзахаас гадна фондын эргэлтийн судалгаан дээр тулгуурлан тухайн үеийн болон нөхөн бүрдүүлэлтийг чанартай хийж гүйцэтгэж байна.

г. Монгол улсын үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт

Монгол улсын Засгийн газраас батлан гаргасан “Монголын уламжлалт бий биелгээ хөтөлбөр”, “Монгол хөөмий хөтөлбөр”, “ Морин хуур, уртын дуу” Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

- “Монгол ардын бүжиг”
- “Монгол ардын дуу”

- “Ардын язгуур урлаг”

-“Өв соёл” сэдэвт номын үзэсгэлэнгүүдийг гаргаж уншигчдын хүртээл болгосон нь уншигч, хэрэглэгчдийн дунд үндэснийхээ урлагийн гайхамшигт өв сантай танилцаж, бахархан дээдлэх, хөгжүүлэх үзлийг дэмжих зорилготой ажил боллоо. Ажилтан албан хаагчдын нийгмийн байдалд анхаарч, ур чадварын нэмэгдэл, шагнал, урамшил олгох ажлыг зохион байгуулж байна.

Хоёр. Удирдлага зохион байгуулалтын ажил

Монгол улсын соёлын тухай хууль, тогтоомжууд болон төрөөс баримтлах Соёлын бодлого, Засгийн газар болон Аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөр, Засгийн газрын болон аймгийн хөгжлийн үндсэн чиглэл, Соёл, урлагийн үндэсний хөтөлбөр, “Ном хэвлэлийн хадгалалт, хамгаалалт”, “Номын сангийн орчин нөхцөл, үйл ажиллагаа”-ны талаарх стандартуудыг хэрэгжүүлэх зорилгоор байгууллагын үр дүнгийн гэрээ, 2010 оны ажлын төлөвлөгөөг боловсруулан Аймгийн засаг даргатай үр дүнгийн гэрээ, байгууллагын ажиллагсадтай үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээ байгуулж, жил, улирлын ажлын төлөвлөгөө, ажлын байрны тодорхойлолтыг ажилтан нэг бүрээр гарган баталгаажуулж ажиллалаа.

Төрийн албаны тухай хууль тогтоомжууд, хөдөлмөрийн тухай хуулийн дагуу

“Ур чадварын нэмэгдэл тогтоох журам”, “Хөдөлмөрийн дотоод журам”-д өөрчлөлт шинэчлэлт хийж баталгаажуулав.

Ажиллагсаддаа “Хамт олны төлөвшил”, “Аймгийн Нийтийн номын сангийн үлгэрчилсэн дүрэм”-ээр сургалт зохион байгуулж, “Нийтийн номын сангийн дүрэм”, “Уншигч, хэрэглэгчдийн дүрэм”-ийг шинэчлэн боловсруулж батлав.

Номын сангийн их засварын талаар Аймгийн засаг даргад хүсэлт гарган, байдлыг танилцуулж, их засварын төсөл гарган, төсвийг батлуулж, 2010.07.27-2010.09.10-ны хооронд их засварын ажлыг хийлгэж дуусгалаа.

Монголын уламжлалт баяр “Цагаан сар”–ыг угтан ахмад ажиллагсаддаа сар шинийн бэлэг гардууллаа. Номын сангийн үйлчилгээний тарифт өөрчлөлт хийж, үйлчилгээний тоог нэмэгдүүлэв.

Номын сангийн ажиллагсадын өөрийгөө хөгжүүлэх тал дээр анхааран ажиллаж, номын сан болон соёлын өвийг хадгалж хамгаалах талаар шинээр гарсан хууль, тогтоомж, дүрэм, заавруудыг түүвэрлэн бэлтгэж, хүн бүр хуулийн “Хууль эрх зүйн гарын авлага” хавтастай боллоо.

Гурав. Арга зүйн ажил

Аймгийн нийтийн номын сангийн үлгэрчилсэн дүрэмд заагдсаны дагуу өөрийн аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа сум, сургуулийн номын сангуудыг заах арга зүйн удирдлагаар ханган ажиллаж сум, сургуулийн номын санч нарт мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. Үүнд:Сумын номын санчдын мэдлэгийг дээшлүүлж мэргэжлийн туслалцаа үзүүлэх зорилгоор “Номын сангийн ажлын норм, хэмжээ”, “Ном сэргээн засварлах ажил”, “Номын сангийн соёл олон нийтийн ажил”, “Номын сан-ном зүйн үйлчилгээ” сэдэвт номын санчдад зориулсан гарын авлага бэлтгэж тараалаа. Манай номын сангийн зүгээс урьд нь тавьсан шаардлагын дагуу сургуулийн номын сангуудын үйл ажиллагаа, тохижилт, байгууллагын зүгээс номын санч нарын ажиллах нөхцөл бололцоог хангаж байгаа талаар судлан Алтан булаг сумын сургуулийн номын сан,

Алтанбулаг сумын Соёлын төвийн номын сан, Жавхлантын ЕБС-ийн номын сан, Жавхлантын ЕБС-ийн номын сан, Хөтөл тосгоны Соёлын төвийн номын сан, Сүхбаатар сумын МСҮТ-ийн номын сан, ЕБС-ийн 1,2,3,4,5,6-р сургуулийн номын сангуудын үйл ажиллагаатай танилцан арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Аймгийн номын санд Сүхбаатар сумын ЕБС-ийн номын санчидтай ярилцлага зохион байгуулж дараа нь хөтөлбөрийн дагуу ЕБС-ийн 1,2,3-р сургууль, МСҮТ-ийн номын сангийн үйл ажиллагаатай танилцан туршлага судлах ажлыг зохион байгуулав.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 30 дугаар тушаалын хавсралт “Ерөнхий боловсролын сургуулийн номын сангийн үлгэрчилсэн дүрэм”-ийн 2.1-д “Хүүхдийн номын ордон нь Ерөнхий боловсролын сургуулийн номын сангийн мэргэжил арга зүйн төв байна” гэсэн заалт, мөн тус дүрмийн 2.4-д “Сургуулийн номын санч, сургуулийн захиргаатай зөвшилцсөний үндсэн дээр мэргэжлийн сургалт, семинарт оролцож мэргэжил боловсролоо тасралтгүй дээшлүүлнэ” гэсэн заалтуудыг үндэслэн, Ерөнхий боловсролын сургуулиудын номын санчдын үйл ажиллагааг сайжруулах, мэргэжил, боловсролыг дээшлүүлэх зорилгоор Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сан нь Улаанбаатар хотын Хүүхдийн номын ордонтой хамтран 3 хоногийн семинарыг 2010 оны 05 дугаар сарын 03-наас 05-ны өдрүүдэд Улаанбаатар хотод Хүүхдийн номын ордонд зохион байгуулан 22 сумын ЕБС-ийн номын санчдыг хамрууллаа.

Мөн Германы Гётегийн институт, хүүхдийн номын ордноос зохион байгуулсан “Номын чимэглэлийн урлагаар уншигчдын эгнээг өргөжүүлэх нь” сэдэвт сургалтанд оролцов.

“Аргазүйн ажлын мэдээлэл” самбар шинээр хийлгэлээ. ЕБС-ийн номын сангуудын номын санчдын судалгаа, анкетыг шинэчлэн боловсрууллаа.

Сум сургуулийн номын санчдын үйл ажиллагааг дүгнэх шалгуур үзүүлэлт боловсруулан гаргалаа.

Дөрөв. Ном зүй, мэдээлэл-лавлагааны ажил

а.Номзүйн бүртгэл, лавлах, картын сан

- Монголын ёс заншил, түүх соёлыг дэлгэрүүлэх, сурталчлан танилцуулах зорилгоор “Монголын цагаан сар” сэдэвт лавлах
- Өрнийн 12 ордны зурлагаар “ Оддын зурхай” лавлах
- Сурагчдад зориулан номын сангийн фондод хадгалагдаж байгаа физикийн хичээлийн номоор “ Физик” санамж өгөх ном зүйн бүртгэл
- Бие хүний соёл, харилцааны соёл зэрэг асуудлуудыг тусгасан “Өөрийгөө хөгжүүлэхүй” ном зүйн бүртгэл
- “ Эрүүл ахуй” ном зүйн бүртгэл
- “Хууль зүй” ном зүйн бүртгэл,
- “Номын санчдад тусламж” картын сан тус тус хийлээ.
- Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангийн “Түүхчилсэн лавлах”-ыг боловсруулж аймгийн Архивын газарт хүргүүллээ.

- ЕБС-д Монгол хэл уран зохиолын хичээлээр заавал судлах

уран бүтээлүүдээс тус номын санд хадгалагдаж байгаа зохиолуудын жагсаалтыг гаргаж БСГ-т хүргүүллээ.

б. Лавлагаа, мэдээлэл

Лавлагааны буланг тогтмол ажиллуулж ном зүйн бүртгэл, картын сан, төрөл бүрийн лавлахууд, өгөгдсөн лавлагааны санг байрлуулж уншигчдын хүртээл болгож байна.

Номын санд ирж байгаа уншигчдын эрэлт хүсэлтэнд хариу өгч хэрэгцээт ном хэвлэл, мэдээллээс 600 гаруй хүнд лавлагаа өглөө. Номын сангийн 2007, 2008, 2009 оны ажлын үзүүлэлтийг графикаар, номын сангийн ажлын стандартын биелэлтийг гаргалаа.

Тав. Фонд бүрдүүлэлт, фонд, каталог, ном сэлбэн засалт

2010 онд Нээлттэй нийгэм форум, Удирдлагын академи, Байгаль орчны төсөл болон бусад албан байгууллага хувь хүмүүсийн хандиваар шинэ номуудыг номын сангийн данс, бүртгэлүүдэд данслан, техник ажиллагаа хийж холбогдох тасгуудад хувиарлав.

2010 оны шинэ ном:

д/д	Нэрс	Нэр төрөл	Тоо ширхэг	Үнэ
1	Худалдан авсан шинэ ном	104	265	2185160
2	Хандивын ном	43	80	127770
	Дүн	**147**	**345**	**2312930**
	Тогтмол хэвлэл	8-17		199850
1	**Нийт дүн**			**2512780**

Уншигчдын гар дээр урагдаж гэмтсэн болон монголын ард түмний олон зуун жилийн оюуны соёлын үнэт өв болсон хуучны ном судрын хадгалалт хамгаалалтанд анхаарч ном хэвлэлд сэлбэн засалт хийж байна.

Ном сэлбэн засалт:

д/д	Нэрс	Тоо
1	Ховор ном	4
2	Бусад ном	2880
	Нийт	**2884**

Байгалийн гамшиг, болзошгүй аюулын үед холбоо барих байгууллагуудын болон номын сангийн ажилтан албан хаагчдын утасны жагсаалтыг бэлтгэж фондын өрөөнд байрлууллаа.

Номын сангийн үсэг, дарааллын болон төрөл ангийн каталогийг редакторлож, каталогийн шүүгээний хаяг болон каталогийн ялгагчууд, картын байрлалыг хянаж, каталогийн шүүгээг сэлбэн засав.

Архив номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавигдах шаардлага стандартын 7.2 , Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага стандартад 4.4.2, Аймаг, нийслэлийн нийтийн номын сангийн үлгэрчилсэн дүрмийн 3.2.6, Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага стандартад 4.3-т заагдсаны дагуу ном хэвлэлийн хадгалалт хамгаалалтанд анхааран ажиллаж, ном хэвлэлийг эмх цэгцтэй байлган, шинжлэх ухааны төрөл анги, үсгийн дарааллаар байрлуулах ажлыг тухай бүрд тогтмол хийж, номын фондын өрөөний чийгшилт, агаарын хэм, тоосжилтонд байнга хяналт тавин ажиллаж байна.

Номын санг автоматжуулах Lib4U цогц программыг, дагалдах техник хэрэгсэл болох компьютер, канон, скайнер, принтер, бар код уншигчийн хамт худалдан авлаа. Дээрх автоматжуулалтын программд орох болсонтой холбогдуулан ном хэвлэлийг эмхлэх, цэгцлэх, бэлтгэл ажлуудыг хийж байна.

Уг программыг ашигласнаар номын фондын бүх ном хэвлэл төдийгүй номын сангийн анхан шатны данс бүртгэлүүд болон, уншигчийн бүртгэл зэргийг бүгдийг компьютерт оруулан, коджуулах тул ном хэвлэлийн хадгалалт хамгаалалтыг сайжруулахаас гадна номын сангийн ажлын мэдээ тайлан, тоо баримтыг гаргахад их ач холбогдолтой болох юм.

Номын сангийн барилгад их засвар орсонтой холбогдуулан ном хэвлэл, номын тавиуруудыг зөөж хураасан байсан бөгөөд их засвар дууссаны дараа номын фондын номын тавиуруудыг байрлуулан, нийт 38000 гаруй ном хэвлэлийг шинжлэх ухааны төрлөөр болон үсгийн дарааллаар байрлуулах ажлыг ном хэвлэлийн хадгалалт хамгаалалтын стандартын дагуу хийлээ.

“Шилдэг ном 2009”-д шалгарсан номоос Сэлэнгэ аймгийн сумдын номын сангуудад хувиарлагдсан номыг тараах ажлыг хийлээ.

Зургаа. Уншлага, үйлчилгээний ажил

Өөрийн номын сангийн фондод байгаа уран зохиолын болон төрөл бүрийн шинжлэх ухааны ном хэвлэлүүдийг уншигчдын хүртээл болгож, оюуны эрэлт хэрэгцээг нь хангах зорилгоор номын сангийн уншлага үйлчилгээний ажлыг зохион байгуулж, төрөл бүрийн олон талт ажил, үйлчилгээнүүдийг явуулж ирлээ.

Уншигч, ирц, ном олголт:

д/д	**Шинэ уншигч**	**Ирц**	**Ном олголт**
1	2310	9310	26009
2	**11620**		**26009**

Зөөврийн номын сангийн үйлчилгээ:

д/д	**Уншигч**	**Ном олголт**

1	188	1861

Мөн цаг үеийн мэдээ мэдээллийг уншигчиддаа түргэн шуурхай, цаг тухайд нь хүргэх зорилгоор 8 нэр төрлийн сонин, 2 нэр төрлийн сэтгүүлээр уншлагын танхимаар үйлчилж байна.

Зөөврийн номын сангийн үйлчилгээг уншигчдад хүртээмжтэй, үр дүнтэй болгохын тулд сургуулийн өмнөх насныхан болон ЕБС-ийн сурагчдыг бага ангиас нь номын сангийн уншигч болгон номын сандаа урьж ном уншуулан чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэн цаашид номын сайн нөхөр болгох зорилттой ажиллаж СБ сумын 2,4-р цэцэрлэгийн ахлах бэлтгэл анги, ЕБ-ийн 1,2,4-р сургуулийн бага ангийн сурагчдад нийт 120 хүүхдэд 1081 номоор үйлчилж хүүхдийн номын үзэсгэлэн гаргаж, “Гуага хэрээ”, “Баавгай тоглоомын талбайд”, “Амьтдын тухай үлгэр” номоор үлгэрийн уншлага хийж, үзсэн номны тухай зураг зурууллаа.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газар, Хүүхдийн төлөө хэлтэс, Спорт сургуулийн байранд 2010.08.01-2010.08.31 хүртэл зөөврийн номын сан ажиллуулж, шинэ номын болон хүүхдийн уран зохиолын номын үзэсгэлэн гаргаж нийт 32 уншигчдад 580 ш номоор үйлчиллээ.

Хүүхдийн уншлагын танхимд, хүүхдийн шинэ номын үзэсгэлэнг 24 ш номоор гаргаж, нийт 84 уншигчдад сурталчилж, “Сэлэнгэ” телевиз болон “Таны телевиз”, ”Сэлэнгийн мэдээ” сонинд номын мэдээлэл хийж сурталчиллаа.

Гэрээр ном олгох тасгийн ойрын фондын номыг уншигч, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн зохион байгуулж, номын ялгагчуудыг шинээр хийлээ.

Уншлаганд гарсан номуудыг номын сангийн ангиллын дагуу номын тавиурт байрлуулах ажлыг тухай бүрд хийж, уншигчийн карт, номын эргэлтэнд хяналт тавин ажиллаж байна.

Мөн номын сангийн өдөр тутмын бүртгэлийг стандартын дагуу цаг тухайд нь хөтлөн, уншигчдын санал хүсэлтийн дэвтрийг байнга ажиллуулж, цаашдын үйл ажиллагаандаа дүгнэлт хийж ажиллаж ирлээ. Уншигчдын ая тухтай үйлчлүүлэх орчин нөхцлийг хангах талаар анхааран ажиллаж, уншлагын танхимуудын цэвэрлэгээ, тохижилтын ажлыг хийж ирлээ.

Долоо. Соёл олон нийтийн ажил

Номын сангаар үйлчлүүлдэг уншигчдын дунд төрөл бүрийн соёл хүмүүжлийн ажлыг зохион явууллаа.Үүнд:

- 1-р сургуулийн Цолмон багштай 5в ангийн хамт олон номын сангийн

уншигч болохоор бүртгүүлсэнтэй холбогдуулан “Ярилцлагат уншлага”-ыг зохион байгуулж ном хэрхэн унших талаар зөвлөгөө өгч, номын сангийн үйл ажиллагаатай танилцууллаа.

- Сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг номын санд хамруулах зорилгоор

Улсын тэргүүний 4-р цэцэрлэгийн бэлтгэл ангийн 38 хүүхдүүдийг номын санд урьж, өөрийн фондод байгаа хүүхдийн номтой танилцуулан “Амьтдын тухай үлгэр”, “Хэрэмний хүүхэд” номуудаар үлгэрийн уншлага хийж, үзсэн номоор нь зураг зуруулж, яриулж урамшууллаа.

- Номын сангийн үйлчилгээний хүрээ, хүртээмжийг өргөжүүлэн өсвөр

үеийн хүүхэд багачуудыг номын санд хамруулахын тулд ЕБС-ийн 5-р ангийн сурагчдын дунд “Номын санг хэн сайн мэдэх вэ” сэдэвт зохион бичлэгийн уралдааныг зохион явууллаа. Уралдаанд нийт 80 гаруй хүүхэд багачууд идэвхтэй оролцож материалаа ирүүлж 1-р байр 12 жилийн 1-р сургуулийн 5б ангийн сурагч Б.Гонгор, 2-р байр 2-р сургуулийн 5б ангийн сурагч М.Цэцэгбаяр, 3-р байранд 1-р сургуулийн 5а ангийн сурагч Э.Эгшиглэн шалгарлаа.

- “Номтой нөхөрлөх өдөр”-ийг зохион байгуулж 12 жилийн 2-р сургуулийн

Эрдэнэ-зул багштай 2 [а] ангийн хамт олныг номын сандаа урьж, уншигчаар бүртгэн карт нээж, номын сантай танилцууллаа. Уг арга хэмжээний үеэр хүүхдийн номын үзэсгэлэн гаргалаа. Зохиолч Сүхдоржтой уулзалт, ярилцлага хийлээ.

- Тэргүүний уншигчид олгодог “Д.Нацагдорж тэмдэгтэн”-ий болзолийг 1-р

сургуулийн 5[в] ангийн сурагч Т.Хасболд, О.Ундрал, С.Анударь нар хангаж “Д.Нацагдорж” тэмдэгээр шагнууллаа.

- Үндэсний өв уламжлал, зан заншил, түүх соёлоо түгээн дэлгэрүүлэх,

хойч үедээ өвлүүлэн үлдээх ажлын хүрээнд “Бичиг соёлын хишиг өдөр”-ийг тохиолдуулан монголын үндэсний уйгаржин монгол бичгээр “Хэн зөв, сайхан бичих вэ” уралдааныг ЕБС-ийн 4-р сургуулийн 5а, 5б ангийн сурагчдын дунд зохион явууллаа. Уг арга хэмжээний үеэр номын сангийн үйл ажиллагаа, номын фондыг сурагчдад танилцуулан хүүхдийн болон шинэ номын үзэсгэлэн, монголын өв соёл, заншилын номын үзэсгэлэн, уйгаржин монгол бичгээр хэвлэгдсэн номын үзэсгэлэн, ховор номын үзэсгэлэнг 126ш номоор гаргалаа.

- Сэлэнгэ аймгийн Нэгдсэн музейгээс зохион байгуулсан “Монголын төр,

нийгмийн зүтгэлтнүүд- Сэлэнгэчүүд” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын арга хэмжээнд оролцож түүхийн сэдэвт номын үзэсгэлэнг 25ш номоор тус тус гаргалаа.

- АНУ-ын Хүүхдийн байгууллагын Монгол дахь салбар “Дөрвөн

навч” байгууллагын “Ном” хөтөлбөрийн хүрээнд улсын хэмжээнд зарлагдсан “Номын анд” ном уншлагын уралдаанд ЕБС-ийн сурагчдаас нийт 10 хүүхэдтэй “Супер уншигч” бүлэг байгуулан оролцож, унших номын жагсаалтын дагуу зохиолуудыг уншуулж, тэмдэглэл хөтлүүлж, уралдааны хөтөлбөрт заагдсан бүтээлүүдийг хийлээ. “Супер уншигч” бүлэгт 12 жилийн 4-р бүрэн дунд сургуулийн 4а ангийн сурагч Б.Энхзаяа, 5-р ангийн сурагч Ө.Энхтэмүүлэн, 12 жилийн 1-р бүрэн дунд сургуулийн 5б ангийн сурагч О.Бат-эрдэнэ, Ч.Мягмар, Б.Гонгор, 12 жилийн 2-р бүрэн дунд сургуулийн 5б ангийн сурагч П.Эрдэнэ-сувд, Х.Анужин, О.Номин, 4-р ангийн сурагч Б.Баяржавхлан, 10 жилийн 5-р сургуулийн 3-р ангийн сурагч Д.Ану-үжин нар хамрагдлаа.

Дээрх уралдаанд улсын хэмжээнд оролцсон нийт 97 номын санчаас, Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангийн номын санч Т.Нарандалай 3-р байранд, “Супер уншигч” бүлэг нь 550 гаруй баг, хүүхдүүдээс мөн 3-р байранд шалгарсан амжилт үзүүлж, 2010.09.18-нд Улаанбаатар хотын Хүүхдийн номын ордонд болсон шагнал гардуулах арга хэмжээнд номын санч Т.Нарандалай оролцож шагналаа гардаж авлаа.

“Номын анд” уралдаан нь өсвөр насны хүүхэд багачууд, сурагчдыг төдийгүй эцэг эх, багш, сурган хүмүүжүүлэгчид, нийгэм, соёлын ажилтнууд болон олон нийтийг номын сангийн үйлчилгээнд өргөн хамруулах, тэдний ном унших дур сонирхолыг дэмжих, мэдлэг боловсролд нь хувь нэмэр оруулах, номын сангийн

үйл ажиллагаа, ном хэвлэл, дэлхийн болон монголын сонгодог зохиолуудыг сурталчлахад ач холбогдолтой, үр дүнтэй ажил боллоо.

Аймгийн Нийтийн номын сангаас "Номын анд" ном уншлагын уралдаанд амжилттай оролцогсдод зориулан 2010.11.10-нд "Хүндэтгэлийн арга хэмжээ" зохион байгууллаа.

Уг арга хэмжээнд аймгийн БСГ-ын соёл хариуцсан мэргэжилтэн Эрдэнэчимэг, Сүхбаатар сумын ЗДТГ-н нийгмийн ажилтан Сарантуяа нар оролцож уншигч хүүхдүүдэд баяр хүргэж, өргөмжлөл "Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэг"-ийг "Супер уншигч" бүлгийн 8 хүүхдэд гардуулав.

Арга хэмжээний үеэр хүүхдүүдийн хийсэн гар зураг, бяцхан ном, зурагт хуудас, "Долоон бор огтоно", "Долоон өндөгтэй доголон шаазгайн үлгэр"-ээр хийсэн баримал, уншсан номын тэмдэглэл зэрэг бүтээлүүдээр үзэсгэлэн гаргаж, хийсэн ажлын тайланг танилцуулав

- 2010.10.20-ны өдөр Аймгийн Засаг даргын тамгын газраас

зохион байгуулсан "Нээлттэй хаалга"-ны өдөрт оролцон, шинэ номын болон хүүхдийн уран зохиолын номын үзэсгэлэн гаргаж, байгууллагын үйл ажиллагааг танилцуулах ажлыг хийж, өөрсдийн болон уншигчдын бүтээлээс үзэсгэлэн гаргасан нь маш үр дүнтэй ажил боллоо.

- 2010.11.15,16-нд Сэлэнгэ аймгийн Хөтөл тосгонд зохион байгуулагдсан

"Соёлын байгууллагуудын нээлттэй хаалганы өдөр"-т оролцож, түүхийн болон уран зохиолын шинэ номын үзэсгэлэнг нийт 36 ш номоор гарган, уншигчдад номын сангийн үйл ажиллагааг танилцуулан нийт 200 гаруй хүнд үйлчиллээ.

- Хүүхэд залуучуудад, өөрт хэрэгцээтэй мэдээ мэдээллийг түргэн, хялбар олж

авахын тулд ном, хэвлэлээ оновчтой сонгож, зөв, эрүүл мэндэд хоргүйгээр ашиглаж сурах талаар мэдээлэл өгөх зорилгоор "Уншигчдын мөрдлөг болговол зохих 12 алтан дүрэм" зөвлөмж боловсруулж "Миний монгол телевиз", "Миний монгол FM радио"-оор дамжуулан уншигчдын хүртээл болголоо.

- Номын санд шинээр бүрдүүлсэн хүүхдийн болон бусад шинэ номуудыг

уншигчдад танилцуулах зорилгоор нийт 620 номоор 12 удаа шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргалаа.

Соёл олон нийтийн ажил	**Номын үзэсгэлэн**
12 удаа	12 удаа

Найм. Байгууллагын тохижилт.

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангийн барилга нь 1972 онд ашиглалтанд орсноос хойш их засварт ороогүй байсны улмаас барилгын гадаад, дотоод өнгө үзэмж муудан, сантехник хуучирч ашиглалтын шаардлага хангахгүй болж элэгдэх, ус алдан шал мөөгөнцөртөх, цөмрөх зэрэг асуудлууд гарах болсон.

Дээрх нөхцөл байдал нь байгууллагын хэвийн үйл ажиллагаа явуулахад хүндрэл учруулж, уншигчдад үйлчлэх болон соёлын үнэт өв болох ном, хэвлэлийг хадгалж хамгаалах улсын стандартыг зөрчих болсон.

Иймээс БСШУЯам болон Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын дэмжлэгтэйгээр Номын сангийн барилгад их засвар хийх 45 000 000 төгрөгийн төсвийг батлуулж, шийдвэрлүүлснээр их засварын ажлыг 2010.07.27-2010.09.10-ны хооронд хийлгэж дуусгалаа.

Их засварын төсөв:

д/д	Санхүүжилтийн эх үүсвэр	Хэмжих нэгж	Тоо
1	БСШУЯ-аас	Төгрөг	30 000 000
2	Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгын газар	Төгрөг	15 000 000
	Нийт дүн	**Төгрөг**	**45 000 000**

Их засварын ажил эхэлсэнтэй холбогдуулан номын сангийн үйл ажиллагааг явуулах төлөвлөгөө гарган ажиллалаа.

Номын сангийн ажиллагсадыг өдөр өдрөөр хуваарь гарган номын сангийн байранд жижүүрт гаргаж, засварын ажлын явцыг хянаж байлаа.

Хариуцлагатай жижүүрт томилогдсон номын сангийн ажиллагсад хуваарийн дагуу ажиллаж засварын явцыг хянах болон засварт хэрэглэгдэж байгаа эд материалыг харж хамгаалах ажилд туслалцаж байлаа.

Номын сангийн тавилга, тоног төхөөрөмжийг гаргаж барилгыг суллан засварын ажлыг хийх нөхцөлийг хангах шаардлагатай байсан тул баталгаатай цоож, хамгаалалт бүхий агуулахад зөөвөрлөн хураах, фондын ном хэвлэлийг өрөө, өрөөнд сэлгүүлэн зөөж засварын ажлыг хийлгэх зэрэг ажлуудыг хийлээ.

Их засварын ажил чанартай, сайн хийгдэж дууссан бөгөөд батлагдсан төсвийн дагуу барилгын цонх, хаалга, сантехникийн шугамыг сольж, шатны хашлага, хүрээг шинэчлэх, өрөө тасалгаануудад паркетан болон чулуун шал дэвсэх, барилгын дотор хана таазнуудыг будах, өнгөлөх, засал чимэглэлийн ажил хийх, цахилгааны монтажийг сольж, гэрэлтүүлгийг шинэчлэх зэрэг ажлуудыг хийлээ.

Их засварын ажил дууссаны дараа фондын номын тавиуруудыг байрлуулан, ном хэвлэлийг шинжлэх ухааны төрлөөр болон үсгийн дараалаар байрлуулах ажлыг ном хэвлэлийн хадгалалт хамгаалалтын стандартын дагуу хийх, мөн байгууллагын тохижилтын ажлыг хийлээ.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгын газраас өгсөн үүрэг даалгаврын дагуу Аймгийн Нийтийн номын сан нь өөрийн байгууллагын хашаанд мод, бут тарих ажлыг зохион байгууллаа. Энэ ажлын хүрээнд шар хуайс модыг худалдан авч, хөрсөнд суулгаж, услах ажлыг хийлээ.

Мод суулгасан төсөв:

д/д	Мод, бутны нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
	Шар хуайс	ш	70	1200	84000

Мөн хаврын цэцэрлэгжүүлэлтийн ажилд бэлдэн хашааны хөрсийг сийрэгжүүлэн, цэнэг услагаа хийж байна.

Цаашид байгууллагын орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтэнд анхааран төрөл бүрийн мод, бутлаг ургамал, цэцэгийг суулган ургуулж, зүлэгжүүлж ажиллахаар төлөвлөж байна.

Байгууллагын манаачийн байрыг бэлтгэн тохижуулав.

Байгууллагын гаднах орчны цэвэрлэгээг, долоо хоног бүрийн тогтсон хуваарьт өдрүүдэд хийж, хуримтлагдсан хогийг цэвэрлэн, ачуулах, өвлийн улиралд нийтийн эзэмшлийн зам талбай дахь хуваарьт газрын цас мөсийг цэвэрлэх ажлыг тогтмол хийж, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2010.11.25-ний өдрийн 1/580 тоот захирамжийн дагуу Нийтийн номын сангийн эзэмшлийн талбай дахь цасыг цэвэрлэх ажлыг хийлээ.

Ажлын өрөө тасалгаа болон уншлагын танхимуудын цэцэгжүүлэлт, тохижилт, цэвэрлэгээг сайжрууллаа. Мөн байгууллагын харуул, хамгаалалтын асуудалд анхааран ажиллаж , баяр, нийтээр амрах өдрүүдийн үеэр хариуцлагатай эргүүл, жижүүрүүдийг томилон ажиллуулж байна.

Ес. Үйл ажиллагаа явуулахад тохиолдсон хүндрэл бэрхшээлүүд

Төсөв мөнгөний хүрэлцээгүйн улмаас төлөвлөгдсөн доорх ажлууд хийгдээгүй. Үүнд:

д/д	Төлөвлөгдсөн ажлын нэрс	Хэмжих нэгж	Зардал
1	ЕБС-ийн номын сангуудын үйлчилгээний чанар, үйл ажиллагааг өргөжүүлэн сайжруулах зорилгоор номын санчдын дунд уралдаан зарлах ажлын шагнал, зохион байгуулах	Төгрөг	300 000
2	Сумын номын санчдын сургалт-семинар зохион байгуулах ажлын зохион байгуулах	Төгрөг	150 000
3	Сумдын номын сангуудын ажлыг газар дээр нь үзэж, арга зүйн зөвлөгөө өгөх ажлын томилолтын зардалд	Төгрөг	350 000
4	Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 80 жилийн ойд зориулсан, орон нутгийнхаа түүх соёлыг сурталчлах “Сэлэнгэ сайхан нутаг” самбар хийх	Төгрөг	150 000
5	ЕБС-ийн бага ангийн багштай хамтран бага ангийн сурагчдад гэрийн даалгаврын цагийг зохион байгуулах	Төгрөг	30 000
6	Миний монгол телевизтэй хамтран Сүхбаатар сумын ЕБС-иудын сурагчдын дунд “Алтан хонх” уралдааныг зохион байгуулах ажлын шагнал, зар сурталчилгааны зардалд	Төгрөг	25 000

7	“Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг тохиолдуулан аймгийн төр захиргааны ажилчдыг оролцуулан уулзалт зохион байгуулах	Төгрөг	50 000
	Нийт дүн		**1 055 000**

Дээрх ажлуудад нийт 1055000 төгрөг зарцуулагдах байсан нь төсөв хүрэлцээгүй тул хийгдээгүй.

Арав. Тайлан мэдээ гаргалт

БСШУЯ, Үндэсний номын сан, Аймгийн БСГ болон бусад байгууллагуудад холбогдох мэдээ тайланг цаг хугацаанд нь гаргаж хүргүүлж байна.

Номын сангийн ажилтнуудын жил, улирал, сарын ажлын тайлан, төлөвлөгөөг гаргуулж тухай бүрд нь дүгнэн ажиллаж байна.

ТӨВ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2010 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Зуунмод

2010 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 6-н зорилт, 29 хэрэгжүүлэх арга хэмжээг тусган, хэрэгжилтэд нь хяналт тавин ажилласны үр дүнд хэрэгжилт 98% байна.

Нэг: Иргэд уншигчдад ном, хэвлэл мэдээллийн материал хүргэх үйлчилгээ.

1. Нийтийн номын сан нь 2010 оны байдлаар үйлчилгээндээ 2179 байнгын уншигч, 12884 ирэгсэдэд, 31071 ном, хэвлэл, мэдээллийн материал олгож уншуулсан.
2. Нийт 26 эмзэг бүлгийн хүүхдүүд, өндөр настангуудад үнэ төлбөргүй уншигчийн карт нээж үйлчилсэн.
3. Нийтийн номын сангийн үйл ажиллагааны талаар 6 санал асуулга бүхий судалгааг улирал бүр 14 хоногийн хугацаатай явууллаа. Уг судалгаанд янз бүрийн насны төрөл бүрийн мэргэжлийн нийт 200 хүн хамрагдсан. Үүнд:
    1. Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийг номын сангаар үйлчлүүлдэг- 54%, хааяа үйлчлүүлдэг-44%, үйлчлүүлдэггүй- 2% тус тус эзэлж байна.
    2. Манай сан хөмрөгт байгаа ном, хэвлэл таны мэдээлэл авах хэрэгцээг хангаж чадаж байна уу гэсэн асуултан иргэд: Хангаж чаддаг-67%, Дунд зэрэг-33%, хангаж чаддаггүй-0% гэсэн хариултыг өгчээ.
    3. Номын сангийн тохижилт үйлчилгээ болон тав тух, заалны ном сонголт хэр байна вэ? гэсэн асуултанд: 81%- сайн, 16%- боломжийн, 3%- муу гэж хариулсан интернэт мэдээллийн танхимд кофе цайгаар үйлчилдэг бол зүйгээр гэсэн 1 санал гарсан.
    4. Харилцааны соёл, зан төлөвийн талаарх асуултанд: Маш сайн-83%, боломжийн-16%, тааруу-1% гэсэн хариултын өгсөн.

5. Номын сангаас уншигчдын дунд зохион явуулдаг соёл чөлөөт цагийн ажилд оролцож байсан уу? Цаашид ямар ажил зохион явуулбал хэрэгцээтэй вэ? гэсэн асуултанд: 36%-оролцож байсан, 64% - оролцдоггүй гэж хариулсан ба цаашид зургийн уралдаан, өөр сонирхолтой оюун ухаан сорьсон тэмцээн, зохион бичлэгийн уралдаан зэргийг зохион явуулах гэсэн саналуудыг гаргасан.
6. Уншигчдын ном уншилтын сонирхол ямар чиглэлийн ном, гарын авлага унших хүсэлтэй байна гэсэн судалгаанд:

- Хүүхдэд зориулсан ном зохиол гарын авлагад: Танин мэдэхүй, сэтгэхүй хөгжүүлэх- 25%, Монголын болон дэлхийн шилдэг уран зохиол- 14%, Гадаад хэл- 12%, Түүх ёс заншил-15%, Байгаль, нийгэм, мэдээлэл харилцаа холбоо, техник технологи-24%, Толь бичиг, нэвтэрхий толь, лавлагааны материал- 8%-г эзэлж байхад
- Нийтийн уншигчдад зориулсан ном зохиол гарын авлагад Уран зохиол- 24%, Менежмент, маркетинг- 8%, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, мэдээлэл харилцаа холбоо, техник технологи- 22%, Амьдрах ухаан, жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх- 17%, Эдийн засаг, санхүү, эрхзүй- 10%, Гоозүй, ёсзүй, эрүүл мэнд-7%, Нийгэм улс төр- 6%, Бусад салбарын зайлшгүй хэрэгцээтэй ном, зохиол гарын авлага- 6% -г тус тус эзэлж байлаа.

Судалгаанд үндэслэн байгууллагынхаа үйл ажиллагаандаа дүгнэлт хийхэд:

- Номын сангаар үйлчлүүлдэггүй иргэдийг үйлчилгээндээ хамруулах тал дээр анхаарах
- Үйлчилгээ болон харилцааны соёл дээр гарсан алдаа дутагдлыг нэн даруй арилгах
- ЕБС-н сурагчдын дунд сонирхолтой тэмцээн зохиохоор гадна түүний хажуугаар төрөл бүрийн уралдаануудыг зарлах
- Уншигч үйлчилүүлэгчдийн номын сонирхол, хэрэгцээ шаарлагага, судалгаан дээр тургуурлан ном худалдан авах, захиалах, фонд бүрдүүлэлт хийх тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй байна.

4. Номын сангийн сан хөмрөгийг уншигчдаас авсан санал асуулгыг харгалзан төсөвөөр 2.684.800 төгрөг, хандиваар 303.000 төгрөгний шинэ номба 7 төрлийн 208.400 төгрөгний тогтмол хэвлэл захиалан иргэдэд хүргэж нийт 3.231.200 төгрөгний ном хэвлэл мэдээллийн материалаар сан хөмрөгөө баяжуулсан.
5. Аймгийн Нийтийн номын сан нь Сэргэлэн сум, Баянхошуу 3-р баг, Зүүндэлгэр 4-р баг, 4-р сургууль, Хүмүүн цогцолбор сургуулийн “А” байр зэрэг газруудад явуулын номын сан ажиллуулж 108 хүнд 185 номоор үйлчилсэн. Улаанбаатар хотын Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн номын сантай 11-н эрдэм шинжилгээний бүтээлээр номын солилцоо хийсэн нь үйлчлүүлэгчдийн хүрээг тэлж уншигчдын тоо нэмэгдсэн. Аймгийн Нүүдлийн номын сан сургалтын төвтэй хамтран албан байгууллага, аж ахуйн нэгж, сумдад тусгай төлөвлөгөө графикийн дагуу явуулын номын санг ажиллуулж байна. 2010 оны байдлаар Аргалант, Шижир-Алт, Заамар сумдад явуулын номын сан ажиллуулсан.

6. “Үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих жил”-д зориулан өөрийн сан хөмрөгт байгаа 26 ширхэг ном, “Гадаад хэл сурцгаая” сэдвийн дор 23 ширхэг ном, “Сургууль төгсөгчдөд зориулсан 24 ширхэг ном, “Төв аймгаас төрөн гарсан зохиолчид”-ын 25 ширхэг, “Хичээлийн шинэ жилд”зэрэг сэдэвчилсэн үзэсгэлэн 8 удаа,“Шинэ ном”-ын үзэсгэлэн 4 удаа нийт 12 үзэсгэлэн гаргасан. Аймгийн музейтэй хамтран музей, номын сангийн үйл ажиллагааг сурталчилах “Нээлттэй өдөрлөг”-ийг 5-р сард Эрдэнэсант, Өндөрширээт суманд зохион

байгуулж шинээр ирсэн болон үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих жилд зориулан номын үзэсгэлэн гаргаж шинэ номын худалдаа зохион байгуулхад 350 хүн хамрагдсан байна.

7. Долоо хоног бүр байгууллагын албан хаагчдын шуурхай хийж, хийсэн болон дараагийн 7 хоногт хийх ажлын талаар ярилцаж мэдээлэл өгдөг.

Хоёр: Уламжлалт үйлчилгээг орчин үеийн нэмэлт үйлчилгээтэй хослуулах замаар үйлчилгээний чанар сайжруулах.

1. Аймгийн Нийтийн номын сангаас их зохиолч Д.Нацагдоржийн мэндэлсний 104 жилийн ойг угтаж ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг номтой нөхөрлүүлэх, уншигч хамт олон болгох, интернэт ашиглан мэдлэгээ дээшлүүлэх, өөрт хэрэгтэй мэдээллийг хайж олж авах чадвартай болох, хэлний болон компьютерийн мэдлэгийг нь сайжруулах, үйлчилгээнийхээ хүрээг өргөжүүлэх зорилгоор “Ухаан далай номоос эхтэй” ном унших 1 сарын аяныг 2010.10.01-ээс 2010.11.01 хүртэл 2 төрлөөр амжилттай зохион явууллаа. Уг аянд аймгийн хэмжээний сургуулиудын сурагч, анги хамт олон идэвхитэй оролцож 1 сарын хугацаанд 550 байнгын уншигч 2370 ирэгсэдэд 4984 ном олгож уншуулсан ба интернэтийн үйлчилгээнд 24 ангийн 200 гаруй хүүхэд үйлчлүүлсэн нь 3-р улиралын үйлчлүүлэгчдын тоотой тэнцэхүйц хэмжээний үйлчлүүлэгчдэд үйлчилсэн дүнтэй байна. Энэ арга хэмжээг дэмжиж БСШУЯ 100.000 төгрөг, Угтаал-Цайдам сумын “Уушиг хайрхан” ХХК 300.000 төгрөг, “Соёмбо принтинг”ХХК 100.000 төгрөг нийт 500.000 төгрөгний дэмжлэг туслалцаа үзүүлсэн.

- Аймгийн Нийтийн номын сан нь Хүүхдийн төлөө төвтэй хамтран “Хүрэл тулга” шүлгийн аймгийн уралдааныг зохион явуулсан.
- Хүүхдийн уншлагын танхим БСГ-тай хамтран уламжлал болгон зохион байгууллдаг “Үлгэрийн баатрууд амилсан нь” тэмцээний зохион байгуулж 4 баг оролцсоноос ХСЧТөвийн Алтан ном баг 1-р байр эзэлсэн.
- Насанд хүрэгчдын уншлагын танхим аймгийн Музейтэй хамтран “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг тусгай удирдамжийн дагуу зохион явуулсан ба “Хүмүүн бичиг” тэмцээнийг албан байгууллагуудын дунд явуулахад аймгийн Цагдаагийн газрын “Шонхор” баг түрүүлсэн.
- Гэрээр ном олгох танхим нь аймгийн ахмадын хороотой хамтран Зуунмод суманд ажиллаж амьдарч байгаа зохиолч яруу найрагч, иргэд уншигчдын дунд “Ном дор мөргөмү” сэдэвт уулзалт ярилцлага зохион байгуулж 20 гаруй зохиолч, 75 иргэд, уншигч, үйлчлүүлэгч нар хамрагдаж, орон нутгийн зохиолч уран бүтээлчдийн 25 ширхэг номоор үзэсгэлэн гаргасан.

2. Уншигчдынхаа идэвхийг өрнүүлэх урамшуулах үүднээс 2010 оны “Тэргүүний уншигч”-дыг уншлагын танхим бүрээр шалгаруулахад Насанд хүрэгчдийн танхимын уншигч 5-р сургуулийн 10б ангийн сурагч А.Цагаанцэцэг, Хүүхдийн уншлагын танхимын уншигч ХЦС-ийн Ц.Ариунаа багштай 3ё ангийн хамт олон, Гэрээр ном олгох танхимын уншигч ХААИС-ийн оюутан С.Байгальмаа нар шалгарч өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдлаа. Мөн ажилтан албан хаагчдынхаа ажлыг дүгнэж “Байгууллагын аварга”-г тодруулж Номын санч-бичиг хэргийн ажилтан Г.Балжинням, Үйлчлэгч Б.Долгор нарыг шагнаж урамшууллаа.

3. Хүүхдийн уншлагын танхимын номын санч 4-р сургуулийн 5а ангийн 15 сурагчдад “Дэлдэн гүнжхэн” цуврал, 4-р сургуулийн 1а ангийн 16 хүүхдэд “Монгол ардын үлгэр”, 4-р цэцэрлэгийн 25 хүүхдэд “Бөмбөлгөөр аялсан нь”

үлгэр, Бүжинхэн цэцэрлэгийн дунд бүлгийн 57 хүүхдэд “Тэмээ үнсэнд хөрвөөх болсон нь”, “Алтан хараацай”, “Эрхий мэргэн”, Хүмүүн цогцолбор бага сургуулийн бэлтгэл бүлгийн 110 хүүхдэд “Монгол ардын үлгэр” номноос, Сувилгаа чийрэгжүүлэлтийн төвийн дунд бүлгийн давхардсан тоогоор 132 хүүхдэд Шошны үр, Гуталт муур үлгэрээр чанга уншлага, тойм яриа хийв.

4. Мэдээллийн танхим болон уншлагын танхимуудыг ашиглан “Дэлхийн зөн”, Эрчим хүчний салбар”, “БОАЖГазар”, “Эрүүл мэндийн газар”, “Нэгдсэн эмнэлэг”, Мэргэшсэн нягтлан бодох бүртгэл”, “Соёлын төвийн эрхлэгчид”, “Дулааны эрчим хүч”, “Тогтвортой амжиргаа” зэрэг нийт 9 сургалт семинар, хурал зохион байгуулагдаж 925 гаруй хүн хамрагдаж 510.000 төгрөгний орлоготой ажилласан байна.

Гурав: Мэдээлэл лавлагаа ном зүйн үйлчилгээ

1. Статистикийн мэдээллийг төвлөрсөн ба төвлөрсөн бус маягт /СУС-3, 10, 15/-аар нэгтгэн БСГ-ийн мэргэжилтэнд явуулсан. Үүнд Төвлөрсөн мэдээлэл СУ-3-аар үйлчилгээний үзүүлэлтийг 2010оныг 2009 оны байдалтай харьцуулбал байнгын уншигч болон иргэсэд тодорхой хувиар өсөж нийт уншигч-14%-иар өссөн, нийт олгосон ном-0.8% өссөн үзүүлэлттэй боловч үүнээс уншлагын танхимаар олгосон нь -21%-иар өссөн, гэрээр олгосон нь-16%-иар буурсан, зөөврөөр олгосон нь 90%-иар буурсан үзүүлэлттэй байна. Мөн шинээр авсан номын тоо-12%-иар буурсан нь тухайн оны төсөвөөс шууд хамааралтай ба фондоос актласан болон хасагдсан ном гараагүй байна. Цаашид тамхимаар, гэрээр, зөөврөөр олгох номуудад тус бүр нь төлөвлөгөө гаргаж урд оны үзүүлэлтээс бууруулахгүй байх тал дээр анхаарч ажиллах шаардлагатай байна. СУ-10 судалгаан дээр жижүүр болон нягтлан бодогчийн орон тоод тус бүр нэг албан хаагчийг шинээр ажилд авч ажиллавал зохих 12 орон тоогоор буюу бүрэн орон тоогоор ажиллаж байна. СУ-15 буюу тоног төхөөрөмжийн судалгаанд ерөнхийдөө нийт үзүүлэлтүүд дээр өөрчлөлт ороогүй. Харин pentuim-VI ба түүнээс дээш 3-н компьютер шинээр авсан, 1ш канон акталж оронд нь 1ш канон шинээр худалдан авсан, 1ш принтер шинээр худалдан авсан ба 1ш принтерийг засуулах шаардлагатай байна.

   БСШУ-ны Сайдын 2008 оны 154 дүгээр тушаалаар батлагдсан "Номын сангийн үйл ажиллагааг үнэлэх тоон шалгуур үзүүлэлт"-ийн дагуу байгууллагынхаа үйл ажиллагаанд үнэлгээ хийж үнэлэлт, дүгнэлтийг хийхэд үйл ажиллагааны чанарын үзүүлэлтийн биелэлт 100%-д хүрч маш сайн үнэлгээг авсан.

2. Лавлагаа мэдээллийг амаар болон бичгээр баримтын, сэдэвчилсэн хэлбэрээр 494 хүнд өгч татгалзлын дэвтэрийг хөтөлсөн.

   Номын сангийн сан хөмрөгт байгаа орон нутгийн холбогдолтой 343 ширхэг номын бүртгэн мэдээлэх номзүй хийж товхимол болгон гаргаж уншигчдын хүртээл болгож байна. Үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан “Гар урлал” сэдвээр санамж өгөх номзүй гарын авлага гаргасан.

   Насанд хүрэгчдийн уншлагын танхимд “Эдийн засгийн шинжлэх ухаан”, “Анагаах ухааны шинжлэх ухаан”, “Хуулийн шинжлэх ухаан” болон орон нутгийн картын санг аривжуулан 178ширхэг карт бичиж мэдээлэл хийсэн байна.

   БСШУЯамны 441 тоот тушаалын дагуу 17 бүртгэл хөтлөхөөс нэгдсэн, нэг бүрчилсэн, өдөр тутмын бүртгэл, лавлагаа ном зүй, татгалзлалын дэвтэр, уншигчын карт, формуляр зэрэг анхан шатны14 бүртгэлүүдийг журмын

дагуу бүртгэж хэвшсэн ба энэ онд сонин сэтгүүлийн бүртгэл, ном солилцоо, фондын ном тоолсон тухай акт зэрэг 3-н бүртгэл нэмж бүртгэж нийт 17 бүртгэлийг хөтлөж байна.

Дөрөв: Уншигчдад электрон хэлбэрээр мэдээлэл хүргэх:

1. Шинээр ирсэн 402 ширхэг номыг электрон каталогит оруулан үсэг дараалал төрөл ангиар нь байрлуулсан. 2010 оны байдлаар хүүхэд, насанд хүрэгч болон гэрээр олгох танхим, үндсэн фондны нийт 29282ш ном буюу ном хэвлэлийг 100%электрон каталогит оруулж зураасан коджуулсаннь номыг төрөл анги, зохиогч, хэвлэсэн он, түлхүүр үг зэргээр хайж иргэдэд түргэн шуурхай үйлчилэх боломжтой болсон.
2. 2010 оны 02-р сард байгууллагын дотоод сүлжээг Миком ХХК-ны ADSL- 1Mb хурдны интернэтийн сүлжээнд холбож Интернэт мэдээллийн өрөөний үйл ажиллагааг тогтмолжуулан үйлчилгээндээ 2010 оны байдлаар 603 хүнд үйлчилж 200.000 төгрөгний орлоготой ажилласан нь урьд оны мөн үеэс 68.6 % -р өссөн үзүүлэлттэй байна.
3. Номын сангийн уламжлалт үйлчилгээнээс гадна иргэдэд хэрэгцээтэй байгаа хувилан олшруулах үйлчилгээг нийт 200 хүнд хүргэсэн.
4. Байгууллагын www.library.tuv.mn домайн нэртэй вэб сайтыг бүтэц зохион байгуулалтыг боловсруулан хийж аймгийн вэб сайттай холбон үйл ажиллагааны болон хэрэгцээт мэдээллүүдээр баяжуулснаар иргэд уншигчид цаг хугацаа орон зай харгалзахгүй мэдээлэл олж авах нөхцөл бүрдсэн.

Тав: Ном хэвлэлийг сэргээн засварлалт

1. Уншлагын танхим бүр ойрын фондод байгаа ном, хэвлэлийг өөрсдийн нөөц бололцоогоор сэлбэн сайжруулж нийт 83 номыг сэргээн засварласан.
2. Насанд хүрэгчдийн уншлагын танхимд шинээр ирсэн 121 номонд нууцлалын ялтас суулгаж ном алдагдахаас хамгаалсан.

Зургаа: Боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх, ажиллах нөхцлийг сайжруулах

1. Нийтийн номын сангийн ажилтан албан хаагчдын үр дүнгийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж мэргэжлийн болон туслах албан хаагчдын 2 хүнийг “Хөдөлмөрийн аварга”-аар шалгаруулан шагнаж урамшуулсан.
2. Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг байгууллагын хүрээнд тэмдэглэн өнгөрүүлж, ажилтан албан хаагчдынхаа хүүхдүүдэд байгууллагын зүгээс бэлэг гардуулсан.
3. Монгол улсын соёл урлагийн ажилтаны өдрийг аймгийн соёлын байгууллагуудтай хамтран тэмдэглэн өнгөрүүллээ. Нийтийн номын сангаас номын санч Д.Бадамцэцэг, жижүүр Б.Үнэнбат нар аймгийн Засаг даргын жуух бичгээр, үйлчлэгч Б.Долгор БСГ-ын хүндэт өргөмжлөлөөр шагнагдлаа. Арга хэмжээний үеэр спортын сонирхолтой тэмцээнүүдийг зохион явуулахад манай байгууллагын баг тамирчид амжилттай оролцож “Гар бөмбөг”-ийн тэмцээнд багаараа 3-р байр, эрэгтэй “Шатар”-ын тэмцээнд жижүүр Б.Батжаргал 1-р байр, эмэгтэй “Шатар”-ын тэмцээнд Номын санч Д.Бадамцэцэг 3-р байр, эрэгтэй “Ширээний теннис”-н тэмцээнд номын худалдааны Д.Батсайхан 1-р байр, эмэгтэй “Ширээний теннис”-н тэмцээнд

номын санч С.Бадамханд 3-р байр, “Дартс”-ын тэмцээнд багаараа 2-р байрыг тус тус эзэлсэн амжилттай оролцлоо.

4. Харилцагч байгууллагуудтай сар, улирал бүр холбогдох тооцоог хийж өр, авлагагүй ажилласан болно.
5. Аймгийн хэмжээний сум сургуулийн номы санч нарын сургалт семинарыг аймгийн БСГазартай хамтран зохион байгууллаа. Сургалт семинарт 67 номын санч хамрагдахаас 55 номын санч хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлсэн.
   Германы “Гёте- институт”-ын монгол дахь төлөөлөгчийн газраас зохион байгуулсан “Номын чимэглэлийн урлагаар уншигчдын эгнээг өргөжүүлэх нь” сэдэвт сургалт семнарт номын сангийн захирал, мэдээлэл-технологийн ажилтан нар хамрагдсан.
   Нийтийн номын сангийн номзүйч-фондоч Л.Долгор Үндэсний номын сангаас зохион явуулсан Солонгос, Монголын хамтарсан “Соёлын өвийн хадгалалт хамгаалалт” сургалт семинарт 3хоног сууж мэдлэг боловсролоо дээшлүүлсэн. Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Үндэсний бичиг үсгийн баяр”, “Номын яармаг-2010” арга хэмжээнд номын сангийн захирал оролцсон. 2010 оны байдлаар давхардсан тоогоор 60 номын санч сургалтанд хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлсэн нь өмнөх жилээс 6 %-р өссөн дүнтэй байна.
   Дэлгэрхаан, Борнуур, Баянжаргалан сум сургуулийн номын сан, 5-р сургууль, аймгийн музейн номын сангуудад номзүйч-фондоч Л.Долгор, Мэдээлэл технологи-хүний нөөцийн ажилтан Г.Батхолбоо, Номын санч С.Бадамханд, Г.Балжинням нар ажиллаж 12300 гаруй номонд ангилал хийж, 4070 ш номонд каталогийн карт бичиж үсэг дараалал төрөл ангийн каталоги зохион байгуулж мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэн номын сангийн бүртгэлүүдийг хөтлөх аргачлалыг зааж үйл ажиллагааг стандартын түвшинд хүргэсэн.
   Баянхангай, Угтаалцайдам, Заамар сумдын сум сургуулийн номын сангуудын үйл ажиллагаанд нь үнэлгээ өгч мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. Мөнгөнморьт, Архуст, Баянжаргалан, Дэлгэрхаан, Борнуур сум, сургуулийн шинээр орсон номын санч нарт мэргэжлийн чиг баримжаа олгох зорилгоор 3 хоногийн дадлагыг номын сан дээрээ хийлгэж мэдлэг чадварыг нь дээшлүүлсэн.
   Аймгийн хэмжээний “Номын санч” сонингийн 4-р улиралын дугаарт хэрэгцээт мэдээллүүдийг нийтлэж бэлтгэн иргэд номын санч нарт мэдээлэл хүрэглээ.

УВС АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2010 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Аймгийн төв номын сангийн хамт олон 2010 онд дотоод зохион байгуулалтын талаар 39 ажил, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх талаар 40 ажлыг хийж гүйцэтгэхээр зорилт тавьж 95%-ийн амжилттай гүйцэтгэлээ.

Манай хамт олон “Үйлчлүүлэгчдийнхээ оюуны эрэлт хэрэгцээг бүрэн дүүрэн хангаж чадахуйц хөгжлийн түвшинд хүрч, Номын санг иргэдэд үйлчлэх нээлттэй “Мэдээллийн төв” болгон хөгжүүлэх эрхэм зорилго тавин ажиллаж байна.

Үйл ажиллагаагаа төрөөс баримтлах соёлын бодлого, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн Засаг Даргын үйл ажиллагааны хөтөлбөр, МУ-ын Соёлын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгон түүнийг хэрэгжүүлэх бодлогыг баримтлан ажиллаж байна.

Дотоод ажлын талаар

2009 оны жил эцсийн мэдээ, тайланг хугацаанд нь үнэн зөв гаргаж аймгийн БСГ, БСШУ-ны яам, МҮНС-д хүргүүллээ. БСГ-ын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг тооцуулж БСГ-ын даргаас 95,4 оноо авч “Маш сайн” гэсэн үнэлгээтэй ажлаа дүгнүүллээ.

2009 онд ажилтнуудтай байгуулсан үр дүнгийн гэрээг дүгнэж байгууллагын оны аварга тэргүүнийг тодруулан шагнаж урамшуулав.

Ажилтнуудад 2009 оны ажлын тайлан тавьж санал бодлыг нь авч дараагийн ажлын төлөвлөгөөнд тусган ажиллаа. Мөн ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ, бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ , хариуцлагын гэрээ байгуулан ажиллаж байна.

Номын сангийн 2010 онд батлагдсан төсвийн тухай хамт олонд танилцуулж сар, улирлын хувиарыг мэдээлэв. Номын сангийн 2010 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан аймгийн БСГ-ын даргаар батлуулан мөрдөн ажиллаж байна.

Ажилтнуудад хариуцсан эд хөрөнгийн картыг шинэчлэн бүртгэж хүлээлгэн өглөө. 2009 оны санхүүгийн тайланг хамт олны хурлаар хэлэлцүүлэв. 2009 оны баримт бичгийг эмхлэн үдэж архивлав.

Номын сангийн 2009-2015 он хүртэл ажиллах стратеги төлөвлөгөөнөөс 2010 онд мөрдөн ажиллах ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.

2010 онд явуулах Соёл түмний ажлын ажлын графикийг гаргаж номын санч бүрээр ил тод байрлууллаа. 2010 онд ажиллах уншигчийн карт хэвлүүлэн орлогод авлаа. Байгууллагын 2009 оны бичиг баримтын тайланг ажилчдад танилцуулж санал хүсэлтийг нь тусган ажиллаж байна.

Аймгийн эрүүл мэндийн газартай хамтран байгууллагын ажилтнуудад эрүүл мэндээ хамгаалах талаар сургалт зохион байгууллаа. Номын сангийн ажилчдын гоо сайханы мэдлэгийг дээшлүүлэх, гоо сайхан байлгах зорилгоор Улаанбаатар хотын орифлеймийн зөвлөх Нордогийг урьж лекц уншууллаа.

Баруун монголын тууль хайлагч уралдааныг аймгийн ЗДТГ, Ойрад ХДТ-тай хамтран зохион байгууллаа.

Ажилтнуудаа бүрэн бүрэлдэхүүнээр нь Улаанбаатар хотод сургалтанд суулгаж мэдлэг боловсролыг нь дээшлүүлэхэд анхаарч ажиллалаа.

“Монгол бичгээр сайхан бичигтэн” шалгаруулах уралдааныг зохион байгуулж дүгнэн бүтээлүүдээр нь үзэсгэлэн гаргалаа.Номын фондтой холбоотой хууль тогтоомжийн заавар зөвлөмжийг эмхэтгэн үйл ажиллагаандаа ашиглаж эхлээд байна.

Номын санчдаас төлбөрт ирсэн 350 гаруй номонд техник ажиллагаа хийж данс бүртгэлд тусган үйлчилгээнд гаргалаа.

2010 онд манай номын сан нийт 29500 хүн 36011 ном олгож үйлчилсэн байна.

Аймгийн засаг даргын захирамж, засгын газрын шийдвэрийн дагуу 2 удаа нээлттэй хаалганы өдөр зохион байгуулахад номын үзэсгэлэн гарган оролцож Увс аймгийн хөдөлмөрчдөд үйлчиллээ.

Энэ онд манай номын сан 808 төрлийн 1046 ш 5502620 төгрөгийн ном хэвлэлээр фондоо баяжуулаж иргэдэд үйлчилсэн байна.

Аймгийн ИТХ- ын шийдвэр болон бусад баримт бичгүүдийг тогтмол авч нэгж болгон иргэдэд үйлчлэж байна. LIB4U программаар электрон каталогт орсон номыг бааз үүсгэн CD-д бичиж дугаарлан хадгалж байна.

Сум сургуулийн номын санчдыг арга зүйн удирдлагаар хангах зорилгоор ҮНС, ХНО-той хамтран 20 гаруй номын санчдыг улаанбаатар хотод 14 хоногийн сургалтанд хамрууллаа.

2010 онд төв номын сангийн шинээр нэвтрүүлсэн үйлчилгээг дурдвал:

Төв номын сангийн номын санчид шинэ ба сэдэвчилсэн номын үзэсгэлэн 55 удаа гаргаж ажиллсан байна.
Уншигчдыг шинээр үнэмлэхжүүллээ.
Өндөр хурдын 10 шинэ компьютертэй болсноор интернэт үйлчилгээг үндэсээр нь шинэчилэлээ.
Засаг даргын нэрэмжит үйлчилгээний шинэ танхимыг нээлээ. Фондын номыг иргэд компьютерээс сонголт хийж унших боломжтой боллоо.
Солонгосын шинэ тосгонтой холбогдож тэдний хөрөнгө оруулалтаар 3 сая төгрөгийн орчин үеийн шинэ номоор фондоо баяжуулж иргэдэд үйлчлэж байна.
Бүх ажилчидаа Улаанбаатар хотод сургалтанд хамруулаж ур чадварыг нь сайжрууллаа.
Улаанбаатар хотод ховор, үнэт номын дурсгалуудаар үзэсгэлэнг гаргаж суртчилалаа.
Шинэ номын мэдээг улирал тутам гаргаж байна.

2010 онд номын сангийн хамт олноос зохион байгуулсансоёл олон түмний ажил

Ахмадын хороо, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо, эрдэм оргил цогцолбор сургууль, Шинэ ирээдүй цогцолбор сургууль, 10-р багийн иргэдэд зөөврийн номоор үйлчиллээ. Аймгаас зохион байгуулсан иргэдэд үйлчлэх нээлттэй хаалганы өдрийн арга хэмжээнд 2 удаа оролцож үйл ажиллагаагаа сурталчиллаа.
Орон нутгийн телевизээр улирал тутам, монгол телвизээр 1удаа, 25 телвизээр 1 удаа номын сангийн үйл ажилгааны талаар сурталчилгаа явуулсан байна.
Оны рекорд номоор Робэрт Т. Киуозаки, Шарон Л. Лэктор нарын хамтын бүтээл “Баян аав, ядуу аав“, Ренчингийн “Заан залуудай” хэмээх номууд шалгарсан байна.
2007-2008онд УИХ-с гаргасан хуулиудаар хуулийн номзүй хийж уншигчдад үйлчилж байна.
Үндэсний бичиг соёлоо дээдлэх, дэлгэрүүлэх хөтөлбөрийн дагуу сайхан бичигтэн уралдааныг зарлаж 56 бүтээл ирснээс 1-р байрѝнд ШИЦС-ын багш Уранчимэг 2-р байрѝнд ЭОЦС-ын Нар мандах 3-р байранд УГК-н сурагч Энхбаяр нар шалгарч алт, мөнгө, хүрэл медалын эзэн боллоо.
Баруун монгол ардын тууль хайлаачдын наадмыг аймгийн БСГ, ХДТ-тай хамтран зохион байгууллаа.

Монголын багш нарын баярыг тохиолдуулан “Багшдаа би хайртай” гар зургийн уралдаан зохион байгуулж ЭОЦС-ын сурагч Биря шагналт байранд орлоо
Мэргэжлийн ном сурталчилах сарын аяныг УГК-тай хамтран зохион байгуулахад Бадамцэцэг багштай анги бусдыгаа хошуучлан оролцлоо
Төв номын сангаас “Эх дэлхийгээ хайрлая” сэдэвт яруу найргийн баярыг аймгийн Байгаль орчны газартай хамтран зохион байгуулах үйл ажиллагаанд 20 оролцогч амжилттай оролцож 120000 мянган төгрөгөөр шагнууллаа.
Залуу номын санч дугуйланг номын санч Жаргал зохион байгуулан ажиллаж байна.
Төрийн соёрхолт зохиолч Р. Чойномын амьдрал уран бүтээлийн талаар дурсамж ярилцлагыг Чандмань- эрдэм сургуулийн багш Цагаанбилэгтэй хамтран 10,11 –р ангийн сурагчдын дунд зохион байгууллаа.
Шилдэг хувийн номын сантай айл өрх шалгаруулах уралдааныг хаан банктай хамтран зохион байгуулàхад 1-р байранд ХДС-ын менежер Батжаргал 2-р байранд ШИЦС-ын менежер Жавхлантөгс 3-р байранд багш Буянаа нар шалгарч өргөмжлөл мөнгөн шагнал дурсгалын зүйлээр шагнуулав.

Байгууллагын удирдлага зохион байгуулалтын талаар

Увс аймгийн Төв номын сан 2010 онд зохион байгуулалтын талаар 39 ажил, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх талаар 40 ажил нийт 79 ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөгөө гарган аймгийн БСГ-ын даргаар батлуулан ажиллаа. Нийт төлөвлөсөн ажлын биелэлт 95% -тай байна.

Байгууллагын удирдлага 2010 оны ажлаа 3 чиглэлд төрөлжүүлэн зохион байгууллаа.

1. Аймгийн засаг дарга, БСШУ-ны сайдтай байгуулсан бүтээгдэхүүний гэрээний биелэлтийг ханган биелүүлэх
1. Байгууллагын хүний нөөцийг чадваржуулах
2. Байгууллагын орчин нөхцөлийг сайжруулах

Аймгийн засаг дарга БСШУ-ны сайдтай байгуулсан бүтээгдэхүүний гэрээг номын сангийн захирал аймгийн БСГ-ын даргатай байгуулан ажиллаж 95,4%- ын биелэлтэй ажлаа дүгнүүллээ.

1. Байгууллагын хөгжлийн гол хүчин зүйл бол тухайн байгууллагын ажилтны чадвараас шууд хамаардаг. Иймээс номын сангийн захирал ажилтнуудаа чадваржуулах, сургах, мэргэшүүлэх, боловсролын зэрэг цол ахиулахад гол анхааралаа чиглүүлэн ажиллалаа. Үүний үр дүнд байгууллагын удирдлага СУИС-ын Соёл урлагийн удирдлагын магистирт суралцаж байна. Ажилтан Ч. Жаргалыг СДС-ын номын санч-мэдээлэлийн ажилтаны ангид дэмжин сургаж төгсгөлөө.

   Номын сангийн нийт ажилтануудыг “100 сонсохоор нэг үз” гэдэг монголын зүйр үг байдагчлан ажлаа сайжруулах, туршлага солилцох, өөрийн нүдээр шинэ орчин нөхцөлтэй танилцах, мэргэшсэн мэргэжилтэнүүдийн хичээлийг сонсох, шаардлагатай гарын авлага олж авах, Улаанбаатар хотын соёлтой танилцуулах зэрэг ажлын олон талт үр нөлөөг бодолцон ХНО, ҮНС- тай гэрээ байгуулан хамтран ажиллаж сургалт явуулан ур чадварыг нь сайжруулж шинэ мэдээллээр хангалаа. Ажлын үр дүнг улирал тутам дүгнэн урамшуулал олгож байна. Улаанбаатар хотод 25TV-р хэвлэлийн бага хурал хийж өөрийн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй тайлагнаж ажилласны үр дүнд 2477120 төгрөгийн шинэ номыг бэлэг, хандивын журмаар авч номын сангийн фондоо баяжууллаа.

2. Номын сан нь үйлчилгээний байгууллага учраас уншигч үйлчлүүлэгчдийн тав тухыг хангасан орчин нөхцөлтэй байх ёстой. Ийм учраас байгууллагын удирдлага нь үйлчилгээнийхээ 3 танхимыг тохижуулан заслаа.

   1-р танхимыг Засаг даргын хөрөнгө оруулалтаар тохижуулж Засаг даргын нэрэмжит танхим болголоо.

   2-рт хүүхдийн уншлагын танхимыг солонгосын шинэ тосгонтой холбоо тогтоон тохижууллаа.

3. Интернэт мэдээллийн танхимийн материаллаг баазыг бүрэн бэхжүүллээ.

Засаг даргын мөрийн хөтөлбөрт орсны дагуу 10 ш шинэ компьютерээр интернэт танхимын хуучин компьютерүүдийг бүрэн шинэчиллээ.

Үүнээс гадна солонгосын шинэ тосгонтой байгуулсан гэрээ ёсоор 400 нэр төрлийн 4сая төгрөгийн орчин үеийн номыг худалдан авч өгсөн нь бидний үйлчилгээнд болон, үйлчлүүлэгчдын сэтгэлд хүрсэн арга хэмжээ болж байна. Улаанбаатар хотод номын сангийнхаа соёлын үнэт ховор, ховордсон номоор үзэсгэлэн гаргасан нь орон нутагуудын хэмжээнд анхдагч ажил боллоо. Энэ үзэсгэлэнг 5 чиглэлээр гаргасан нь үзэгчдийн таашаалд нийцсэн ажил боллоо.

Байгууллагын дотоод хяналт шинжилгээний талаар

Байгууллагын дотоод хяналт шинжилгээ хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна. Байгууллагын дотоод хяналт шинжилгээгээр хийх ажлуудын ерөнхий чиглэл нь:

1. БСГ-ын даргатай байгуулсан бүтээгдхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ, байгууллагын жилийн ажлын зорилт биелэлтэнд хяналт тавих
2. Ажилчдын ажлын цаг ашиглалт, хөдөлмөрийн бүтээмжид хяналт тавих
3. Байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, ашиглалт хамгаалалтанд хяналт тавих
4. Байгууллагын төсөв, санхүүгийн зарцуулалт, ил тод байдалд хяналт тавих
5. Байгууллагын мэдээ, тайланг цаг хугацаанд нь үнэн зөв гаргаж холбогдох газаруудад хүргүүлж байгаа эсэхэд хяналт тавих
6. Байгууллагын бичиг баримтын эмх, цэгц, архив хөтлөлтийн үйл ажиллагааг стандартын түвшинд байлгахад хяналт тавих зэрэг ажлууд байна.
7. Номын сангийн үйл ажиллгаанд мөрдөн ажиллах стандарт, дүрэм, журам хөтлөгдөх бүртгэл тооцооны хөтлөлтийг улирал дутам шалган дүгнэж зааварчилгаа өгөн ажиллаж байна.
8. Сайн ажилсан ажилтанг алдаршуулах, жилийн эцэст ажлаа дүгнэж байгууллагын аварга, тэргүүний шалгаруулах, аймгийн болон яамны, засгийн газрын шагналд тодорхойлох зэрэг урамшууллын дэмжлэг үзүүлж байна.

Хууль тогтоомж , шийдвэрийн
хэрэгжилт түүний үр дүн

Номын сан нь үйл ажиллагаандаа Монгол Улсын төрөөс баримтлах соёлын бодлого, Соёлын тухай хууль , Засгийн газрын болон аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт Монгол Улсын хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль эрх зүйн актыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Номын сангийн хамт олон нь МУ-ын хууль тогтоомжийг нийтэд сурталчилах зорилгоор төрийн мэдээлэл, хууль зүйн мэдээлэл сэтгүүл, хууль зүйн мэдээ сонинг улирал тутам захиалж уншигч үйлчлүүлэгчдийн хэрэгцээнд гаргаж байна.

УИХ-с гарсан хуулиуд, Засгийн Газраас гарсан тогтоол шийдвэрүүдээр сүүлийн 5 жилд ном зүйн бүртгэл хийж иргэдэд сурталчилан ашиглуулж байна.

Хууль эрх зүйн чиглэлээр гарсан шинэ ном хэвлэлүүдээр фондоо баяжуулж байна.

40 гаруй хуулиар хувийн хэрэг бүрдүүлэн нийтэд сурталчилан ажиллаа.

Аймгийн засаг даргын үйл ажиллагааны 2009-2012 онд хэрэгжүүлэх хөтөлбөрөөс номын сангийн талаар тусгагдсан заалтанд хувийн хэрэг нээн ажиллаа.

БСШУ-ны сайдын 2007.11.08.-ны өдрийн 415-р тушаалаар батлагдсан Аймаг, нйислэлийн нийтийн номын сангийн үлгэрчилсэн дүрмийг үндэслэн номын сангийнхаа ажиллах дүрмийг боловсруулан хамт олны хурлаар батлан ажиллаж байна.

МУ-ын ЗГ-ын 2008-2012 оны мөрийн хөтөлбөрт номын сантай холбоотой 1.2.22-р заалт гарсан .Үүнийг хэрэгжүүлэх зорилгоор Аймгийн Төв номын сангаас 2009-2010 он хүртэл уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг гарган ажиллаа.

Аймгийн Төв номын сан нь Увс аймгийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа бүх номын сангуудад арга зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаанд нь туслах зорилгоор БСШУ-ны яамнаас 2005-2008 онд номын сангийн талаар гарсан тушаал шийдвэрээр сэтгүүл гарган хүргүүллээ.

БСШУ-ны сайдын 441-р тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн хэмжээний номын санч нарын дунд сургалт семинар зохион байгуулж номын сангийн бүртгэлүүдийг хөтлөх талаар бичмэл сэтгүүл гарган хүргүүллээ.

Номын сангийн бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Стандартчилал хэмжил зүйн үндэсний зөвлөлийн тогтоолоор батлагдсан шинэ стандартыг мөрдөн ажиллах ажлын хүрээнд холбогдох хууль журмыг үндэслэн өөрийн байгууллагын ажил албан тушаалын жагсаалт, байгууллагын үйл ажиллагааны дотоод журам ,ажиллах дүрмийг шинэчлэн боловсруулж хамт олны хурлаар хэлэлцүүлэн байгууллагын даргын тушаалаар баталгаажуулан ажиллаж байна

Дээрх стандартын дагуу Номын сангийн орчны нөхцөл үйл ажиллагаанд тавих үндсэн шаардлагад нийцүүлэн ажиллах талаар санаачлага гарган ажиллаж байна.

Монгол Улсын ЗГ-с хэрэгжүүлж байгаа “Монгол бичиг”-ийг хөгжүүлэх, дээдлэх үндэсний бичгээ сэргээх, хүүхэд залууст эзэмшүүлэх, өвөг дээдсээс уламжлан ирсэн өв соёлоо хадгалж хамгаалах зорилготой үндэсний томоохон хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор жил бүр “Монгол бичгээр сайхан бичигтэн” уралдаан зарлаж бүтээлүүдээр нь үзэсгэлэн гаргаж байр эзлүүлэн тодорсон эзнийг нь шагнан урамшуулж байна.

Мэдээллийн дотоод сүлжээ вэб үйлчилгээний талаар

2010 онд номын сангийн дотоод сүлжээний программын хүчин чадлыг сайжруулсан. Мэдээллийн технологичийг улаанбаатарт сургалтанд хамруулсан. Улирал тутам вэб хаягаар суртчилгаа явууллаа. Нийт номын 90% -ийг электрон каталогид оруулсан. Уншигчид фондын номын лавлагааг компьютерээс сонгох боломжтой боллоо. Уншигчдыг үнэмлэхжүүллээ.

Байгууллагын санхүүгийн байдал

Манай байгууллага 2010 онд 89420700 төгрөгний төсөв батлагдсаны дагуу үйл ажиллагаа явуулж жил эцэсийн дүнгээр 89420700 төгрөгийн гүйцэтгэлтэй гарлаа. Төсвийн өр болон авлага байхгүй. Өөрийн үйл ажиллагааны орлого 15000000 төгрөгийг 100% оруулж ажиллаа. БСШУ-ны сайдын 2010.08.30-ны өдрийн 380 тоот тушаалын дагуу 2533000 төгрөгийн ном хэвлэлээр фондоо баяжуулснаас гадна өөрийн сурталчилгаанаас хандив, бэлгийн журмаар 2477120 төгрөгийн шинэ номоор фондоо баяжууллаа.

Төсвийн зарцуулалт үр дүн:

№	Зарлагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл
1.	Үндсэн цалин	37625000	37625000
2	НДШ	4138800	4138800
3.	Бичиг хэрэг	480000	480000
4.	Гэрэл цахилгаан	859177	859177
5.	Түлш халаалт	31885597	31885597
6.	Тээвэр шатахуун	903500	902955
7.	Шуудан холбоо	480000	480000
8.	Цэвэр бохир ус	737326	737326
9.	Дотоод албан томилолт	2153700	113400
10.	Нормын хувцас зөөлөн	1000000	243500
11.	Урсгал засвар	960000	247760
12.	Төлбөр хураамж	258400	217600
13.	Ном хэвлэл	492500	492500
14.	Соёл урлагын сан/ шинэ ном/	2533000	253000
15.	Нэг удаа тэтгэмж	400000	400000
16	Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж	4513700	4513700
17	Зардлын эх үүсвэр	89420700	89420155
	үндсэн үйл ажиллагааны орлого	1500000	1500000
	Төсвөөс санхүүжилт	87920700	87920700
	Дүн		

Манай байгууллага 2010 онд 87920700 төгрөгний төсөв батлагдаж үйл ажиллагаа явуулсанаас 87920700 төгрөгний гүйцэтгэлтэй гарлаа.

Төсвийн өр авлага байхгүй. Өөрийн үйл ажиллагааны орлого 1500000 төгрөг олохоос 1500000 ₮ олж өөрийн орлогыг 100 хувь биелүүлсэн.

Хөтөлбөрийн хэрэгжилт

- Монгол Улсын Засгийн Газрын 2008-2012 оны мөрийн хөтөлбөрт номын сантай холбоотой 1.2.22-р заалт гарсан. Үүнийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Төв номын сангаас 2009-2010 он хүртэл уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаа.
- Аймгийн Засаг даргын 2009-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт номын сантай холбоотой заалтаар хэрэгжих ажлын төлөвлөгөө гарган ажиллаа.

Хяналт шинжилгээ, тайлан мэдээний байдал:

- Номын сан нь статистикийн СУ-3, СУ-10, СУ-15 гэсэн 3 төрлийн мэдээг гаргаж өгдөг. Үүнээс СУ-3 мэдээг улирал тутам, СУ-10 СУ-15 мэдээг жил эцсээр гаргаж аймгийн БСГ, Статистикийн хэлтэс, ҮНС-д хүргүүлж хэвшсэн.
- Байгууллагын ажилчдаас болон үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авч үйл ажиллагаандаа тусган ажиллаа.
- Номын сангийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллах стандарт, дүрэм, журам хөтлөгдөх бүртгэл тооцооны хөтлөлтийг улирал тутам шалган дүгнэж зааварчлагаа өгөн ажиллаа.
- Сайн ажилласан ажилтанг алдаршуулах, жилийн эцэст ажлаа дүгнэж байгууллагын аварга, тэргүүнийг шалгаруулах, аймгийн болон яамны ,ЗГ-ын шагналд тодорхойлох зэрэг урамшууллын дэмжлэг үзүүллээ.

Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байдал

- Сурч боловсрох, мэдлэг боловсрлоо дээшлүүлэхэд нь байгуулагаас цалинтай чөлөө олгон сургаж байна.
- Байгууллагын зардлаар бүх ажилчдыг улаанбаатар хотод сургалтанд хамруууллаа.
- Эмч нарын зөвлөлгөөний шийдвэрийн дагуу эмчилгээнд явах, рашаан сувилалд амрсан ажилчдад тэтгэмж олгож байна.
- Монгол улсын хөдөлмөрийн хуулинд заагдсан тэмдэглэлт баяр ёслолын үеэр ажилчдад хүндэтгэл үзүүлж гарын бэлэг, дурсгалын зүйл өгөхөөс гадна байгууллагын зардлаар аялал зугаалганд оролцуулж байна.
- Ажилчдын амьдралд тулгамдсан асуудлаар дэмжлэг үзүүлэн тодорхой хэмжээний цалинтай чөлөө олгож байна.

  Сайн ажилласан ажилчдыг урамшуулах, шагнах, аврага тэргүүнээр шалгаруулах зэрэг арга хэмжээ авлаа.

Мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх талаар

- 2010 онд аймгийн төв номын сангийн хамт олон бүрэн бүрэлдхүүнээр Улаанбаатар хотод ҮНС, ХНО –той хамтран 14 хоногийн сургалтанд хамрагдж мэргэжил мэдлэгээ дээшлүүлсэн.
- Номын санд мэргэжлийн 6 номын санч ажиллах ёстой. Одоогийн байдлаар 100% мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байна.
- Номын санч Цэндхүү улсад хөдөлмөрөө үнэлүүлэн алтангадас одон авсан бол номын санч Сүрэнжав, Бадам, Лхагважав нар Монгол улсын СТА-ны цол тэмдэгээр шагнагдсан байна. Жаргал, Мөнхцэцэг нар өсөх ирээдүйтэй мэргэжлийн залуу боловсон хүчнүүд юм.
- 2010 онд мэргэжлийн номын санчид Улаанбаатар хотод бүрэн бүрэлдхүүнээрээ сургалтанд хамрагдаж мэргэжил мэдлэгээ дээшлүүлсэн.
- Номын санч Сүрэнжав 2удаа, Бадам 1удаа аймгийн аврага тэргүүнээр шалгарч шагнуулж байсан нь одоогоор ажиллаж байгаа мэргэжлийн боловсон хүчний чадвар боломжийн байна.

- **Сахилга хариуцлагын талаар:**
    - Ажилчдын ажлын хариуцлага, сахилга, дэг журамыг цаг ямагт сайжруулахын тулд ажилчидтай үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээ, хариуцлагын гэрээ байгуулан улирал тутам дүгнэн ажиллаж байна.
    - Цаг ашиглалтыг сайжруулах сахилга хариуцлагыг өндөржүүлэх талаар 2010 онд байгууллагын даргын 3 удаагийн тушаал гарсан байна.
    - Байгууллагын дотоод хяналт шалгалтын хуваарийг гаргаж, хяналт шалгалт хийн шалгалтын мөрөөр арга хэмжээ авч ажиллаа.
    - Цаг ашиглалтын байдалд байгууллагын ня-бо өдөр тутам дэвтэр хөтлөж тэмдэглэн ажиллаж байна
    - Монгол улсын төрөөс баримтлах соёлын бодлого, соёлын тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг хавтас нээн эмхэтгэн нийтэд сурталчилж байна

Фондын хадгалалт хамгаалалтын талаар

- Увс аймгийн номын сан нь 71200 ш боть номтой
- Фондын номын хадгалалт хамгаалалт, орчин нөхцлийг нь сайжруулах талаар тусгай төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.
- 2010 онд фондын нийт номын ялгагч ба хаягжуулах ажлыг шинчиллээ.
- Улирал тутам номыг стандартын дагуу ариутгах, хортон шавьжаас хамгаалах ажлыг тогтмолжуулалаа.
- Энэ онд 5000ш номыг сэлбэн засах зорилт тавьж 6000ш номыг сэргээн засварлаж ажилласан нь төлөвлөгөөгөө 1,2%-р давуулан биелүүсэн байна.

Төв номын сан

Номын сан өөрийн эмблемтэй боллоо

Номын сангийн эрхэм зорилго

Àéìãèéí çàñàã äàðãûí íýðýìæèò уншлагын òàíõèì

Фестюль тохижуулсан байдал

Õ¿¿õäèéí óíøèëàãûí òàíõèìыг
солонгосын шèíý òîñãîíû õºðºíãº
oðóóëàëòaap тохижуулав.

Сэдэвчилсэн номын үзэсгэлэн

Шинэ номын үзэсгэлэн

Сэдэвчилсэн номын үзэсгэлэн

Óíøèã÷ эëåêòðîí êàòàëîãîîñ
õàéëò õèéæ áàéãàà íü

Хүүхдийн танхимын шинэ номын үзэсгэлэн

Улаанбаатар хотод бүрэн бүрэлдэхүүнээрээ сургалтанд

Улаанбаатар хотод болсон Номын санчдын сургалтын үеэр

Улаанбаатар хотод зохиогдсон эдийн засгийн форум соёлын өдрүүдийн үеэр СТӨ-ний фестюльд гаргасан номын үзэсгэлэн дээр

Бид байгууллагынхаа аврагыг жил бүр шалгаруулдаг уламжлалтай

Соёл олон түмний ажлаас

“Монгол бичгийн сайхан бичигтэн” шалгаруулж байгаа нь

"Миний мэргэжил сайхан" бүтээлийн үзэсгэлэн





ХОВД АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН
2010 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2010.12.27

Ховд аймгийн Нийтийн номын сан нь 2010 онд 72 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна. Монгол Улсын засгийн газраас Соёлын байгууллагын талаар дэвшүүлсэн зорилт, төрийн бодлого, шийдвэр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гол анхаарлаа хандуулан ажиллалаа.

Бид оюуны хурдацтай хөгжил бүхий мэдээллийн эрин зуунд цаашид номын санг, иргэдийн зөвхөн ном унших уншлагын газар биш, тэд ном уншихын зэрэгцээ сүүлийн үеийн мэдээ, мэдээллээр хангагдаж өөр хоорондоо мэдээлэл солилцож байх "Мэдээллийн төв" болгон хөгжүүлэх зорилготой ажиллаж ирлээ.

2010 онд манай байгууллага үйлчилгээний чанарт ахиц гаргаж, төлөвлөгөөт үзүүлэлтээ биелүүлэх, номын фондыг баяжуулан, техник тоног төхөөрөмжөөр хангах, барилгын их засвар хийж, материаллаг баазаа бэхжүүлэх зэрэг олон зорилтот ажил дэвшүүлэн ажилласан.

Уншлага үйлчилгээний талаар

Бид ажлаа сар улирал жилээр төлөвлөж, гүйцэтгэлийг нь шалгаж тухай бүрд нь дүгнэж ажлын хариуцлага тооцон ажиллахаас гадна, Аймгийн Боловсрол, Соёлын газар, Нийгмийн бодлогын хэлтэстэй бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гурвалсан гэрээ байгуулан ажиллалаа.

2010 онд манай байгууллага Мэдээлэл, ном зүйн тасаг, номын сангийн фондын тасаг, Эрдэм шинжилгээ, чөлөөт уншлагын танхим, Уншлагын их танхим, Хүүхдийн Үл мэдэх танхим, Америкийн соёл мэдээллийн төв зэрэг тасаг танхимуудын жигд ажиллагааг бүрэн ханган ажиллалаа.

Мэдээлэл, ном зүйн тасаг нь Номын тооллогын ажлыг цэгцлэх, номоо ДДС-ийн ангилалд оруулах, данс бүртгэлийг шинэчлэх ажлыг бүрэн хийж дууссан бөгөөд нийт номыг төрөл анги, үсэг дарааллын каталог шинээр байршуулж 30%-ийг электрон каталогт орууллаа.

Тус тасаг 2010 онд шинээр ирсэн 739 номонд ном зүйн ажиллагаа хийж уншлага үйлчилгээнд оруулав.

Номын фондын тасаг нь фондондоо 66388 мянган ном агуулж, жилдээ 2360 номыг уншлага үйлчилгээний 5 тасаг танхимуудад захиалгын дагуу хувиарлан олголоо. Мөн шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн 22 удаа гаргаж сурталчиллаа.

Уншлагын их танхим нь манай байгууллагын хамгийн их үйлчлүүлэгчидтэй, цаг ямагт ачаалалтай байдаг танхим юм. Энд ЕБС-ийн 8-11 ангийн сурагчид хамрагдаж бие даасан байдлаа хөгжүүлж, дотоод гадаадын сор болсон бүтээлүүдээр үйлчлүүлдэг. Тус танхим нэг ээлжиндээ 100 уншигч суух суудалтай бөгөөд энэ онд тус танхимаар 1300 уншигч карт нээлгэж, 18261 ирцэд 29100 ном олгогдов. Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн 16 удаа гаргаж сурталчиллаа.

Хүүхдийн номын өргөөнд ЕБС-ын 1-7 ангийн сурагчид уншлаганд хамрагдаж "Үл мэдэх", "Их мэдэх "гэсэн 2 танхимд хуваагддаг бөгөөд 2009 оны 6 сараас их мэдэх танхим ажиллаагүй болно. Учир нь уг танхимд Албан бусын сургалт явуулах шаардлага гарсан тул өрөө тасалгаа хүрэлцээгүй улмаас уншигчдыг бусад 2

танхимд хувааж байршуулав. Тус танхимуудаар энэ онд 1300 уншигчид карт нээлгэж, 17600 ирцэд 27618 ном олгож уншууллаа. Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн 14 удаа гаргаж сурталчиллаа.

Тус танхимын номын санчид ном уншуулахаас гадна сурагчдыг номтой нөхөрлүүлэх талаар сургууль, анги хамт олон болон багш, эцэг эхчүүдтэй хамтран ажиллаж тэдний дунд танин мэдэхүйн олон талт арга хэмжээнүүдийг байнга зохиодог. Энэ бүхнийг жилийн эцсээр дүгнэж "Тэргүүний уншигч анги хамт олон", "Шилдэг хамтрагч сургууль" зэргийг шалгаруулж шилжин явах хаяг, дарцаг гардууллаа.

Насанд хүрэгчдийн уншлагын танхим нь Иргэд болон оюутан сурагчид багш нарын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх тэдний танин мэдэхүйг хөгжүүлэх, судалгаа, эрдэм шинжилгээний ажил явуулахад нь туслах зорилгоор байгуулагдсан. Ойрын фондондоо 3600 орчим номтой уг танхим жилдээ 465 уншигчид карт нээж, 6750 ирцэд 10200 ном хэвлэл олгож үйлчиллэхээс гадна уншигчдынхаа дунд танин мэдэхүйн олон арга хэмжээг удаа дараа явуулж байна. Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн 8 удаа гаргаж сурталчиллаа.

Гэрээр ном олгох тасаг нь 2008 онд аж ахуйн нэгж, албан байгууллагуудын дунд "Оюуны банк таны гэгээрэхийн үндэс" сэдэвт болзолт гэрээг жилийн хугацаанд байгуулж уг арга хэмжээнд 20 гаруй байгууллага оролцлоо.Тус тасаг жилийн хугацаанд 450 уншигчд карт нээж, 4250 ирцэд 9250 ном хэвлэл олгож шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн 8 удаа гаргаж сурталчиллаа.

Америкийн соёл мэдээллийн төв нь Энэ төв нь байгуулагдаад 4 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байна. Гадаад хэл суралцагчдад зориулсан сурах бичиг техник хэрэгсэлээр бүрэн хангагдсан уг танхимаар насны хязгаарлалтгүй, хэн бүхэн хамрагдах боломжтой бөгөөд 2010 онд 450 уншигчид карт нээж, 4000 ирцэд 7550 ном хэвлэл олгон үйлчилсэн байдаг. Байгуулагдсан цагаас хамрагсдын хүрээ улам өргөжсөн ба энэ онд 6000 минутын үнэгүй интернет ашигласан байна. Тус тасгаас шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн 8 удаа гаргаж сурталчиллаа.

Тэрээр Англи хэлний ярианы клубаар 408, сургалтанд 52, ганцаарчилсан зөвлөгөөг 83 хүнд өгч 660 хүнийг лекцэнд хамруулжээ. Тус төвийн үйлчлүүлэгч оюутан сурагчид, уншигч иргэдийн дунд Англи хэлний мэргэжилтэн нар байнга сургалт семинар явуулдаг бөгөөд энэ онд Нийтийн номын сан Энх тайвны корпустай хамтран Вагнер Лоураг гэрээгээр ажиллуулж байна. Гадаад мэргэжилтэн Англи хэл заах болсоноор англи хэл сонирхогчдын тоо нэмэгдэж, сургалтын чанар сайжрах боллоо.

Америкийн соёл мэдээллийн төвөөс сурагчдын англи хэлний мэдлэг боловсрол дээшлүүлэх зорилгоор "Access" хөтөлбөрийн 5 дахь шатны сургалтанд хамрагсадыг шалгаруулж авлаа. Үүнд нэгдүгээр шатанд нийтдээ 57 сурагч оролцсоноос 10 хүүхэд тэнцэж шалгарлаа. Эдгээр хүүхдүүд англи хэлийг 2 жилийн

хугацаанд Америкийн элчин сайдын яамны зардалаар үнэ төлбөргүй суралцах юм. Одоогоор уг шалгалтанд тэнцсэн 10 хүүхэд сургалтандаа хамрагдаж хичээл нь жигд явагдаж байна.

Америкийн соёл мэдээллийн төвөөс оюутан сурагчдын Англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор танин мэдэхүйн олон талт арга хэмжээ авч явууллаа. Үүнд "Хүний наймааны хэргээс урьдчилан сэргийлье", "Англи хэл сурах алтан зарчим" лекцүүдийг уншиж, "Гэр бүл хүчирхийлэл" сэдэвт семинар зохион байгууллаа.

Америкийн мэдээллийн төвийн үйл ажиллагаатай танилцах "Access" хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдэд сертификат гардуулах зорилгоор АНУ-ын элчин сайд С.Эдлтон, Олон нийттэй харилцах албаны дарга Марися, мэргэжилтэн Отгон нар 2010 оны 06 сарын 16нд манай байгууллагад ажиллаад буцлаа. Тэрээр Англи хэл суралцаж буй хүүхдүүдийг өндрөөр үнэлж ном сурах бичиг гардууллаа.

Тэд Ховд дахь соёл мэдээллийн төв зохих түвшинд ажиллаж, үйл ажиллагаа нь тогтмолжин жилээс жилд өргөжин хөгжиж байгаад талархал илэрхийлээд цаашид хийх ажлын төлөвлөгөөг хамтран төлөвлөөд буцлаа.

Уншигчдын хэрэгцээ шаардлага хангах, иргэдэд мэдээлэл түгээх, тэднийг номын сангийн үйлчилгээнд татан оролцуулах олон талт арга хэмжээ зохион явуулсны үр дүнд 2010 онд фондыг 739 номоор баяжуулж, 3961 уншигчдад карт нээж, 50861 ирцэд 83718 ном хэвлэл олгон үйлчиллээ.

Нийтийн номын сангийн 2010 оны уншлага үйлчилгээний мэдээ

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө /жилээр/	Гүйцэтгэл	хувь
1	Номын фонд	500	739	148
2	Байнгын уншигч	3800	3961	104%
3	Олгож уншуулсан ном	75000	83718	111%
4	Ирц	45000	50861	113%

Уншлага үйлчилгээний үзүүлэлтийг сүүлийн таван жилээр гаргавал:

		2006	2007	2008	2009	2010
1	уншигч	2867	3525	4549	4000	3961
2	Ирц	35112	44750	50000	45500	50861
3	Ном олголт	60051	76758	81415	75000	83718
4	фондын баяжилт	778	925	1275	750	739





Соёл олон түмний ажил

2010 онд номын сангийн тасаг танхимуудаас иргэдийг гэгээрүүлэх, тэдний оюун, танин мэдэхүйг хөгжүүлэх зорилгоор сургалт сурталчилгааны олон талт арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

Оны эхний 9 сарын байдлаар танин мэдэхүйн уралдаан тэмцээн 23 удаа явуулж түүнд 774, тойм яриа 23 удаа зохион байгуулж 625, Урилгат уншлага 35 удаа зохион байгуулж 686 уншигч оролцож, 5 удаагийн номын өдөрлөг 342, үйлчлүүлэгч, дүрийн тоглолт 2 удаа явуулж 71 уншигч тус тус оролцож 38 удаагийн шинэ болон сэдэвчилсэн номын

үзэсгэлэн гаргаж сурталчиллаа. Үүнд ЕБС, түүний анги хамт олны дунд Монголын

багш нарын баярыг тохиолдуулан “Багшдаа барих миний бэлэг”, Олон улсын эмэгтэйчүүдийн баяраар “Ээждээ барих миний бэлэг”, сэдэвт уншлага үйлчилгээний аян зохиохоос гадна уран зураг, зохион бичлэгийн уралдаан зарлаж дүгнэлээ. Оны эхнээс Их зохиолч Д.Нацагдоржийн мэндэлсний 103 жилийн босгон дээр БСШУЯ-ны сайдын 211 дүгээр тушаалыг үндэслэн сурагчдыг ном хэвлэлтэй нөхөрлүүлэх үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих зорилгоор Д.Нацагдоржийн тэмдгийн болзол, журмыг бүх сургуулиудад хүргэн танилцууллаа. Үндэстэн ястнуудын түүх соёлоос суралцах, түүхэн өв уламжлал хадгалах, хамгаалах зорилгоор Тува үндэсний түүх соёл, хэл, ёс заншил сэдвийн хүрээнд эрдэм шинжилгээний бага хурал зохион байгууллаа. Энэ үеэр иргэдийн дунд танин мэдэхүйн АХА тэмцээн явуулж 38 тува иргэн оролцож мэдлэг оюунаа сорив. 2010 оны 05 сарын 18-20 ны өдрүүдэд Аймгийн БСГ-тай хамтран сум сургуулийн номын санчдын дунд сургалт семинар зохион байгууллаа. Үүнд 28 номын санчид оролцлоо. Энэ үеэр шинэ номын үзэсгэлэн гаргаж, “2009 оны Шилдэг ном”-ыг сумдад хувиарлан гардуулав. Иргэдэд номтой нөхөрлөх идэвхи өрнүүлэх, тэдэнд ном хэвлэлээ сурталчилах, худалдаалах, солилцох зорилгоор зохион байгуулсан уг үйл ажиллагаанд бүх сум сургуулийн номын санчид тус аймагт номын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, хувь хүмүүс оролцож нийтдээ 500 орчим номын үзэсгэлэн гаргалаа. Хоёр өдрийн турш үргэлжилсэн яармаг худалдаанд хүмүүс шинэээр гарсан болон ховор ном хэвлэлтэй танилцахаас гадна, хэрэгцээтэй номоо худалдан авч солилцож, өөрт байгаа номоо худалдаалж байлаа. Энэ үеэр орон нутгийн зохиолчидтой уулзалт хийж тэдний бүтээлээр үзэсгэлэн гаргаж тэндээс 2 бүтээлийг нь “2009 оны орон нутгийн шилдэг бүтээл” шалгаруулахад зохиолч Жүгдэрбарамын “Хад нэвт ургасан цэцэг” ном шалгарав. Мөн эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлээс хүний их эмч Морхын анагаах ухаан эмчилгээ ном шалгарлаа.

Номын яармагт оролцсон сум, сургуулийн номын санчид өөрсдийн уншигчид хүрээлсэн ном бүтээлүүдээрээ үзэсгэлэн гаргахын зэрэгцээ тус тусынхаа ажил үйлчилгээг сурталчилсан үзэсгэлэн самбар гаргаж олон нийтэд танилцууллаа. Яармаг зохион байгуулах комисс тэдгээрийг үзэж танилцаад хамгийн идэвхитэй оролцсон, , иргэдэд хүрч үйлчилдэг үйл ажиллагаа нь тогтмолжсон тэргүүний номын сан, номын санчдыг шалгаруууллаа. Үүнд “Тэргүүний номын сан”-гаар Эрдэнэбүрэн сумын номын сан шалгарч 50.0 мянган төгрөгийн номоор шагнагдсан

бол, Сургуулийн “Тэргүүний номын санч”- аар Мөнххайрхан сумын 11 жилийн сургуулийн номын санч Цэндсүрэн шалгарч БСГ-ын шагналыг гардлаа.

Шилдэг онигоочдын баярыг 2010 оны 4-р сарын 2 нд ХДТ-т зохион явуулав. Уралдаанд 12 онигоочид оролцож тэргүүн байрыг Цэвэлмаа 2-р байрыг Хас банкны ажилтан Од нар эзэллээ.

Зохион байгуулсан ажлынхаа үр нөлөө, ач холбогдлыг бусдад хүргэх зорилгоор орон нутгийн Ховд телевиз, Ховдын мэдээ сонинд, мэдээ сурвалжлагаа явуулан сурталчиллаа. 2010 оны 8 сарын 10-12-ны өдрүүдэд Ховд аймагт Баруун бүсийн соёлын өдрүүд, Баруун Монголын Бурхан шашинтны соёл уламжлалын төв Гандан Пунцаг Чойлон хийдийн нээлт, Хөгжимт драмын театр, Музейн 60 жилийн ой, Тыва үндэстний соёлын өдрүүдийн

баяр наадам боллоо. Уг үйл ажиллагаанд Нийтийн номын сангийн хамт олон идэвхтэй оролцож шинэ номын үзэсгэлэн худалдаа гаргалаа.

Номын санчдын мэдлэг боловсрол дээшлүүлэх бусадтай мэдлэг оюунаа хуваалцах, ажлын туршлага солилцох зорилгоор сум сургуулийн номын санчдыг 2010 оны 09 сарын 17-30-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо явуулж сургалаа.

МҮНС, Хүүхдийн номын ордонтой хамтран зохион байгуулсан Номын сан мэдээллийн төв сургалт семинарт сум, сургуулийн 34 номын санч оролцож мэдлэг мэргэжлээ дээшлүүллээ.

Сургалтыг сумын соёлын төвийн номын санчид МҮНС–тай, сургуулийн номын санчид Хүүхдийн номын ордонтой тус тус хамтран зохион байгууллаа. Номын санчид сургалтанд оролцохоос гадна МҮНС, Хүүхдийн номын ордон, Хотын төв номын сан болон их дээд сургуулиудын номын сангийн үйл ажиллагаатай танилцаж туршлага солилцлоо.

Ган үзэг яруу найргийн наадмыг 2010 оны 11 сарын 12 нд нийтийн номын сангийн уншлагын танхимд зохион явуулав. Уг яруу найргийн наадамд ЕБС-ийн 1-5, 7-8, 9-11, оюутан гэсэн 4 ангилалаар явагдлаа. Яруу найргийн наадамд 64 сурагч оюутан оролцож шүлэг найргаа уншлаа.

Нийтийн номын сангаас жил бүр уламжлал болгон зохион байгуулсан “Шувуун саарал” богино өгүүллэгийн наадам

Шувуун саарал богино өгүүллэгийн наадам 2010 оны 11-р сарын -24 ны өдөр уншлагын их танхимд боллоо.

Наадмын шүүгчээр Чулууны нэрэмжит Алтан гадас одонт хөгжимт драмын театрын уран сайхны удирдаач н.Эрхэмбаяр, Монголын зохиолчдын холбооны гишүүн зохиолч н.Бямбаа, Нийтийн номын сангийн ахлах номын санч, аргазүйч Д.Саранцэцэг нар шүүн явуулав.

Энэхүү наадамд ЕБС-н 1-5 анги, 7-8 анги, 9-11 анги, Насанд хүрэгсэд гэсэн 4 насны ангиллаар нийт 80 гаруй оюутан, сурагчид оролцож 1-5 ангийн насны ангилалд 31 хүүхэд оролцсоноос 12 жилийн 3-р дунд сургуулийн 5в ангийн сурагч Б.Бямбасүндэл 1-р байр эзэлж өргөмжлөл, алтан медаль, 12 жилийн 3-р дунд сургуулийн 4д ангийн сурагч С.Аззаяа 2-р байр эзэлж өргөмжлөл, мөнгөн медаль,12 жилийн 2-р сургуулийн 4б ангийн сурагч Х.Ахмарал 3-р байр эзэлж өргөмжлөл, хүрэл медаль, 12 жилийн 1-р сургуулийн 1г ангийн сурагч Батхишиг тусгай байр эзэлж өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр тус тус шагнаж урамшууллаа.

7-8 ангийн насны ангилалд 24 хүүхэд оролцсоноос 12 жилийн 3-р сургуулийн 7б ангийн сурагч Б.Баялагмаа 1-р байр эзэлж өргөмжлөл, алтан медаль, 12 жилийн 1-р дунд сургуулийн 8а ангийн сурагч Энхзаяа 2-р байр эзэлж өргөмжлөл, мөнгөн медаль, Цаст-Алтай цогцолбор сургуулийн 8а ангийн сурагч Д.Хишигбуян 3-р байр эзэлж өргөмжлөл, хүрэл медаль, Прогресс сургуулийн 7б ангийн сурагч Н.Тэмүүлэн тусгай байр эзэлж өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр тус тус шагнаж урамшууллаа.

9-11 ангийн насны ангилалд 16 хүүхэд оролцсоноос Цаст-Алтай цогцолбор сургуулийн 9б ангийн сурагч О.Дэлгэрмаа 1-р байр эзэлж өргөмжлөл, алтан медаль, Цаст-Алтай сургуулийн 10в ангийн сурагч Б. Хишигмаа 2-р байр эзэлж өргөмжлөл, мөнгөн медаль,12 жилийн 6-р сургуулийн 9в ангийн сурагч Б.Сэлэнгээ 3-р байр эзэлж өргөмжлөл, хүрэл медаль, Цаст-Алтай цогцолбор сургуулийн 9б ангийн сурагч А.Заяа тусгай байр эзэлж өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр тус тус шагнаж урамшууллаа.

Насанд хүрэгсэдийн ангилалд 7 хүн оролцсоноос :ХоИС-н МХУЗ-н 4-р курс оюутан Д.Даваадулам 1-р байр эзэлж өргөмжлөл, алтан медаль, МСҮТ-н БЗЧ-н 1-р курс оюутан Бурмаа 2-р эзэлж өргөмжлөл, мөнгөн медаль, ХоИС-н МХУЗ-н 4-р курсын оюутан Э.Өлзийжаргал 3-р байр эзэлж өргөмжлөл, хүрэл медаль, ХоИС-н Хятад хэлний 2-р курсын оюутан С.Ихбаяр тусгай байр эзэлж, өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр тус тус шагнаж урамшууллаа.

“Нээлттэй хаалганы өдөр” Байгууллага сар бүр нээлттэй хаалганы өдөр зохион байгуулж иргэд, уншигчдэд үйл ажиллагаагаа нээлтэй хүртээмжтэй хүргэхийн тулд байгууллагууд дээр нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулж байгаа. Үүнд 2010 оны 10-р сарын 22-ны өдөр Ард Аюушийн талбайд НЭЭЛЛТЭЙ ХААЛГАНЫ өдрийг зохион байгуулан явууллаа. Энэ үеэр 282 ширхэг шинэ номоор үзүэсгэлэн гаргаж 180 гаруй иргэдэд мэдээлэл өгч 20 гаруй номоор гэрээр олгон үйлчиллээ. Мөн Жаргалант сумын 12 жилийн 2-р сургууль дээр уг үйл ажиллагааг явууллаа. Энэ үеэр 60 гаруй сурагчид карт нээлгэж, 200 гаруй шинэ номоор үйлчлэв. Энэ үйл ажиллагаанд 60 гаруй сурагчдад карт нээж 200 гаруй шинэ номоор үйлчиллээ. Мөн Норвегийн тусламжийн байгууллагатай хамтран “Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн эсрэг хамтдаа” аян зохион байгууллаа.

Энэ үеэр ЕБС-ийн сурагчдын дунд “ӨӨРӨӨСӨӨ АХАДСАН АЧАА” сэдэвт дүрийн тоглолт, Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт гэсэн гарын авлага хийж сурталчлах, Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар видео бичлэг, кино үзүүлэх арга хэмжээ явууллаа.

Номын сангийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх зорилгоор нийт номын 30 хувийг электрон катологт оруулах ажил хийлээ.

Цаашид энэ ажил тасралтгүй үргэлжилсээр 2011 оны 12 сар гэхэд дуусгавар болгох зорилттой ажиллаж байна.

Олон нийтийн ажил , гадна орчны тохижилт

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Жаргалант сумын Тамгын газар , хот тохижуулах албанаас зохион байгуулсан хаврын ажилд идэвхтэй оролцож, ойр орчныхоо хог цэвэрлэх хайс хамгаалалтай сайжруулах, мод бут тарих ажлуудыг удирдамж заасврын дагуу хийж гүйцэтгээд байна. Нийтдээ 20 ширхэг хайлаас тарьж, цэцгийн мандалуудад олон төрлийн цэцгийн үр суулгалаа.

2010 оны 8 сард байгууллагын халаалт сайжруулах, сантехник шинэчлэх зорилгоор 800.0 төгрөгний ажил хийлээ. Үүнд байгууллагын хуучирч муудаж зэвэрч цоорсон турба пар сольж шинэчлэн нийт 360 пар угааж цэвэрлэлээ. Мөн бохир цэвэр усны систем сайжруулах зорилгоор 70 метр газар доорхи системийг бүрэн сольж 1300.000 мянган төгрөгний ажил хийж гүйцэтгэв.

Цаашид ойрын хугацаанд шийдвэрлэх хэд хэдэн асуудал байна.

Үүнд:

- Нийт номыг 2011 онд электрон католöгт бүрэн оруулж дуусгах
- Компьютер, техник хэрэгслийг сайжруулж хүртээмжтэй болгох
- Номын сангийн шинэ барилгын зураг төсөл зохион холбогдох байгууллагуудад хүргүүлэх

ХӨВСГӨЛ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2010 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2010-12-20

Номын сангийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн, үйл ажиллагааны чиглэлийг тодорхой болгон хүн бүрт хэрэгцээ шаардлагыг нь хангахуйц хүссэн мэдээллийг хүргэж нийгэмд идэвхтэй, мэдлэгтэй иргэнийг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилго тавин, уншигч хэрэглэгчийн оюун санааг хөгжүүлэх, тэднийг бие даан мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд туслах үүнд чиглэсэн орчин бололцоог бий болгоход үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа.

Нэг. Бүтэц зохион байгуулалт. Тайлангийн хугацаанд тус номын сан нь 7 орон тоотойгоор ажиллаж хүн тус бүртэй бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээ хийж улирал жилээр дүгнэн хяналт тавьж шагнал урамшил, ур чадварын нэмэгдэл олгох зэрэг захиргааны зүгээс дэмжлэг үзүүлж ажиллагсдын идэвхийг өрнүүлэх ажил хийгдэж байна. Тус номын сан нь:

- Нийтийн уншлагын танхим
- Гэрээр ном олгох-уншлагын танхим
- Хүүхдийн уншлагын танхим зэрэг нийт 140 суудалтай танхимуудтай. Үйлчилгээний танхимууд, гэрээр ном олгох тасаг тус бүр нь өргөн

хэрэглээний ном хэвлэлийн ойрын фондтой ба үндсэн фондоосоо уншигчдын захиалгаар ном хэвлэлийг авч үйлчилдэг.

Хоёр. Номын сангийн үндсэн үйл ажиллагаа

Номын сан нийтдээ 2361 уншигчийг шинээр бүртгэж 18684 ирэгсдэд 26268ш ном хэвлэл олгож үйлчиллээ.

ЕБС-иудын номын сантай болон ШШБГ-тай ном солилцооны гэрээ байгуулан уншигчдын захиалгаар 301 ш ном солилцоогоор авч уншлаганд гаргав. Нүүдэл, зөөврийн номын сан ажиллуулж нийт 290 хүн хамруулан үйлчлэв.

Гурав.Фонд каталоги зохион байгуулалтын талаар

Дэлхийн зөн Монгол ОУБ, хувь хүмүүсийн хандив, төсөвт тусгагдсан зардлаар нийт 3347950 төгрөгийн 386 ш номоор фондоо баяжуулав. /Хандиваар 56 ш 264,5 төгрөгийн ном, Соёл урлаг хөгжүүлэх сангаас 265ш 2533,0 төгрөгийн ном, Төсөлөөр 67 ш 581,9 төгрөгийн ном/

Шинээр авсан номуудыг электрон каталогт оруулахаас гадна үсэг дараалал, төрөл ангийн уламжлалт каталогт мөн тусгаж байна. 473,0 төгрөгийн тогтмол хэвлэл захиалан уншлаганд ашигладаг.

Манай номын сан 2010 онд Аймгийн засаг даргын нөөцөөс 13,3 сая төгрөгийн дэмжлэг авч компьютер техник хэрэгсэл, номын сангийн цогц программ аван дотоод сүлжээнд холбогдон электрон каталогийн ажлыг эхлээд явж байна. Номын сангийн үйл ажиллагааг автоматжуулах зорилгоор 2010 оноос Lib4U программ хангамжийг ашиглан мэдээллийн электрон каталогийн санг бүрдүүлэх, номыг бар коджуулах, тооллого хийх, уншигчдыг бүртгэх ажлыг автоматжуулах, уншигчийн зураасан кодтой үнэмлэх хэвлэх, номын сангийн удирдлагыг боловсронгуй болгоход шаардлагатай төрөл бүрийн тайлан мэдээ, статистик үзүүлэлтүүдийг гаргах, номын сангийн уламжлалт цаасан каталогийн картуудыг дахин бичилгүйгээр стандартын дагуу программаас шууд хэвлэн гаргах боломжтой болсон. Уг программыг авч ашигласнаас хойш фондын номын 20%-ийг мэдээллийн электрон каталогийн санд оруулаад байна.

Шилдэг ном-2009, Японы засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд ирсэн 9000 гаруй номыг сумын соёлын төвийн номын сангуудад хүлээлгэн өгөв.

Лавлагаа, номзүйн ажил

Лавлагааны фондоо шинэчлэн зохион байгуулж, уншлагын танхимууд өөрсдийн онцлогт тохируулан номзүй, хууль эрх зүй, ЕБС-ийн сурагчдын уншвал зохих ном зохиолууд, зөвлөгөө булангууд зохион байгуулж лавлах хэвлэл, номзүйн болон санамж өгөх материалуудаар баяжуулж, мэдээллийн самбар байнга ажиллуулан уншигчдад хэрэгцээтэй мэдээлэлүүдийг гаргаж байна. /ЕБС-ийн төгсөгчдөд зориулж Элсэлт-2010, Шалгалтын хуудас хэрхэн бөглөх, Интернетээр бүртгүүлэх, Ногоочдод зөвлөгөө, Эрүүл мэндийн зөвлөгөө, Хүнсний ногоо хадгалах, Шинэ номын мэдээлэл, жагсаалт, сэдэвчилсэн номын жагсаалт г.м/ Үзэсгэлэнд гаргасан номуудад товч тайлбар бичиж сурталчилж байв.

109 нэрийн лавлагаанд хариулт өгч аман лавлагааны дэвтэрт бичилт хийж, татгалзлын дэвтэрт 86 удаагийн тэмдэглэгээ хийж фонд бүрдүүлэх ажилд тусгасан. Шинэ ирсэн 210 ш номонд санамж өгөх номзүй хийж фондын ном

хэвлэлээ сурталчлав. Сэдэвчилсэн номын жагсаалт 140ш номоор хийв. /Чингүнжавын түүх намтартай холбогдолтой ном хэвлэлийн материал, зохиолч нарын уран бүтээлийн үзэсгэлэн бүрд номзүйн жагсаалт гаргаж байв.

Мэдээлэл сурталчилгаа соёл олон нийтийн ажил

Уншигч хэрэглэгчдэд хэрэгцээ шаардлагатай мэдээллийг хүргэх, номын сангийн фондыг сурталчлахын тулд соёл олон нийтийн ажлыг төрөл бүрийн аргаар зохион явуулж ирлээ.

Сэдэвчилсэн номын үзэсгэлэн 32 удаа, шинэ номын үзэсгэлэн 25 удаа гаргасан.

“Монголын уран зохиолын сангаас”, “Адал явдалт романууд” гэх зэрэг үзэсгэлэнгүүд гаргаж уран зохиолын номын сурталчилгаа хийсэн.

Хотгойдын Шадар ван Чингүнжавын 300 жилийн ойд зориулж “Хотогойдын шадар ван Чингүнжав-300”, “Хотогойдын түүхээс” сэдэвт үзэсгэлэнгүүдийг гаргаж 300 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан зохион бичлэг, реферат, АХА тэмцээнүүдэд оролцогч болон эх түүхээ сонирхогч уншигчдын хэрэгцээг хангасан.

Хөвсгөл аймгийн зохиолчдын холбооны ойд зориулж “Хөвсгөл аймгаас төрсөн эрдэмтэд, зохиолч нарын уран бүтээлээс” сэдэвт номын үзэсгэлэнг Б.Ширэндэв, Ж.Бадраа, Билэгсайхан, Ч.Дагвадорж, Д.Даваанягм, Д.Намсрай, Б.Жамд, Л.Хүрэлбаатар нарын 92 зохиолчдын 400 гаруй ном, тохимлоор зохион байгуулж

сурталчилгаа хийв. Ойн нээлтийн үйл ажиллагааг өөрийн байранд зохион байгуулж, яруу найргийннаадамд оролцохоор ирсэн 40 гаруй яруу найрагчид үзэсгэлэнгийн нээлтэнд оролцож үзэж сонирхов.



Хөвсгөл аймгийн соёлын ажилтнуудын зөвлөгөөнд зориулж өөрийн номын сангийн үйл ажиллагааг харуулсан үзэсгэлэн гаргаж өөрсдийн хийж бүтээсэн ажлаа хөдөөгийн номын санчдад туршлага болгох зорилгоор сурталчилгаа хийв. Төв хөдөөгийн 70 гаруй соёлын ажилтнууд үзэж сонирхож туршлагаа хуваалцав. Энэ үеэр сумдын номын сангуудын хийсэн ажлын баримт материалын үзэсгэлэнг мөн зохион байгуулан үзүүллээ.

Номын сангаас зохиож буй ажил болон шинэ болон сэдэвчилсэн номын мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр 12 удаа сурталчисан байна.

Мэдээллийн самбар, булангуудаар төрөл бүрийн мэдээлэл, зөвлөгөөнүүдийг гаргаж уншигчдын хүртээл болгодог



Их зохиолч Д.Нацагдоржийн мэндэлсэн өдөрт зориулж “Номын баяр” сарын ажил зохион явууллаа. Энэ үеэр “Номын баяр” сарын ажлын удирдамж, “Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн” шалгаруулах уралдааны болзлыг сургуулиудад тарааж сурталчилгаа хийн “Урилгат уншлага” 14 удаа, “Бүтээлч уншлага” 2 удаа,

номын сангаар хэрхэн зөв үйлчлүүлэх, номтой яаж харьцах, номын сантай танилцуулах уншлага 8 удаа явуулж нийт 580 уншигчдыг хамруулан оролцуулав. Зургийн уралдаан 2 удаа, бяцхан номын уралдаан, рефератын уралдаан, АХА тэмцээн зохион явуулж дүнгээ гаргав. Мөн 3-4-р ангийн сурагчдын дунд “Уншсан номоо хэн сайн ойлгосон бэ?” уралдаан явуулж ном уншлагыг нь үр дүнтэй болгож байв. Уралдаан тэмцээн бүрт зохих шагнал урамшлыг өгч бяцхан уншигч хүүхдүүдийн ном



унших хүсэл сонирхлыг нь өрнүүлж байлаа. Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн болзлыг 5 сурагч хангаж уг шагналын эзэн боллоо. Номын баяр сарын ажлын хүрээнд явагдсан уралдаан тэмцээний бүтээлүүдээр 2 удаа үзэсгэлэн гаргаж уншигчдын оролцоог идэвхжүүлэн сурталчлав. Номын баярын үеэр Д.Нацагдоржийн намтар уран бүтээл, шүүмж судлалын номууд, холбогдолтой гэрэл зургууд, сонин хэвлэлд гарсан материалуудаар үзэсгэлэн гаргав.

Мөн уншигчдын дунд “Номын баатруудыг хэн сайн амилуулах вэ” дүрийн тоглолт багт наадмын уралдаан тэмцээн зохион байгуулж байлаа. Уг тэмцээний тэргүүн байрыг 2-р сургуулийн $11^{а}$ ангийнхны бүтээсэн Ч.Лодойдамбын зохиол “Тунгалаг тамир”, Ц.Дамдинсүрэнгийн “Чемодантай юм”, 2-р байранд Гурван Эрдэнэ сургуулийн $5^{г}$ ангийнхан “Царцаа Намжил” үлгэрээр, 3-р байранд Далай ван сургуулийн $4^{а}$ анги “Мэргэн шүүгч” “Их залхуу” үлгэрүүдээр тус тус орж шагнал хүртлээ.

“Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн” /2010 он/ Ирээдүй-21р зуун цогцолбор сургуулийн $5^{а}$ ангийн сурагч Баяржаргал

Уншигчдын дунд зохиосон АХА тэмцээн

“Бичиг, соёлын хишиг өдөр”- аяны үеэр зохиосон “Монгол бичиг”, эсээ бичвэрийн уралдааны үзэсгэлэнгийн хэсгээс



Монгол улс тунхагласны өдөрт зориулж “Монгол Улс” сэдэвт түүхийн номын үзэсгэлэн гаргав. Үзэсгэлэнд холбогдох материалуудыг бичиж тодотгож, түүхийн холбогдолтой зураг үзүүлэн гаргав.

Номын тойм яриа, чанга уншлага 20 удаа хийж 86 ш ном сурталчлав. 70 гаруй номонд товч тайлбартай зурагт хуудас хийж номын мэдээлэл гаргав.

“Төр ба иргэн- хамтын зүтгэл” нээлттэй өдөрлөгт 2 удаа оролцож байгууллагын үйл ажиллагааны тухай танилцуулга хийж энэ ажлын үеэр 50 гаруй хүнд уншигчийн карт нээж номын сангийн үйлчилгээнд хамруулан, 100 гаруй хүүхэд залуучуудад өөрийн номын сангийн танилцуулгыг тараалаа.

Мэргэжил арга зүйн ажил

Номын санчдын сургалт семинар зохион байгуулах, мэдлэг мэргэжлийг дээшлүүлэхэд зориулан арга зүйн өрөөг өргөжүүлэн тохижуулж үйл ажиллагааг нь тогтмолжуулсан. Харьяа номын сангуудын номын санч нарт Lib4U програмд номыг хэрхэн шивэх, номын сангийн данс бүртгэлийг хөтлөх, "Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн" шалгаруулах болзол, Номын сангийн үйл ажиллагаа тоног төхөөрөмжийн стандарт, Зөөврийн номын сан ажиллуулах журам, Сумын номын санчийн ажлын чиг үүрэг, Номын сангийн фондын хадгалалт хамгаалалт, Санамж өгөх номзүй, Номын зурагт хуудас, Мэдээллийн самбарт гаргах мэдээ зөвлөгөө, Хүүхэлдэйн тоглолтын тайзны загварууд, Үзэсгэлэнгийн тавиуруудын зураг загварууд зэрэг сэдвүүдээр зөвлөгөө өгч материалыг цаасан хэлбэрээр болон плашаар тараав. Мөн номын санч нарт зориулж 8 сэдвээр 2 удаа зөвлөмж эмхтгэн бэлтгэж гаргав. Нийт 23 номын санчид арга зүйн зөвлөгөө өгсөн.

Төв, хөдөөгийн номын санчдын сургалт семинарыг 3 удаа зохион байгуулан явуулав.

МУҮНС-тай хамтран номын санчдын сургалт зохион явуулж сургалтанд 23 сумын нийтийн, ЕБС, МСҮТ-ийн нийт 27 номын санч оролцож, ННА-ийн шинэчилсэн заалтуудыг хэрэглэх, Орон нутгийн каталогийн зохион байгуулалт, Номын сангийн автоматжуулалт, програм хангамж, үйлчилгээний соёл болон номын сангийн үйл ажиллагаанд баримтлах эрхзүйн баримтуудын талаар мэргэжлээ дээшлүүлсэн.

ЕБС-ийн номын санчдын сургалтыг ХНО-той хамтран УБ хотод зохион явуулж нийт 25 номын санчид хамрагдан суралцав.

Байгууллагын тохижилт

- 2009 онд номын сангийн барилгын их засварыг дуусган зориулалтын байр тоног төхөөрөмжөөр хангагдан ажиллаж байна.
- Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагатай хамтран “Номын сан” төсөл хэрэгжүүлж эхний хөрөнгө оруулалтаар 18 ширээ, 36 сандал, 6ш номын тавиур, хөгжим, хивс, ном зэрэг 4084,9 төгрөгийн хөрөнгө оруулалт хийж хүүхдийн уншлагын танхимыг тохижуулав.
- Нийтийн уншлагын танхимын ширээ, сандлыг БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 3068,8 шинэчлээд байна. /20 ширээ, 40 сандал, номын тавиур, номын санчийн ширээ/
- Байгууллагын гадна орчныг мод, цэцэг, зүлэг тарьж цэцэрлэгжүүлэн өнгө үзэмжийг нь сайжруулан тохижуулав.
- Яруу найргийн наадамд оролцсон хот хөдөөгийн яруу найрагчидтай хамтран “Яруу найргийн төгөл” цэцэрлэгийн эх суурийг тавиад тохижуулан өргөжүүлж байна.

ТӨРИЙН ШАГНАЛТ ЯРУУ НАЙРАГЧ Р.ЧОЙНОМЫН НЭРЭМЖИТ ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2010 ОНЫ ТАЙЛАН

2010-12-23

¹	Нийлүүлэх бүтээгдэхүүн	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт
1.	**<u>Бүтээгдэхүүн 1.1</u>** 10-аас доошгүй нэр төрлийн тогтмол хэвлэл улирал тутам захиалж уншигчдад үйлчлэх	1-р улиралд 19 хэвлэл 2-р улиралд хэвлэл 3-р улиралд хэвлэл 4-р улиралд хэвлэл захиалж ашиглуулна	10-13 нэр төрлийн тогтмол хэвлэл 272600 мянган төгрөгийн хэвлэл захиалан уншигчдад ашиглуулж байна.
2.	**<u>Бүтээгдэхүүн 1.2</u>** 2009 онд байнгын 1825, ирцээр 14850 бүгд 16675 уншигчдад 31700 ном олгож үйлчлэх	<u>1.Их танхим</u> Байнгын уншигч 800 Ирцээр 7000 хүнд 15000 номоор үйлчилнэ. <u>2. Бага танхим</u> Байнгын уншигч 900 Ирцээр 7500 хүнд 16000 ном олгоно	2010 онд 1825 байнгын, 14850 ирцээр 16675 бүгд 31700 ном олгож үйлчлэхээс байнгын 1190, ирцээр 16137 бүгд 17327 уншигчдад 31928 ном олгож үйлчилсэн байна. 970.4 мянган төгрөгийн орлого оруулсан нь 2009 оны орлоготой харьцуулахад 271%-иар биелүүлсэн байна.

		3. Гэрээр ном олгох танхим Байнгын уншигч 125 Ирцээр 350 хүнд 700 номоор үйлчилнэ	
3	**Бүтээгдэхүүн 1.3** Шинэ номын мэдээлэл гаргаж, сурталчлах	1. Зарим номуудад тайлбарт танилцуулга хийх	Шинээр ирсэн 270 номын жагсаалтыг гарган мэдээллийн самбарт болон Цагдаагийн газар, ХАА-н банк, нэгдсэн эмнэлэг, Хэрлэн сумын ЕБ-ын 1, 4-р сургууль, Тэмүүжин цогцолбор сургуулиудад мэдээллийн самбараар сурталчилсан
4	**Бүтээгдэхүүн 1.4** Шинэ номын үзэсгэлэн гаргах	1.Шинээр авсан номуудаар цуврал тайлбарт мэдээлэл гаргах 2. Онцлог номын тайлбар танилцуулга бичиж гаргах	Шинэ номын үзэсгэлэнг танхимуудад 9 удаа гаргаснаас гадна ХАА-н банк, нэгдсэн эмнэлэг, ЕБ--ын 4-р сургууль, Тэмүүжин цогцолбор сургуулиудад нийт 325 номыг 782 уншигчдад сурталчилсан. Шинээр ирсэн “Итгэлт хамбын тайлагдашгүй нууц”, “Нууц”, “Нууцыг тайлах түлхүүр”, “Дэлхийн түүх”, Монголын мөнгөн үеийн хүүрнэл зохиолын түүвэр, “Хайрын сургамжит өгүүллэг”, “Иргэн таны эрх зүйн хөтөч”, Бизнесийн эрх зүй”, “Өнөөдөр амьдрах зарчим”, “Далд ертөнцийн ил нууц”, “Үйгүй салхи”, “Хямралыг хэрхэн гэтлэх вэ” зэрэг номуудын тайлбарт танилцуулгыг гаргасан. Хэрлэн сумын соёлын төвтэй хамтран “Номын ертөнц” номын өдөрлөгийг зохион байгуулж, Хэрлэн сумын ЕБСургуулийн 1-р ангийн сурагчдын дунд “Шидэт ном” бяцхан ном бүтээх уралдааныг зарлаж уг уралдаанд “Тэмүүжин

			цогцолбор" сургуулийн 79 сурагч, "Хан Хэнтий" цогцолбор сургуулийн 24 сурагч, 4-р сургуулийн 38 сурагч нийт 145 сурагчдын бүтээл ирсэнээс "Хан Хэнтий" цогцолбор сургуулийн 1а ангийн сурагч Б. Есөнжин, Тэмүүжин цогцолбор сургуулийн 1б ангийн сурагч У. Наран-тунгалаг, 4-р сургуулийн 1в ангийн сурагч Н. Бүнчинсүрэн нарын бүтээл шалгарсан. Мөн шинэ ном, ховор номын үзэсгэлэн гаргаж сурталчилсан.
5	**<u>Бүтээгдэхүүн 1.5</u>** Мэдээллийн сан ажиллуулах	-Дотоод мэдээллийн сан -Гадаад мэдээллийн сан -Хууль эрх зүйн мэдээллийн сан -Орон нутгийн онцлог мэдээллийн сан - Сонгосон буюу хандсан хүмүүст зориулсан мэдээллийн сан	Хэнтий аймгийн Биндэр сумын харьяат Э. Бат-Үүл Монгол улсын баатар цолоор шагнагдсан тухай, Хэнтий нутгаас хоёр генерал төрлөө, Сургамжит өгүүллэг номноос 2 мэдээлэл, Иргэний шинэчилсэн бүртгэл, Хэрлэн голын тухай, Эссэ хэрхэн бичих вэ, Эссэ бичих агуу бөгөөд санаанд оромгүй долоон сануулга, амьдралын хуудас, Д. Нямсүрэнгийн нэрэмжит наадамд нутгийнх нь найрагч түрүүллээ, хүнсний ногоо тариалах, хадгалах, арчлах талаар цуврал мэдээлэл, Өгч чаддаг байх нь чухал, Уучлах гэдэг ухааных, 1983-2009 онуудад Болор цом наадамд түрүүлсэн зохиолчдын талаар зэрэг 10 мэдээлэл гаргаж, мэдээллийн самбарт байрлуулсанаас гадна сургуулийн номын сангуудаар дамжуулан мэдээлсэн Өөрийн байгууллагын сүүлийн 3 жилийн уншлага үйлчилгээ, ном олголт, фондын баяжилт, өөрийн орлого, зохион байгуулсан соёл олон түмний ажлын талаар 39 ширхэг хэвлэмэл хуудсаар мэдээлэл гаргасан Номын ертөнц өдөрлөгийн үеэр "Номын сан" үйл

			ажиллагааны танилцуулга мэдээллийг хийж, 100 гаруй хүмүүсд тарааж байгууллагаа сурталчилсан. Тэмүүжин цогцолбор сургуулийн “Сургуулийн нэг өдөр”-т зориулж шилжилтийн 8-р ангид “Эх орон, аав ээж багш нараа хайрлаж, хүндлэх, уучлах” сэдвээр бэлтгэн хичээл заасан явдал шинэлэг ажил боллоо
6	**<u>Бүтээгдэхүүн 1.6</u>** Номын санчдад зориулж бичмэл сэтгүүл гаргаж гарын авлага болгох	1.Сэдэв сонгож, холбогдох материалыг бэлтгэх 2. Уншлаганд гаргаж сум, сургуулийн номын санчдад хүргэх	Номын сан ном зүйн ангилал, номын сангийн үйлчилгээг автоматжуулахад баримтлах зөвлөмж, номын сангийн зөвлөлийн ажиллах нийтлэг журам, төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар” сэдвүүдээр бичмэл сэтгүүл гаргаж аймгийн цагдаагийн газар, сумдын соёлын төвийн эрхлэгч, номын санч нарт ашиглуулж сурталчилж байна. Номын сангийн үйлчилгээг автоматжуулахад шаардлагатай программ хангамжийн талаар мэдээлэлийг дамжуулсаны үр дүнд Дархан сумын соёлын төв LiB4U программыг үйл ажиллагаандаа хэрэглэж байна.
7	**<u>Бүтээгдэхүүн 1.7</u>** Мэдээлэл- лавлагаа номзүйн үйлчилгээ	МСҮТөвийн номын санчтай хамтран оюутан сурагчдад зориулсан номуудаар ном зүйн бүртгэл хийх	МСҮТөвд мэргэжлийн холбогдолтой зохиол бүтээлээр үзэсгэлэн гаргаж сурталчилж байна

		Аймгаас төрж гарсан алдартан, суут хүмүүсийн амьдрал уран бүтээлийн тухай мэдээлэл цуглуулж лавлагаа хийх	“Хан Хэнтий нутгийн зохиолчид”, Чингис хаан” орон нутгаас төрж гарсан алдартнуудын ном хэвлэлийн ном зүйн материал цуглуулсан.
8	**Бүтээгдэхүүн 1.8** Сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргаж сурталчлах	1.Сэдэв сонгож, холбогдох номыг жагсаалтаар гаргах	Гадаадын уран зохиол , үлгэр өгүүллэг, мэндлэх хүндлэх ёс, инээдмийн баярын өдөрт, Д. Содномдоржийн намтар уран бүтээл, дэлхийн яруу найргийн өдөрт сэдвүүдээр 6 удаа үзэсгэлэн гаргасан
9	**Бүтээгдэхүүн 1.9** “Бичиг соёлын хишиг өдөр” –ийг зохион байгуулах	1. Гоо бичигтэн шалгаруулах /Монгол бичгээр/ ЕБ-ын сургуулийн хэл уран зохиолын багш нартай хамтран зохион байгуулах 3.Хуучин монгол бичгээр хэвлэгдсэн ном товхимолоор үзэсгэлэн гаргах	1.Бичиг соёлын хишиг өдөрт зориулан Хэрлэн сумын ЕБДСургуулийн 5-7 анги, 8-11-р ангиудын дунд “Гоо бичигтэн” уралдааныг шалгаруулж нийт 25 бүтээл ирсэнээс Тэмүүжин цогцолбор сургуулийн 7-р ангийн сурагч Д. Анхцогт, 8-р ангийн сурагч Д. Даваахүү нар тэргүүн байр эзэлж, өргөмжлөл гардуулсан. 2. Номын санд олон жил үр бүтээлтэй ном уншсан 6-н сурагчдыг Д. Нацагдорж тэмдэгтэн”-ээр шалгаруулласа. 3.Хуучин монгол бичгийн 36 номоор сэдэвчилсэн үзэсгэлэн гаргаж сурталчилсан

10	**<u>Бүтээгдэхүүн 1.10</u>** “Үлгэрийн баатрууд амилсан нь” дүрийн тоглолтын уралдаан зохион байгуулах	1. Хэрлэн сумын хэмжээнд удирдамж боловсруулах 2.Дүгнэж тайлан гаргах	Хэрлэн сумын 5 цэцэрлэгийн хооронд “Үлгэрийн баатрууд амилсан нь” дүрийн тоглолт зохион байгуулж нийт 3 цэцэрлэгийн 5 баг оролцож 1-р байр 5-р цэцэрлэгийн бэлтгэсэн “Онгироо туулай” , 2-р байр 2-р цэцэрлэгийн “Үнэг хэрээ чоно гурав”, 3-р байр 5 цэцэрлэгийн “Бээлий” багууд байр эзэлж өргөмжлөл гардуулсан
11	**<u>Бүтээгдэхүүн 1.11</u>** Төрийн шагналт Ардын уран зохиолч С. Эрдэнийн уран бүтээлээр зурагт хуудас гаргаж сурталчлах	1. Намтар уран бүтээл зохиолоор илтгэл бичих 2. Номын үзэсгэлэн гаргах	Төрийн шагналт ардын уран зохиолч С.Эрдэнийн намтар уран бүтээлээр илтгэл бичиж 21 номоор үзэсгэлэн гаргаж нийт 60 гаруй уншигчдад сурталчилсан
12	**<u>Бүтээгдэхүүн 1.12</u>** Номын санд шинээр ирсэн номуудад каталогийн карт бичих	1.Номын сангийн стандартын дагуу ном хэвлэлд карт бичих	2008-2010 онуудад шинээр ирсэн нийт 812 номуудад каталогийн карт бичиж , электрон каталоги, төрөл ангийн каталогит байрлуулсан.
	<u>Бүтээгдэхүүн 1.13</u> АХА тэмцээнийг ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулах	1.Хэрлэн сумын ЕБ-ын сургуулиудын ахлах ангийн сурагчид оролцох 2.Зохион байгуулж орон нутгийн телевизээр сурталчлах	Хэрлэн сумын ЕБ-ын дунд сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд 200 асуулттайгаар “АХА” тэмцээн явуулж, Тэмүүжин цогцолбор сургуулийн 11б ангийн сурагч Б. Ичинхорлоо түрүүлж, өргөмжлөл мөнгөн шагналаар шагнасан.

13	**Бүтэгдэхүүн 1.14** “Болор цом” наадамд түрүүлсэн яруу найрагчдын шүлгүүдийг эмхэтгэж бичмэл сэтгүүл гаргаж сурталчлах	1.Шүлгүүдээр бичмэл сэтгүүл гаргаж сум, сургууль, албан байгууллагуудад сурталчлах	1983-2009 оны Болор цом яруу найргийн наадамд түрүүлсэн 30 яруу найрагчдын түрүүлсэн шүлгүүдээр бичмэл сэтгүүл гаргаж сурталчилж байна.
14	**Бүтээгдэхүүн 1.15** Инээдмийн баярын өдөрт зориулж Хэрлэн сумын сургуулиудын дунд тэмцээн уралдаан зохион байгуулах	1. “Хэн олон онигоо мэдэх вэ” уралдаан зохион байгуулах 2. ЕБ-ын сургуулийн сурагчдын дунд шог хошин гар зургийн уралдаан зохион байгуулах	Инээдмийн баярын өдөрт зориулж “Шог зургийн уралдаан” Хэрлэн сумын ЕБ Сургуулийн 7-11-р ангийн сурагчдын дунд зохион байгуулж, 41 бүтээлээ ирүүлсэнээс 1-р байрт Тэмүүжин цогцолбор сургуулийн Амарбат, 2-р байрт ЕБ-ын 4-р сургуулийн 9-р ангийн сурагч О. Жагдагсүрэн, Цэрэннадмид нарын бүтээл шалгарч өргөмжлөл гардуулсан
15	**Бүтээгдэхүүн 1.16** Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар албан хаагчдад сургалт явуулах	1.Хичээлийг Power Point-программ дээр боловсруулах 2. Ажилтан албан хаагчдаас боловсруулсан баримт бичгийг “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”-ын дагуу гүйцэтгэж байгаад хяналт тавих 3.Ажилтан албан хаагчдаас боловсруулсан баримт бичгийг стандартын шаардлага хангуулж архивлах	Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, байгууллагын архивын ажлын заавар баримт бичгийн стандарт номуудаас Power Point-ээр хичээл бэлтгэж, ажилтан албан хаагчдад хичээл заасан. ЕБ-ын 4-р сургуулийн бичиг хэрэг болон хөдөө сум сургуулийн номын санчид, соёлын төвийн эрхлэгчдэд албан хэрэг хөтлөлтийг стандартын шаардлага хангаж үйлдэх талаар зөвлөмж өгч ажилласан

16	**Бүтээгдэхүүн 1.17** Өнгөрсөн онуудын баримт бичгийг үдэж архивлах	1.Байнга, 70 жил хадгалах баримтуудыг нягтлан шалгаж, архивлах 2. Баримт бичиг нягтлан шалгах комисс байгуулах	1988 оноос хойшхи байгууллагын баримт бичигт нягтлан шалгалт хийж байнга, 70 жил хадгалах, түр хадгалах нийт 9 төрлийн 48 хавтас хадгаламжийн нэгжийн 1095 хуудас баримт бичгийг нөхөн бүрдүүлсэн.
17	**Бүтээгдэхүүн 1.18** Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулан, хөтлөгдөж байгаа хэргүүдийн бүрдэлд хяналт тавьж, бүрдүүлэн хүлээн авах	1.ХХНЖагсаалтыг боловсруулах 2.Хөтлөгдөж байгаа хэргүүдийг албан хаагчдаас бүрдүүлэн архивла	1.Аймгийн нийтийн номын сангийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж, 49 хадгаламжийн нэгжийг бүрдүүлж, хадгалах хугацааг тогтоосон. 2.2009- онд хөтлөгдөж дууссан менежерийн үр дүнгийн гэрээ, түүний биелэлт, ажилтан албан хаагчдын үр дүнгийн гэрээ, биелэлт, ирсэн явуулсан бичиг, захирлын тушаал, хөдөө сумдын номын сангуудын үйл ажиллагаатай томилолтоор ажилласан баримт бичиг, Статистикийн тайлан, Арга зүйн зөвлөмж аргачлал зэргээр хадгаламжийн нэгж бүрдүүлэн архивын зааврын дагуу үдэж хавтаслан архивласан
18	**Бүтээгдэхүүн 1.19** Фондын 3000 номонд сэргээн засварлалт хийх	Фондын номонд сэргээн засварлалт хийх	3043 номыг сэлбэн зассан
19	**Бүтээгдэхүүн 2.1** ЗД-ын мөрийн хөтөлбөрийн 2.18 заалт Аймгийн төв номын санг цахим	1.Орчин үеийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах 2.Интернэт мэдээллийн танхим	Номын сангийн гэрээр ном олгох танхимыг мэдээллийн танхим болгоход 10 сая төгрөгийн төслийг ДЗОУБ-д, номын сангийн их засварын

	мэдээллийн сүлжээнд холбон, сумын номын сангийн фондыг жил бүр баяжуулж, уншигчдын тоог нэмэгдүүлэх 2.18.1 Төв номын санг интернэтэд холбоход дэмжлэг үзүүлнэ 2.18.2 Номын фондыг жил бүр баяжуулна	тохижуулах болон номын сангийн их засварын төслийг боловсруулж ИТХ хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх 3. Фондын номыг электрон каталогит оруулах / 70 хувь/ 4.Номын сангийн үйлчилгээг өртгөтгөж уншигчдад мэдээллийг цахим хэлбэрээр түгээх 5. Сумдын номын сангуудад БСШУЯам, Нээлттэй Нийгэм Форум, Азийн сан, Үндэсний төв номын сангаас хандивласан номуудыг хуваарилах	төслийг Аймгийн ИТХ-д оруулаад байна. “Шилдэг ном -2009”-д шалгарсан номуудыг 22 суманд тус бүр 16 нэр төрлийн 20 ширхэг нийт 3.991.300 төгрөгний номыг хандиваар хувиарлан өгсөн. 2010 онд 270 нэр төрлийн 430 ширхэг 4.136.035 төгрөгний номыг худалдан авч фонд баяжилт хийсэн. Хандиваар 179 төрлийн 200 ширхэг 1761.639 төгрөгний номыг цуглуулсан Номын сангийн LiB4U программд фондын 21417 нэр төрлийн 51296 ширхэг номуудыг электрон каталогит оруулж, үндсэн фонд, хүүхдийн уншлагын танхим, нийтийн уншлагын танхимын монгол номуудыг оруулж фондын 90%-ийг каталогит оруулсан. Цахим номын санд байгаа зохиолчдын намтар, хүүхдийн зохиолууд зэрэг зохиол бүтээлийг сурталчилж мэдээлэл гаргаж, Хэрлэн сумын соёлын төв, цагдаагийн газар, Хэрлэн сумын ЕБ-ын 1, 4-р сургууль, Тэмүүжин цогцолбор сургуулийн номын сангуудад цахим номыг ашиглах талаар заавар өгч уншуулж байна
20	**<u>Бүтээгдэхүүн 2.2</u>** Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн 2.15 заалт	1. Номын санчдыг мэргэжил дээш-лүүлэх төвийн болон орон	“Үндэсний бичиг үсгийн баяр”-т оролцож, “Шилдэг ном-2009”- шалгарсан ном хэвлэлийг сумдын номын сангуудад хуваарилж ажилласан. Боловсрол Соёлын Газрын дарга, Аймгийн

	Соёл урлагийн байгууллагуудын ажилтнуудын мэргэшил ур чадварыг сайжруулах, эчнээ сургалтанд сургах ажлыг үе шаттай зохион байгуулах	нутгийн сургалтанд хамруулах 2. Сум болон сургуулийн номын санчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх 3.Мөрөн, Дэлгэрхаан, Дадал, Батширээт, Хурх, Бэрх, Өмнөдэлгэр, Галшар, Баян-Овоо, Норовлин сумдын болон сургуулийн номын сангийн ажилтай танилцаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх	нийтийн номын сангийн даргын баталсан удирдамжийн дагуу 2010 оны 05-р сарын 03-ны өдрөөс 05-р сарын 13-ны өдрийн хугацаанд Бэрх, Биндэр, Өлзийт тосгон, Цэнхэрмандал, Бор-Өндөр хотын соёлын төвийн болон сургуулийн номын сангийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийж мэргэжил арга зүйн зөвлөлгөө өгч ажиллаа. Хөдөө сумдыг орон нутгийн байршлаар нь бүсчилсэн хэлбэрт хувааж, бүсийн соёлын ажлыг сайжруулах, харилцан туршлага судлах, бусад соёлын байгууллагадаа үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор зохион байгуулсан. Бэрх нь зүүн бүсийн төвд хамрагдаж Батноров, Норовлин, Баян-Овоо сумдыг хамруулсан. Бэрх, Батноров, Норовлин сумдын соёлын төвийн захирлууд оролцсон. Бэрх, Өлзийт, Цэнхэрмандал, Хурхын номын сангуудад 2 сарын хугацаатай үүрэг даалгавар өглөө Хүүхдийн уншлагын танхимын номын санч Э. Цэрэн-Од, СУИС-ын магистр, Хүмүүнлэгийн ухааны их сургуульд захирал Ц. Ариунтуяа соёл судлалын чиглэлээр магистрт тус тус суралцаж, Хүүхдийн номын ордонд ном сэлбэн засалт, хүүхдийн уншлагыг удирдах нь сургалтанд Т. Отгонтуяа оролцсон.
21	**<u>Бүтээгдэхүүн 2.3</u>** БСШУЯамны 316-р тушаалын	1.Данс бүртгэлийг шинэчлэх 2.Нэгдсэн бүртгэлийг шинэчлэх	1. Шинээр ирсэн болон хандиваар ирсэн номуудыг нэг бүрчилсэн бүртгэлд стандартын

	хэрэгжилт		дагуу бүртгэн, бүртгэлийг хийж байна
22	**<u>Бүтээгдэхүүн 2.4</u>** Засгийн Газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан хөдөө орон нутгийн алслагдсан хүн амыг мэдээллээр хангах хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлж, "Явуулын номын сан"-гийн үйлчилгээг нэвтрүүлнэ.	1. Дадал, Батширээт, Хэрлэнбаян-Улаан, Галшар, Батноров, Дархан, Баян-Овоо зэрэг алслагдсан сум суурин, байгууллага хамт олон, отрын малчдад гэрээгээр ном олгох 2. Тайлан мэдээ гаргах	Баянхутаг суманд 172 номоор алслагдсан 5 өрхийн 9 хүнд 27 номоор, Тэмүүжин цогцолбор, Хэрлэн сумын 2-р цэцэрлэгт нүүдлийн номын сангийн гэрээ хийж номын тухай мэдээлэл хийж 35 багш сурагчдыг хамруулсан Батноров сумын 5-р багийн малчин 18 өрхөд 2 удаа 30 ш номоор үйлчлээд байнаБаян-Адарга сумын номын сантай нүүдлийн номын сан ажиллуулж 65 уншигчдад 136 ном олгож үйлчилсэн.
23	**<u>Бүтээгдэхүүн 2.6</u>** Засгийн Газрын 143 тогтоол, аймгийн төрийн байгууллагуудын шударга ёс, ил тод байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах Шударга ёс зүй, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах	1.Ажилтан албан хаагчдад сургалт зохион явуулах 2.Ёс зүйн асуудлаар гарын авлага бэлтгэж гаргах	Шударга ёс, ил тод байдлын төлөвлөгөөг гаргаж, байгууллагын мэдээллийн самбарт үйл ажиллагаагаа ил тод байлгах үүднээс төсвийн сар, улирлын орлого зарлагын мэдээ тайланг нийтэд ил тод дэлгэн олон нийтэд мэдээлж байна. Байгууллагын ажилтан албан хаагчдад "Харилцааны сэтгэл зүй, албан харилцааны ёс зүй" сэдвээр сургалт явуулж, гарын авлага гаргаж уншигчдад ашиглуулж байна.
24	**<u>Бусад ажил</u>**		"Тохижилт соёлжилтын аян"-аар байгууллагын гаднах саадыг өндөрлөж, "номын сан" гэрэлтүүлгэтэй хаягийг шинээр хийсэн. Дээд өрөөнүүдийн халаалтын шугамыг 2.3 сая төгрөгөөр засварлуулж ажиллалаа. Ажилтан албан хаагч бүр 5 цэцэг, 2 цэцэгийн мандал, 30 ширхэг шар хуайс, хайлаас, 2ш

			нарсыг шинээр тарьж арчилж байна
25			Үндсэн фондын тооллогыг 1-р сарын 02-ноос эхэлж 03-р сарын 01-нд дуусгасан.

Номын сангийн захирал Ц. Ариунтуяа